

ШИФР : 04/21

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН 112 ДАХЬ КМ
ОРЧМООС ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТАЛБУЛАГ
/БАЯНБУЛАГ БАГ/, ЗАГДАЛ БАГ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН
СУМЫН БЭЛЭНДАЛАЙ СУУРИН, ДАРХАН-ЭРДЭНЭТ ЧИГЛЭЛИЙН
УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ОРХОН СУМЫН
УУЛЗВАРТАЙ ХОЛБОХ 92.13КМ АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

БОТЬ-7/11

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

ШИФР : 04/21

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН 112 ДАХЬ КМ
ОРЧМООС ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТАЛБУЛАГ
/БАЯНБУЛАГ БАГ/, ЗАГДАЛ БАГ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН
СУМЫН БЭЛЭНДАЛАЙ СУУРИН, ДАРХАН-ЭРДЭНЭТ ЧИГЛЭЛИЙН
УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ОРХОН СУМЫН
УУЛЗВАРТАЙ ХОЛБОХ 92.13КМ АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

БОТЬ-7/11

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

ЗАХИРАЛ  /Б.АНАНДА/ИНЖЕНЕР  /Д.УРАНЧИМЭГ/

УЛААНБААТАР 2021

Бүлгийн дугаар	Бүлгийн нэр	Хуудасны тоо
100	ЕРӨНХИЙ	1/1-29
200	МАТЕРИАЛ, МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ	2/1-52
300	ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ БА ХЭМЖИЛТИЙН ХҮЛЦЭХ АЛДАА	3/1-6
400	ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАЛТ	4/1-5
500	ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ	5/1-13
600	ЧУЛУУН БА ШОРООН ОРД	6/1-7
700	ХӨДӨЛГӨӨН НЭВТРҮҮЛЭХ	7/1-7
800	СУУРИЙН ДООД ҮЕ	8/1-6
900	ЦЕМЕНТЭЭР БЭХЖҮҮЛСЭН ХӨРСӨН СУУРЬ	9/1-13
1000	ТӨМӨР БЕТОН ХУЧЛАГА	10/1-57
1100	ХӨВӨӨ	11/1-4
1200	ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ	12/1-14
1300	ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖИЙН БЕТОНЫ АЖИЛ	13/1-46
1400	ТӨМӨР БЕТОН ГҮҮРИЙН АЖИЛ	14/1-21
1500	ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ	15/1-5
1600	ЗАМЫН ТОНОГЛОЛ	16/1-11
1700	ТӨМӨР БЕТОН ШОН СУУРИЙН АЖИЛ	17/1-15

БҮЛЭГ 100 – ЕРӨНХИЙ

БҮЛЭГ 100 – ЕРӨНХИЙ

101. БАЙРШИЛ БА ХАМРАГДАХ ГАЗРУУД.....	3
102. ГЭРЭЭНД ХАМРАГДАХ ЗҮЙЛҮҮД (ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД)	3
103. АЖЛЫН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ	4
104. ЗУРАГ ТӨСӨЛ	4
105. АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ АКТ	7
106. БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ	8
106. БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ	9
107. ТӨСЛИЙН ЧАНАРЫН БАТАЛГАА БА ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
108. ХЭМЖИХ НЭГЖ, ТОВЧИЛСОН ҮГС	12
109. СТАНДАРТ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА.....	15
110. БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ.....	15
111. АЖИЛЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ.....	16
112. ТҮР БАРИЛГА	16
113. БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД.....	16
114. УС, ЦАС, МӨС, ЭЛСНИЙ ХАМГААЛАЛТ	20
115. ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АВААР ОСОЛ	20
116. ХАШАА, ХААЛГА БАРИХ, ХАМГААЛАХ, ЗАСВАРЛАХ	22
117. ТЭСРЭХ БОДИСЫГ ХЭРЭГЛЭХ	22
118. ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ	24
119. ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ ШИЛЖҮҮЛЭХ.....	26
120. ЗАХИАЛАГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ.....	26
121. ГАЗАР АВАХ.....	26
122. УСАН ХАНГАМЖ	27
123. МАТЕРИАЛ БА ХИЙЦ ХЭСГҮҮД	27
124. ЦООНОГ БА ШИНЖИЛГЭЭНИЙ НҮХНЭЭС АВСАН МАТЕРИАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	28
125. МАТЕРИАЛ, ХИЙЦ ХЭСГҮҮДИЙГ ХАДГАЛАХ	28
126. ШИНЖИЛГЭЭНИЙ СЕРТИФИКАТ	28
127. ГЭРЭЛ ЗУРАГ	29
128. ЗАМЫН МЭДЭЭЛЛИЙН САМБАР	29
129. ТАЛБАЙН ЕРӨНХИЙ БАЙГУУЛАМЖУУД.....	29
130. ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ, ХЯНАЛТЫН ИНЖЕНЕРИЙН БАЙР СУУЦ БА АЖЛЫН БАЙРЫГ ХАНГАХ ХУГАЦАА	29

131. ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ ТҮҮНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БА ИНЖЕНЕРТ ЗОРИУЛСАН ОРОН СУУЦ, АЖЛЫН БАЙР, ТЭДГЭЭРИЙН ТАВИЛГА ТОНОГЛОЛЫН ДААТГАЛ, ЭЗЭМШИЛ.....	29
132. ТАЛБАЙН ЛАБОРАТОРИ БА ИНЖЕНЕРИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТАВИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР АРЧЛАЛТ.....	29
133. ТҮР СУУРИНГ БУУЛГАХ	30
134. ИНЖЕНЕРИЙГ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖООР ХАНГАХ.....	30
135. МАШИНААР ХАНГАХ	30
136. ИНЖЕНЕРИЙН ИЛҮҮ ЦАГИЙН ТӨЛБӨР.....	30
137. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ	30
138. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	31

101. БАЙРШИЛ БА ХАМРАГДАХ ГАЗРУУД

Замын дагуух чиглэлийн талаархи нарийвчилсан мэдээллийг Инженерийн нарийвчилсан зураг төсөлд (ИНЗТ) үзүүлсэн болно. Ажлын талбай нь зурагт үзүүлсэн доорхи зүйлс хамаарах буюу эсвэл гэрээнд тусгагдсаны дагуу байна. Үүнд:

- Замын зурвас газар,
- Шороон ордууд,
- Хаягдал зайлуулах газар,
- Туслах замууд,
- Түр замууд,
- Гүйцэтгэгчийн түр байгууламжууд,
- Хадгалах, агуулах газрууд,
- Түр лагериуд,
- Талбайн завод, лабораториуд,
- Замын дагуу байгуулах үйлчилгээний цогцолбор

Замын зурваст орсон зөөгдөх барилга байгууламж, шугам сүлжээ, тэдгээрийн хамгаалах ажлын хамрах талбай

102. ГЭРЭЭНД ХАМРАГДАХ ЗҮЙЛҮҮД (ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД)

Төслийн хүрээнд хийгдэх ажлууд нь дараах гол зүйлүүдээс бүрдэх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.

- Талбайн лабораториуд, лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулах
- Бетон зуурмагийн үйлдвэр, чулуу бутлуурын үйлдвэр, холигчийн үйлдвэрүүдийг суурилуулж ажиллахад бэлдэх,
- Хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд, үйлдвэрүүдийн тохиргоог хийж Стандартчлал Хэмжил Зүйн төвөөр баталгаажуулах
- Ажлыг хэрэгжүүлэх зураг АГЗ (shop drawings) хийж батлуулах
- Талбайг цэвэрлэх, цэг тэнхлэг тавих, гадаслагаа хийх,
- Шороон болон чулуун ордуудыг нээж ашиглах зөвшөөрөл авах, материалын нөөц овоолго хийх, хамгаалалтын хашаа барих,
- Далан барих, уул давааны хэсэгт гүнзгий ухмал хийх
- Авто замд ус гаргах хоолой барих, тэдгээрийн толгой, далавч барих, орох гарах амсрын бэхэлгээг хийх,
- Төмөрбетон гүүр барих
- Шуудуу, хөрсөн доорх шүүрүүлэлт, жижиг ус зайлуулах байгууламжууд, хажуугийн болон уулын шуудуу, голын гольдрол татах, үерийн хамгаалалтын далан хийх бусад төрлийн шуудуунууд, шуудууны доторлогоо хийх гэх мэт, гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр ус зайлуулах шаардлагатай бүх байгууламжуудыг засварлах, шинээр барих
- Хуучин асфальтобетон хучлагыг холигч машинаар бутлан холих, ачиж тээвэрлэх, түр овоолго хийж суурийн доод үед хэрэглэхэд бэлдэх
- Суурийн доод үе барих,
- Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь ба хөвөө барих,

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- n) Битум цацлага хийх
- o) Асфальтобетон хучлага барих
- p) Бетоны арчилгаа хийх
- q) Тэмдэг тэмдэглэгээ хийх
- r) Гэрэлтүүлгийн тоноглолыг бэлтгэж суурилуулах,
- s) Замын тоноглолыг суурилуулах,
- t) Түр замын арчлалт хийж ажлын талбайгаар өнгөрч буй хөдөлгөөнийг зохицуулах,
- u) Мал амьтны гарц гаргах
- v) Ажлыг хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах үүднээс шаардлагатай нэмэлт ажлуудыг хийх,
- w) Барилга хүлээн авсан гэрчилгээг олгох хүртэлх ажлыг бүхэлд нь хариуцах, баталгаат засварын хугацааны туршид засвар арчлалтыг хийж, гэмтэл согогыг арилгах ажлыг гүйцэтгэх.
- x) Санхүүжилт авах материалын бүрдүүлэлт, хэмжилтийн зураг (ХЗ) боловсруулж батлуулах
- y) Зам барилгын ажлын дууссан үед эцсийн гүйцэтгэлийн зургийг (ГЗ) боловсруулж батлуулна.
- z) Зам барилгын ажлын явцыг видео бичлэг хийн ажлын танилцуулгад ашиглаж болно” гэж оруулав.

Дулаан, цэвэр бохир ус, цахилгаан, холбооны шугамыг зөөх хамгаалах ажлыг тухайн шугам сүлжээний ашиглагчийн зааврын дагуу Монгол улсад мөрдөгдөж буй норм дүрэм, аюулгүй ажиллгааны стандартуудыг баримтлан гүйцэтгэнэ.

103.АЖЛЫН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ

Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ Гэрээний нөхцөлд заасан ажлын хөтөлбөр төлөвлөгөөг графикийн хэлбэрээр бэлтгэсэн байх ба үүн дээр, төслийн зам баригдах газар орны цаг агаарын нөхцөлийг харгалзан хийгдэх бүх бэлтгэлийг хангах, машин техник, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийг оруулж ирэх, барилгын ажлыг явуулах, тэдгээрийн харилцан хамаарал, саад бэрхшээл зэргийг харуулсан мэдээлэлүүдийг оруулсан байна. Гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор графикчилсан төлөвлөгөөг танилцуулна. Ажлын төлөвлөгөөнд зам барилгын ажлын явцад хийгдэх зургуудыг хийх ажил тусгагдана. Ажлын төлөвлөгөөг боловсруулах программыг Гүйцэтгэгч нь Инженертэй зөвшилцөх бөгөөд Зөвлөх болон Гүйцэтгэгч нь ижил төрлийн программ ашиглахаар ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Программ ашиглалтын аливаа зардлыг Гүйцэтгэгч хариуцана.

104. ЗУРАГ ТӨСӨЛ

Зам барилгын ажилд 4 төрлийн зураг мөрдөгдөнө. Гэрээний зураг буюу улсын магадлалаар баталгаажсан Инженерийн нарийвчилсан зураг төсөл (ИНЗТ)-д энэхүү төслийн бүхий л ажлыг хэрэгжүүлэх инженерийн үндсэн шийдэл тусгагдсан байна. Харин ажлын явцад боловсруулагдах “Shop Drawings” буюу Ажил Гүйцэтгэх зураг (АГЗ), санхүүжилтийг баталгаажуулахын тулд хийгдэх Хэмжилтийн зураг (ХЗ) болон эцсийн Гүйцэтгэлийн зураг (ГЗ)-ийг Инженер хянаж баталгаажуулна. Гүйцэтгэгч нь Инженерээр Зургийг баталгаажуулсан нөхцөлд тухайн ажлыг хийж эхлэх, санхүүжилт авах, Замыг хүлээлгэж өгөх боломжтой болно.

ИНЗТ-ийг барилгын ажлын явцад мөрдөж ажиллах бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд хийж болох аливаа өөрчлөлтийг Зураг төсөл зохиогчтой заавал зөвшилцөнө.

Зураг хийхдээ Гүйцэтгэгчийн баримтлах ерөнхий зарчмууд:

- Бүх хээрийн хэмжилтийг өндөр нарийвчлалтай хийж, Инженерийн зөвшөөрсөн аргачлалаар боловсруулах.
- Туслан гүйцэтгэгч нар, материал ханган нийлүүлэгчдээс авсан мэдээлэл, зургийг хянаж нэгтгэх
- Хэрэглэх материалын шинжилгээ судалгааг бүрэн байгаа эсэхийг хянах
- АГЗ-г Төслийн баримт бичиг, ИНЗТ-тай тулгаж хянах
- Инженерт хүргүүлсэн огноог тавьж гарын үсэг зурах
- Номер дугаар бүхий албан ёсны захиаг хавсаргах
- АГЗ-г электрон хэлбэрээр илгээхдээ баримт бичгийн өөрчлөлт болон алдаанаас сэргийлсэн аюулгүй форматыг сонгоно.
- АГЗ Инженерээс санал болон тодруулга засварласан хэлбэрээр буцан ирсэн тохиолдолд өөрчлөлт оруулан засварлан дахин хянуулахаар явуулна.
- Инженерийн зааварчилгаа болон гэрээнд заасан даалгаврыг баримтлана.

Ажлын явцад баримтлах, гүйцэтгэх зураг төслийг дараах байдлаар ангилна.

Үүнд:

- Инженерийн Нарийвчилсан зураг төсөл (ИНЗТ)
- Ажил Гүйцэтгэх Зураг (АГЗ)
- Хэмжилтийн зураг (ХЗ)
- Гүйцэтгэлийн эцсийн зураг (ГЗ)

(1) Инженерийн нарийвчилсан зураг төсөл (ИНЗТ)

Улсын экспертизээр батлагдсан *инженерийн нарийвчилсан зураг, техникийн шаардлага, хайгуул хэмжилтийн тайлан, тайлбар бичиг зэргээс бүрдсэн* зураг төслийг Инженерийн нарийвчилсан зураг төсөл (ИНЗТ) гэнэ.

ИНЗТ нь барилгын ажлыг гүйцэтгэх техникийн үндсэн баримт бичиг бөгөөд түүнийг дагаж мөрдөн барилгын ажлыг хэрэгжүүлнэ. Барилгын ажлын явцад Гүйцэтгэгчийн болон Инженерийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай тохиолдолд зөвхөн Зураг төсөл зохиогчийн зөвшөөртэйгээр ИНЗТ-д өөрчлөлт оруулж болно.

Мөн Гүйцэтгэгчийн болон Инженерийн хүсэлтээр ИНЗТ-д оруулах аливаа өөрчлөлтийг зураг төсөл зохиогч боловсруулж болно. ИНЗТ-ийн өөрчлөлтөөс шалтгаалан төсөвт өртөг нэмэгдэхээс бусад тохиолдолд аливаа өөрчлөлт нь Гүйцэтгэгчийн гэрээний хугацааг өөрчлөх шалтгаан болохгүй.

ИНЗТ-ийн өөрчлөлтөөс шалтгаалан магадлашгүй ажлын зардлын хязгаарт оруулах төсөвт өртгийн өөрчлөлтийг Гүйцэтгэгчийн хүсэлтээр Инженер зөвшөөрсөн тохиолдолд Захиалагч баталгаажуулах бөгөөд энэ нь Зураг төсөл зохиогчид хариуцлага ноогдуулах үндэслэл болохгүй.

(1) Ажил Гүйцэтгэх зураг (SHOP DRAWINGS)

Ажил Гүйцэтгэх Зураг буюу (АГЗ)/(SHOP DRAWING) гэдэг нь барилгын талбар дээр

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

нарийвчилсан хэмжилт хийж ИНЗТ-ийн шийдлийг хэрэгжүүлэх, ажил гүйцэтгэх арга замыг тусгасан зураг юм.

Инженер АГЗ-г хүлээн авах хугацааг ажлын үе шат бүрээр гарган Гүйцэтгэгчид зааварчилгаа өгнө. АГЗ-г тогтоосон цаг хугацаанд нь ирүүлэхгүй байх, засвар болон зааварчилгаа өгөгдөн буцаагдсан АГЗ-ийн хариуг тогтоосон цаг хугацаанд нь ирүүлэхгүй байх зэрэг нь Гүйцэтгэгчийг ажлын төлөвлөгөөнөөс хоцрогдолт үүсэхэд хүлээх хариуцлагаас чөлөөлөхгүй.

Гүйцэтгэгчийн санал болгосон АГЗ-ийг Инженер зөвшөөрч батлахдаа гүйцэтгэгчийн технологийн хүчин чадал, материалын олдоц, ажил гүйцэтгэх аргачлал зэрэгт тулгуурлан ИНЗТ-ийн үндсэн шийдлийг өөрчлөхгүйгээр АГЗ-аар дамжуулан ИНЗТ-ийн зарим деталь хэсэгчлэл зэрэгт өөрчлөлт, тодруулга оруулж болно. Харин аливаа өөрчлөлт нь гэрээний үнэнд өөрчлөлт ороход хүргэх бол Захиалагчтай, ИНЗТ-ийн техникийн шийдлийг өөрчлөхөд хүргэх бол Зураг зохиогчтой зөвшилцөж баталгаажуулна. Дээрх асуудлууд үүсээгүй тохиолдолд Инженер АГЗ-ыг баталгаажуулж мөрдүүлнэ.

Анхаарах хүчин зүйлс:

- ИНЗТ- г нарийн судалсны дараа тухайн шатны ажлыг хийх АГЗ-г хийнэ.
- Зам барилгын үе шатны ажил бүрийг эхлэхээс 14 хоногийн өмнө тухайн Гүйцэтгэгч АГЗ (SHOP DRAWING) хийж Инженерээр баталгаажуулна.
- Нэг төрлийн ажлын хувьд хэд хэдэн ажил эхлэх хүсэлтийг нэг АГЗ-гийн хүрээнд өгч болно.
- Замын далан суурь, хучлагын ажлын үеүдийн гүйцэтгэхдээ замын ажил гүйцэтгэх хэсгийн хөндлөн огтлолын зургийг АГЗ-ийн бүрэлдэхүүнд оруулна. Түүнчлэн ажил гүйцэтгэх хэсгийн урт, зарцуулах хугацаа, график төлөвлөгөө, ажлын аргачлал, хэмжилтийн материал болон хэрэглэх материалын сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнг Инженерт танилцуулна.
- Хийцийн ажил гүйцэтгэхдээ тухайн хийцийг суурилуулах байршил дээр нарийн хэмжилт хийж түүн дээр үндэслэн АГЗ-ийг хийх ба төлөвлөлтийн шийдлийг хэрхэн буулгасныг харуулж, хэсэглэлийг нарийвчлан үзүүлнэ. Түүнчлэн хийцийн бүтэц, хийх аргачлал, хэрэглэх материалын сертификат, Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүн зэргийг АГЗ-ийн хамт Инженерт танилцуулна.
- Инженер АГЗ-г хянаж баталгаажуулж Гүйцэтгэгчид буцаан өгөөгүй тохиолдолд замын барилгын ажил цааш үргэлжлэх боломжгүй. Гүйцэтгэгч нь АГЗ-г тухайн ажил эхлэхээс 14-өөс багагүй хоногийн өмнө Инженерт танилцуулж баталгаажуулсан байх шаардлагатай.
- Инженер АГЗ-ийг 7 хоногт багтаан хянаж, баталгаажуулна. АГЗ-ийг барилгын ажлын цонхтой хугацаанд боловсруулж, зөвшилцөж батлуулахыг зөвлөмж болгов.
- Зам барилгын ажил гүйцэтгэх үед үе шатны ажилбар тус бүрээр АГЗ хийж, Инженерээс зөвшөөрөл авч баталгаажуулалт хийгдсэний дараа дараагийн үе шатны ажил эхэлнэ.
- Үе шатны ажлын зургууд Инженерээр баталгаажсан бол ажлын талбай дээр ажиллах инженерүүд болон ажилтнууд, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч өгч мөрдүүлнэ.

(2) Хэмжилтийн зураг (ХЗ)

Гүйцэтгэгч Гэрээнд заасан нөхцөлд, графикийн дагуу Захиалагчаас санхүүжилт хүсэх тохиолдолд ХЗ - г боловсруулж Инженерээр хянуулна. Энэхүү зураг нь тухайн үеийн Зам,

барилгын ажлын Гүйцэтгэлийг баталгаажуулахад шаардлагатай зайлшгүй баримтын нэг болно. Гүйцэтгэл бичих өдрөөр тасалбар болгон бүх хийгдсэн ажилд хэмжилт хийсний үндсэн дээр ХЗ-г боловсруулна. ИНЗТ-ийн дагуу тухайн үед хийгдсэн хэсгийг хэмжилтийн үндсэн дээр үзүүлсэн зургуудаас ХЗ бүрдэх бөгөөд ИНЗТ болон АГЗ-тай уялдсан байна.

Инженер нь дараах материалуудын хамт ХЗ-ийг хянаж, санхүүжилт олгох баримт бичгийг баталгаажуулна. (үүгээр хязгаарлагдахгүй)

- Гүйцэтгэгчийн лабораторт хийгдсэн шинжилгээний үр дүн
- Хэмжилтийн материалын үр дүн
- Хэмжих хэрэгслийн тохиргоо болон Стандартчлал Хэмжил Зүйн Төвийн баталгаажуулалтын сертификатууд, шилжүүлгийн коэффициентууд
- Итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтүүд, бараа материалын үйлдвэрийн сертификатууд
- Санхүүжилт болон ажлын тоо хэмжээний тооцоолол, хэмжилтийн зураг
- Тухайн ажлыг хэрэгжүүлэх хүсэлтүүд, түүний биелэлт

(3) Гүйцэтгэлийн эцсийн зураг (ГЗ)

Гүйцэтгэгч барилга угсралтын ажил дууссаны дараа замын нийт уртад хэмжилт хийж, Гүйцэтгэлийн зургийг гаргана. Гүйцэтгэлийн зураг нь ИНЗТ болон АГЗ-тай нягт уялдаатай байх хэрэгтэй. Инженер ГЗ-ийг ИНЗТ болон АГЗ-тай харьцуулан хянаж, зөрүүг хүлцэх алдааны хэмжээнд байгаа тохиолдолд шууд баталгаажуулна. Харин хүлцэх хэмжээнээс зөрүүтэй аливаа зөрүүг засах үүргийг Гүйцэтгэгч хүлээнэ. Зургийг бэлтгэхэд тухайн төслийн материалыг ханган нийлүүлэгч нар, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид, бусад туслан гүйцэтгэгчид оролцож болно.

ГЗ дараах мэдээллийг агуулна. (үүгээр хязгаарлахгүй) Үүнд:

- Байгууламжийг сүүлийн байдлаар хэмжилт хийж нарийвчилсан зураг
- Ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, тоног төхөөрөмж нийлүүлэгчдийн тухай мэдээлэл
- Итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт, үйлдвэрийн сертификат

105. АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ АКТ

Гүйцэтгэгч нь ажил хүлээлгэн өгөхдөө дараах 3 төрлийн акт, баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

Баримт бичгийн бүрдэл 1

- 1) Цэг, тэнхлэг хүлээлгэж өгсөн акт
- 2) Барилга угсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрөл
- 3) Барилгын ажил хариуцсан даамал, талбайн инженер, объектын дарга томилсон тушаалууд
- 4) Барилга барих газар олгосон орон нутгийн захиргааны захирамж
- 5) Зам гүүрийн барилга объектын ажлын зураг
- 6) Тайлбар бичиг
- 7) Зам гүүрийн барилга объектын зураг хийх техникийн даалгавар
- 8) Барилга барих газрын геологийн дүгнэлт
- 9) Техникийн шаардлага
- 10) Ажлын зурагт хийсэн экспертизийн дүгнэлт

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- 11) Барилгын ажил гүйцэтгэх гэрээ
- 12) Үндсэн болон туслах реперийг бэхэлсэн акт, хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн актууд
- 13) Барилгын ажил явагдсан хугацаанд ажигласан цаг уурын ажиглалтын мэдээ
- 14) Улаан ном (Барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх явцын барилгын ажлын тэмдэглэл, талбайн журналыг зохих ёсоор хөтөлсөн байх);

Баримт бичгийн бүрдэл 2

Гүйцэтгэгч дараах ажлын актууд (гарын үсэг, тамга тэмдэг бүрэн гүйцэд, бичилт бүрэн байх)-ыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар баталгаажуулан, фото зургийг материалд хавсарган бичиг, баримтын товъёог хийсэн байна. Үүнд:

- 1) Карьер, орд газруудыг дарсан акт, сумын байгаль орчныг хамгаалах улсын байцаагчийн дүгнэлт;
- 2) Зураг төслийн байгууллагын зохиогчийн хяналтын дүгнэлт, түүний биелэлт ;
- 3) Удирдах дээд байгууллага, орон нутгийн засаг захиргаанаас өгөгдсөн албан шаардлага, акт, дүгнэлт, тэдгээрийн биелэлт;
- 4) Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээхэд замын тэмдэг, тэмдэглэгээ болон тоноглол хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан эсэх, тухай орон нутгийн Замын цагдаагийн газрын дүгнэлт, зөвшөөрөл

Баримт бичгийн бүрдэл 3

Гүйцэтгэгч дараах ажлын актуудыг Инженерээр баталгаажуулан, (график, схем, фото зургийг материалд хавсаргах) бичиг, баримтын товъёог хийсэн байна. Үүнд:

- 1) Ажил гүйцэтгэх график;
- 2) Талбайн хэмжилтүүд;
- 3) Лабораторийн шинжилгээний дүгнэлтүүд;
- 4) Ил болон далд ажлын актууд болон ажил гүйцэтгэх хүсэлтүүд (барилгын ажилд хэрэглэсэн түүхий эд, материал, бүтээц эдэлхүүний үйлдвэрийн паспорт, гарал үүсэл, тохирлын болон техникийн гэрчилгээ, чанарын баталгааг гэх зэрэг холбогдох материалдыг хавсаргасан байх);
- 5) Зөвлөх багийн албан шаардлагууд, тэдгээрийн биелэлт;
- 6) Хэмжилт, материалын шинжилгээний дүгнэлтүүд;
- 7) Ажил Гүйцэтгэх Зураг (SHOP DRAWING);
- 8) Хэмжилтийн зураг (ХЗ);
- 9) Гүйцэтгэлийн зураг (ГЗ);

106. БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ

Гүйцэтгэгч, гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор төлөвлөж буй зохион байгуулалтын арга хэмжээ ба ажлыг хийж гүйцэтгэх аргачлалаа Инженерт танилцуулна. Аргачлал нь дараах зүйлсийг агуулсан байх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

Талбайн лабораторийн зохион байгуулалт, хангамж,

- Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага
- Түр байгууламжуудын зохион байгуулалт,
- Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, төлөвлөж буй үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ,

ханган нийлүүлэлт

- Гүйцэтгэгчийн түр лагерь ба материал нөөцлөх газруудын байршил
- Орд газрын ашиглалт, чулуу бутлалт, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт,
- Бусад чулуун материалын үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, хадгалалт, ашиглалт,
- Шороон ордын ашиглалт, тэдгээрт хүрэх туслах замууд,
- Зам барилгын үе шатны ажлуудыг гүйцэтгэх
- Замын ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах материалын хангамж, ашиглалт, хадгалалт,
- Бетон хольц бэлтгэх төхөөрөмж
- Бетон зуурмагийн үйлдвэр, тоног төхөөрөмж,
- Цахилгааны хангамж, ашиглалт
- Түр замууд, тэдгээрийн тогтмол арчилгаа
- Ухмал ухах аргачлал,
- Усан хангамжийн зохион байгуулалт,
- Ажлын ээлжийн зохион байгуулалт,
- Мэргэжилтэй болон туслах ажилчдын хангамж,
- Гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянах,
- Чанарын хяналт, шинжилгээ хийх аргачлалууд болон ашиглах тоног төхөөрөмж.

Ажлыг гүйцэтгэх явцдаа Гүйцэтгэгч, дээр дурдсан зүйлсийн дагуу бэлтгэж танилцуулсан зохион байгуулалт, аргачлалдаа аливаа нэмэлт өөрчлөлт оруулахаар бол тэдгээрийг хэрэгжүүлэхээс өмнө Инженерт дэлгэрэнгүй байдлаар нарийвчлан танилцуулна.

Хэрвээ Гүйцэтгэгч байнгын ажлын зарим хэсгийг ажлын цагаас бусад үед хийж гүйцэтгэх хүсэлтэй бол тэдгээрийг хянах боломжоор хангах үүднээс, нэгээс доошгүй хоногийн өмнө Инженерээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

106. БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ

Зам барилгын ажлын үе шат бүхэнд ажил эхлэхийн өмнө Ерөнхий гүйцэтгэгч нь тухайн ажлыг гүйцэтгэх технологи аргачлалыг боловсруулж инженерээр баталгаажуулах бөгөөд зөвхөн энэ нөхцөлд барилгын ажил эхлэхийг зөвшөөрнө.

(1) ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Ерөнхий гүйцэтгэгч нь төслийн ажлын эхэнд дараах төлөвлөгөөнүүдийг боловсруулж инженерээр батлуулсан байна. Үүнд:

- 1) Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуй, Байгаль орчныг хамгаалах Төлөвлөгөө
- 2) Төслийн Чанарын Хяналтын Төлөвлөгөө
- 3) Хяналт Шинжилгээний Төлөвлөгөө

Ажлын аргачлалыг боловсруулж батлуулах үйл ажиллагаа нь ямар ч төрлийн ажил дээр нэг загвараар явагдана. Ойлгомжтой болгох үүднээс төмөр бетон хучлагын ажлын технологи аргачлалыг жишээ болгон дор үзүүлэв.

(2) АЖЛЫН АРГАЧЛАЛ ХИЙХ ЗАГВАР (ТӨМӨР БЕТОНЫ АРГАЧЛАЛА)

- 1) АГЗ –г боловсруулж Инженерээр баталгаажуулсан байх
- 2) Хучлага дэвсэхэд ашиглагдах бүх төрлийн машин механизм, тоног төхөөрөмжүүд техникийн үзлэгт орсон байх
- 3) Хучлага дэвсэх ажилд оролцох гар ажилчид, механизмын операторчин, жолооч нар, бетон зуурмагийн үйлдвэрийн ажилтнууд болон инженер техникийн ажилчид аюулгүй ажиллагааны сургалтанд сууж, түүнийг нотлох үнэмлэх авсан байх
- 4) Нарийн мэргэжлийн операторчин, жолооч, механизмчид мэргэжлээрээ 3 –аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, мэргэжлийн үнэмлэхтэй байх
- 5) Бетон зуурмагийн үйлдвэрийн пүүний хэмжилт болон тунлалт зэрэг нь үнэн зөв, хэвийн байгаа эсэхийг стандартчлал хэмжил зүйн газраар баталгаажуулж, тохиргоог хийлгэсэн байх
- 6) Гүйцэтгэгчийн лабораторийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл стандартчлал хэмжил зүйн төвөөр шалгагдаж, тохируулга хийгдсэн байх
- 7) Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэхэд хүрэлцээтэй байх хүн хүчний хангамж, туршлагыг нотлох
- 8) Бетон хольц итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан байх
- 9) Бетонд хэрэглэглэгдэх бүх материалиудыг инженерээр батлуулсан байх
- 10) Батлагдсан орцоор инженерийн хяналтан дор гүйцэтгэгчийн лабораторт болон бетон зуурмагийн үйлдвэрт туршилтын зууралт хийж уг зуурмагийн (trial mix) шинж чанар нь техникийн шаардлагын үзүүлэлтийг хангаж баталгаажсан байх
- 11) Бетон дэвсэх талбайн туршилт (masterpiece) –ыг тусгайлсан газар хийж ямар зүйл дээр алдаа дутагдал гарч болзошгүйг анхааран арга хэмжээ авч хучлагын ажил хийх жишиг аргачлал, загварыг инженерээр баталгаажуулсан байх
- 12) Агаарын хэм, салхины хурд, хур тунадасны байдал нь бетон дэвсэх үеийн агаарын хэмд тавигдах техникийн шаардлагыг хангаж буйг баталсан хэмжилт болон урьдчилсан цаг уурын мэдээ
- 13) Ган тор, дагуу болон хөндлөн заадсын хийцийг инженерээр шалгуулж, баталгаажуулсан байх
- 14) Гүйцэтгэгч нь суурийн үеийг бэлтгэхээс эхлэн бетоны арчилгааг хийж дуусах хүртэлх хучлагын бүх үе шатны ажлын аргачлалыг өмнө нь хийсэн талбайн туршилт (masterpiece)-дээр үндэслэн боловсруулж хийнэ. Уг аргачлалыг инженерээр батлуулсан байх шаардлагатай.

107. ТӨСЛИЙН ЧАНАРЫН БАТАЛГАА БА ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ерөнхий гүйцэтгэгч нь төслийн чанарын баталгаа/чанарын хяналтын төлөвлөгөөг боловсруулж инженерээр баталгаажуулна. Уг төлөвлөгөө нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Чанарын удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Ерөнхий гүйцэтгэгчийн чанарын удирдлагын зохион байгуулалт, харилцан уялдаа холбоог диаграмм, схем ашиглан үзүүлэх бөгөөд тэдний гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

2. Талбай дээрх чанарын удирдлагын багийн бүтэц зохион байгуулалт

Барилга баригдах объектэд ажиллах чанарын удирдлагын багийн зохион байгуулалт, харилцан уялдаа холбоог диаграмм, схем ашиглан үзүүлэх бөгөөд тэдний гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

3. Чанарын хяналтын удирдлага болон багийн гишүүдийн чиг үүрэг

Чанарын хяналтын багт ажиллаж буй удирдлага болон мэргэжилтнүүдийн чанарын хяналтын чиглэлээр хүлээх үүрэг, хариуцлагыг нэг бүрчлэн тодорхойлно.

4. Худалдан авалт

Материалын Худалдан авалтыг хийхийн өмнө тухайн нийлүүлэгчийн талаарх мэдээлэл, шинжилгээний үр дүн, чанарын сертификат зэргийг Инженерээр хянуулж зөвшөөрөл авна. Гүйцэтгэгч нь нийлүүлэгчийг сонгохдоо сайн судлах хэрэгтэй ба аль болохоор нийлүүлэгчдийг олон солихгүй байхыг эрмэлзэнэ. Нийлүүлэгч нь олон жилийн туршлагатай, нэр хүндтэй, бараа материал, техник тоног төхөөрөмжийн чанарын сертификаттай байна. Чанарын баталгаа, бичиг баримтгүй бараа материал төслийн хүрээнд авахгүй байвал зохино.

5. Баримт бичгийн хяналт

Гүйцэтгэгч нь баримт бичгийн хяналт болон удирдлагын журмыг боловсруулж баталсан байна. Компаний удирдлагын түвшний болон талбайн өдөр тутмын хэмжилт туршилтын бүх бичиг баримтууд бүгд хамрагдана. Бүх бичиг баримтууд чиглэл чиглэлээрээ кодлогдсон байх бөгөөд электрон болон цаасан хэлбэрээр хадгалагдана. Инженерт танилцуулах, шалгуулах материалууд нь өмнө талдаа өргөн мэдүүлэх нүүр хуудас (Submittal package cover)-тай байна.

6. Материалын хяналт

Ажлын талбайд авчрах бүх материалууд нь энэхүү техникийн шаардлагыг хангаж байгаа болон тэдгээрийн хадгалалт хамгаалалт, хүчинтэй байх хугацаа нь гэрээний хэрэгжилтийн нийт хугацаанд уг шаардлагыг байнга хангаж байхыг илтгэх бүрэн бичиг баримтыг хөтөлж Инженерт танилцуулна.

7. Тодорхойлох, тэмдэглэх, мөшгөх

Барьж, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүд дээр тэмдэглэгээ хийх бөгөөд үл тохирол гарсан тохиолдолд уг тэмдэглэгээний дагуу мөшгөлт хийж шалтгааныг тодруулна.

8. Хүний нөөцийн бүртгэл

Хүний нөөцийн алба болон Чанарын удирдлагын багийнхан төслийн хүрээнд мэргэжлийн өндөр ур чадвар, дадлага туршлагатай, багаар ажиллах чадвартай, ёс суртахууны доголдолгүй ажилтнуудыг шилж сонгон ажиллуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд орлон ажиллах мэргэжилтнүүд болон ИТА-ын нөөцийг бүрдүүлсэн байна. Ёс суртахууны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын ноцтой доголдол гаргасан ажилтнуудыг төслийн хүрээнд ажиллуулахыг зөвшөөрөхгүй.

9. Чанарын бүртгэл

Чанарын холбогдолтой бичиг баримтуудыг нягт нямбай хөтлөх бөгөөд хадгалахдаа гаднын нөлөө хүрэхээргүй аргаар хадгалбал зохино.

10. Үл тохирлын удирдлага (*Non-Conformance Management*)

Дотоод хяналтын төлөвлөгөөгөөр хийгдэх хяналт шалгалтаар болон гэнэтийн нөхцөлд барилгын ажлын явцад илэрсэн үл тохирлын шалтгааныг мөшгөж, цаашид энэ төрлийн үл тохирол гаргахгүй болгох бүх арга хэмжээг авна.

11. Шалгалт болон туршилтын үр дүнг тайлагнах маягтууд (*Recording Inspection And*

Test Results)

Төслийн хүрээнд хийгдэх шинжилгээ туршилт, хэмжилтийн үр дүнг боловсруулж өгөх маягтуудыг боловсруулж батлуулах

12. Чанарын аудит

Гүйцэтгэгчийг төлөөлж дотоод аудитын баг ажиллуулах бөгөөд дотоод хяналтаар илрүүлсэн доголдлыг арилгах арга хэмжээ авна.

13. Ажил гүйцэтгэх аргачлал

Ажил гүйцэтгэх аргачлалыг зүйл 106-д заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

14. Машин механизмын засвар болон үйлчилгээний ажлын хяналтын төлөвлөгөө

Төсөлд хэрэглэх бүх машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрүүдийн ээлжит үйлчилгээ болон засвар хийх болон техникийн бүрэн байдлыг шалгах төлөвлөгөөг хийж боловсруулна.

15. Хяналт шинжилгээний төлөвлөгөө (ITP) *Inspection and test plan*

200-р бүлэгт заасны дагуу ажлын үе шат бүрийн туршилт шинжилгээ хийх төлөвлөгөөг хийнэ. Инженер баталсан тохиолдолд цаашид энэ төлөвлөгөөний дагуу туршилт шинжилгээ хийх

108. ХЭМЖИХ НЭГЖ, ТОВЧИЛСОН ҮГС

(а) Хэмжих нэгж

Хэмжих нэгжийн тэмдэглэгээнүүд нь BS 5775 (ISO 31/1)-д өгөгдсөн SI /СИ/ системийн дагуу байх ба тэдгээрийн ердийн товчилсон үгсийг дор жишээ болгон үзүүллээ. Харгалзах нэгжийн талаар бичиг баримтуудад дурдсан байвал адил SI /СИ/ нэгжүүдийг орлуулна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

μм	микрон = м x 10 ⁻⁶
мм	миллиметр
м	метр
км	километр
мм ²	хавтгай дөрвөлжин миллиметр
м ²	хавтгай дөрвөлжин метр
км ²	хавтгай дөрвөлжин километр
га	гектар
м ³	шоо метр
л	литр
рад	радиан
с	секунд
°С	Цельсийн хэм
кг	килограмм
г	грамм = кг x 10 ⁻³
мг	миллиграмм = кг x 10 ⁻⁶
мг/л	литр дэх миллиграмм
т	тонн = кг x 10 ³
кг/м ³	нэг шоо метрт оногдох килограмм
т/м ³	нэг шоо метрт оногдох тонн
Н	Ньютон
Н/м ²	нэг хавтгай дөрвөлжин метрт оногдох Ньютон
Па	Паскаль = 1 Н/м
МПа	Мега Паскаль = Па x 10 ⁶
Ж	Жоуль
Вт	Ватт
Кв	Киловатт
А	Ампер
В	Вольт

б) Дараах товчилсон үгсийг ашиглав.

Товчилсон Үзүүлэлт
тэмдэглэгээ

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

ЧБХ	Чулуулгийн бутрагдлын хэмжээ
ДХБХ	Дундаж хамгийн бага хэмжээ
БШЧ	Битумын шинж чанар
ХДҮ	Хөрсний даацын үзүүлэлт
БХ	Бутрагдалтын харьцаа
ХҮИ	Хавтгай, үзүүрлэгийн индекс
ИГА	Иржгэр гадаргуутай арматур
ЧЭТ	Чулуулгийн элэгдлийг тодорхойлох
УХ	Урсалтын хязгаар
ШС	Шугаман суулт
ЧА	Чийгийн агуулалт
ХҮХИН	Хамгийн их хуурай нягт
ТЧХ	Тохиромжтой чийгийн хэмжээ
УХИ	Уян харимхайн илтгэлцүүр
СХ	Суналтын (тасралтын) хязгаар
УХМ	Уян харимхайн модуль, УХИ х (0.425 мм-ийн шигшүүрээр нэвтрэн өнгөрөх хувь)
УХҮ	Уян харимхайн үзүүлэлт, УХИ х (0.075 мм-ийн шигшүүрээр нэвтрэн өнгөрөх хувь)
ЭЭ	Элсний эквивалент
ХЖ	Хувийн жин
SI /СИ/	Хэмжих нэгжийн олон улсын стандарт
ЧХХЧ	Чулууны хүйтэнд тэсвэрлэх чадварыг тогтоох шинжилгээ, 5 эргэлтэд алдагдал тооцох
С	Суналт
ББ	Битумын барьцалдалт
СББ	Суналтын бат бэх
НТК	Нэгэн төрлийн илтгэлцүүр
ЭДС	Эрдсийн доторх сүвшил
ЕПЦ	Ердийн портланд цемент
ш	Ширхэг (нэгж) ө.х., 6 ш.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

№	Дугаар (дараалал) ө.х., №. 6
у/ц	Ус/цементийн харьцаа
ж	Жин
%	Хувь
хам.их	хамгийн их
хам.бага	хамгийн бага
голч	голч /диаметр/
цаг	цаг
мин	минут
сек	секунд
дх	долоо хоног

109. СТАНДАРТ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Стандарт техникийн шаардлагуудын хувьд доорх товчилсон үгсийг ашиглав:

MNS	Монголын үндэсний стандарт
AASHTO	Америкийн стандарт (Америкийн мужийн зам тээврийн удирдах ажилтнуудын холбоо)
ASTM	Америкийн туршилт шинжилгээ, материалын нийгэмлэг
BS	Британийн стандарт
BSCP	Британийн стандарт
ISO	Олон улсын стандартчиллын байгууллага
ГОСТ	ОХУ-ын стандарт

Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагад дурдсан Стандарт техникийн шаардлагууд болон бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувь иж бүрэн багцыг Инженерийн талбайн ажлын байранд хангаж өгнө. Мөн тэдгээр стандарт техникийн шаардлагууд болон тэдгээртэй адил төстэй бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувь иж бүрэн багцыг Гүйцэтгэгч өөрийн хэрэгцээнд зориулан талбай дахь ажлын байрандаа хадгалж ашиглана.

110. БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Төслийн ажилтай холбоотойгоор ажлын талбайд болон ойролцоо хэсэгт Захиалагчийн ажиллуулж байгаа бусад Гүйцэтгэгчид болон Захиалагчийн ажиллагсад ажиллаж байгаа

талаар Инженерт мэдэгдэнэ. Захиалагчийн ба гуравдагч этгээдийн өмч мөн бишээс үл хамааран, нөгөө талаар Инженерийн зүгээс уг ажлыг Гүйцэтгэгчид хариуцуулсан эсэхээс үл хамааран гэрээний нөхцөлийн дагуу Гүйцэтгэгч нь аливаа ажилд ямар нэг байдлаар хөндлөнгөөс оролцох ёсгүй. Гүйцэтгэгч нь бусдын хийсэн ажил, ханган нийлүүлсэн болон талбайд барьж суурилуулсан зүйлсийг хүндэтгэн үзэх бөгөөд Гүйцэтгэгчийн өөрийн буюу түүний ажиллагсдын, эсвэл туслан гүйцэтгэгчдийнх нь буруугаас тэдгээр зүйлс алдагдсан, эвдэрсэн тохиолдолд хариуцлагыг хүлээнэ.

111. АЖИЛЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ

Гүйцэтгэгч барилгын ажилтай уялдуулан өөрийн ажилтан, ажилчдыг ажлын талбай руу болон талбайгаас зөөх зардалд, гадаадын мэргэжилтнүүдийг оролцуулан, гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүйгээр, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, элсүүлэх, ажлын талбай руу болон талбайгаас нааш цааш зөөвөрлөхөд зарцуулах бүх зардлыг төсөвтөө тооцож оруулна.

112. ТҮР БАРИЛГА

Гэрээнд гарын үсэг зурсны дараа, ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч, түр барилгын талаар хийхээр төлөвлөж буй ерөнхий зохион байгуулалтыг харуулсан нарийвчилсан зургийг Инженерт танилцуулна. Гүйцэтгэгч, доор дурдсан зүйлсийг агуулсан, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдаагүй, бүрэн мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:

- Тооцоо,
- Диаграмм,
- Түр барилгын ажлыг хэрхэн гүйцэтгэхээр төлөвлөж буйг харуулсан танилцуулга,
- Гадаслагааны тухай мэдээлэл,
- Бусад холбогдох мэдээлэл.

Бүх түр барилгын ажлуудыг Инженерийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч, гэрээний нөхцөлүүдийн дагуу нийт ажлыг хийж гүйцэтгэхэд түр барилгын ажлууд нь хэрхэн түүний хөтөлбөртэй уялдаж байгаа талаар нотлон харуулна. Түр барилгуудыг барих, тэдгээрийн аюулгүй байдал, засвар арчлалт, ажил дууссаны дараа тэдгээрийг буулгах, ажлын үеэр ашигласан тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд гэх мэт түр ажилтай холбоотой зүйлсийн хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээнэ. Гүйцэтгэгчийн болон түүний туслан гүйцэтгэгчийн түр барилгын ажилтай холбоотой гаргасан саналыг Инженерээс зөвшөөрсөн аливаа зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийг гэрээний дагуу хүлээх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

113. БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

Барилгын ажлын үед дараах ерөнхий шаардлагууд тавигдана. Үүнд:

- (1) Гүйцэтгэгч шөнийн цагаар ажил гүйцэтгэх тохиолдолд хангалттай гэрлээр хангах ба Инженерт ажлын явцыг ажиглах, хянах, материалын шинжилгээ, туршилт хийх нөхцөлөөр хангах үүднээс нэмэлт гэрэлтүүлэг суурилуулж өгнө.
- (2) Ажлын талбайд байгаа буюу Захиалагчийн хангасан материалыг зөвхөн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд ашиглана.
- (3) Гүйцэтгэгч ажлын талбайн ойр орчмын барилга байгууламжид хүрэх замыг гэрээний нийт хугацааны туршид арчилж байна.
- (4) Гүйцэтгэгч, тэсрэх, дэлбэрэх болон цацраг идэвхт материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглахдаа Засгийн газрын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Гүйцэтгэгч, ажлын талбайд болон түүний ойр орчны газар, хөрс, зам болон бусад газруудыг

бохирдуулахаас сэргийлэх ба ажлыг хэрэгжүүлж байх явцад үүсэж болзошгүй аливаа хүндрэлтэй асуудал, саад бэрхшээл зэргийг багасгахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эдгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тэдгээр хүндрэлтэй асуудлыг нэгэнт үүссэний дараа багасгах биш, харин гарахаас нь өмнө хянаж, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байна. Аливаа ажил ба бусад бүх холбогдох үйл ажиллагаануудыг Монгол улсад дагаж мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмын (байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг оролцуулан) шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Зам барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гэж Инженер үзэж зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа мод, бут, бусад өвс ургамлыг огтолж, тайрч зайлуулахгүй.

(5) Гүйцэтгэгч дараах зүйлүүдтэй холбогдуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Үүнд:

- a. Гол горхи, усны урсац, нуур болон бусад адил төстэй зүйлсийг Инженерийн зөвшөөрөлгүй гео-нэхмэл эдлэл буюу өөр бусад аргыг ашиглан, лаг шаврын хаалт хийж, үерт автах, эрэг ёроол нь угаагдах, ус бохирдохоос сэргийлэх, тэдгээрийн чанар, харагдах байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх, хүн, амьтан, ургамлыг гэмтээх, үхэлд хүргэхгүй байхтай холбогдуулсан арга хэмжээ;
 - b. Усан хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс, мөн усны чанарт муугаар нөлөөлж, түүнийг бохирдуулахаас сэргийлэхийн тулд гүний усны нөөцтэй (шүүсэн усыг оролцуулан) холбогдуулсан арга хэмжээ.
 - c. Урсгал ус, нуураас барилгын зориулалтаар ус авахыг хориглох, заавал худаг гаргаж, ажил дууссаны дараа хүлээлгэн өгөх
- (6) Ажлыг гүйцэтгэх явцад гарсан хаягдал материал буюу лаг шаврыг ойролцоох газарт зайлуулах, шаардлагатай бол Гүйцэтгэгч тэдгээрийг зөвшөөрөгдсөн хаягдал материал зайлуулах газарт зөөн хаяж, тухайн газрыг анхны байдалд нь оруулан нөхөн сэргээх ажлыг Инженерийн тавьсан шаардлагыг хангахуйц хэмжээнд өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.
- (7) Гүйцэтгэгч нь чулууны орд газарт олборлолт хийх, чулуу бутлах, бетон зуурах, цутгах г.м. болон Гүйцэтгэгчийн бусад үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх тоос шороо, бохирдлыг (гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүй) багасгах үүднээс тунгаагуур болон бусад байгууламжийг барьж, ашиглах ба ажил дууссаны дараа буулгана. Үүнтэй холбогдуулан Гүйцэтгэгчийн гаргах санал нь энэхүү техникийн шаардлагын зүйл 114-ийн шаардлагыг хангаж байх ёстой. Бүхий л бохир ус болон бусад хаягдал шингэнийг ямар нэг бохирдол үүсгэхгүй байдлаар зайлуулна. Гүйцэтгэгч ажлыг хэрэгжүүлэх үед гарсан аливаа хаягдал материалыг Инженерийн буюу эсвэл холбогдох байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гол, горхи, нуур, цөөрөмд хаяхгүй.
- (8) Гүйцэтгэгч ажилдаа тоосжилт болон агаараар тархдаг хорт хийг багасгахад чиглэгдсэн арга ажиллагааг мөрдөж ажиллана. Тоосжилт үүсэж болзошгүй тохиолдолд ус шүрших арга хэмжээг авна. Нөөц материал, хаягдал материалын овоолгыг өөр тийш нь ачиж зөөхөөс өмнө норгож чийглэх тухай зааврыг Инженер өгч болно. Инженерийн зүгээс тоосжилт үүсгэж болзошгүй гэж үзсэн бүх материалыг өндөр хашлагатай тэвш бүхий машинаар тээвэрлэн зөөнө. Иймэрхүү материалыг машины тэвшний хашлагаас илүү гаргалгүй ачиж, цэвэрхэн брезентээр тэвшний талууд болон арын хаалтаас дор хаяж 300 мм илүү гарган унжуулж сайтар хучна.
- (9) Гүйцэтгэгч буюу түүний туслан гүйцэтгэгчид нь материал, үйлдвэр заводын ханган

нийлүүлэгчдийн машин техникийн ашиглаж буй ажлын нэг хэсэг болох бүх хуучин замууд болон адил төстэй замууд дээрх тэдгээр машин техникийн явалтаас үүссэн тоос, шавар буюу бусад гаднын биетийг тогтмол цэвэрлэнэ.

- (10) Шатахууны агуулах ба машин техникийг цэвэрлэх газар нь ойр хавийн сайр, гол горхиноос хамгийн багадаа 300 м-ийн зайд байрласан байна.
- (11) Бетон хольц бэлтгэх завод, чулуу бутлуур, чийглэж холих үйлдвэр зэргийг суурин газар, газар тариалангийн талбай, үйлдвэр, аж ахуйн газруудаас хангалттай хол зайд суурилуулна. Боломжтой бол тэдгээрийг ойролцоох суурин газруудаас 1.0 км-ээс доошгүй зайд суурилуулна.
- (12) Гүйцэтгэгч ажлыг төлөвлөх ба хэрэгжүүлэхдээ хүрээлэн буй орчинд нөлөөлөх дуу чимээний холбогдолтой, Монгол улсад мөрдөгдөж байгаа шаардлагуудыг судалж үзсэн байна. Гүйцэтгэгч дуу чимээ намсгагч төхөөрөмжүүдийг ашиглалтын бэлэн байдалд байлгах ба ажлыг гүйцэтгэж байх явцад дуу чимээний нөлөөллийг багасгах бүх шаардлагатай арга хэмжээг авна.
- (13) Гэрээний нөхцөлд дурдсан шаардлагуудаас гадна Гүйцэтгэгч, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх хууль, дүрэм, зарлиг, тогтоол, журам, шийдвэрүүд болон бусад хуулийн механизмуудын талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд эдгээр нь доорх зүйлсээс бүрдэх боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
 - ✓ Техникийн шаардлагын нэмэлт,
 - ✓ байгаль орчин,
 - ✓ эрүүл мэнд, аюулгүй байдал,
 - ✓ ажил олголтын байдал, гадаадын мэргэжилтнүүдийг оролцуулсан,
 - ✓ сургалт,
 - ✓ татвар, хураамж, төлбөр ба бусад,
 - ✓ түр ба байнгын барилга байгууламж,
 - ✓ түр суурин, ариун цэврийн байгууламж ба усан хангамж.
 - a) Ажлын талбай ба түр сууринд Гүйцэтгэгчийн барьсан бүх барилгууд, тэдгээрийн орчны болон талбайн ерөнхий байдал нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд болон ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдолтой тухайн орон нутгийн бүх дүрэм, журмын шаардлагыг хангах ба гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй.
 - b) Хүмүүсийн амьдрах бүх байр сууцууд нь бат бөх, цаг агаарын ямар ч нөхцөлд тэсвэртэй байгууламжууд байх ба шаардлагатай зүйлсээр тоноглогдсон, засвар арчлалтыг тогтмол хийж ашиглахын зэрэгцээ цэвэр байх нөхцөлийг бүрдүүлнэ. Оршин суугчдын ая тухтай, аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай бол хангалттай халаалт, гэрэлтүүлэг, агааржуулагч, дулаалга зэргээр хангана.
 - c) Барилгын түр суурин нь ойролцоох суурин газраас 200-аас 500 м-ээс хол зайд байрлана. Ажиллагчдын амьдрах байр сууц, бусад байгууламжуудыг стандартын дагуу, Инженерийн шаардлагыг хангах хэмжээнд барьж байгуулан, арчилна.
 - d) Түр суурин байгуулах газрууд нь үерт автахааргүй байх ёстой бөгөөд намаг болон бусад гадаргын ус хуримтлагддаг газруудаас хамгийн багадаа 75 м хол зайд байрлана.
 - e) Түр сууринг түүнээс гарч буй болон түүний дундуур явсан шуудуунууд нь тэр хавийн болон нийтийн усан хангамжийн системд аюул учруулахааргүй газарт байгуулна.

- f) Хэрвээ өөрөөр заагаагүй бол ажилд хэрэглэх байгалийн гаралтай болон тохиромжтой материалын эх үүсвэрүүд нь ажлын талбайд байсан байгаагүйг үл харгалзан, тэдгээрийн байршлыг тогтоох, ашиглалтын зөвшөөрөл, орд газрын лиценз ба ус ашиглах эрх гэх мэт шаардлагатай бүх зөвшөөрлийг авах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.
- g) Хэрвээ Гүйцэтгэгч, ажлын талбайн орчинд радио холбоогоор хангах тохиолдолд тэдгээр төхөөрөмжийг ашиглах нөхцөл боломжоор Инженерийг хангана. Зөвхөн Инженерийн хэрэгцээнд хангах холбооны төхөөрөмжийн хангалтын шаардлагуудыг энэхүү техникийн шаардлагад заасан болно.
- h) Гүйцэтгэгч нь, ажлын талбайн эргэн тойронд шаардлагатай хаалт, хашаа хийж, засаж хамгаалан, ажил дууссаны дараа буцааж буулгах ба Захиалагч, Инженер, бусад гүйцэтгэгчид болон ажлын талбай руу орох эрх бүхий бусад хүмүүсийн аюулгүй байдлыг зохих байдлаар хангах бөгөөд өөрийн хүлээсэн бусад үүрэг хариуцлагад ямар нэг хор хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх ёстой.
- i) Гүйцэтгэгч нь түр барилгын тохиромжтой болоод аюулгүй байдал, харуул хамгаалалтын болон шаардлагагүй болсон үед тэдгээрийг буулгах хариуцлагыг бүхэлд нь дангаараа хүлээнэ. Түр барилгын ажилд дараах зүйлс багтах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
- ✓ агуулах, бетон эдлэлийн талбай,
 - ✓ тулгуур шон, гадаснууд,
 - ✓ тавцан, трап, шат, угсралтын/дамжуурга шат,
 - ✓ хэв хашмал, вандан шат,
 - ✓ далан, усны хаалт, кессон (ус тусгаарлах хорго),
 - ✓ шпунтэн тулгуур, тулаас хийх, нүх ухах,
 - ✓ хашаа,
 - ✓ бусад холбогдох ажлууд орох ба үүнээс гадна Гэрээг хэрэгжүүлж, ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан буюу угсарч ажиллуулсан Гүйцэтгэгчийн өөрийн тоног төхөөрөмжтэй холбогдолтой түр барилгууд байж болно. Энэхүү заалт нь ажлыг гүйцэтгэх зорилгоор буюу түүнтэй холбогдуулан Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгчдийн хангаж, угсарсан тоног төхөөрөмжтэй холбоотой бүх түр барилгын ажлуудад хамаарна.
- j) Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгчдийн түр барилгын ажлууд, тэдгээрийн холбогдолтой аливаа зургуудыг Инженер хянаж шалгах нь Гүйцэтгэгчийг гэрээний заалтуудын дагуу түүнд оногдсон аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй.
- k) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас болон бусад шалтгаанаар түр зогсоовол талбайд байгаа бүх барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зогсолтын бүх хугацааны турш харж хамгаалан, түүнийг үйл ажиллагаагаа дахин эхлэх үед шууд ашиглахад бэлэн байлгах үүргийг хүлээнэ. Гэрээний нөхцөлийн дагуу, зогсолтын хугацааны турш ажлын талбайг харж хамгаалах үүрэг, хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ.
- l) Хэрвээ, барилгын ажлын явцад, археологийн чанартай малтмал, зоос, олдвор олдсон тохиолдолд Гүйцэтгэгч нь Монгол улсын засгийн газрын холбогдох байгууллагуудад яаралтай мэдэгдэх ба тэдгээр олдворуудыг Монгол улсын өмч болгож, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь соёл, шашны холбогдолтой аливаа барилга байгууламжид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах явдлыг баталгаажуулна.
- m) Барилгын ажлын явцад мал, амьтны хөдөлгөөн зохицуулна.

114. УС, ЦАС, МӨС, ЭЛСНИЙ ХАМГААЛАЛТ

Хэрэв өөрөөр заагаагүй бол, гол, ус, харз, хур тунадас болон бусад эх үүсвэрээс буюу өөр ямар нэг шалтгааны улмаас үүссэн ус, цас, мөсийг хэрхэх асуудлыг Гүйцэтгэгч хариуцна. Ус гаргах ба усны чигийг өөрчлөхдөө бусад ажил болон байгууламжуудыг үерт автуулах, эвдрэх, нурах болон ус бохирдохоос зайлсхийнэ.

Гүйцэтгэгч ажлыг бүхэлд нь ус, цас, мөс, элсэнд дарагдахаас хамгаалж, энэ зорилгоор далан, усны хаалт, насосны төхөөрөмж, тулгуур, тулаас, ус зайлуулах түр байгууламж, худаг, хайс барьж, цас цэвэрлэгч зэргээр хангана.

Байнгын ажлыг эхлэхийн өмнө Гүйцэтгэгч газрын гадаргууг ус, цас, мөснөөс зохистойгоор хамгаалахад шаардагдах ус зайлуулах байгууламж, шуудуу барих, нүх ухаа ажлууд болон бусад арга хэмжээг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

Барилгын ажлын үед Гүйцэтгэгч элэгдэл, суулт үүссэнээс шалтгаалж ямар нэг эвдрэл үүсэх, элс шуурч, урьд хийсэн ажлыг дарж булахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ. Энэхүү урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд шуудуу, угаагдалтыг шалгах чулуун асгаас хийх болон барьж буй замаас тодорхой зайд, салхины зонхилох чиглэлд шороон далан хийх, түр хашилт, хаалт барих зэрэг ажлууд байж болох ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүй.

Гол горхи, ус, тэдгээрийн гольдрол эсвэл ус зайлуулах бусад байгууламжийн ажилд саад болохооргүй Инженерийн заасан газарт хаягдал болон нөөц материалыг буулгана. Гүйцэтгэгч эдгээр урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг аваагүйгээс шалтгаалан ажлын талбай болон ойролцоох байгууламж, өмч хөрөнгө эвдэрч сүйдсэн тохиолдолд тэрээр өөрийн зардлаар хохирлыг барагдуулна. Ус хуримтлагдаж, газрын гадаргуу дээр тогтоол ус үүсэх, гадаргын урсац үүсгэхгүйн тулд өдөр бүр ажил дууссаны дараа хийгдэж дууссан ажлын үе бүрийн гадаргууг тэгшилнэ. Барилгын ажлын үед болон түүнийг дууссаны дараа баталгаат засварын хугацааг дуустал ажлын аль нэг хэсэгт ус хуримтлагдсанаас хөрсөнд нэвчиж, угаагдалт үүсгэсэн тохиолдолд, үүнд өртсөн аливаа материал болон ажлыг Инженерийн зааварласнаар, өөрийн зардлаар зайлуулж, шинээр дэвсэх буюу дахин хийнэ.

115. ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АВААР ОСОЛ

Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах эрхтэй бүх хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллыг хангахад шаардлагатай бүх урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд Монгол улсад буюу тухайн орон нутагт мөрдөгддөг хууль тогтоомжийн шаардлагуудаас гадна, Инженерийн бодлоор ажлын талбайд зөвшөөрөлгүй орсон гаднын хүмүүс, мөн Гүйцэтгэгчийн хяналтын дор хийгдэж буй аливаа үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийг хамгаалах зэрэг ажилд мөрдөх шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээнүүд орно. Гүйцэтгэгч дараах хариуцлагыг хүлээх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:

- a) Аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмжөөр хангаж, засвар арчлалтыг хийх, ажлын талбайд ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэндэд аюул, эрсдэл учруулахааргүй ажлын арга барилыг мөрдөж ажиллах.
- b) Ажилд ашиглагдах бодис, бусад зүйлстэй харьцах, тэдгээрийг хэрэглэх, хадгалах, тээвэрлэх, хаяж зайлуулахтай холбоотойгоор аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байх тохиромжтой зохион байгуулалтыг хийнэ.
- c) Инженерийн зөвшөөрлөөр, шөнийн ээлжинд хийж гүйцэтгэх ажлын аюулгүй байдлыг

- баталгаажуулах үүднээс хангалттай хэмжээний гэрэлтүүлэг болон цахилгаан тасарсан үед ажиллуулах нөөц /аваарын/ гэрэлтүүлгийн төхөөрөмжөөр хангана.
- d) Талбайн бүх газрууд руу ямар нэг аюул, эрсдэл буюу бэртэл гэмтэлгүйгээр хүрч очих туслах зам барьж, тогтмол засвар арчлалт хийж байна.
 - e) Барилгын ажлын талбай дахь бүх байр сууц, ажлын байр, засварын газар, лаборатори, хяналтын байр, агуулах зэрэгт зориулан ариун цэврийн байгууламж, ашиглах ажлуудыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль журам, тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийн дагуу Инженерийн шаардлагыг хангах хэмжээнд хийх ба эрүүл мэндэд хор хохирол учрах, агаар, ус, ойролцоох гол горхи бохирдуулах явдал гаргуулахгүй ажиллана.
 - f) Түр суурингуудад хогийн сав байрлуулж, тэдгээрийг тогтмол цэвэрлэж байх, хог хаягдлыг холбогдох дүрэм, журмын дагуу эрүүл ахуйн шаардлага хангах хэмжээнд зайлуулна.
 - g) Гүйцэтгэгч, ажил дууссаны дараа өөрийн зардлаар Инженерийн тавьсан шаардлагын хэмжээнд бүх түр байгууламжуудыг буулган, хог хаягдлыг шатаан, бохирын сав болон нүх, жалгыг буцааж булан, сайтар хааж, гаднах талбайг бүхэлд нь цэвэр цэмцгэр болгоно.
 - h) Ажил явагдаж буй газарт хангалттай тооны бие засах газар ба бусад ариун цэврийн байгууламжуудыг барьж байгуулан тэдгээрийг Инженерийн болон тухайн орон нутгийн нийтийн эрүүл мэндийн асуудал эрхлэх албаны тавьсан шаардлагыг хангах хэмжээнд, эрүүл ахуйн нөхцөлийн дагуу тогтмол цэвэрлэж, ариутгаж байна.
 - i) Олон гэр бүл нэг дор амьдардаг газар болон хуаран маягийн байгууламжтай газруудад нийтийн жорлонтой бол хүйс бүрт зориулсан тус, тусдаа өрөөтэй барина. Эдгээр тасалгаануудын хаалган дээр "эрэгтэй", "эмэгтэй," гэсэн тод тэмдэглэгээ хийх буюу амархан ойлгогдох зураг, тэмдэг наасан байна. Хэрвээ эдгээр хүйс тус бүрт зориулсан бие засах газрууд нь нэг байшинд байвал тэдгээрийг шалнаас тааз хүртэл өндөр, хатуу ханан хаалт хийж тусгаарлана.
 - j) Олон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан удирдах хүмүүстэй харилцан зөвлөлдөж, ажлын талбай, ажилчдын байр, түр суурин доторх шумуул, ялаа, хортон шавьж, амьтан зэргийг устгах шаардлагатай арга хэмжээг авна.
 - k) Хүний амь хохирсон буюу хүнд гэмтсэн, улмаар үүнээс болж эмнэлэгт хүргэгдэж гурваас дээш хоногоор хэвтсэн тохиолдолд Инженерт яаралтай мэдэгдэнэ. Эхний үед ийм мэдээллийг амаар хүргэж болох ба болсон явдлын дараа 24 цагийн дотор Гүйцэтгэгч дэлгэрэнгүй тайланг бичгээр бэлтгэж танилцуулна. Иймэрхүү ноцтой аваар ослын талаар хуулийн байгууллагад мэдэгдэхтэй холбоотой аливаа шаардлагыг Гүйцэтгэгч дагаж мөрдөнө.
 - l) Эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал болон эд хөрөнгийн эвдрэл гэмтэлтэй холбоотой аливаа бусад аваар осол, үйл явдлыг Гүйцэтгэгч бүртгэх ба аваар осол гарсан даруйд зохих маягтын дагуу бэлтгэсэн мэдээллийг Инженерт болон хуулийн байгууллагуудад танилцуулна.
 - m) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас болон бусад шалтгаанаар түр зогсоовол ажлыг аюулгүй байдалд орхиж байгаа эсэхийг баталгаажуулна. Тэрээр өөрийн төслийн удирдлагын багаас Инженерийн хүлээн зөвшөөрөх нэг хүнийг зогсолтын үеийн хугацааны туршид хөдөлмөр хамгааллын асуудлыг хариуцан ажиллуулахаар томилон, түүний нэр, холбоо барих утасны дугаарыг Инженерт мэдэгдэнэ.
 - n) Гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, мөн тэдгээрийн ажиллагсад, Гүйцэтгэгчээс

талбайд байх эрх олгосон хүмүүс нь эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалалтай холбоотой хууль, дүрэм журмын заалтуудыг бүх талаар дагаж мөрдөнө.

- о) Энэ зүйлийн заалтууд нь Гүйцэтгэгчид хамаарахаас гадна, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийснээр түүний туслан гүйцэтгэгчид хамаарна. Гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээнд эдгээр заалтууд орсон эсэхийг тэрээр баталгаажуулна.

116. ХАШАА, ХААЛГА БАРИХ, ХАМГААЛАХ, ЗАСВАРЛАХ

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Бетон болон бетонон бүтээгдэхүүн. Бетоны дүүргэгчид агуулагдах хүхэрлэг нэгдлийг тодорхойлох арга	Concrete and Concrete Structures. Sulfate Content in Concrete Aggregates. Testing Methods	MNS 4982:2000
Хүнд бетон. Ойлт ба уян налархай чанараар нь бетоны бат бэхийг тодорхойлох арга	Weighty Concrete. Method for Determination of Strength by Reflection and Elasticity	MNS 3323:1991
Хүнд бетон Кашкаровын алхаар бат бэхийг тодорхойлох арга	Weighty Concrete. Method for Determination of Strength by Cashkirov's Hammer.	MNS 4113:1991
Бетон дахь шүлтэнд уусдаг цахиурын исэл агуулсан эрдсийг таних хурдавчилсан арга	Standard Method of Test for Rapid Identification of Alkali-Silica Reaction Products in Concrete	MNS AASHTO 299:2005
Хэт богино авиагаар бетоны бат бэхийг тодорхойлох арга	Method for Determination of Strength of Concrete by Ultrasonic Methods	MNS 4114:1991
Хүнд, хөнгөн бетоны бат бэхийг хэт богино дууны аргаар тодорхойлох	Method for Determination of Strength by Sound Short Proofing for The Weighty and Lightweight Concrete	MNS 2794:1979
Бетон хольц. Техникийн шаардлага	Concrete mortal. General Specifications	ГОСТ 7473-2010
Бетон Фрост багажаар бетоны хүйтэн тэсвэрлэлтийг хурдавчилсан аргаар тодорхойлох туршилтын арга	Methods for determination of frost resistance in concrete	ГОСТ 10060-2012
Шинэ бетоны туршилт ба үнэлгээ, тархалтыг тодорхойлох туршилт	Testing fresh concrete. Flow table test	BS EN 12350 Part 5
Шинэ бетоны нягтруулалтын зэргийг тодорхойлох	Testing concrete. Method for determination of compacting factor	BS1881:Part 103
Бетон.Үл эвдэх, механик аргаар бат бэхийг тодорхойлох	Concretes. Determination of strength by mechanical methods of nondestructive testing	ГОСТ22690-2015
Талбай дээр бетоны нягтыг цөмийн аргаар тодорхойлох	Standard Test Methods for In-Place Density of Unhardened and Hardened Concrete, Including Roller Compacted Concrete, By Nuclear Methods	ASTM C 1040

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Шинээр зуурсан бетоноос дээж авах	Standard Method of Test for Sampling Freshly Mixed Concrete	AASHTO T 141-01
Бетон ба бетон бүтээгдэхүүн. Бетоны гулзайлтын бат бэхийг тодорхойлох арга	Standard Test Method for Flexural Strength of Concrete (Using Simple Beam with Third-Point Loading)	MNS ASTM C 78/C 78 : 2016
Бетон бүтээцийг арматурчлах мяндас полимер (FRP) арматур. Техникийн ерөнхий шаардлага	Fiber-Reinforced Polymer Bar for Concrete Reinforcement. General Specifications	MNS GOST 31938 -2015
Бетон ба төмөр бетон бүтээц. Арматурын хамгаалах бетон үеийн зузаан, арматурын хэмжээ, байрлал тодорхойлох радиацийн арга.	Concrete and Reinforced Concrete Structures. Radioactive Method for Determination of Concrete Protective Covering Thickness, Reinforcement Dimensions and Locations	MNS GOST 17625:2010
Бетон ба төмөр бетон бүтээц. Арматурыг хамгаалах бетон үеийн зузаан, арматурын байрлал тодорхойлох соронзон арга.	Concrete and Reinforced Concrete Structures. Magnetic Method for Determination of Concrete Protective Covering Thickness, Reinforcement Dimensions and Locations	MNS GOST 22904:2010
Бетон. Ангилал, ерөнхий техникийн шаардлага	Concrete Classification and General Specifications	MNS IEC3173 :2002

Хүснэгт 2-14. Замд хэрэглэгдэх цементийн чулуунцрын үзүүлэлт

Чулуунцрын материалын төрөл	Чулуунцрын материалын агууламж, %
C ₃ A	< 7
C ₃ A+ C ₄ AF	< 24
C ₃ S	> 55

2) Бетоны туршилтын давтамж

А. Туршилт шинжилгээ хийх давтамж:

Дараах шинжилгээнүүдийг бетоны зориулалтыг харгалзахгүйгээр хийнэ. Үүнд:

Бетоны хүйтэн тэсвэрлэлтийг MNS 1918:1985 стандартын дагуу үндсэн аргаар нэг барилгын ажил эхэлснээс хойш 6 сард нэгээс доошгүй удаа итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлнэ.

- Бетон хольцын конусан суултыг хольцыг талбай дээр ирэх бүрт
- Бетон хольцын агаарын агууламжийг хольцыг талбай дээр ирэх бүрт
- Бетоныг өрөмдөж дээж авах
- Шмидт болон Кашкаровын аргаар бетоны бат бэхийг тодорхойлох
- Бетоны хүйтэн тэсвэрлэлтийг хурдавчилсан аргаар тодорхойлох

В. Зориулалтаас хамаарч ялгаатай хийгдэх шинжилгээний төрөл болон давтамж:

Цементобетон хучлагын зориулалттай бетон бол:

- Тохиолдлын журмаар тасралтгүй зуурагдаж буй бетон хольцоос нэг ээлжинд Бетон хольцоос 9 ширхэг призм хэвээр дээж авч 3, 7, 28 хоногтойд нь гулзайлтын үеийн 3-аас доошгүй иж бүрдэл хэвэнд дээжийг авна. 1 иж бүрдэлд 9 ширхэг призм хэв орно. суналтын бат бэхийг шалгана.
- Инженер зааварчилсан тохиолдолд шоо хэвэнд 9 ширхэг дээжийг хэвлэж 3, 7, 28 хоногтойд нь шахалтын бат бэхийг тогтооно.
- Бетон хольцын зөв дэвсгэдэх /удобоукладываемость/ чанар ээлж бүрт нэгээс цөөнгүй удаа,
- Бетон хольцын тээврийн хэрэгслийн тэвшинд байх хугацаа, машин тус бүрд
- Бетон хольцын нягт ээлж бүрт нэгээс цөөнгүй удаа, үзүүлэлт өөрчлөгдөх бүрт нэмэлтээр хийгдэх

С. Хиймэл байгууламжийн зориулалттай бетонд

- Тохиолдлын журмаар тасралтгүй зуурагдаж буй бетон хольцоос нэг ээлжинд 2-аас доошгүй иж бүрдэл хэвэнд дээжийг авна. Хиймэл байгууламдын хийц тухай бүрт 1 иж бүрдэлд 6 шоо призм хэвээр дээж авна. Бетон хольцоос дээж авч 6 ширхэг шоог хэвээр дээж авч 7, 28 хоногтойд нь шахалтын бат бэхийг тогтооно.
- Хэрэв инженерийг зааварчилсан тохиолдолд гулзайлтын үеийн суналтын бат бэхийг шалгана.

Д. Туршилтыг хүчингүйд тооцох нөхцөл

Гүйцэтгэгч туршилт хийхдээ урьдчилан мэдэгдэж Инженерийг байлцуулах ба хэрэв байлцуулаагүй бол тухайн өдрийн бетон хольцыг чанарын хяналтын туршилтад тэнцэхгүй гэж үзнэ.

211. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, БАРИЛГЫН АРГАЧЛАЛ БА ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫГ БАТАЛГААЖУУЛАХ ТУРШИЛТУУД

(1) Лабораторийн шинжилгээ

Газар шорооны ажил болон хучилтын үеүдэд ашиглах байгалийн гаралтай ба боловсруулсан материалын лабораторийн туршилт шинжилгээг Гүйцэтгэгч нь Инженертэй зөвлөлдөж гүйцэтгэнэ. Материалын стандартад тодорхойлсон эцсийн бүтээгдэхүүнд тавих шаардлага болон барилгын ажилд хяналт тавих зорилгоор газар дээр нь хялбар тодорхойлж болох материалын шинж чанарын хоорондын харилцан уялдааг бий болгохын тулд ийм туршилтуудыг хийдэг.

Лабораторийн туршилтыг хольц ба байгалийн гаралтай материал дээр хийж гүйцэтгэх ба Гүйцэтгэгч нь урьдчилан төлөвлөсөн материалын туршилт хийхээс хоёр долоо хоногийн өмнө урьдчилсан төлөвлөгөөгөө Инженерт танилцуулсан байна.

(1) Талбайн туршилтууд

Барилгын ажилд ашиглахаар Гүйцэтгэгчийн төлөвлөсөн тоног төхөөрөмж, аргачлалын дагуу бүх газар шорооны үеүд болон хайрган хучилтад ашиглах материалын дэвсэх, нягтруулах бүрэн хэмжээний талбайн туршилтуудыг Гүйцэтгэгч хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь холих хувь хэмжээг нэгэн жигд байхыг баталгаажуулах ба материалыг нэгэн ижил төлөвт байлгахын тулд маш сайн холино.

Гүйцэтгэгч нь материалыг дэвсэж, боловсруулалт хийж, шаардагдах хэмжээнд хүртэл нягтруулахад түүний тоног төхөөрөмж болон барилгын аргачлал тохирч байгаа эсэх, түүнчлэн дууссан газар шорооны ажил эсвэл хучилтын үед тавигдах тодорхой шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг харуулах зорилгоор туршилтуудыг явуулна.

Туршилт хийх талбай бүр нь 100 м-ийн урттай байх ба барилгын ажил хийгдэх өргөнийг бүхэлд нь хамарна.

Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөртөө талбайн туршилт явуулах болон шаардагдах шинжилгээг төлөвлөнө. Хучилтын үе бүрт хийх туршилтыг Гүйцэтгэгч туршилт хийхээс 21 хоногийн өмнө Инженерт мэдэгдэнэ.

Талбайн туршилт хийх бүрт дараах өгөгдлүүдийг бүртгэж авна. Үүнд:

- Материалын найрлага ба зэрэглэл
- Нягтруулалтаас хойших материалын найрлага ба зэрэглэл
- Нягтруулах үеийн чийгийн агуулга, тодорхойлсон нягтруулалтын хамгийн тохиромжтой чийгийн агуулга
- Нягтруулах техникийн төрөл, хэмжээ, дугуйны даралт, доргилтын давтамж, нэг мөрөөр явах тоо
- Талбайн туршилтыг явуулахын өмнө болон туршилт явуулах хугацааны туршид дээжид хэмжсэн хамгийн их хуурай нягт эсвэл төлөвлөсөн нягт
- Нягтруулсан үеийн зузаан

- Инженерийн зааварласан бусад холбогдох мэдээлэл

Гүйцэтгэгч газар шорооны ажил болон хучилтын үе бүрт зориулсан 100 м-ийн урттай хэсэг бүр дээр хамгийн багадаа найман иж бүрдэл туршилтыг явуулна. Үе бүрт явуулсан бүх найман иж бүрдэл туршилтын үр дүн нь материалын шаардлагад нийцэж байвал талбайн туршилтыг амжилттай болсон гэж үзнэ. Талбайн туршилтын үед бүртгэж авсан өгөгдлүүд нь Гүйцэтгэгчийн санал болгож, Инженерийн зөвшөөрсний дагуу, энэхүү техникийн шаардлагад нийцсэн материал бүрийг нийлүүлэх, дэвсэх, боловсруулах болон барилгын техникийг сонгон авах аргачлалыг тодорхойлох үндэс болох юм. Хэрвээ Инженер иж бүрдэл туршилтын аль нэгийг үр дүнд хүрээгүй гэж үзвэл Гүйцэтгэгч Инженерийн удирдлагын дор дахин туршилтууд явуулна.

Ажлыг гүйцэтгэх явцад, хэрвээ материалд тавигдах шаардлагууд тогтмол хангагдахгүй байгаа нь барилгын хяналтын туршилтаар харагдаж байвал Гүйцэтгэгч шалтгааныг судалж, тогтоох хүртэл тухайн газар шорооны ажил буюу хучилтын үе дээр хийгдэж буй ажлыг зогсооно. Тухайн үед ашиглах бүх материалыг нийлүүлэх, дэвсэх болон боловсруулахад шаардлагатай өөрчлөлт хийсэн аргачлалыг тогтооход хэрэглэх засвар өөрчлөлт оруулсан иж бүрдэл өгөгдлүүдийг тодорхойлох зорилгоор цаашид хийх лабораторийн шинжилгээ болон талбайн туршилтууд энэхүү судалгаанд хамрагдана.

Барилгын ажлын санал болгосон аргачлалыг талбайд туршсан туршилтын явцад бүртгэгдсэн иж бүрдэл өгөгдлүүдийг Инженер зөвшөөрөх нь энэхүү техникийн шаардлагыг хангах аливаа хариуцлагаас Гүйцэтгэгчийг чөлөөлөхгүй.

212. ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ, ХУЧИЛТЫН ҮЕҮД БОЛОН УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙГ БАРИХ, АЖИЛД ТАВИХ ХЯНАЛТ

Энэ техникийн шаардлагын зүйл 109-ийн дагуу зохиогдсон төслийн чанарын хяналтын төлөвлөгөө болон Инженерийн явуулах чанарын баталгааны туршилтын дагуу, бүх газар шорооны ажил, хучилтын үеүд, ус зайлуулах байгууламжийн ажлууд нь чанарын туршилтад хамрагдана. Гүйцэтгэгч ажлынхаа дэс дарааллын дагуу ийм хяналтын туршилтыг явуулах хугацааг ажлын төлөвлөгөө болон тендерийн саналдаа заавал тооцсон байх ёстой.

Дараагийн үе шатны ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь газар шорооны ажлын хэсэг бүрийн үе болгонд, хучилтын үе бүрт, ус зайлуулах хийц, байгууламжийг барих ажлуудыг шалгуулах хүсэлтийг Инженерт гаргана. Ийм хүсэлтэд Гүйцэтгэгчийн шинжилгээний үр дүнгийн хувиуд болон ажлыг гүйцэтгэх зураг (shop drawing) хавсаргана. Үүний дараа Инженер тухайн хэсэгт нүдэнд ил ус тогтсон, давхраатсан, материал овойж гарсан /тэгшилсэн хэсэгт ил үзэгдэх/ эсэх, чулууны ялгарал, том хэмжээтэй материал байгаа эсэх, холилт ба нягтруулалт нь нэгэн жигд эсэхийг шалгах үзлэг хийнэ. Энэхүү үзлэгээр нь хангалттай гэж үзсэн тохиолдолд Инженер баталгаа гаргах замын хэсгийг багаж, төхөөрөмжөөр шалгана. Эдгээр шалгалтын үр дүнг Инженер гүйцэтгэгчид бичгээр мэдээлэх ба үүний зэрэгцээ тухайн үе болон хэсгийг хүлээн авах буюу татгалзах шийдвэрээ гаргана.

Инженер өмнөх үе шатны ажлын чанарыг бичгээр баталгаажуулж, хүлээн авах хүртэл дараагийн үеүдэд хийгдэх ажлыг ямар ч тохиолдолд эхлүүлэхгүй. Гүйцэтгэгч нь батлуулахаар мэдүүлсэн ажлын талбай, гадаргуугийн байдлыг хамгаалах, хадгалах үүргийг бүрэн хүлээнэ.

Ямар нэг үеийг баталгаажуулсны дараа 48 цагаас илүү хугацаанд хамгаалалтгүй орхисон тохиолдолд Гүйцэтгэгч энэ үеийг дахин батлуулахаар хүсэлт гаргана. Хэрвээ Инженер

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

шаардвал, энэ үе дээр хяналтын тэгшилгээ, барилгын хяналтын туршилт, зөвшөөрөгдөх алдааны шалгалтыг энэхүү техникийн шаардлагын дагуу явуулна.

Ямар нэг үеийг Инженер баталгаажуулсан боловч, Гүйцэтгэгч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хур тунадас болон бусад шалтгаанаар үүссэн эвдрэлийг засах хариуцлагыг хүлээн. Шороон далангийн үед ямар нэгэн эвдрэл гарвал түүнийг дахин тэгшлэх, нягтруулах, барилгын хяналтын туршилт ба зөвшөөрөгдөх алдааны шалгалтыг энэхүү техникийн шаардлагын дагуу явуулна.

213. ХИЙМЭЛ БАЙГУУЛАМЖ

Хиймэл байгууламжид хэрэглэх бетон хольц нь (дугуй болон дөрвөлжин хоолой, тоннель, гүүр г.м) 210-р зүйлд дурдсан стандартууд техникийн шаардлагуудад нийцэж байх ёстой. Тэдгээрийн нарийн хэмжээс, бетоны анги ба арматурын деталиудыг ажил гүйцэтгэх зурагт үзүүлж, инженерээс зөвшөөрөл авна.

Хиймэл байгууламжийн бетон нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 1200-ийн шаардлагад нийцэх ёстой. Төмөр бетон хиймэл байгууламжид хэрэглэгдэх арматур нь (хүснэгт 2-7)-ийн шаардлагыг хангасан байна. Бүх бетоныг доргиох аргаар нягтруулна.

Дугуй хоолойн цагираг болон дөрвөлжин хоолойн их бие хэсэглэлийг цутгаснаас хойш 21 хоногийн дараа бетоны бат бэх хангалттай гэж Инженер зөвшөөрсөн тохиолдолд дараагийн ажилд (зөөж тээвэрлэх, хэсэглэл угсрах зэрэг) хэрэглэнэ. Цутгасан өдрийг хоолойн гадаргуу дээр арилахгүй байдлаар бичиглэл хийж тэмдэглэнэ.

214. ЗАМЫН ТЭМДЭГ

(а) Замын тэмдгийн будаг

Монгол улсын замын тэмдгүүдийн хэлбэр, дүрс, өнгө, хэмжээ зэрэг үзүүлэлтэд тавигдах шаардлагыг тусгасан "MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" гэх стандартыг замын тэмдэг бэлтгэх, үйлдвэрлэх, MNS 4596:2014 ын дагуу тавигдсан байна.

"MNS 4596:2014" стандартаар замын хөдөлгөөний зохион байгуулалтын техник хэрэгсэл болох замын тэмдэг түүнчлэн замын хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг бүх төрлийн авто замуудад байрлуулахдаа мөрдөнө.

215. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

Замын тэмдэглэгээний ажилд MNS 4759:2014, MNS EN 1871:2018 стандартуудыг мөрдөнө. Энэхүү стандарт нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний горим, нөхцөл байдлыг хөдөлгөөнд оролцогчдод мэдээлэхэд зориулсан замын тэмдэглэлүүдэд үйлчлэх бөгөөд тэмдэглэлийн хэлбэр дүрс, хэмжээ, өнгө, түүнчлэн хэрэглэх нөхцөлийг тогтооно.

ИНЗТ-д заасны дагуу MNS 4596:2014 стандартын шаардлагыг баримтлан тэмдэглээг хийнэ.

Замын тэмдэглэгээг будах будгийг AASHTO M 248 "Цагаан ба шар өнгийн ойлгогч термопластик материал (хатуу хэлбэр)"

AASHTO M 247 "Замын хөдөлгөөний будагт хэрэглэх шилэн дэвсгэр"-г заасан шаардлагыг

хангасан шилэн дэвсгэрийг ашиглан гэрэл ойлгох чанартай болгоно.

216. ЗАМЫН ТЭМДЭГ ХИЙХЭД ЗОРИУЛСАН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ МАТЕРИАЛ

Гэрэл ойлгогч материал нь AASHTO M 268 – “Хөдөлгөөний хяналтад зориулсан ойлгогч самбар”-т заасан нөхцөлүүдийг хангасан байх ёстой. Түүнчлэн дараах шаардлагууд тавигдана.

Үүнд:

- a. Ойлгогч материал нь ямар ч өнцгөөс харахад тасралтгүй ойлгогч гадаргуутай байна. Энэ нь гадаргуугийн дор суулгасан бөөрөнхий хэлбэрийн линз бүхий толигор нимгэн хальснаас бүрдэх ба ар тал нь хамгаалалттай, дэвсгэр үе хийсэн, наалдамтгай байна.
- в. Замын тэмдгийн ойлгогч 45 градусын өнцгөөр, Улаанбаатараас баруун тийш харуулж, босоо байрлуулж хэрэглэхэд ямар нэг хагарал, цэврүү, хялгасан ан цав, хэмжээний хувьд өөрчлөлт гарахгүй байх ёстой.
- с. Ойлгогч гадаргууг үндсэн суурь материал дээр тогтоох наалт нь 20 0С-ийн хэмд хүрээр цохиход салахгүй, гараар зөөвөрлөхөд сэвтэж гэмтэхгүй, мөн хуурахгүй байх ёстой. 25°С-ийн хэмд усан дотор 8 цаг байлгахад ирмэг зах нь ямар нэг байдлаар хуйларч эргэхгүй байх ёстой. Цавуу нь ойлгогч материал дээр толбо үүсгэх ёсгүй. Цавуу нь ойлгогч материалыг нааснаас хойш -20°С хэмээс +93°С хэмд 48 цагийн хугацаанд түүнийг найдвартай тогтоон барьж байх шаардлагатай.
- d. 20 орчим мм-ийн голчтой хүрээг тойруулан нугалахад 0.5 мм-ийн зузаантай хөнгөн цагаан дэвсгэр дээр наасан ойлгогч материалд ямар нэг хагарал үүсэхгүй байх ёстой.

217. ЗАМЫН ТЭМДГҮҮДИЙН ӨНГӨ

Замын тэмдэгний өнгөний код MNS FED ST 595C :2014 стандартыг мөрдөнө.

Замын тэмдэг, шон ба бусад тоноглолд хэрэглэх стандартын өнгө нь доорх Британийн стандартуудад заасны дагуу байна.

Улаан	BS 381 C No. 537
Цэнхэр	BS 4800 No. 18 E 53
Шар	BS 381 C No. 537
Ногоон	BS 4800 No. 14 C 39
Саарал	BS 4800 No. 10 A 11
Шаргал	BS 381 C No. 352
Хар	BS 873 хэсэг 1 – бүлэг 1-3.3

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

218. ХАШЛАГА

Хашлага болон түүний бүрдэл хэсгүүд нь AASHTO M180 – “Замын хашлаганы атираатай ган төмөр”-т заасан шаардлагыг хангасан, А ангиллын, 1 дүгээр төрлийн ган байна

219. ГЭРЛИЙН ТУСГАЛААС ХАМГААЛАХ ТОНОГЛОЛ

Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол нь үйлдвэрлэгчийн сертификат, болон дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан шинжилгээний бичигтэй байна.

BS EN 12676-1: 2000 Замын гэрлийн тусгалаас хамгаалах систем- Хэсэг1: Шаардлага ба үзүүлэлтүүд

BS EN 12676-2: 2000 Замын гэрлийн тусгалаас хамгаалах систем- Хэсэг2: Туршилтын арга

220. ХУВАНЦАР ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХАШЛАГА

Хуванцар хөдөлгөөн тусгаарлагч хашлага нь дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан байх ёстой.

National Cooperative Highway Research Program /NCHRP 350/-ийн туршилт

AASHTO MASH –т заагдсан туршилтын аргаар туршсан байна.

221. ХӨДӨЛГӨӨН ТУСГААРЛАГЧ ХУВАНЦАР ТОРХ

Хөдөлгөөн тусгаарлагч хуванцар торх нь дараах 2 стандартын туршилтын дагуу туршигдсан байх ёстой.

National Cooperative Highway Research Program /NCHRP 350/-ийн туршилт

AASHTO MASH –т заагдсан туршилтын аргаар туршсан байна.

222. ШИЛЭН ГЭРЭЛ ОЙЛГОГЧ

Шилэн гэрэл ойлгогчийн геометр үзүүлэлт нь дараах техникийн шаардлагыг хангасан байна.

BS EN 1463-2:2000- Замын тэмдэглэгээний материалууд. Замын гэрэл ойлгогчтой тоноглолууд. Турших техникийн шаардлага

Хүснэгт 2-15 Замын тэмдэг, тэмдэглэгээний стандарт

Стандартын нэр /Монгол хэл дээр/	Стандартын нэр /Англи хэл дээр/	Стандартын дугаар
Замын тэмдэглэгийн материал. Физик шинж чанар	Road marking materials. Physical properties	MNS EN 1871:2018
Шон суурьтай замын тэмдэг.Замын гэрэлтдэг тэмдэг	Road vertical signs - Variable message traffic signs - Part 1:	MNS EN 12966 : 2016
Гэрэл ойлгогч материалын шинж чанар шалгагчийг сонгох шалгаруулах, үнэлэх, сургахад баримтлах стандарт заавар	Standard Guide for Selection, Evaluation, and Training of Observers	MNS ASTM E 1499 : 2016

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Багажаар хэмжсэн өнгөний координатуудаас өнгөний хүлцэх хязгаар болон өнгөний ялгааг тооцох арга"	Standard Practice for Calculation of Color Tolerances and Color Differences from Instrumentally Measured Color Coordinates	MNS ASTM D 2244 : 2015
Авто замын хаалт. Техникийн ерөнхий шаардлага	Barrier closure for the auto roads. General technical requirements	MNS 6517 : 2015
"Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм"	Rules of application of traffic signs, road markings, traffic lights, guardrails and delineators	MNS 4596 : 2014
Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага	Traffic signs. Technical requirements	MNS 4597 : 2014
Авто замын тэмдэглэгээ. Техникийн ерөнхий шаардлага	Road markings. General technical requirements	MNS 4759 : 2014
Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага	Traffic lights. General technical requirements	MNS 4980 : 2014

223. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Материалын шинжилгээ, барилгын туршилт болон барилгын хяналтын шинжилгээнд зориулж тусдаа хэмжилт болон төлбөр хийгдэхгүй. Гүйцэтгэгч нь нэгж ажлын үнэлгээ болон нийт үнийн дүнд энэхүү техникийн шаардлагын бүлэг 200-ийн бүх шаардлагыг хангах зардлыг тусгасан гэж тооцно.

**БҮЛЭГ 300 – ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ БА
ХЭМЖИЛТИЙН ХҮЛЦЭХ АЛДАА**

БҮЛЭГ 300 – ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ БА ХЭМЖИЛТИЙН ХҮЛЦЭХ АЛДАА

301. ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ.....	2
(a) Нарийвчилсан хэмжилт, гадаслагааны ажил.....	3
302. ХҮЛЦЭХ АЛДААНУУД.....	4
a) Хэвтээ чиг	4
b) Хучилтын үеүдийн зузаан.....	4
c) Далан ба хучилтын үеүдийн гадаргуугийн төвшин.....	4
d) Хучилтын үеүдийн ба далангийн гадаргуугийн тэгш байдал	4
d) Далан ба ухмалын хажуу налуу.....	5
e) Далан ба ухмалын өргөн	5
f) Хажуугийн шуудууны гүн.....	5
g) Барилгын ажлын хяналт, шинжилгээ	5
303. ХҮЛЦЭХ АЛДААНААС ЗӨРҮҮТЭЙ АЖЛЫГ ЗАСАХ.....	6
(a) Газар шорооны ажил	6
(b) Суурь үе ба суурийн доод үе.....	6
304. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	6

301. ЦЭГ, ТЭНХЛЭГ ТАВИХ

(а) Ерөнхий

Захиалагч нь барилгын цэг, тэнхлэгийг тавихад хангалттай хайгуулын мэдээллийг Гүйцэтгэгчид өгөх ба Гүйцэтгэгч бүх шаардлагатай хяналтын цэгүүдийн гадаслагааг хийж, тэдгээрийг арчилж хамгаалах хариуцлагыг хүлээнэ. Цэг, тэнхлэг тавих, гадаслагаа хийх нь үндсэн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй дагалдан хийгдэх ажил гэж үзэх бөгөөд үүнийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийх ба үүнд тусад нь төлбөр шаардагдахгүй. Гүйцэтгэгч хайгуулын үндсэн мэдээлэл, гадаслагааг хүлээн авмагцаа анхны хяналтын цэг, шугам, төвшин ба хэмжилтүүдийн нарийвчлалыг тодруулж, бодитоор шалгана.

Хэрэв Гүйцэтгэгч Захиалагчийн өгсөн хайгуулын мэдээлэлд ямар нэгэн алдаа буюу зөрүү байгааг илрүүлбэл Инженерт даруй мэдэгдэх ёстой. Хэрэв мэдээлсэн алдаа нь үнэн байвал засварласан зураг буюу алдааг залруулахтай холбогдсон зааврыг Инженер өгнө. Барилгын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь анхан шатны хэмжилтийн цэгүүд болох, Монгол улсын геодезийн координатын (өндрийн) цэгүүдтэй холбогдсон, замын трассын дагууд байгаа репер болон хэвтээ хяналтын цэгүүдийн (өнцгийн орой, хэвтээ муруйн эхлэл, төгсгөл цэг г.м) байршил, бэхэлгээ зэргийг шалгаж, Захиалагчаас хүлээн авна. Үндсэн реперүүд нь замын ихэнх хэсэгт хоорондоо 2 км-ээс ихгүй зайд, гол төлөв замын зурвасын гадна, өнцгийн оройны ойролцоо байрлалтай байдаг.

Гүйцэтгэгч туслах реперүүдийг замын дагууд хооронд нь 200 м-ээс ихгүй зайд, замын тэнхлэгээс гадагш 50м-ээс багагүй зайд, аль болох өндөр газарт байрлуулж бэхэлнэ.

Бэхэлгээг дараах байдлаар хийнэ. 250x250x400 мм хэмжээтэй бетон гулдмай цутгаж, түүндээ 22 мм-ийн голчтой, 200 мм урт төмөр гадсыг гулдмайн дээд гадаргуугаас 20 мм дээш цухуйлган суулгаж бэхжүүлсний дараа уг хийцийг туслах репер байрлуулах цэгт ухаж суулган, эргэн тойрны газрыг сайтар чигжиж булна. Гулдмайн дээд ирмэг газрын төвшинтэй ижил байх ба дээд гадаргуу дээр тухайн реперийн дугаарыг арилдаггүй будгаар тод бичсэн байна.

Газарт суулгасан гулдмайгаас хааш хаашаа 0,5 м-т 200 мм гүнтэй шуудууг эргэн тойронд нь ухаж, гарсан шороог шуудууны гадна талаар овоолж орхино. Ухсан шуудууны аль нэг өнцөгт төмөр буюу модон гадсыг 400-500 мм ил цухуйж байхаар суулгана. Зарим түр реперийг Инженерийн зөвшөөрлөөр энд дурдсанаас өөрөөр өөрөөр бэхэлж болно. Зарим туслах реперийг байрлуулж, бэхэлсний дараа тэдгээрийг үндсэн реперийн байрлуулж болно. Энэхүү техникийн шаардлагын зүйл 107-д заасны дагуу бүх реперүүд, хэвтээ хяналтын цэгүүдийг “Барилга ашиглалтад хүлээлгэж өгсөн гэрчилгээ”-г олгох хүртэл, хамгаалах ажлыг Гүйцэтгэгч хариуцна. Гүйцэтгэгч нь бүх реперийн болон хэвтээ хяналтын цэгүүдийн өндөржилт, координат, байршлыг үзүүлсэн хүснэгтийг Инженерт гарган өгч байхын дээр хэмжилтийн ажлын шинэчлэгдсэн мэдээллээр байнга хангах үүргийг хүлээнэ. Гүйцэтгэгч нь улсын геодезийн сүлжээний өндрийн тэмдэгтүүд болон зургийн тэмдэгтийг эвдэх, гэмтээж, зайлуулж болохгүй.

Барилгын ажилд саад болох магадлалтай тэмдэгтүүдийн талаар Гүйцэтгэгч Инженерт мэдэгдэх ба тэдгээрийг зайлуулах буюу шилжүүлэн байршуулахад шаардагдах арга хэмжээний талаар холбогдох байгууллагатай харьцаж, шийдвэрлэх ажлыг Инженер хариуцна.

Хэрэв тэмдэгтүүдийг Инженерийн зөвшөөрөлгүйгээр зайлуулах болон хөндсөн тохиолдолд түүнийг дахин суурилуулах зардал болон үүнээс үүдэн гарах төлөвлөгөөний тасалдлын хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээнэ. Гүйцэтгэгчийн талаас алдаатай хэмжилт хийснээс болж ажлын явцад ямар нэгэн хэмжилтийн ажлыг нэмж хийх шаардлага гарвал буруу хийгдсэн ажлыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засаж залруулна.

(b) Нарийвчилсан хэмжилт, гадаслагааны ажил

Репер болон хэвтээ хяналтын цэгүүдийг хүлээн авсны дараа Гүйцэтгэгч тэдгээрийн координат, өндөржилтийг нарийвчлан шалгаж, үр дүнг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Үүний дараа замын дагууд суулгаж бэхэлсэн туслах реперүүдийн өндөржилтийг үндсэн реперийн өндөржилттэй холбож тогтоон үр дүнг Инженер батлуулна. Гүйцэтгэгч нь энэхүү техникийн шаардлагын зүйл 301 /а/-д заасны дагуу замын тэнхлэгийн шугамыг зурагт үзүүлснээр Инженерийн зааварчилснаар тэдгээрийг дахин хянаж үзсэн аливаа зүйлийг харгалзан 25м-ээс ихгүй буюу түүнээс богино зайтайгаар гадаслах бөгөөд техникийн шаардлагын зүйл 302-т заасан хүлцэх алдааны дотор барилгын ажлыг гүйцэтгэхийн тулд дагуу налуугийн хугарлын цэгт болон зарим онцлог газарт гадаслагаа хийхэд эдгээр богино зайг ашиглах шаардлагатай болно. Гадаслагааг хийсний дараа Гүйцэтгэгч цэг, тэнхлэг тавьсан замын тэнхлэгийн дагууд, зуут /пикет/ болон нэмэх цэгүүдийн зай хэмжээ, газрын өндөржилтийг нарийвчлан шалгаж, газрын төвшний дагуу ба хөндлөн огтлолыг замын нийт өргөнд тодорхойлох хэмжилтийг гүйцэтгэнэ. Мөн үүнтэй адилаар замын тэнхлэгийн дагуух бүх төлөвлөгдсөн хоолой ба байгууламжуудын хөндлөн, дагуу хэмжилтийг гүйцэтгэнэ. Төлөвлөгдсөн болон засварлах хоолойны тэнхлэгийн дагууд газрын төвшинг тодорхойлохдоо замын тэнхлэгээс хоёр тийш Инженерийн зааварчилсан хязгаар хүртэл тодорхой зайнд хэмжилтийг гүйцэтгэнэ. Бүх холбогдох мэдээллийг (дугаар, байршил, төвшин г.м) угаагдаж арилдаггүй будгаар тодорхой тэмдэглэж бичсэн лавлагааны гадас, самбарыг ухмал ба далангийн налуу, хучилтын үеүдийн төвшинг ямар ч үед шууд тодорхойлох боломжтойгоор, замын тэнхлэгтэй перпендикуляраар, замаас тодорхой зайд байрлуулна. Эдгээр нь Гүйцэтгэгчид барилгын ажлыг шалгах, хянах зориулалтаар ашиглагдана.

Талбайн цэвэрлэгээг хийж дуусмагц Гүйцэтгэгч нь лавлагааны 50x50x1200 мм хэмжээтэй модон гадсыг хөрсийг нь хуулсан талбайн хоёр захаас гадагш 0,5-0,8 м зайнд, 400 мм гүн суулгана. Тэнхлэгийн дагууд байрлах лавлагааны гадаснуудын хоорондын зай 20 м-ээс ихгүй байна. Гадасны газраас дээш ил гарсан хэсгийг цагаанаар будсан байна. 25-45 мм-ийн урттай хадаасыг гадсан дээр үе тус бүрийн өндрөөр зоох ба хадаасны толгой нь хэмжилт хийх цэг ба замын тэнхлэгийг зааж өгнө. Гадсан дээр зуутын дугаар болон тэнхлэгээс хуулсан хөрсний зах хүртэлх цэвэр зайг Инженерийн шаардлагад нийцүүлэн тод, арилахааргүй тэмдэглэсэн байна. Замын дагууд хийгдсэн бүх гадаслагааг Гүйцэтгэгч нь шаардлагатай хугацааны туршид арчлан хамгаалж, эвдрэл гэмтэл гарсан бол нэн даруй засварлаж, тэмдэглэгээг тогтмол сэргээж байна. Хэмжилтийн ажлыг хэмжилтийн нарийвчлалын шаардлага хангах багажийн тусламжтайгаар гүйцэтгэх ба өгөгдлийг Инженерийн зөвшөөрсөн формат ба нарийвчлалын стандартын дагуу нэгтгэн боловсруулна. Зам барилгын үе шат бүрт замын хөндлөн огтлолын зургийг 1:200 масштабтайгаар хэвлэж, үе шатын ажил хүлээлцэх бүрт Инженерт танилцуулна. Дагуу огтлолын зургийг хэвтээ чиглэлд 1:2000 масштабтай, босоод чиглэлд 1:200-гийн масштабтайгаар боловсруулна. Гүйцэтгэгчээс ажлын явцын зургуудыг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор зам, хоолой, бусад байгууламжуудын байрлал ба төвшинг баталгаажуулна. Гүйцэтгэгч нь нэг удаад 10 км-ээс багагүй урттай замын ажил гүйцэтгэх зургийг танилцуулна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Инженерийн зааварласан зам, хоолой ус зайлуулах байгууламжуудын эцсийн төвшин нь зурагт үзүүлснээс өөр байж болно. Мөн тухайн ажлыг гүйцэтгэсний дараа гүйцэтгэлийн зургийг Гүйцэтгэгч боловсруулж Инженерээр хянуулна. Энэ нь тухайн ажлыг санхүүжүүлэх нэг зайлшгүй нөхцөл болно.

Далангийн дүүргэлтийн газар шорооны ажлыг дуусангуут, гэхдээ далангийн дээд үе болон хучилтын үеүдийн ажлыг эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь модон эсвэл төмөр гадаснуудыг өндөрлөсөн далангийн хоёр талын ирмэгт, замын тэнхлэгээс ижил хэмжээтэй тогтмол зайд, аль болох бөх суулгана. Ухмал ба өндөрлөгөөтэй хэсэгт талбайн нөхцөлөөс шалтгаалан тэнхлэгээс гадас хүртэлх зай өөрчлөгдөж болох ба ийм тохиолдолд Инженерийн зөвшөөрсөн зайд суулгана. Далангийн гадаргуугаас дээш ил байх гадасны өндөр нь 1м-ээс багагүй байна. Гадсан дээр зорчих хэсгийн хөндлөнгийн аль ч цэгт замын тэнхлэг болон төвшинг нарийн утас ашиглан шууд тодорхойлоход шаардлагатай бүх холбогдох мэдээллийг арилахгүйгээр тэмдэглэсэн байх ёстой. Гадаснуудын хоорондох зай нь 20 м-ээс ихгүй байх ажил гүйцэтгэх хугацааны туршид Гүйцэтгэгч тэдгээрийг засварлан сэргээж байна. Инженерийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр аль нэг гадсыг хөдөлгөж болохгүй.

302. ХҮЛЦЭХ АЛДААНУУД

а) Хэвтээ чиг

Замын хэвтээ чиг нь зурагт үзүүлсэн буюу зургаас тооцож гаргасан замын хучилтын тэнхлэгээр тодорхойлогдоно. Дэвссэн хучлагын тэнхлэг ба түүнтэй зэрэгцээ орших бусад чигийн нарийвчлал ± 10 мм-ийн дотор байвал зохино.

б) Хучилтын үеүдийн зузаан

Дурын 1000 метрийн дотор 5 цэгт хэмжсэн хучилтын аль ч үеийн дундаж зузаан нь Инженерийн зааварласан буюу тогтоосон зузаанаас 99%-иас багагүй, 120%-иас ихгүй байна. Үүний дээр, хучилтын аль ч үеийг дурын цэгт хэмжсэн зузаан нь Инженерийн зааварласан, эсвэл техникийн шаардлагад зааснаас 99%-иас бага, 120%-иас их байх ёсгүй.

в) Далан ба хучилтын үеүдийн гадаргуугийн төвшин

Хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн аливаа цэгт хэмжсэн төвшин ба зургаас тооцсон зохих төвшингийн хоорондох зөрүү нь (хүснэгт 3-1)-д үзүүлсэн хүлцэх алдаанаас илүү байх ёсгүй. (Хүснэгт 3-1)-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд Инженерийн сонгосон цэгүүдэд, замын тэнхлэгийн дагууд 20 м тутамд, тухайн үеийн голд болон хоёр захад гадаргуугийн төвшнийг хэмжихээс гадна гол замын суурь үеийн болон хучлагын гадаргуу дээр тэнхлэгээс хоёр тийш 1.75 м-т, салаа замын суурь үеийн болон хучлагын гадаргуу дээр тэнхлэгээс хоёр тийш 1.5м-т тус тус нэмэлт хэмжилт хийнэ. Уулзвар дээр төвшинг торон хэмжилтийн аргаар хийх бөгөөд цэгүүдийн байршлыг Инженер тодорхойлно.

г) Хучилтын үеүдийн ба далангийн гадаргуугийн тэгш байдал

Хүснэгт 3-1: Хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн хүлцэх алдаа

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Үе / Layers	Гадаргуугийн төвшингийн хамгийн их зөрүү		3м-ийн рейкийн доогуурх хөндий хамгийн хэмжээ	Хөндлөн хэвгийн хүлцэх алдаа
Асфальтобетон хучлага	± 5 мм		3 мм	±0.15%
Суурь үе	- 10 мм		8 мм	±0.30%
Суурийн доод үе	± 15 мм		12 мм	±0.40%
Далангийн гадаргуу	- 25 мм		20 мм	±0.50%
Хөвөө	± 10 мм	8 мм	±0.25%	

Инженерийн сонгосон газарт 3м-ийн төмөр рейкийг замын тэнхлэгт паралель буюу перпендикуляраар байрлуулж хучилтын үеүдийн болон далангийн дээд үеийн гадаргуугийн жигд байдлыг шалгана. Рейкийн доор гарах хөндий зайн зөвшөөрөгдөх хамгийн их хэмжээг (хүснэгт 3-1)-д үзүүлэв. Хөндлөнгийн хэвгий нь зураг төслийн хэмжээнээс (хүснэгт 3.1)-д зааснаас хэтэрч болохгүй.

е) Далан ба ухмалын хажуу налуу

Засаж тэгшилсэн ба нягтарсан ухмал ба далангийн хажуу налууугийн огцмын хүлцэх хэмжээ зураг төсөлд тусгагдсанаас +0,20 байхыг зөвшөөрнө.

ф) Далан ба ухмалын өргөн

Замын тэнхлэгээс ухмалын хажуу налууугийн доод зах хүртэл хэмжсэн хэвтээ зай нь ±200 мм байх ба энэ нь ухмалын ёроолын өргөний зөвшөөрөгдөх хүлцэх алдаа болно. Замын тэнхлэгээс далангийн ирмэг хүртэл хэмжсэн далангийн өргөн нь зурагт үзүүлснээс багагүй, эсвэл зурагт үзүүлснээс +300 мм-ээс ихгүй байна.

г) Хажуугийн шуудууны гүн

Газрын гадаргуу болон хажуугийн шуудууны ёроолын төвшингийн зөрүүгээр хэмжигдсэн шуудууны гүн нь зурагт үзүүлсэн гүнээс багагүй, эсвэл мөн хэмжээнээс 100 мм-ээс ихгүй байна. Хэрэв хажуугийн шуудууны гүн зурагт заасан хэмжээнээс бага хийгдсэн бол зохих хэмжээнд хүртэл засна.

г) Барилгын ажлын хяналт шинжилгээ

Хэрэв өөрөөр заагаагүй бол, энэхүү техникийн шаардлагад тодорхойлсон хэмжээ нь хамгийн бага буюу хязгаарлагдмал хэмжээ бөгөөд төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсанаар, эсвэл техникийн шаардлагын бүлэг 200-д тогтоосон давтамжаар хийгдсэн бүх туршилт, шинжилгээ нь тухайн хэсгүүдэд тодорхойлсон хэмжээний алдаа дээр дурдсантай тэнцүү буюу бага байх нөхцөлд ажлыг овор хэмжээний хувьд болсон гэж үзнэ.

303. ХҮЛЦЭХ АЛДААНААС ЗӨРҮҮТЭЙ АЖЛЫГ ЗАСАХ

Ямар нэг ажлын хэмжээ техникийн шаардлагын зүйл 302-т зааснаас зөрсөн тохиолдолд Гүйцэтгэгч зөрүүтэй хийгдсэн ажлыг бүрэн хэмжээгээр тодорхойлж, дор дурдсан байдлаар дахин засварлана. Дахин засварлах талбайн хамгийн бага хэмжээ нь өнгөн хучлагаас бусад үеүдэд 3 м өргөн, 30 м урттай байна. Харин асфальтбетонбетон хучлагын засварыг хийхдээ хучлагыг нийт өргөнөөр сольж, 50метрээс бага урттай байж болохгүй.

(а) Газар шорооны ажил

Ухмал болон далангийн овор хэмжээний аливаа алдааг Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын бүлэг 500-д нийцүүлэн засварлана. Дахин засварлах талбай нь хамгийн багадаа 50 м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнийг хамаарна.

Хэрэв ухмалын налуу нь зурагт заагдсан хэмжээнээс илүү огцом, эсвэл илүү бол зурагт заагдсан хэмжээнд заагдсан хэмжээнд хүртэл засаж тэгшилнэ. Харин далангийн хажуу налуу нь заагдсан хэмжээнээс илүү огцом байвал шатлан ухаж гарсан материалыг зайлуулаад, оронд ижил төрлийн дүүргэгч материалыг дэвсэж нягтруулан налууг тэгшлэх ажлыг бүлэг 500-д нийцүүлэн гүйцэтгэнэ. Ухмал, далангийн хажуу налууг илүү ухах болон гүйцэтгэгч өөрийн буруугаас үүдэн гарсан газар шорооны ажилд нэмэлт төлбөр тооцогдохгүй. Далангийн өндөрлөгөө, хиймэл байгууламжийн ойролцоох буцаан дүүргэлтийн ажил материалын чанар техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбайн зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх юмуу эсвэл шинжилгээгээр муу гэж нотлогдсон талбайгаас хоёр тийш тус бүр 30м уртад, уг хэсгийн тогтоосон хэмжээтэй байх ба талбайн хэмжээг Инженер тогтооно. Далангийн дээд үе бусад тусгай зорилалтын үеийн төвшин хүлцэх алдаанаас хэтэрсэн бол техникийн шаардлагад нийцүүлэн тэдгээрийг нийт өргөн ба гүнд дахин засна.

(б) Суурь үе ба суурийн доод үе

Хэрэв суурь үеийн төвшин ба өргөн, түүнчлэн гадаргуугийн тэгш байдал нь хүлцэх алдаанаас хэтэрсэн, суурийн доод үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдаанаас хасах тал руу зөрүүтэй байвал эдгээрийг нийт гүнд нь хуулан авч, дахин шинээр дэвсэх ажлыг техникийн шаардлагад нийцүүлэн хийнэ. Харин суурийн доод үеийн төвшин ба өргөн нь хүлцэх алдаанаас нэмэх тал руу хэтэрсэн, гэхдээ энэ нь 50 мм-ээс их бол техникийн шаардлагад заасан хэмжээнд хүртэл хусаж, тэгшилж болох боловч Инженер зөвшөөрөөгүй тохиолдолд үеийг нийт гүнд нь хуулан авч, дахин шинээр дэвсэнэ. Дахин хийх хэсэг нь хамгийн багадаа 30м урт, 3 м-ийн өргөнтэй байх, эсвэл Инженерийн тодорхойлсон талбай байна. Хэрэв суурь болон суурийн доод үеийн барилгын ажлын чанарын шинжилгээний дүн нь Техникийн шаардлагад заасан хэмжээнд хүрэхгүй байгаа хэсэгт Гүйцэтгэгч үеийн нийт зузаанд дахин боловсруулалт хийнэ. Дахин засварлах талбай нь зөвшөөрөл авахаар танилцуулсан нийт хэсэг бүхлээрээ байх, эсвэл шинжилгээний үр дүн муу гарсан байршлаас Инженерийн саналаар хоёр тийш хамгийн багадаа 50 м-ийн уртад, уг хэсгийн нийт өргөнөөр тогтоогдсон хэсэг байна.

304. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын зүйл 301, 302, 303-т тавигдсан шаардлагуудыг хангахтай холбогдсон зардлыг гүйцэтгэгч ажлын нэгж үнэ ба өртөгтөө оруулан тооцсон гэж үзнэ. Энэхүү техникийн шаардлагын зүйл 302, 303-т заасныг үл харгалзан, газар шорооны ажил, хучилтын

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Үеүдийн хэмжилт ба төлбөрийг хэмжилтийн хөндлөн огтлолын зурагт үндэслэн хийх ба зөвшөөрөгдсөн хүлцэх алдааны дотор байх зөрүүгийн хувьд ямар нэг нэмэгдэл төлбөр хийгдэхгүй. Хэдийгээр эдгээр хүлцэх алдааны дотор байлаа ч гэсэн далангийн дээд үе, хөвөө болон хучилтын бүх үеүдийн баригдсан дундаж зузаан нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс бага байж болохгүй.

**БҮЛЭГ 400 – ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ӨНГӨН
ХӨРС ХУУЛАЛТ**

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

БҮЛЭГ 400 – ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАЛТ

401. ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ.....	2
(a) Ерөнхий.....	2
(b) Модноос бусад цэвэрлэгээ.....	2
(c) Модыг зайлуулах.....	2
402. ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ	3
403. ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ.....	3
404. ХУУЧИН ГҮҮРИЙГ НУРААХ ЗАЙЛУУЛАХ	3
405. ХАШАА, МОД, ХАШИЛТЫГ ХАМГААЛАХ.....	4
406. ИНЖЕНЕРИЙН ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ.....	4
407. ХУДАГ ГАРГАХ.....	4
408. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	4

401. ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

(а) Ерөнхий

Талбайн цэвэрлэгээ гэдэг нь хаалт, саад, өвс, ургамал, хог, шороо, материалын үлдэгдлийг цэвэрлэж зайлуулах, өнгөн хөрс хуулах, бут, сөөг, үндэс, хожуул, зулзаган мод, бул чулуу зэргийг булгалах, сугалах, цэвэрлэж, зайлуулах, тэдгээрийг булгалж сугалахад үүссэн нүхнүүдийг буцаан дүүргэж, засах зэрэг ажлууд юм. Талбайн цэвэрлэгээний бүхий л ажил нь энэхүү техникийн шаардлага, Монгол улсын хууль тогтоомж болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дагуу хийгдэнэ.

Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлуулах явцад Гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар анхааралтай ажиллана. Зурагт үзүүлсэн эсвэл Инженерийн зааварласан газруудад талбайн цэвэрлэгээг хийнэ.

Гүйцэтгэгч өөрсдийн түр суурин, шороон ба чулууны орд газар, материал нөөцлөх талбай ба хаягдал зайлуулах газар болон бусад ажлын талбайд Инженерийн заавраар талбайн цэвэрлэгээг хийнэ. Дээр дурдсан газрууд нь төлбөрт хамаарагдахгүй.

Инженер талбайн цэвэрлэгээний явцад буулгаж, зайлуулж болохгүй тусгай мод, хожуул эсвэл объектуудын талаар зааварлана. Гүйцэтгэгч талбайн цэвэрлэгээний явцад нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй байх шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ба хэрэв өмч хөрөнгө, инженерийн шугам сүлжээнд ямар нэгэн гэмтэл учруулбал Гүйцэтгэгч нь гарсан хохирлыг бүрэн засах хариуцлагыг хүлээнэ.

Өнгөн хөрсийг зурагт заасан ба Инженерийн зааварчилсан гүнд хуулж, зайлуулах ажил талбайн цэвэрлэгээнд багтана.

(а) Модноос бусад талбайн цэвэрлэгээ

Инженерийн заавраар талбай дахь цэвэрлэгээг хийсэн бол цэвэрлэж зайлуулсан бүх зүйлс болон материал нь модноос бусад цэвэрлэгээнд хамаарна. Нийтийн болон хувийн өмчид хохирол учруулах буюу хүрээлэн буй орчинд хамаарах шаардлагыг зөрчихгүйгээр гүйцэтгэгч нь хаягдал материалыг зайлуулах буюу хаяна. Техникийн шаардлагын бүлэг 600-д заасны дагуу хаягдал зайлуулах цэгийг тогтооно. Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан талбайг цэвэрлэх ажлыг хийсний дараа гол ажил эхлэхээс өмнө зүлэг дахин ургавал нэмэлтээр талбайн цэвэрлэгээг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

(b) Модыг зайлуулах

Талбайн цэвэрлэгээгээр зайлуулан цэвэрлэх модыг хаяж болохгүй, Инженерийн заасан газар шилжүүлэн суулгана.

Гүйцэтгэгч Инженерийн зааврын дагуу талбайн цэвэрлэгээг хийхдээ аль болох газрын төвшинтэй ойролцоогоор модыг тайрч авах ба энэ Техникийн шаардлагын дэд зүйл 401(2)-ийн заалтуудын дагуу хаягдал зайлуулах цэгт хаяна. Мөн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зааврын дагуу модны гол, том хэмжээний салаа мөчир зэргийг тайрч болно.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Гүйцэтгэгч хожуул болон модны үндсийг булгалан сугалж авч зайлуулна. Хожуул болон үндсийг сугалж булгалахад үүссэн бүх нүхийг зөвшөөрөгдөх материалаар буцаан дүүргэж газрын төвшинд хүртэл эсвэл ухмал хэсэгт бол шороон далангийн төвшинд хүртэл 95% (AASHTO T180) байхаар нягтруулна.

402. ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ

Талбайн цэвэрлэгээ хийгдэх хэсгүүдэд өнгөн хөрсийг зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан гүнд Гүйцэтгэгч хуулж зайлуулна. Хэрэв Гүйцэтгэгч заагдсан гүнээс илүү гүн хөрсийг хуулбал өөрийн өртгөөр заагдсан хэмжээнд хүртэл дүүргэж нягтруулна.

403. ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ

Гүйцэтгэгч зураг болон Инженерийн зааварчилгааны дагуу барилга, байшин, суурь, хуучин төмөрбетон хоолой, хашаа болон хиймэл байгууламж болон хөшөө, овоо болон бусад байгууламжуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн буулгах, нураан зайлуулах ажлыг хийнэ. Инженерийн шийдвэрийн дагуу дахин ашиглах боломжгүй бүх төрлийн материалыг Гүйцэтгэгч талбайгаас зайлуулан энэхүү Техникийн шаардлагын 401(b)-д заасны дагуу хаягдал зайлуулах цэгт аваачиж буулгана. Хэрэглэж болох буулгагдсан бүх материал нь Захиалагчийн өмч байх бөгөөд захиалагч тэдгээрийг ачиж явах хүртэл эсвэл баталгаат засварын хугацаа дуусах хүртэл Гүйцэтгэгч хадгалан хамгаална.

Барилга, байгууламж, хуучин суурь, хоолой, хашаанууд болон ямар нэгэн хиймэл байгууламжуудыг буулган зайлуулснаас үүсэх хоосон зайг энэхүү Техникийн шаардлагын зүйл 507-д заасан шаардлагуудын дагуу буцаан дүүргэж нягтруулна.

404. ХУУЧИН ГҮҮРИЙГ НУРААХ ЗАЙЛУУЛАХ

Инженерийн зааварласан үед Гүйцэтгэгч янз бүрийн байршилд байгаа хуучин төмөрбетон гүүрүүдийг нураах бол нураагдсан гүүрээс гарсан дахин ашиглах боломжтой гэж үзсэн материалыг Инженерийн зааварчлагын дагуу Захиалагчид хүлээлгэн өгнө. Үлдсэн материалыг энэ Техникийн шаардлагын дэд зүйл 401 (b)-д заасны дагуу Гүйцэтгэгч талбайгаас зайлуулан заагдсан газар аваачиж хаяна. Гүүрийг нураах ажилд хайс, тавцан, завсрын тулгуур, дам нуруу болон усны доод төвшингөөс дээших байгууламжуудыг зайлуулах ажил орно.

Гүйцэтгэгч гүүрийг нураасны дараа гүүрийн талбайд эрэг хөвөөг сайтар хийж өгөх ёстой. Гүйцэтгэгч, орлуулах түр гүүр болон зөвшөөрөгдсөн түр ажлуудыг гүйцэтгэж дуусан тээврийн хөдөлгөөнийг нээх хүртэл гүүрийг нурааж болохгүй. Гүүрийг нураах үед гарах материал нь устай холилдож бохирдохоос сэргийлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэгч авна. Хэрэв гүүрийг нураах үед ямар нэг материал ус руу унавал Гүйцэтгэгч нэн даруйд нь уснаас гаргах ёстой.

405. ХАШАА, МОД, ХАШИЛТЫГ ХАМГААЛАХ

Инженерийн эвдлэлгүй орхихыг зааварласан ямар нэгэн жим зөрөг, хашаа, хана, хашилт, мод, бут, зүлэг ба бусад зүйл зэргийг ажил гүйцэтгэж байх явцад эвдэрч гэмтэхээс хамгаалсан шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс болж ямар нэг хохирол учирвал сэргээн засварлах ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

406. ИНЖЕНЕРИЙН ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ

Инженерийн шугам сүлжээг хамгаалах, шилжүүлэх ажлыг тухайн шугам сүлжээний ашиглагчийн заавар болон Инженерийн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ. Гарах зардлыг гүйцэтгэлээр нь Гүйцэтгэгчид олгоно.

407. ХУДАГ ГАРГАХ

Инженерийн зааварчилснаар худгийг гаргаж болно. Худаг гаргахтай холбогдон гарах зардлыг төсөвт заасан болон захиалагчийн санал гүйцэтгэлээр нь Гүйцэтгэгчид олгоно.

408. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(а) Зүйл: Талбайн цэвэрлэгээ

Нэгж : Га

Замын чулуун ба шороон ордын талбай болон замын уртад хийх талбайн цэвэрлэгээний ажлыг (байгууламжаас бусад) гектараар хэмжинэ. Түр суурин, чулуун ба шороон орд, нөөц материал, хаягдал материалын цэг, тэдгээрт хүрэх туслах замууд,суваг, шуудууны талбайн цэвэрлэгээний зардлыг Гүйцэтгэгч өртөг зардалдаа багтаасан гэж тооцно. Талбайн цэвэрлэгээний ажлын зардалд дараах зүйлүүд багтана. Үүнд:

- Өвс, ногоо, хог шороо, бут ширэг болон бүх төрлийн бартаа саадыг цэвэрлэх, булгалж сугалах, хаях;
- Өнгөн хөрсийг хуулж зайлуулах;
- Бул чулуу, хожуул болон үндсийг зайлуулах гэх мэт мод тайрах ажил;
- Шаардлагатай тээвэрлэлт;
- Ажлыг бүрэн дуусгахад шаардагдах ажилчид, материал, багаж, техник дагалдах материалуудын нөхөн төлбөр;
- Энэ техникийн шаардлагын зүйл **401**, **402** болон **405**-ын шаардлагыг хангах.

(b) Зүйл: Төмөрбетон хоолойнуудыг зайлуулах

Нэгж : Метр

Төмөрбетон хоолойг зайлуулах ажлыг шугаман метрээр хэмжинэ. Уртын хэмжээс нь хуучин хоолойны тэнхлэгийн дагуу хэмжигдэнэ. Төмөрбетон хоолойнуудыг зайлуулах ажлын

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

үнэлгээнд дараах ажлууд орно:

- Төмөрбетон хоолойн орох гарах амсрын байгууламжуудыг ухаж аван зайлуулах;
- Бетон ба чулуун өрлөг, толгой, хана, далавч, рисбермыг буулгаж, зайлуулах;
- Буцаан дүүргэх;
- Бүх төрлийн тээвэрлэлт;
- Нурааж зайлуулах ажлыг Техникийн шаардлагын зүйл 403-т заасны дагуу гүйцэтгэх;
- Шаардлагатай бүх нураан буулгах ажил;
- Нураасан зүйлсийг хаяж зайлуулах.

(с) Зүйл: Төмөрбетон гүүрийг нураан буулгах

Нэгж : Бүхэлд нь төлөх мөнгө

Бетон гүүрийг нураан буулгах үнэлгээний тогтолцоо нь бүхэлд нь төлөх мөнгө байна. Гүүрийг нураах үнэлгээнд дараах өртгүүд орно:

- Нураах;
- Хайс, тавцан, завсрын тулгуур, дам нуруу болон усны доод төвшингөөс дээших бусад байгууламжууд гэх мэт дахин ашиглах боломжтой материал;
- Шаардлагатай бүх тээвэрлэлтүүд;
- Ажлыг бүрэн дуусгахад шаардагдах ажилчид, материал, багаж, техник дагалдах материалуудын нөхөн төлбөр;
- Энэхүү техникийн шаардлагын зүйл 404-т заасан шаардлагуудыг мөрдөх.

(д) Зүйл: Хөшөө, овоо болон бусад байгууламжийг шилжүүлэх буюу зайлуулах

Нэгж: Гүйцэтгэлээр төлөгдөх төлбөр

Инженерийн зааварчилснаар хийгдэнэ гэж заасан 408(b), 408(c), 408(d)- ээс бусад хөшөө, овоо болон бусад байгууламжуудыг зайлуулах буюу шилжүүлэх ажлын төлбөрийг гүйцэтгэлээр хийнэ.

(е) Зүйл: Худаг гаргах

Нэгж: метр

Худаг болгон цахилгаан шахуургатай хоолойд таарсан тагтай байна.

Өрөмдөх	Гүн	Нэгж
Эхний 30 м	0-30 м	м/м
Нэмэлт гүн	30-40 м	м/м
Нэмэлт гүн	40-50м	м/м

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Нэмэлт гүн	50-60м	м/м
Нэмэлт гүн	60 -ээс дээш	м/м

f) Зүйл: Холбоо ба цахилгааны шугамыг өргөх, шилжүүлэх

Нэгж: Захиалагчийн санал, Гүйцэтгэлээр төлөгдөх төлбөр

БҮЛЭГ 500 - ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

БҮЛЭГ 500 - ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ / SECTION 500 – EARTHWORK

501. БҮЛГИЙН АГУУЛГА	2
502. ЕРӨНХИЙ.....	2
503. УХМАЛ МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ	3
504. ДАЛАНГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ.....	4
505. ДАЛАН БАРИХ.....	4
506. НАМАГТАЙ БОЛОН БАМБАЛЗУУР ХӨРСИЙГ ЧУЛУУГААР ДҮҮРГЭХ.....	7
507. ХУУЧИН АСФАЛЬТОБЕТОН ХУЧЛАГЫГ ХУУЛАХ.....	8
508. ДАЛАНГ НЯГТРУУЛАХ.....	9
509. ХАЯГДАЛ МАТЕРИАЛ.....	9
510. ТУРШИЛТЫН НЯГТРУУЛАЛТ	10
511. ХАЖУУ НАЛУУГ ТЭГШИЛЖ ЗАСАХ.....	10
512. ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТ ХИЙХ.....	11
513. ДАЛАНГИЙН ОГЦОМ ХАЖУУ НАЛУУГ ГЕОТОРООР БЭХЛЭХ.....	11
514. ХАЖУУГИЙН ШУУДУУ	11
515. УХМАЛЫН ХАЖУУ НАЛУУ ДАХЬ ТОГТВОРГУЙ МАТЕРИАЛ.....	11
516. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	11

501. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт далан барих болон ухмалын ухалтын ажил багтах ба эдгээр нь хажуугийн шуудуу, шатлал, даланд дүүргэгч материалыг асгах, тэгшлэх, нягтруулах, суурийн доод үеийн үеийн материалыг асгах, тэгшлэх, нягтруулах, намгархаг газрыг ухах, хатуу чулуун дүүргэлт хийх, зүлэгжүүлэх ажлууд багтана.

502. ЕРӨНХИЙ

Газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерийн зааврын дагуу талбайн цэвэрлэгээ, мод, хожуулыг булгалах, сугалах, намаг болон шаварлаг хөрсийг зайлуулах, өнгөн хөрсийг хуулах зэрэг ажлыг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг Инженерийн зааварчилснаар буюу зургийн дагуу гүйцэтгэнэ.

Аль ч аргаар хольж боловсруулсан суурийн нягтруулсан нэг үеийн зузаан 150мм-ээс багагүй, 225мм-ээс ихгүй байх шаардлагатай. Суурийн нягтарсан зузаан 225мм-ээс их байх тохиолдолд дэвсэлтийг 2 үеэр үелүүлэн хийнэ. Материалыг газар дээр нь холихдоо талбайд хайрган (хөрс) материалыг дэвссэний дараа цементийг жигд тарааж, аливаа чулуун материал болон цементийн ялгарал буюу бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх замаар барилгын ажлаа явуулна. Нягт ба чийг нь нийт зузааны хэмжээгээр жигд тархсан байна. Материалын суулт, үеийн нягтруулалт, нягт болон чийгийн хангамж, гадаргуун тэгш байдлыг тодорхойлох зорилгоор 200м-ээс багагүй урттай хэсэгт эхлээд туршилтын үе дэвсэнэ. Туршилтын үе батлагдсаны дараа үндсэн ажлыг эхэлнэ. Туршилтаар баталгаажуулсан, инженерийн хүлээн зөвшөөрсөн аргачлалын дагуу суурийн үндсэн ажлыг хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь техникийн шаардлагад заасан ширхэглэлийн бүрэлдэхүүнийг хангахын тулд зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс өөр материал авч нэмэлтээр холих шаардлагатай бол дараах нөхцөлүүдийг хангана. Үүнд:

- Материал бэлдэх, олборлох, холихтой холбоотой бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- Суурийн тогтвортой байдлыг хангах үүднээс /нягтралтыг сайжруулах/ уян налархайгүй, органик нэгдэл агуулаагүй элс эсвэл буталсан чулууг хольцод нэмж болно.

- Нэмэх материалын хувь хэмжээг лабораторийн туршилтын дүгнэлт болон тогтоосон орцыг үндэслэн Инженертэй зөвшилцөж тогтоох ба нэмэх материалын хэмжээ нь хольцын жингийн 15%-иас илүүгүй байна.

Хэрэглэх материалын шинж чанарыг урьдчилсан байдлаар нарийвчлан судлахад үзүүлэлтүүд нь чанарын шаардлага хангасан нь тогтоогдсон байх шаардлагатай. Ус болон цементийг уян хоолойгоор холигч машинд дамжуулах, эсвэл газар дээр нь тараагч төхөөрөмжөөр урьдчилан тарааж бэлтгэсэн байна.

Усны машинтай холбогдсон холигч (рейсаклинг) машин 1 мөрөөр холилт хийн явмагц 6-10т жинтэй хөнгөн индүүний нэг мөрөөр явж нягтруулна. Холигч машин зэргэлдээх мөрөөр холилт хийн, индүүгээр нэг удаа явж нягтруулсны дараа автогрейдерээр нарийн тэгшилгээг эхэлнэ.

Холих үйл ажиллагааны нэг оролтын өргөн холигч машины (ресайклинг) ажлын өргөнөөр тодорхойлогдох бөгөөд дагуу залгаас гаргахгүйн тулд нэг удаагийн оролтын урт 100-120 метрээс ихгүй байна. Эхний явалтын дараа хажуугийн эгнээний эхний байрлалд буцан ирж холилтыг үргэлжлүүлнэ. Энэ үйл ажиллагаа замын суурийн нийт өргөнд хийгдэнэ. Холигч машины роторын эргэлтийн хурд 180 эрг/мин, хөдлөх ажлын хурд 5-12 м/мин байна.

Мөн цементийг дараахь 2 аргаар тарааж болно. Үүнд:

- Хуурай аргаар тараах
- Цементийг усанд ууссан хэлбэрээр тараах арга

Хуурай аргаар тараах: Цементийг зориулалтын тараагч машинаар тараах бол тохируулсан хурд болон орцын дагуу тараана. Цементийг салхигүй болон бороогүй нөхцөлд тараах ёстой. Тарааж буй цементийн зузаан 25 мм-ээс бага байх бөгөөд түүний зузаан нэгэн жигд байхад сайтар анхаарах хэрэгтэй. Цементийг хуурай аргаар тараах тохиолдолд зориулалтын цемент тараагч машин нь холигч машины урд байрлана.

Цементийг усанд уусгаж хэрэглэх: Энэ аргыг цементийн ямар ч агууламжтай тохиолдолд хэрэглэж болно. Цементийн уусмал дахь цемент болон усны харьцаа 1:1 байвал зохино. Энэ аргын давуу тал нь байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр цементийн зүй бус хаягдал гарахаас сэргийлж, орцын нормыг чанд мөрдөх боломжийг олгодог.

Цементийг усанд уусгаж хэрэглэх тохиолдолд холигч машины урд цементийн уусмалыг тээвэрлэж буй машин байрлах бөгөөд холигч машинтай уян хоолойгоор холбогдсон байна. Холигч машин нь ус болон цементийн уусмалыг хэмжих автомат тохируулагчтай байна.

Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь дэвсэх технологи аргачлалыг схемчилвэл:

Дүүргэгч материалыг автосамосвалаар зөөж буулгана → Нэмэлт материал хийх бол талбайд буулгана → Автогрейдерээр нарийн тэгшилгээ хийнэ → Цементийг тараагч машинаар жигд тараана → Холигч машинаар эхний боловсруулалтыг хийнэ → Гадаргууг усална → Индүүдэж нягтруулна → Арчилгааг хийнэ.

Усыг автоцистернд тээвэрлэх ба ихэвчлэн холигч машин урд байрлана. Холилтын давтамжийн тоо нь холигчийн төрөл болон материалын онцлог шинж, чийгийн агууламж, холигчийн хурдаас хамаарна.

Усыг жин буюу эзэлхүүнээр хэмжиж болно. Хольцонд хийх усны хэмжээ болон хугацааг Инженер тодорхойлно. Цемент, ус ба хайрга нь жигд холигдох ёстой бөгөөд нэг багцыг холих

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

хугацаа 30 секундээс бага байж болохгүй.

(3) Тээвэрлэх төхөөрөмж

Хольцыг тээвэрлэж буй өөрөө буулгагч машинуудын тэвшийг Инженерийн зааварчилсны дагуу сайтар хучсан байх ёстой. Хольцыг 20 км дотор тээвэрлэнэ.

(4) Автогрейдэр

Автогрейдерүүд нь сийрүүлэх төхөөрөмжөөр тоноглогдсон, нэг явалтаар замыг нийт өргөнд нь хэлбэржүүлэхэд хангалттай урт хутга, дугуйны суурь, нийт жинтэй байх ёстой. Автогрейдерүүд нь хутга болон хэвгий тохируулдаг автомат удирдлагатай байх ёстой.

Газар дээр нь холих аргаар боловсруулалт хийж хольцыг тарааж тэгшлэхдээ автомат мэдрэгч бүхий автогрейдерийг ашиглана.

Суурийн нарийн тэгшилгээг автогрейдерээр гүйцэтгэхдээ дараах ажилбаруудыг хийнэ. Үүнд :

- i) Суурийг автогрейдерийн тусламжтайгаар жигдхэн тэгшилнэ.
- ii) Замын хүндрэлтэй хэсэгт болон налууд тэгшилгээ хийхээс өмнө мэдэгдэхүйц үзэгдэх хотгор гүдгэрийг хольцын материалаар дүүргэж буюу хусаж тэгшилнэ.
- iii) 3 метрийн рейкээр хучилтын гадаргуугийн тэгш байдлыг шалгана.
- iv) Засварлах газрын хонхор хэсэгт жигд дүүргэлт хийж, хавтгай, тэгш болгох бөгөөд үүний дараа доргиурт индүүгээр индүүднэ.

(5) Суурь дэвсэгч - Грейдэр болон дэвсэгчийг хослуулан ажиллуулж болно.

1. ЦБХС-ийг талбайд холигч машин (ресайклер) ашиглан дэвсэж болно. Энэ төрлийн сууринд ашиглах төхөөрөмж нь материалыг зохих гүнд холих хүчин чадалтай, ажиллагаа хэвийн байх ба ухах гүний хэмжээ нь наад зах нь 20 мм-ээс багагүй байна.

Холигч төхөөрөмж нь жигд хөдөлгөөнийг хадгалж, хурд нь 5-12 м/мин хооронд хэлбэлзэнэ. Хольцыг нэгэн жигд, тэгш дэвсэх зорилгоор тэгшлэгч хавтантай байна. Мөн хөрсийг ухах, зорж авах шүднүүд нь элэгдээгүй, жигд өндөртэй байна.

2. Мөн суурь үеийг нэг зурвасын өргөнөөс багагүй өргөнтэй дэвсэх хүчин чадалтай, илүү өргөнөөр дэвсэх нэмэлт төхөөрөмж залгах боломжтой дэвсэгчээр дэвсэнэ. Дэвсэгч нь дараах тоноглолоор тоноглогдсон байна. Үүнд:

- Ачигч бункер ба тараах механизмтай байх;
- Хольцыг жигд үеэр тэгш дэвсэх зорилгоор доргиулагч бүхий тэгшлэгч хавтантай байх;
- Дэвсэгч нь хэвгий болон налуу мэдрэгчтэй байх;
- Дэвсэгч нь гадаргуугийн аливаа доголдуудыг шалгах хяналтын механизмаар тоноглогдсон байх ёстой.

(6) Нягтруулах тоног төхөөрөмж

Төмөр бултай буюу хийн дугуйт индүүгээр нягтруулна. Доргиурт индүүний жин 9 – 12т-оос багагүй байна. Бичил хагарал үүсэх үе шатанд 12тн жинтэй ган дугуйт индүү

шаардлагатай. Хийн дугуйт индүү нь 20–30тн жинтэй, дугуйны даралт 0.7 МПа байна.

Холигч машины араас нарийн тэгшилгээний ажлыг автогрейдерээр гүйцэтгэж, дууссан даруй нь нягтруулалтын ажлыг эхлүүлнэ. Нягтруулалтыг ихэвчлэн ган булт доргиурт болон энгийн горимоор ажилладаг индүү явж эхний, урьдчилсан нягтруулалтыг хийнэ. Суурийг бүрэн нягтруулахын тулд өөр олон төрлийн нягтруулах тоног төхөөрөмжийг сонгон ашиглах боломжтой юм. Нягтруулах төхөөрөмжөөр суурийн ирмэгийг гэмтээх эсвэл замын хөдөлгөөн болон цаг агаарын байдлаас болж гэмтэхээс болгоомжлох хэрэгтэй.

(7) Арчлах

- *Усаар арчлах:* Даралт хуваарилагчийг машинд суурилуулсан байх ба замын гадаргууд шууд нөлөө үзүүлэлгүйгээр усан манан үүсгэж гадаргууг арчилна.

- *Хамгаалалтын битумэн хальсаар арчлах* тохиолдолд Инженерийн зөвшөөрсөн техникийн үзүүлэлт бүхий өөрөө явагч битум цацагч ашиглана.

- *Нийлэг гялгар цаас бүхий тааран материал* ашиглаж болно. Нийлэг хальсан бүрхүүл нь цагаан, гэрэл нэвтрүүлдэггүй хальс бүхий 0.10 мм-ээс багагүй зузаантай байх ба тааран материалын нэг тал дээр бэхлэгдсэн ус тогтоох чадвар бүхий материал байна.

Ус нэвтрүүлдэггүй нийлэг гялгар цаасыг Инженерийн зөвшөөрөлтэйгөөр ашиглана. Нарийн шүршүүрээр шүршиж, чийглэсэн гадаргууг ус нэвтрүүлдэггүй гялгар цаасан хучлага эсвэл нийлэг бүрхүүлтэй тааран материалаар хучна. Бэхжүүлсэн суурийн гадаргууг хучихын өмнө гадаргууг сайтар норгоно. Ус нэвтрүүлдэггүй нийлэг гялгар цаасан хучлага эсвэл нийлэг бүрхүүлтэй тааран материалын цайвар өнгөгэй талыг дээш харуулан хучна. Хучлагыг сунгах байдлаар суурийн гадаргуун ирмэгийг давуулан бүрхэх ба арчилгааны явцад хучлагыг сайтар хамгаална. Хучлагуудын хажуугийн зах өөр хоорондоо дор хаяж 300 мм-ээр давхцаж хучигдах ёстой ба давхацсан хучлагын хэсгийг цемент эсвэл скотчоор нааж бэхжүүлж хамгаална. Хучлагын цоорсон хэсгийг тэр даруй нөхөж засна

(8) Хатуулаг шалгах багаж

ЦБХС-ийг барьж дууссаны дараа тусгай багаж ашиглан үеийн хатуулгийг шалгана. Humboldt Stiffness Gauge (HSG) гэсэн багаж байдаг. Энэхүү багаж нь ЦБХС үед гажилт өгөхийн тулд хэр зэрэг хүч шаардагдахыг заадаг.

904. БАРИЛГЫН АЖИЛ

(1) Ерөнхий

ЦБХС-ийг дэвсэхдээ цементийн хольц жигд тарж, аливаа ялгарал буюу бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх замаар барилгын ажлаа явуулна. Үеүдийн нягт ба чийг нь нийт зузааны хэмжээгээр жигд тархсан байна. Үеийн нягтруулалт, нягт болон чийгийн хангамж, гадаргуун өнгөлгөөг турших зорилгоор 200м урт хэсэгт туршилтын үеийг дэвсэнэ. Туршилтын үе батлагдсаны дараа үндсэн ажлаа эхэлнэ.

(2) Гадаргууг бэлтгэх

Суурийн доод үе: ЦБХС-ийг дэвсэхээс өмнө далангийн дээд хэсгийн гадаргууг сайтар нягтруулж, талбайн нягтыг шалгахад ХҮХИНягт 98-аас доошгүй хувийг хангасан байх ёстой. Гадаргуугийн тэгш байдал дагуу болон хөндлөн чиглэлд 3м-ийн рейкийн доогуурх хөндий зай 8 мм-ээс хэтрэх ёсгүй. ЦБХС-ийг дэвсэхээс өмнө гадаргууг чийгтэй (нойтон бус) байлгана.

Суурийн үе: ЦБХС дэвсэх доод үеийн гадаргууг хог хаягдал, илүүдэл материалаас сайтар цэвэрлэж суурь үе авахаас өмнө чийглэж өгнө.

Талбайн төвшинг хянах зорилгоор гадаслагаа хийнэ. Гадаслагааг замын захын цэгүүдийн дагуу параллель байдлаар байрлуулах ба утас татах эсвэл бусад хяналтын аргуудаас сонгож хэрэглэнэ. Хэрэв суурь огцом эргэлтэй хэсэгт дэвсэгдэх бол тэрхүү уулзварт хангалттай урт бүхий шилжилтийн хэсгийг байгуулах ба суурийн гадаргууд тухайн замын ангиллын шаардлагыг зөрчихөөр гэнэтийн эсвэл мэдэгдэхүйц өөрчлөлт оруулахаас сэргийлнэ.

(3) Цаг агаарын нөхцөл

1. Агаарын температур: агаарын температур буурч 5°C хүрсэн бол ЦБХС-ийн ажлыг эхлүүлж болохгүй бөгөөд өсч буй агаарын температур 5°C хүртэл бол ЦБХС-ийн ажлыг эхлүүлж болохгүй.
2. Цас/бороо: Бороо буюу цас орж байгаа тохиолдолд ЦБХС-ийн ажлыг гүйцэтгэж болохгүй. Нэгэнт тавьсан ЦБХС-ийн үе дээр бороо, эсвэл цас орвол гадаргуу хангалттай бэхжсэн тохиолдолд гадаргууг хур тунадасаас хамгаалах арга хэмжээ авна.

(4) Хугацаа

Хайрган материал буюу хөрсийг цементтэй хольсноос хойш 45 минутын дотор хольцыг урьдчилан бэлтгэсэн гадаргуу дээр дэвсэх ёстой. Үүнээс гадна холигч руу ус хийснээс хойш 2 цагийн дотор хольцыг дэвсэх, тэгшлэх, нягтруулах бүхий л ажиллагаа дууссан байх ёстой. Нэг зурваст хольцыг дэвссэний дараа 30 минутын дотор зэрэгцээ зурваст хольцыг дэвсэх шаардлагатай.

(5) Дэвсэлт ба нягтруулалт

1. Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурийн хольцыг дэвсэхээс өмнөхөн даланг чийглэсэн байх ёстой бөгөөд чийгийг хольц дэвсэх хүртэл хадгална. Шаардлагатай чийгээс их ус нэмж, суурийн материалыг хэт зөөлрүүлэхээс болгоомжлох хэрэгтэй. Ус илүүдэж, тогтоол үүсгэхийг хатуу хориглоно. Хольцыг дэвсэгч эсвэл ямар нэг төрлийн тараагч төхөөрөмжөөр тараах ба суурийн нягтруулалт дууссаны дараа түүний хөндлөн огтлолын хэлбэр, хэвгий болон төвшин нь ажлын зурагтай нийцэж байх ёстой. Цементийн агууламж нь орцоор батлагдсаны дагуу байвал зохино.

Хольцыг зэрэгцээ байдлаар дэвсэх тохиолдолд дэвсэх өргөнөөс хамааруулан 2 ба түүнээс дээш дэвсэгчийг ашиглана. Нэг дэвсэгч 2 эгнээгээр явж тараах үед барилгын заадас үүсгэхээргүй хугацаанд тохируулан дэвсэх оролтын уртыг тодорхойлно. Хоёр зэрэгцээ эгнээгээр тараах хоорондын хугацаа 30 минутаас бага байвал заадас хийхгүй. Эсрэг тохиолдолд барилгын заадас хийх шаардлагатай. Хольцыг дэвсэж дууссаны дараа, нэмэлт эгнээг дэвсэх шаардлагатай болсон тохиолдолд дэвссэн суурийн дагуу чиглэлд зэрэгцээ байдлаар суурийн захыг зүсэж авна. Суурийн хольцыг тараахдаа хэт их хуурайших эсвэл чийг алдалт явагдахаас сэргийлнэ.

2. Нягтруулсан ЦБХС-ийн хуурай үеийн нягт AASHTO T-180 стандартын дагуу хамгийн их хуурай нягт 99%-аас багагүй. Нягтруулалтын үеийн чийгийн агууламж зохист чийгийн агууламжаас $\pm 2\%$ -ийн хэлбэлзэлтэй байж болно

Тэгшилгээ болон нягтруулалтыг тогтмол хэмжиж, ажлын зурагт заасан төвшинд хүргэх ба нягтруулсны дараа нягтыг талбайн туршилтаар баталгаажуулахдаа үеийн зузааныг дахин

нягтлан тодорхойлно. Нягтарсан нэг үеийн зузаан нь зурагт зааснаас багагүй байна.

Суурийн нягтарсан үеийн зузаан 225мм-ээс их байх үед дэвсэлтийг 2 үеэр хийнэ. Суурийн хольцыг дэвссэний дараа тэр даруй нягтруулах шаардлагатай бөгөөд нягтруулж дууссан суурь нь шаардлагатай төвшин, хөндлөн огтлолын хэлбэр болон жигд зузаантай байна. Суурийг төлөвлөсөн хугацаанд шаардлагатай нягттай болтол нь нэгэн жигд нягтруулсан байх ёстой. Нягтруулах төхөөрөмжөөр суурийн ирмэгийг гэмтээх эсвэл замын хөдөлгөөн болон цаг агаарын байдлаас шалтгаалж гэмтээхээс болгоомжлох хэрэгтэй. Нягтруулж дууссан гадаргуу нь нэгэн жигд ба бүрэн гүйцэд нягтруулагдсан байх шаардлагатай.

Суурийн гадаргууд үүсэх сул чулууг цаг тухайд нь зайлуулна. Нягтруулах үеийн чийгийн агууламж зохист чийгийн агууламжаас $\pm 2\%$ -ийн хэлбэлзэлтэй байж болно. Индүүгээр нягтруулахад тохиромжгүй тохиолдолд гар индүүгээр нягтруулна. Өндөрдсөн цэгүүдийг сууринд аль болох гэмтэл бага учруулах байдлаар автогрейдер болон өөр ижил төстэй төхөөрөмжийн тусламжтайгаар хусна. Инженерийн зааварчилсны дагуу илүүдэл материалыг хөвөө эсвэл зэргэлдээ талын далан руу шилжүүлнэ. Суурийн гадаргуу дээр аливаа сул материалыг үлдээхгүй байх ёстой. Төлөвлөсөн төвшинд хүргэхийн тулд нягтарсан суурь дээр нэмж хольц дэвсэхийг хориглоно. Нягтруулалт хийсний дараа төвшин намдсан нь тодорхой болсон тохиолдолд заавал дахин сэндийлсний дараа материал нэмнэ

Индүүдэх явцад засварлаж байгаа гадаргуу нь үргэлж чийглэг байх хэрэгтэй. Хэрэв хэтэрхий их ууршилттай байвал чийгийн уурших хугацааг тооцох шаардлагатай. Индүүдэх явцад гадаргууд хуйлрал, том ширхэглэлт материалын ялгарал, сулралт, ховхролт болон бусад гэмтлийн үзэгдлүүд үүсвэл талбайд дахин холилт хийнэ. Дахин холилтыг 10 м-ээс багагүй урттай газарт хийнэ. Дахин холилт хийсэн урт биш хольцын гадаргууг малтуур, гаапуу мэтийн зохих гар багажийн тусламжтайгаар гараар тэгшилж болно. Нягтруулалтыг дуусгахын өмнө дахин нэг удаа сүүлийн тэгшилгээг хийнэ. Баригдаж буй суурийн үеийн зузаан, өндөр зэрэг үзүүлэлтүүд нь ажлын зурагт заасан шаардлагыг хангаж байх шаардлагатай

(6) Технологийн үйлдэл хийх урт ба засвар

Хольцыг талбайд хамгийн багадаа 20-30м урт хэсэгт дэвссэний дараа нягтруулалтыг эхлүүлэх бөгөөд технологийн нэг үйлдлийн урт 100-300 метрээс багагүй байна.

Нэг удаагийн технологийн үйлдлийн уртын хэмжээг оролтын урт гэж нэрлэж болно.

Ажлын хэсэг буюу оролтын урт. Хэт богино оролт нь дагуудаа олон залгаас гаргах бөгөөд, улмаар залгаас бүрд зузааны хэмжээ өөрчлөгдөх магадлал их байна. Харин хэтэрхий урт оролт хийвэл дараагийн зэрэгцээ 2 дахь явалтын үед хольсон материалын чийг алдагдах, улмаар зэрэгцээ зурвасын нягтруулалт харилцан адилгүй болох магадлалтай. Нягтруулалтыг хамгийн багадаа 20-30м урт хэсэгт хольцыг дэвссэний дараа эхлүүлнэ.

Өндөрдсөн цэгүүдийг сууринд аль болох гэмтэл бага учруулах байдлаар автогрейдер болон өөр ижил төстэй төхөөрөмжийн тусламжтайгаар хусаж авна. Инженерийн зааварчилсны дагуу илүүдэл материалыг хөвөө эсвэл зэргэлдээ талын далан руу шилжүүлнэ. Суурийн гадаргуу дээр аливаа сул материалыг үлдээхгүй байх ёстой. Суурийн төлөвлөсөн төвшинд хүргэхийн тулд нягтарсан суурь дээр нэмж хольц дэвсэхийг хориглоно. Нягтруулсны дараа төвшин намдсан нь тодорхой болсон тохиолдолд заавал дахин сэндийлсний дараа материал нэмж засварлана. Хамгийн сүүлд гадаргуугаас суларсан материалыг зайлуулж, шаардлагатай бол гадаргууг бага зэрэг чийглэн хийн дугуйт индүүгээр индүүднэ.

(7) Барилгын заадас

Дагуу: Дэвсээд 30 минутаас илүү хугацаа өнгөрсөн нягтруулсан зурвастай залгуулан зэрэгцээ зурваст дараагийн хольцыг дэвсэх тохиолдолд нягтруулсан үеийн ирмэгийг нийт зузаанаар зүсч босоо гадаргуу үүсгэнэ. Зүсэлтийг тухайн өдрийн ажил дуусахаас өмнө хийнэ.

Хөндлөн: Хэрэв дэвсэх ажиллагаа түр зогсож, дараагийн өдөр үргэлжлэхээр бол тухайн өдөр дэвсэж буй хольцын зузааныг аажмаар нимгэрүүлж (тэнхлэгийн дагуу бм-ийн зайд) хольцын зузааны талд хүргэнэ. Дараагийн өдөр ажил эхлэхдээ нимгэн хэсэг дээр шинэ хольц дэвсэж шаардлагатай зузаан хүртэл дүүргэнэ.

Суурийн гадаргуу дээр асфальтбетон хучлага дэвсэх үед хучлага болон суурийн заадсуудыг давхцуулж болохгүй. Заадас хоорондох зай 30 см-ээс багагүй байна.

(8) Гадаргууг тэгшилж, засах, эцсийн нягтруулалт хийх

Гадаргууд шаардлагатай налуу болон хэвгий гаргахын тулд дагуу налуу болон хөндлөн хэвгийг хянах хяналтын системтэй, автомат удирдлагатай зүсэх төхөөрөмж бүхий дэвсэгч ашиглана. Дэвсэгчийн араас доргиурт болон энгийн горимоор ажилладаг индүү явж эхний урьдчилсан нягтруулалтыг хийнэ.

1. Хучилтын гадаргууг шалгах

Эхний нягтруулалт хийгдсэний дараа 3м урт рейк ашиглан хучилтын гадаргуугийн дагуу налуу болон хөндлөн хэвгий гарсан эсэхийг шалгана.

2. Гадаргууг дуусгах, эцсийн нягтруулалт

Хийн дугуйтай индүүгээр индүүдэх ба шаардлагатай тохиолдолд индүүдэх явцад бага зэрэг чийглэн индүүдэж сул материалыг зайлуулсны дараа заслын индүүдлэг хийнэ.

Хамгийн сүүлд гадаргуугаас суларсан материалыг зайлуулж, шаардлагатай бол гадаргууг бага зэрэг чийглэн хийн дугуйт индүүгээр индүүднэ. Хийн дугуйтай индүүгээр индүүдэх ба шаардлагатай тохиолдолд индүүдэх явцад бага зэрэг чийглэн индүүдэж сул материалыг зайлуулсны дараа заслын индүүдлэг хийнэ. Эхний нягтруулалт дууссаны дараа гадаргуугийн дагуу болон хөндлөн хэвгийг хэмжилтийн багаж эсвэл 3 м-ийн рейк ашиглан хэмжилт хийнэ. Рейкийг замын аль ч хэсэгт тавьсан рэйк болон гадаргуугийн хоорондын бүлэг 300-д зааснаас хэтрэх ёсгүй.

(9) Эхний арчлалт

Гадаргуугийн заслын ажлыг хийж байх явцад чийгийн хэмжээ орцын нормд заасан чийгийн агууламжаас багагүй байхаар гадаргууг нарийн ширхэгтэй шүршүүрээр эсвэл усан манангаар чийглэж өгнө. Гадаргууг хэзээ ч өндөр даралттай усаар шүршиж болохгүй. Эхний арчлалтыг нягтруулалт хийж дууссанаас хойш 24 цагийн туршид тогтмол хийнэ.

(10) Бичил хагарлууд

Гадаргууг 24 цагийн турш чийгтэй байлгаж, арчлалт хийсний дараа ЦБХС-ийн хатуулгийг тусгай багаж (тухайлбал, Humboldt Stiffness Gauge (HSG) буюу түүнтэй адил багаж) ашиглан шалгана. Хэрэв багажны заалт 50–60 мН/м буюу кН/мм хооронд байвал бичил хагарлын нягтруулалтыг эхлэх шаардлагатай. Хэрэв багажны заалт үүнээс бага бол усаар чийглэх арчлалтыг дахиад 24 цаг үргэлжлүүлэн гадаргуун хатуулаг нь 50 – 60 мН/м хүртэл хийнэ. Хатуулгийн туршилтыг замын тэнхлэгийн дагуу 30-50м тутамд хийх бөгөөд дараа нь бичил хагарлын нягтруулалт хийх зорилгоор туршилт хийсэн газруудад тэмдэг тавина.

Дууссан ЦБХС-ийн бичил хагарлын нягтруулалтыг хийхдээ доргиурыг хамгийн дээд хүчин чадал хүртэл ажиллуулсан 12 тонны доргиурт индүүгээр цагт 3 км-ийн хурдтайгаар индүүдэн хийж болно. Инжене зөвшөөрвөл бичил хагарал хийх бусад аргуудаас сонгож болох бөгөөд аргачлал батлагдсан байх шаардлагатай. Нягтруулалтыг замын ирмэгийн 0.3м-ийг эс тооцвол замын нийт өргөнөөр гүйцэтгэнэ. Дээрхи аргыг ашигласан тохиолдолд тэмдэг тавьсан хэсгүүдэд индүүний 1-2 явалтын дараа хатуулгийн хэмжээ өмнөх хэмжилтээс 40%-иар буусан тохиолдолд бичил хагарлын нягтруулалтыг дууссан гэж үзнэ. Индүүний явалт бүрийн дараа хатуулгийг хэмжих ба хатуулгийн хэмжээ өмнөхөөс 40%-иар буурмагц индүүдлэгийг зогсооно. Ийнхүү хатуулгийн хэмжээг 40%-иар бууруулахын тулд индүүний хэдэн явалт шаардагдахыг тогтооно. Инженерийн зөвшөөрлөөр батлагдсан аргачлалын дагуу бичил хагарал үүсгэх бусад аргуудаас сонгон хэрэглэх боломжтой.

(11) Эцсийн арчлалт

Бичил хагарлын нягтруулалтыг хийж дууссаны дараа тухайн хэсгийг 48 цагийн хугацаанд чийг өгч арчлалт хийнэ. Үүний дараа асфальт дэвсэхээс өмнө хийдэг битумэн цацлагын нэгэн адил МС-30 битумээр цацлага хийж хамгаалалтын хальс үүсгэнэ. Битумыг 0.8-1.2 кг/м² -аар бодож цацна. Хэрэв битумэн цацлага хийсний дараа томоохон хагарал үүсвэл зохих маркийн битумэн материалаар хагарлыг бөглөнө. Битумэн цацлага хийсний дараа 3 хоногийн турш битумэн хальсыг чийг өгч арчилна.

(12) Хөдөлгөөний хязгаарлалт

ЦБХС дэвссэнээс хойш 7 хоногийн дотор буюу арчлалт дуусахаас нааш аливаа тээврийн хөдөлгөөн явуулахыг хориглоно.

Арчилгааны явцад гэмтэл учруулахгүйгээр нягтруулж дууссан суурийн зарим хэсэгт суурийн нягтруулалт дууссанаас хойших 48 цагийн дараа хөнгөн тэрэг хөдөлгөөнд орж болох ба тоног төхөөрөмж эсвэл замын хөдөлгөөний улмаас гэмтэл үүсэхээс сэргийлж, арчилгаа хийгдэж дуусаж, хангалттай хатуулаг чанартай болсны дараа бусад тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оруулна. Суурийг дэвссэнээс хойш 7 хоногийн дотор аливаа хүнд даацын тоног төхөөрөмжийг замын хөдөлгөөнд оролцуулж болохгүй бөгөөд хучлагын ажлыг эхлүүлж болно. Инженерийн зөвшөөрөлтэйгөөр суурийн дээгүүр цемент болон усыг тээвэрлэж болно. Ажлын заадастай залгаж шинэ суурь барих явцад хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс шалтгаалж гүйцэтгэж дууссан суурийн гадаргууд гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлнэ.

(13) Хөвөө

ЦБХС-ийг дэвсэж нягтруулалт ба хамгаалалтын хальс үүсгэж арчлалт хийсний дараа нэн даруй хөвөөний ажил эхэлнэ. ЦБХ суурь дээр хөвөөний материал тарсан тохиолдолд Инженерийн зааварчилсан аргаар суурийн гадаргууг гэмтээлгүйгээр цэвэрлэнэ. ЦБХ суурийн арчлалтыг хөдөлгөөний хязгаарлалтын хамт 7 хоног хийсний дараагийн ажлыг эхлүүлж болно.

905. ЧАНАРЫН ХЯНАЛТ

(а) Шахалтын бат бэх

Шахалтын бат бэхийг ЦБХ суурь дэвссэн өдөр тухай бүрт 3 цилиндр хэвэнд өдөр бүр MNS ASTM D 2217:2002, AASHTO T-180-10 стандартыг баримтлан 2-оос багагүй удаа иж бүрдэл бүхий дээж авч, 7 болон 28 хоногийн бат бэхийг шалгана

Дээжлэн авсан хольцыг 150мм-ийн цилиндр хэв дотор 5 үеэр, үе бүрийг 56 цохилтоор нягтруулж, талбайн арчилгаатай ижил нөхцөлд 6 хоног, усанд 1 хоног хадгалсаны дараа 7 хоногийн бат бэхийг шалгана. Лабораторид туршилтын дээж бэлтгэх материалын хамгийн том ширхэглэлийн хэмжээ 31.5 болон 37.5мм байж болох ба хайргыг орлуулах аргаар хийж болно.

Инженерийг зааварчилсан тохиолдолд гулзайлтын үеийн суналтын бат бэхийг шалгана. Гулзайлтын бат бэхийг турших сорьцыг лабораторид бэлтгэхдээ 150 мм диаметртэй, 300 мм өндөр хэвэнд 4.54 кг жинтэй алхаар 45.7 см-ийн өндрөөс чөлөөт уналтаар нягтруулна. Нэг үеийг нягтруулах давтамжийн тоо 56 байна. Дээжийг бэлтгэснээс хойш 7 хоногийн дараа шахалтын бат бэх, гулзайлтын бат бэхийг MNS 1272-99 стандартын дагуу тус тус тодорхойлно. 28 хоногийн бат бэх шалгах дээжүүдийг талбайн нөхцөлөөр чийг өгч арчлах ба дээж эвдэрч гэмтэх, алга болохоос хамгаалах шаардлагатай. Илүү найдвартай болгох үүднээс ижил тооны дээжийг хадгалах вандан тавиур дээр тэмдэглэгээ хийж хадгалах нь зүйтэй.

(b) Талбайн чийн ба нягт

Чийг: Нягтруулах үеийн талбайн чийг нь AASHTO T-180 стандартын дагуу лабораторийн нөхцөлд тодорхойлсон чийгийн зохистой агууламжаас $\pm 2\%$ - тай тэнцүү байж болно. Талбайн чийг болон нягтыг ЦБХ суурийн уртын 100-200м тутамд MNS ASTM D 1556:2002, AASHTO T-318-02 стандартын дагуу шалгана.

Нягт: Дээр 904 (д)-д заасны адил AASHTO T-191 стандартын дагуу шалгана.

(c) Гадаргуугийн тэгш байдлыг дээр 1004 (ё) -д заасантай адил шалгана.

Нягтруулсан гадаргуу дээр 3м-ийн рейкийг замын тэнхлэгтэй параллель болон перпендикуляраар байрлуулахад рейкийн доорх хамгийн их зай 8 мм-ээс илүү байвал засварлана. Хэрэв суурийн үе 2 давхаргатай байвал гадаргуун тэгш байдлыг зөвхөн дээд давхарга дээр үзнэ.

(d) Суурийн хатуурлыг шалгах

ЦБХС-ийг нягтруулан эхний арчилгаа дууссаны дараа суурийн хатуулгийг (Humboldt Stiffness Gauge (HSG) гэдэг багажаар шалгана. Энэхүү багаж нь сууринд гажилт өгөхийн тулд хэр зэрэг хүч шаардагдахыг заадаг. Хатуулаг нь шаардлагатай хэмжээнд хүрсэн бол бичил хагарлын индүүдлэгийг эхлүүлэх бөгөөд түүний тусламжтай бичил хагарлыг үүсгэхэд индүүний хэдэн явалт шаардлагатай байгааг тогтооно.

(e) Суурийн зузааныг шалгах

Суурийн зузааныг хэмжихэд 100 мм-ийн диаметртэй өрөмдөлт, туршилтын төхөөрөмж ашиглан, нягтруулж дууссан суурийн 1000-2000 м² бүрт бүрэн гүнээр дээж авч хэмжинэ. Дараа нь дээж авахад үүссэн нүхийг адил орц бүхий дахин боловсруулж, цементээр бэхжүүлсэн материалаар дүүргэж сайтар нягтруулна.

(f) Цемент

Цементийг лабораторийн шинжилгээгээр шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж тогтоосны дараа сууринд хэрэглэнэ. Энэ төрлийн хольцноос талбай дээр холилт хиймэгц, эсвэл үйлдвэрлэж гаргасны дараа дээж авч, MNS AASHTO T 211-90 : 2016 стандартын дагуу цементийн агууламжийг тогтмол шалгана.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Цементийн чанарыг “ЦБХ суурийн техникийн шаардлага” барилгын дүрмэнд заасан шаардлагаар тодорхойлно

(г) Талбайн үндсэн шаардлагууд

1. Дүүргэгч материал нь техникийн шаардлагын хүснэгт 9-6-д заасан шаардлагад нийцсэн байх.
2. Цементийн зарцуулалт болон минерал дүүргэгчийн ширхэглэлийг нарийн тогтоох
3. Хольц нь нийт үеийнхээ зузаанд жигд байх ёстой
4. Дэвсэх үед ширхэглэл ялгаралгүй жигд, гадаргуу тэгш байх
5. Хольцын чийгийн агууламж зохистой хэмжээнд байх
6. Үеүүдийг дэвсэх ажиллагаа цементийн бэхжих хугацаанаас бага байх.
7. Гадаргуу тэгш, нам дор цэггүй, тасраагүй, нягт байх ёстой.

Хүснэгт 9-8. Суурь үеийн гадаргууд тавигдах шаардлага

№	Шалгах үзүүлэлт		Тогтоосон утга буюу хүлцэх алдаа		Шалгах арга ба давтамж
			Суурийн дээд үед	Суурийн доод үед	
1	Нягтралын зэрэг, % (хэмжилтийн утга)		99	98	200м тутамд багадаа 2 хэсгийг шалгана
2	Тэгш байдал (мм)		8	-	3м рейк: 200м тутамд чиглэл тус бүрд 10 удаа хэмжинэ
3	Босоо төлөвлөлтийн өндөржилт (мм)		-10 мм	-10 мм	Нивлер: 200м тутамд 4 багагүй огтлолыг хэмжинэ
4	Өргөн (мм)		Зурагт зааснаас багагүй		Хуваарьт уртын хэмжүүр: 200м тутамд 4 огтлолыг хэмжинэ
5	Зузаан (мм)	Хэмжилтийн утга	-10	±12	Хөдөлгөөний зурвас бүрийн 1000-2000 м ² тутамд 1 хэсгийг шалгана
		Хүлцэх алдаа	-20	±30	
6	Хөндлөн хэвгий (%)		±0.30	-	Налуу хэмжигч: 200м тутамд 4 огтлолыг хэмжинэ

906. БАРИЛГЫН АЖЛЫН ДАРААЛАЛ

ЦБХС-ийн ажлыг доорх дарааллын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Суурийн доод үеийг тэгшилж, нягтруулна.
- Ширхэглэл тохирсон материалыг тогтоосон орцын дагуу талбайд цемент болон устай хольж, ЦБХС-ийн материалыг бэлтгэнэ.
- Туршилтын дэвсэлтийг Инженерийн заавраар хийнэ.
- Суурийн нягтруулалтыг хийнэ.
- Эхний арчлалтыг хийнэ.
- ЦБХ суурийн бичил хагарлыг хийх.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- Эцсийн арчлалтыг хийнэ. 3 хоногийн туршид тогтмол арчилгаа хийж арчилна.
- Суурийн доод үеийг тэгшилж, нягтруулсны дараа ЦБХС-ийн дээд үеийг дэвсэнэ
- Гадаргуугийн хамгаалалтын битум цацлага хийнэ.
- Дараагийн үеийн ажлыг эхлүүлэхэд талбайг бэлдэж, суларсан хэсгийг сайтар цэвэрлэж, Инженерээр шалгуулна.

907. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

ЦБХС-ийн ажлын хэмжээг хөндлөн огтлолын талбайг үндэслэн эзэлхүүнээр бодож гаргана. Зурагт зааснаас илүү гарсан тоо хэмжээг Гүйцэтгэгч өөрөө хариуцах ба нэмэлт төлбөр хийгдэхгүй. Зурагт тусгагдаагүй бол ажлын тоо хэмжээг тухайн ажлын нэгж үнэлгээгээр тооцож төлбөр хийнэ.

(а) Зүйл: ЦБХ суурийн үе, Нэгж: м³

Ажлыг гүйцэтгэж дуусгаад хүлээлгэн өгөх хүртэл шаардагдах бүхий л материал, тоног төхөөрөмж, цалингийн зардал төлбөрт багтсан байна. Энэхүү бүлэгт дурдсан буюу Инженерийн зааварчилсны дагуу туршилт шинжилгээг хийхэд гарсан зардалд аливаа нэмэлт төлбөр хийхгүй.

(б) Зүйл: Цементийн орцын өөрчлөлт, Нэгж: кг

Цементийн орцын өөрчлөлт:

Тендерийн нэгж үнэлгээг тооцохдоо Инженерийн баталсан цементийн орцыг хуурай дайрган материалын жингийн хувиар бодож авна. Цементийн орц өөрчлөгдвөл батлагдсан орцын норм, талбайд тухайн үеийг дэвсэх, нягтруулах, хүлээлгэн өгөх зэргээс хамааран орцын өөрчлөлтийн төлбөрийг тусад нь хийнэ. Орцын өөрчлөлт гэдэг нь цементийг илүү их хэмжээгээр хэрэглэсэн бол Гүйцэтгэгчид зөрүүг нэмж төлөх, бага хэрэглэсэн бол Гүйцэтгэгчээс суутгана гэсэн үг юм.

БҮЛЭГ 1000 – АСФАЛЬТАН ХУЧИЛТЫН АЖЛУУД

БҮЛЭГ 1000 – АСФАЛЬТАН ХУЧИЛТЫН АЖЛУУД

1001. БҮЛГИЙН АГУУЛГА.....	2
1002. “А” ДЭД БҮЛГИЙН АГУУЛГА.....	2
1003. БИТУМ БАРЬЦАЛДУУЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	2
1004. БИТУМ БАРЬЦАЛДУУЛАГЧИЙН ХАДГАЛАЛТ, АРЧЛАЛТ.....	2
1005. БИТУМ БАРЬЦАЛДУУЛАГЧИЙГ ХАЛААХ.....	3
1006. БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ.....	4
1007. АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ.....	4
1008. АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ.....	4
1009. АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “А” ДЭД БҮЛЭГ.....	4
1010. ТОДОРХОЙЛОЛТ.....	5
1011. БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГТ АШИГЛАХ МАТЕРИАЛ.....	5
1012. ГАДАРГУУГ БЭЛДЭХ.....	6
1013. БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГ ХИЙХ.....	6
1014. ЦАЦАХ ҮЕИЙН ТЕМПЕРАТУР.....	7
1015. БИТУМЭН ЦАЦЛАГЫГ АРЧЛАХ, ҮЙРМЭГ ЧУЛУУ ЦАЦАХ.....	7
1016. ХҮЛЦЭХ АЛДАА.....	7
1017. АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “Б” ДЭД БҮЛЭГ.....	8
1018. ДЭД БҮЛЭГ “В” – АСФАЛЬТОБЕТОН ХУЧИЛТ.....	8
1019. МАТЕРИАЛ.....	8
1020. ФИЗИК ШИНЖ ЧАНАР БА ШИРХЭГЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	10
1022. ГАДАРГУУГ БЭЛДЭХ.....	12
1023. АСФАЛЬТБЕТОН ХОЛЫЦНЫ ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ.....	13
1024. ТАЛБАЙН ТУРШИЛТУУД.....	14
1025. АСФАЛЬТОБЕТОН ХОЛЫЦЫГ ХОЛИХ.....	15
1026. ХОЛЫЦЫГ ДЭВСЭХ.....	16
1027. ХОЛЫЦЫГ НЯГТРУУЛАХ.....	17
1028. ӨНГӨЛГӨӨ, ИРМЭГ БА ЗААДАС.....	18
1029. АСФАЛЬТОБЕТОН БОЛОН ХАРЛУУЛСАН БУТАЛСАН ЧУЛУУН ХОЛЫЦООС ДЭЭЖ АВАХ БА ШИНЖЛЭХ.....	19
1030. ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭНҮҮД.....	19
1031. ХҮЛЦЭХ АЛДАА.....	19
1032. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – ДЭД БҮЛЭГ “В”.....	20

1001. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт битум барьцалдуулагч болон буталсан чулууг асфальтобетон хучлагад хэрхэн хэрэглэх талаар зааварчилсан болно. Бүлэг дотроо гурван дэд бүлэгт хуваагдана. Үүнд:

Дэд бүлэг “А” Ерөнхий

Дэд бүлэг “Б” Битумэн цацлага ба битум түрхлэг

Дэд бүлэг “В” Асфальтобетон хучлага

1002. “А” ДЭД БҮЛГИЙН АГУУЛГА

“А” Дэд бүлэгт битум барьцалдуулагчид бүх шаардлагыг тайлбарласан болно.

1003. БИТУМ БАРЬЦАЛДУУЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бүх битум барьцалдуулагч нь энэхүү Техникийн шаардлагын 200-р бүлэгт заасан шаардлагад нийцсэн байх ёстой.

1004. БИТУМ БАРЬЦАЛДУУЛАГЧИЙН ХАДГАЛАЛТ, АРЧЛАЛТ

Гүйцэтгэгч нь барьцалдуулагч материалыг их хэмжээгээр зөөвөрлөх бол тухай бүрд нь барьцалдуулагчийн температур, болон тоо хэмжээний талаар Инженерийн зөвшөөрсөн байдлаар тэмдэглэл хөтөлнө. Энэхүү техникийн шаардлагын 1205-р Зүйлд тавигдсан шаардлагыг хангаагүй аливаа барьцалдуулагч материалыг Инженер барилгын ажилд ашиглахыг зөвшөөрөхгүй.

Гүйцэтгэгч нь битумын агуулах, халаах станцыг байнга цэвэр байлгах эдгээрийн ойр орчмын өвс ургамлыг хадаж цэвэрлэсэн байна. Галын аюул гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс торхуудыг хооронд нь хангалттай зайнд байрлуулна.

Битум зөөгч болон битумын тогоог байнгын холилт хийх насосоор тоноглож, бүхий л хугацаанд цэвэр байлгана. Битумын марк өөрчлөгдөх тохиолдолд өөр төрлийн битумуудыг хольж хадгалах, хэрэглэхийг зөвшөөрөхгүй. Шинэ маркийн битумыг хүлээж авахын тулд ондоо торхнуудыг бэлтгэсэн байх ба бүх ажлын тогоо болон битум зөөгчийг зөвшөөрөгдсөн уусмалаар сайтар угааж цэвэрлэнэ. Битумын тогоо болон битум зөөгчийг цэвэрлэхэд гарсан хаягдлыг зориулалтын бохир усны худагт зайлуулж хаяна. Ингэхдээ Гүйцэтгэгч газрын гадаргуу болон урсгал усны урсац, хөрсний усны судлыг бохирдуулахгүй байх бүх талын арга хэмжээг авсан байна. Гүйцэтгэгч бохир усны худгийг Инженерийн зөвшөөрсөн байдлаар тодорхой хугацаанд султгаж, бохир усыг зайлуулж байна. Барилгын ажил дууссаны дараа Гүйцэтгэгч эдгээр бохир усны худаг ба сувгийг зайлуулж, Инженерийн шаардлагын хэмжээнд хүртэл тухайн орчны талбайг нөхөн сэргээнэ. Гүйцэтгэгч бүх тогоо, урьдчилан халаах худгууд, багаж, тоног төхөөрөмжийг туйлын цэвэр байлгах ёстой. Битумийг тогоо буюу агуулахаас битум зөөгч рүү юүлэхдээ нарийн утсаар хийсэн торон шүүлтүүрээр шүүж хийнэ.

Битумыг төмөр замын тээврээр авч байгаа тохиолдолд замын рельс, дэр болон бусад тоноглолыг бохирдуулахгүй, байнга цэвэр байлгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч байна.

1005. БИТУМ БАРЬЦАЛДУУЛАГЧИЙГ ХАЛААХ

Халаах болон хадгалалтын явцад битумэн барьцалдуулагчийн температурыг 160-170°C-аас аль болох багасгахгүйгээр, барьцалдуулагчийг шахуургаар шахах боломжтой хэмжээнд байнгын холилтойгоор байлгана.

Гүйцэтгэгч нь битумэн барьцалдуулагчийг зөвхөн зохих шахуурга болон нарийвчилсан заалт бүхий термометрээр тоноглогдсон тогоо буюу хүрэлцэх хэмжээний багтаамж бүхий агуулахад сайтар холилтойгоор халаана. Термометр нь эвдэрсэн буюу нарийн заадаггүй саванд барьцалдуулагчийг халаахыг зөвшөөрөхгүй.

Цойлох шахалттай шүршигчийг ашиглахаар бол цацах үеийн зунгалаг чанар нь 70-аас 100 центисток байх ба шүрших шахалттай шүршигчид 35 –аас 65 центисток хүртэл байна.


Барилгын ажилд ашиглах битумыг 170°C-аас дээш хэмд халааж болохгүй. Хэт халаасан битумыг Гүйцэтгэгч ажлын талбайгаас зайлуулж хаяна. Халаах болон хадгалалтын явцад битумэн барьцалдуулагчийн температурыг 150-160°C-аас аль болох багасгахгүйгээр, байнгын холилтойгоор байлгана.

Битумын нэгэн төрлийн байдлыг хангахын тулд халаах болон хадгадах саванд холигч төхөөрөмж насосыг суурьлуулж, тогтмол ажиллуулж болно. Дээр зааснаас дээш халсан буюу эсвэл удаан халаасны улмаас шатсан, шинж чанар өөрчлөгдсөн битумыг гаргаж, ажлын талбайгаас зайлуулах хэрэгтэй.

Барьцалдуулагчийн эзэлхүүнийг 15°C-т хэмжих буюу эсвэл Нефтийн Стандарт Хэмжилтийн тохиргооны хүснэгтийг (ASTM D 1250) ашиглан 15°C-тай байхад шилжүүлж тохируулсан хэмжээг үндэслэн, Инженерийн зааварласан буюу тодорхойлсон орцоор барьцалдуулагчийг хэрэглэнэ.

Хүснэгт 10-1: Битумыг халаах болон зуурах, нягтруулах үеийн температур

№	Бэлтгэх нөхцөл	БНД90/130 маркийн битум
1	Хольцыг бэлтгэх эрдэс материалын халаах температур, °C	150-160°
2	Хольцыг бэлтгэх хобогчийг халаах температур, °C	150-160°
3	Сорьц бэлтгэх температур, °C	125-150°
4	Нягтруулж дуусах үеийн температур, °C	90°



Битум хадгалах тогоо нь байнгын холилт хийх төхөөрөмжөөр тоноглогдсон байдал

1006. БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

Гүйцэтгэгч битумтэй холбоотой барилгын ажлыг цаг агаарын тааламжгүй нөхцөлд буюу Инженерээс урьдчилан анхааруулсан нөхцөлд ажлыг гүйцэтгэхгүй.

Битумэн материалыг чийгтэй буюу хөлдүү гадаргууд, эсвэл хольцыг дэвсэж нягтруулахад тааламжгүй цаг агаарын нөхцөлд, мөн Инженерийн баталсан ажлын аргачлалд дурьдсан хүн хүч, машин техник, багаж хэрэгслийн иж бүрдэл бүрэн хангагдаагүй бол хучилтыг дэвсэхгүй. Битумэн эмульс болон зарим төрлийн шингэн цацлага хийхээс өмнө гадаргууг чийглэх зааврыг Инженер өгч болно.

Гүйцэтгэгч агаарын ба замын гадаргуугийн температур $+10^{\circ}\text{C}$ буюу түүнээс дээш, салхины хурд 36 км/цагаас бага нөхцөлд битумэн хольцыг гадаргууд дэвсэнэ.

1007. ХӨВӨӨНИЙ АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ

Асфальт хучилт дэвсэж дууссан хэсэгт хөдөлгөөний хязгаарлалтыг 1 хоног хийсний дараа хайрган хөвөөний ажлыг эхлүүлж болно

1008. АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Гүйцэтгэгчийн битумтэй ажиллах арга ажиллагаа нь ард иргэдийн буюу өөрийн ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл учруулахгүй байх нөхцлийг хангасан байна. Нэн ялангуяа Гүйцэтгэгч нь:

- a) Битумэн материалыг галын дөл эсвэл оч унах талбайн орчинд байлгахыг хориглох,
- b) Битум хадгалах сав, халаах сав, холигч, түгээгч эсвэл талбайд ашиглах тоног төхөөрөмжүүд температур хэмжигчтэй байх. Зөвхөн ажлын температурт халаана,
- c) Халуун битумд ус хүргэхгүй байлгах,
- d) Халуун битумтэй ажиллахад зохих хамгаалалтын хувцас, гутал ба бээлийгээр иж бүрэн хангах,
- e) Тоосжилтийг хамгийн бага төвшинд бууруулах,
- f) Ажлын тогоо, битум хадгалах торхнуудын амсрыг битүү байлгах, хэрэв задгай агуулахтай бол хаалт тор татаж мал, амьтан орохоос сэргийлэх зэрэг арга хэмжээг авсан байна.
- g) Цистерн, авто-цистерн эсвэл бусад саван дахь битумэн түрхлэгийг шалгахын тулд шүдэнз, ил гал ашиглахыг хориглоно.
- h) Бүрэн агааржуулсан зохистой тээврийн хэрэгслээр битумэн түрхлэгийг тээвэрлэнэ.
- i) Зөвхөн туршлагатай мэргэжилтэн битумэн түрхлэгтэй ажиллах нөхцөлийг хангана.

1009. АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “А” ДЭД БҮЛЭГ

Энэхүү Техникийн шаардлагын 1201 – 1208 Заалтуудыг биелүүлэхэд аливаа хэмжилт буюу төлбөр тусад нь хийгдэхгүй. 1200-р Бүлгийн “А” дэд бүлгийн шаардлагыг биелүүлэхтэй холбогдон гарсан зардлыг Гүйцэтгэгч 1200-р Бүлгийн Б, В, дэд хэсгүүдийн нэгж үнэлгээнд оруулсан гэж тооцно.

ДЭД БҮЛЭГ “Б” – БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГ

1010. ТОДОРХОЙЛОЛТ

Битумэн цацлага гэдэг нь зунгалаг чанар багатай битумэн барьцалдуулагчийг шингээлт сайтай, хучилтгүй гадаргууд цацаж хэрэглэхийг хэлнэ.

Битумэн түрхлэг гэдэг нь битумэн барьцалдуулагчийг битумэн хольц бүхий хучлагын гадаргууд нимгэн үеэр цацахыг хэлнэ.

1011. БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГТ АШИГЛАХ МАТЕРИАЛ

Битумэн цацлагад битумын эмульс эсвэл шингэн битумыг ашиглана. Шингэн битум нь MNS AASHTO M82 шаардлагад нийцсэн MC-30 ба MC-70 маркийн шингэн битум байна.

Битумыг улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж баталгаажуулсан байна. Инженерээс өөрөөр заагаагүй бол шингэрүүлсэн битум, эмульс цацлага 0.8-1.4 л/м², түрхлэг 0.4-0.6 л/м² -ийн хэмжээгээр цацаж, талбайд цацалтын хэмжээг хянана.

Битумэн эмульсыг шингэн цацлагад Инженерийн зөвшөөрлөөр ашиглаж болно. Ашиглахдаа ажлын аргачлал бичиж Инженерээр батлуулсан байх шаардлагатай. Битумэн цацлага хийсний дараа гадаргуу нь 24 цагийн дотор хатсан байх ба цацлагын гадаргууд нэвчих гүн 3-10мм байх ёстой.

Хэрэв Гүйцэтгэгч цацлага хийсэн гадаргуугаар өөрийн машин техник, эсвэл нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхээр бол тухайн хэсэгт шигшсэн материал цацаж хамгаалж өгнө.

Битумэн цацлагатай гадаргуунд цацах шигшсэн материал нь органик бодис, шавар болон бусад тохиромжгүй бодис агуулаагүй байх шаардлагатай ба нарийн ширхэгтэй буталсан чулуу, элс, бутлуураас гарсан чулууны тоос зэргийг ашиглана. Шигшсэн материалын ширхэглэлийн үзүүлэлтүүд нь AASHTO M43, №10-ын хэмжээ буюу Инженерийн зааварчилсаны дагуу байна. Битумэн түрхлэгт ашиглах барьцалдуулагч нь:

- (i) асфальтбетон үеийг дэвсэхийн өмнөхөн халуунаар нь 0.3 л/м² -ийн хэмжээтэй цацах, нэвчилт сайтай битум;
- (ii) асфальтбетон үеийг дэвсэхийн урд, шингэрүүлэгч ууршихад хүрэлцэхүйц хугацааны өмнө 0.2 л/м²-ийн хэмжээтэй цацагдах дунд зэргийн хурдтай өтгөрдөг шингэрүүлсэн битум;

Битумэн цацлага ба түрхлэгт хэрэглэх битумын эмульсийн найрлага, орцыг гүйцэтгэгчийн лабораторид урьдчилан тогтоож Инженерээр хянуулах ба үүний дараа талбайд тодорхой тооны туршилт хийж Инженерээс зөвшөөрөл авсаны дараа ажлыг гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь битумэн цацлага ба түрхлэгийг хийх бүрдээ хэрэглэх барьцалдуулагчийн температур, бүрэлдэхүүн материалуудын харьцаа, хийгдэх газрын байршил зэргийг харуулсан хүснэгтийг тогтмол хөтлөх ба Гүйцэтгэгчийн болон Инженерийн холбогдох хүмүүс гарын үсэг зурж байна.

1012. ГАДАРГУУГ БЭЛДЭХ

Гүйцэтгэгч цацлага ба түрхлэг хийх гадаргууг механик шүүрээр шүүрдэх, хийн шахуургаар /компрессор/ үлээлгэх, усаар шүршиж угаах, эсвэл бусад тохиромжтой аргаар сайтар цэвэрлэх ба суларсан хөрс болон бусад гадны материалыг зайлуулна. Битумэн цацлага ба түрхлэг хийгдэх гадаргуу нийт өргөндөө бүрэн цэвэрлэгдсэн байна.

Цацлага, түрхлэг хийгдэх гадаргуугийн чиг, хөндлөн хэвгий ба төвшинг шалгаж, ажлыг эхлэхээс өмнө Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл гадаргууг засаж тэгшилнэ. Гүйцэтгэгч битумэн цацлагын ажлыг эхлүүлэхийн өмнөхөн Инженерт цацлага хийх зөвшөөрөл авах хүсэлт гаргана.

Инженерээс ажлыг эхлүүлэх зөвшөөрөл авмагцаа Гүйцэтгэгч цацлага хийхийн өмнө гадаргуун нийт өргөнд нь нэгэн жигд бага зэрэг ус цацаж өгөх ба ингэхдээ ус тогтох буюу үеийг усанд дэвтэж хорохоос зайлсхийх ёстой. Тохиромжтой нөхцлийг хангахын тулд усны хэмжээг бага багаар нэмж цацна. Гадаргууд ус тогтсон бол цацлага хийхээс өмнө усыг гадагшлуулж, зохих хэмжээнд хүртэл хатаах арга хэмжээ авна

1013. БИТУМЭН ЦАЦЛАГА БА БИТУМЭН ТҮРХЛЭГ ХИЙХ

Гадаргууг Техникийн шаардлагын 1212-р Зүйлд заасны дагуу Инженерийн зөвшөөрөх хэмжээнд бэлтгэсэний дараа шингэн цацлага буюу түрхлэгийг зохих орц, нормыг баримтлан хийнэ. Инженер гадаргуун бэлтгэлийг зөвшөөрсөнөөс хойш 4 цагийн дотор цацлага болон түрхлэгийг гүйцэтгэсэн байна. Барьцалдуулагчийг гадаргуугийн нийт өргөнөөс бага зэрэг илүү гаргаж цацна. Цацалт, түрхлэгийн норм буруу байвал Гүйцэтгэгч ажлыг нэн даруй зогсоож энэ тухай Инженерт мэдэгдэх ба ингэснээр Инженер норм хэмжээг өөрчлөх заавар өгнө.

Цацлага, түрхлэг хийх талбайн ирмэгийг замын шулуун хэсэгт 15м, эргэлтэд 7.5м-ээс илүүгүй зайтайгаар гадаслаж утас буюу төмөр утас татаж тэмдэглэнэ.

Барьцалдуулагчийг энэхүү техникийн шаардлагын 1224 (а) Дэд-Зүйл-д заасан шаардлагад нийцүүлэн хамгийн багаар 7000 литрийн багтаамжтай жигд даралтат цацагчаар цацна. Бага талбайд буюу цацагчийн хошуу бөглөрсний улмаас муу цацагдсан газруудыг засварлах зорилгоор Инженерийн зөвшөөрөлтэйгээр гар аргаар цацаж болно.

Цацлага ба түрхлэг жигд хийгдэхээр цацагчийн хошууг тохируулах ба ажлыг эхлэхээс өмнө тохиромжтой материал (хар цаас, лист төмөр зэрэг) дээр буюу зориулалтын хавтгай тэвшинд цацаж туршина. Туршилтыг замын гадаргуу дээр хийж болохгүй ба газар асгарсан аливаа битумыг зайлуулж цэвэрлэнэ.

Цацах явцад цацагчийн хошуу бөглөрөх буюу эвдэрвэл цацлагыг нэн даруй зогсооно. Дутуу цацсан хэсгийг гараар цацаж гүйцээнэ. Дараагийн цацлагыг эхлүүлэхээс өмнө цацагч машиныг зассан байна.

Цацлага, түрхлэгийг эхлүүлэх, зогсоох үед талбайн эхлэл, төгсгөлийн ирмэгийг тод, цэвэрхэн гаргах зорилгоор 2м-с доошгүй өргөнтэй хар цаас буюу гөлмөн төмрийг цацлага хийж буй талбайн нийт өргөнд хөндлөн дэвсэж өгсөн байна.

Ажилбар бүрийн дараа гөлмөн төмрийг сайтар цэвэрлэх хэрэгтэй ба туршилтад ашигласан тэвшийг өдөр бүрийн ажлын дараа цэвэрлэнэ.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Цацалтын үед замын хашлага, замын тоноглол, хоолойн толгой, далавч, мод, бут зэрэг бохирдож болох зүйлсийг хамгаалах ба санамсаргүй байдлаар битум цацарч тэдгээрийг бохирдуулсан бол Инженерээс зөвшөөрсөн тохиромжтой аргаар сайтар цэвэрлэнэ.

1014. ЦАЦАХ ҮЕИЙН ТЕМПЕРАТУР

Даралтаар шахах үеийн хамгийн бага температур, цацах үеийн температурын хязгаар болон шингэрүүлсэн битумыг халаах температурын хязгаарыг Хүснэгт 12-2-д үзүүлэв.

Хүснэгт 10-2 Дунд зэргийн хурдтай өтгөрдөг шингэрүүлсэн битумыг шахах, цацах ба халаах температур

Барьцал -дуулагч	Температур (°C)*			
	Шахах үеийн хамгийн бага температур	Цацах		Халаах хязгаар
		Цойлох шахалт	Шүрших шахалт	
МС30	10	40 - 50	50 – 60	65
МС70	25	55 - 70	65 – 80	85

* Эдгээр нь зөвхөн чиг баримжаа болгох зорилгоор өгөгдөж байгаа үзүүлэлтүүд болно. Харин тухайн үеийн тохиромжтой температурыг, цаг агаарын болон замын нөхцөл байдал, битумын температур ба зурамтгай чанарын харьцаа зэргээс хамааруулан Гүйцэтгэгч тодорхойлж, Инженер зөвшөөрсөн байх шаардлагатай.

1015. БИТУМЭН ЦАЦЛАГЫГ АРЧЛАХ, ҮЙРМЭГ ЧУЛУУ ЦАЦАХ

Битумэн цацлага хийсний дараа энэхүү Техникийн шаардлагын 1211-р Зүйлд тодорхойлсон хугацаанд барьцалдуулагч нь нэвчээгүй буюу эсвэл энэ хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэх шаардлагатай болсон бол битумын илүүдлийг шингээж, цацлага хийсэн гадаргууг хамгаалах зорилгоор үйрмэг чулуун материалыг шаардлагатай хэмжээгээр цацаж өгнө. Машины дугуй хамгаалаагүй гадаргуу дээгүүр явахааргүй байхаар үйрмэг чулуун материал нийт талбайд жигд тараагдсан байна.

Цацлага хийсэн гадаргуу дахь үйрмэг чулуу болон бүх сул материалыг дараагийн барьцалдуулагчийг цацахаас өмнө зайлуулна.

1016. ХҮЛЦЭХ АЛДАА

Нийт өргөнд нэг удаад цацах барьцалдуулагчийн хэмжээ нь тогтоосон нормоос $\pm 10\%$ -ээс илүүгээр зөрж болохгүй. Битум цацагч нэг удаагийн явалтаараа цацах барьцалдуулагчийн дундаж хэмжээ нь дор хаяж тогтоосон нормтой тэнцүү байна. Битум цацагчийн даацыг үндэслэн тодорхойлсон тооцооны зөв эсэхийг шалгах зорилгоор битумэн цацлагын үед өдөрт нэгээс доошгүй удаа машины торхны багтаамжийг шалгаж үзнэ.

Битум болон шингэрүүлэгчийн харьцааг цацлага хийгдэх тухай бүрт нь нэг удаа шалгаж байна.

1017. АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – “Б” ДЭД БҮЛЭГ

(а) Зүйл: Битум цацлага ба битум түрхлэг

Хэмжих нэгж : м²

Битумэн цацлага ба түрхлэгийг энэхүү Техникийн шаардлагын 1211-1216-р зүйлүүдийг ханган хийгдсэн хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Ажлын хэмжээг бодохдоо цацлага ба түрхлэг хийгдсэн цэвэр өргөнийг замын тэнхлэгийн дагуу заагдсан уртаар үржүүлж гаргана. Цацлага ба түрхлэг хийгдсэн талбайн өргөнийг 20-25м тутамд хэмжиж, тэдгээрийн дунджаар цэвэр өргөнийг тодорхойлно. Заагдсан хэмжээнээс илүү гарсан талбайд төлбөр хийгдэхгүй.

Битумэн цацлага ба түрхлэгийн нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Барьцалдуулагчийг бэлтгэх, тээвэрлэх ба тогтоосон орцоор цацах,
- Битумэн цацлага ба түрхлэгийг зорчих хэсгийн захаас хоёр тийш тус бүр 150мм илүү гарган гүйцэтгэх,
- Огцом налуу газар ажиллах,
- Үйрмэг чулуу цацах,
- Энэхүү Техникийн шаардлагын 200 ба 300-р Бүлгүүдийн шаардлагад нийцүүлэх

1018. ДЭД БҮЛЭГ “В” – АСФАЛЬТОБЕТОН ХУЧИЛТ

“АСФАЛЬТОБЕТОН” гэдэг нь ширхэглэлийн зохистой найрлага бүхий хуурай чулуун материал, эрдэс нунтаг ба битумыг тусгай төвлөрсөн заводад халуунаар нь хольж, зурагт заасан хэмжээ, налууг баримтлан Техникийн шаардлагын дагуу халуунаар нь дэвсэж нягтруулсан хийцийг хэлнэ. Энэхүү техникийн шаардлагыг бүх төрлийн асфальтобетон хучилт барихад ашиглана.

1019. МАТЕРИАЛ

(а) Зунгалаг чанартай битум

Барьцалдуулагч нь Техникийн шаардлагын 200-р зүйлд нийцсэн БНД 90/130 маркийн өтгөн битум байна.

Материалын эх үүсвэр өөрчлөгдөх болон шинжилгээгээр шинж чанар өөрчлөгдсөн нь тогтоогдвол, мөн талбайд татан авалтын 200 тн тутамд давтан шинжилгээг гүйцэтгэнэ. Талбайд татан авалт хийхээс өмнө итгэмжлэгдсэн лабораториор физик механик болон химийн шинж чанарын туршилтыг хийж, баталгаажуулсан байх шаардлагатай

(б) Буталсан чулуу

Асфальтобетон хольцонд MNS 390 : 2010 стандартын шаардлагыг хангасан уулын буталсан чулууг хэрэглэнэ. Чулуу нь буталсан чулуу байх ба өгөршсөн, хавтгай буюу хайрслаг ширхэглэлтэй материал (миканит), шавар, шавранцар, органик материал болон бусад хортой бодис агуулаагүй байна. Мөн шаварлаг шохойн чулуу, элсэн чулуу, занар зэргээс гарган авсан дайрга хэрэглэж болохгүй.

Хучилтын дээд үеийн хольцын дайрганд хавтгай хэлбэрийн ширхгүүд жингийн 15%-иас хэтрэхгүй байна. Доод үеийн хольцын дайрганд агуулагдах өгөршсөн, хэврэг чулуулгийн ширхгүүд 25%-иас хэтэрч болохгүй.

75 μ m шигшүүрээр өнгөрөх чулууны хэмжээ жингээрээ 1 %-иас хэтрэхгүй байна. Материалын физик шинж чанар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Лос Анжелесийн элэгдэл < 25
- Сульфат натрийн бат бэх < 12
- Хувийн жин > 2.4
- Сүвшил -
- Үзүүрлэг, хавтгай хэсэг дээрхи
- Асгаасан нягт -
- Цидиндр шахалтын бутрагдалт < 25
- Тоосорхог, шаварлаг хэсгийн хэмжээ < 1
- Ус шингээлт < 2.0
- Цохилттой бутрагдалт < 15
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн

Нарийн ширхэглэлийн чулуу нь (4.75 мм-ийн шигшүүрээр өнгөрсөн) том ширхэгтэй элс, буталсан чулуу буюу буталсан хайрганаас бүрдэнэ. Чулуу нь бат бэх, барзгар ширхэгтэй, шавар, шавранцар, миканит болон бусад хортой бодис агуулаагүй байна. Нарийн ширхэглэлийн чулууны элстэй адилтгах (AASHTO T176) хэмжээ 50-аас доошгүй, 0.425мм шигшүүрээр өнгөрөх чулууны хэврэгшлийн индекс 4-с ихгүй ба AASHTO T104 стандартын дагуу содын сульфатын бат бэхийн 5 удаагийн туршилтаар орсны дараах жингийн алдагдал 12% ихгүй байна. Гүйцэтгэгч чулууг овоолон хураахдаа материал ширхэглэлээрээ ялгарахаас сэргийлсэн арга хэмжээ авна. Чулууг хэвтээ үеээр, овоолсон чулууны өндөр 1.5 м илүүгүй байхаар хураана. Хэрэглэхээс өмнө итгэмжлэгдсэн лабораториор физик механик шинж чанарын туршилтыг хийж, баталгаажуулсан байх.

(с) Эрдэс нунтаг

Эрдэс нунтагийг талбайд татан авалт хийхээс өмнө итгэмжлэгдсэн лабораториор физик болон химийн шинж чанарын туршилтыг хийж, баталгаажуулсан байх шаардлагатай. Материалын эх үүсвэр өөрчлөгдөх болон шинжилгээгээр шинж чанар өөрчлөгдсөн нь тогтоогдвол, мөн талбайд татан авалтын 200тн тутамд давтан шинжилгээг гүйцэтгэнэ

Эрдэс нунтаг нь чулууны тоос, зуурч болгосон шохой, Портланд цемент болон Инженерийн баталсан бусад эрдсээс бүтнэ. Эрдэс нутгийг хэрэглэх үед нунтаг нь хуурай, хялбар урсах аливаа бөөгнөрөлгүй байна.

Эрдэс нутгийн ширхэглэлийн найрлага дараах хязгаарт байна. Үүнд:

Шигшүүрийн хэмжээ	Шигшүүрээр өнгөрөх жингийн хувь
600 μ m	100

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

300 μm	95 - 100
75 μm	70 – 100

Чулууны тоос болон ижил төстөй материалаас гаргаж авсан эрдэс нунтаг нь миканит, органик материал болон бусад бохир бодис агуулаагүй байх ба уян налархайн индекс нь 4%-с дээшгүй байна.

(d) Элс

Асфальтбетон хольцонд MNS 0392-2014 стандартын шаардлага хангасан бүлэглэсэн буюу холимог бүлэглэлийн Мкр 2,1-3,1 бүхий байгалийн буюу нунтагласан элсийг хэрэглэнэ. Нарийн ширхэглэлтэй элсийг нунтагласан том ширхэгтэй элсээр баяжуулж болно. Нунтагласан элсийг дайрга бэлтгэхэд хэрэглэх чулуу бат бэхээс багагүй уулын чулуулагаас бэлтгэнэ. Нунтагласан элсний 0.075мм-ээс жижиг хэмжээний хэсгүүд 5%-аас хэтрэхгүй байж болох бөгөөд үүний дотроос шавар 3 %-иас хэтрэхгүй байна.

Элс болон буталсан чулууны тоосорхог, шаварлаг хэсгийн хэмжээ стандартад заасан хэмжээнээс их үед тоосгүйжүүлэх, угаах арга хэмжээ авч, туршилтыг инженер баталгаажуулсан тохиолдолд хэрэглэнэ

1020. ФИЗИК ШИНЖ ЧАНАР БА ШИРХЭГЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Асфальтобетон хольц

Хэрэв Инженер өөрөөр заагаагүй бол том болон нарийн ширхэгтэй чулуу, эрдэс нунтгийг жишиг орц, нормын дагуу хольсны дараа ширхэглэлийн хуваарь Хүснэгт 10-3-д өгсөн хязгаарт багтах орцыг сонгоно. Ширхэглэлийн хамгийн том хэмжээ 20 мм-ээс хэтрэхгүй байна. Асфальтобетон хольцонд БНД 90/130 маркийн битум хэрэглэнэ. Лабораторийн шинжилгээний дүн болон талбайн туршилтыг үндэслэн Хяналтын инженер зөвшөөрвөл ширхэглэлийн хязгаарыг өөрчилж болно.

Хүснэгт 10-3: Асфальтобетон хольцонд орох чулууны ширхэглэлийн хязгаар

Шигшүүрийн хэмжээ, мм	Шигшүүрээр өнгөрөх жингийн хувь	
	Асфальтбетон хольцын төрөл	
	Доод үе	Дээд үе
	А-11	Б-5
25 мм	100	100
19 мм	95 - 100	95 - 100
12.5 мм	70 - 90	75 - 90
9.5 мм	35 - 55	65 - 75
4.75 мм	45 - 65	45 - 65
2.36 мм	20 - 35	35 - 50
0.600мм	11 - 23	18 - 30
0.300мм	5 - 16	10 - 21
0.150мм	4 - 12	6 - 16
0.075мм	2 - 7	4 - 8

Асфальт бетон хольц нь Хүснэгт 10.3-д заасан шаардлагыг хангаж байх ёстой.

Хүснэгт 10.4: Асфальт бетоны физик шинж чанар

Үзүүлэлтүүд	А-11 төрөл	Б-5 төрөл
Маршалын тогтворжилт, (кг.х)	> 900	> 900
Уян чанар (мм)	20 - 40	20 - 40
Хольцын сүвшил (%)	3 - 5	3 - 5
Чулууны сүвшил (%)	15 - 19	14 - 16
60 °С температурт усанд живэлтийн үеийн тогтворжилтын алдагдал	75% -аас доошгүй	75% -аас доошгүй
Битумын хэмжээ,%	5 - 5,5	5.5 - 6.5
Дээжний 2 талаас нягтруулах тоо	50 : 50	75 : 75

Гүйцэтгэгчийн анх санал болгосон жишиг орцын норм дахь барьцалдуулагчийн хэмжээ, ширхэглэлийн хязгаарыг материалын онцлог шинж чанар, лабораторийн шинжилгээний дүн болон талбайн туршилтыг үндэслэн Инженер зөвшөөрвөл өөрчилж болно.

1021. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

(a) Ерөнхий

Энэхүү Техникийн шаардлагын 100-р Бүлгийн дагуу Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гүйцэтгэхэд ашиглах тоног төхөөрөмж болон ажлын аргачлалыг тодорхой боловсруулж Инженерт танилцуулна.

Инженер ямар ч үед Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг үзэж шалгах эрхтэй. Гүйцэтгэгч нь Инженерийг байлцуулан тоног төхөөрөмжийн тохиргоог тогтмол хийж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засч залруулна.

Асфальтобетон хольцыг холих, дэвсэх болон нягтруулахад ашиглах бүх тоног төхөөрөмж нь зохих хүчин чадалтай, ашиглалтын үзүүлэлт сайтай байх ёстой бөгөөд тэдгээрийг ашиглаж болохыг Инженер зөвшөөрсөн байна. Хуучирсан буюу элэгдсэн тоног төхөөрөмжийг ажиллуулахгүй.

(b) Асфальтобетон хольц холих төхөөрөмж

Битумэн материалыг (MNS AASHTO D 290:2004) стандартад тохирох асфальт заводод холих бөгөөд шаардлага хангахуйц тасралтгүй ажиллагааг хангасан үйлдвэрийг талбайд байрлуулсан байна. АБЗавод нь халаасан чулуулаг материал хадгалах 3-аас доошгүй сав, эрдэс нунтгийг хадгалах 1 сав, шаардлагатай тооны битумын агуулах, ажлын тогоотой байна. Бүх савнууд нь чийг орохоос хамгаалсан тагтай байна.

Асфальт үйлдвэр нь давтамжит ажиллагаатай, автомат удирдлагатай, барилгын ажлыг тасралтгүй явуулахад хангалттай хүчин чадалтай, эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон, хольцны найрлагыг энэхүү шаардлагын 1031-р зүйлд тодорхойлсон хүлцэх алдааны дотор байлгахгаар

тохируулга хийх бололцоотой, Инженерээс шаардсан үед асфальтобетоны орц нормын талаарх мэдээллийг хувилан гаргах программтай, шинэ төхөөрөмж байх ёстой. Мөн бэлэн болсон халуун хольцыг хадгалах 100 тн-оос доошгүй багтаамжтай халуун бункерээр тоноглогдсон байна.

Битум хадгалах сав нь байнгын холилт хийх төхөөрөмжөөр тоноглогдсон, битумын ажлын температурыг тогтоосон хэмжээнээс ± 5 градусын хэлбэлзэлтэйгээр байлгах боломжтой. БНД 90/130 битумын температурыг 160°C -аас, полимер битумын хэмийг 170°C -аас дээш гаргахгүйгээр барьж байх термостатаар тоноглогдсон байх бөгөөд термостатыг гадна талаас нь харахад хялбар байхаар суурилуулсан байна. Дээр зааснаас дээш халсан буюу эсвэл удаан халаасны улмаас шатсан, шинж чанар өөрчлөгдсөн битумыг гаргаж, ажлын талбайгаас зайлуулах хэрэгтэй.

(с) Асфальт дэвсэх төхөөрөмж

Асфальт дэвсэгч нь бункер, халаагч бүхий доргиурт брусс, дамжуулагч шнекээр тоноглогдсон өөрөө явагч дэвсэгч байна. Асфальт дэвсэгч нь асфальт хольцыг төвшин, хүлцэх алдааны тогтоосон хэмжээнд гадаргууд ямар нэгэн өө, согог, материалын ялгарал ба бөөгнөрөл гаргахгүйгээр дэвсэх чадвартай байх ёстой. Дэвсэлтийн явцад гадаргуугийн тэгш байдлыг хангах зориулалтын төхөөрөмжөөр (Averaging Beam) тоноглогдсон, бүрэн автомат ажиллагаатай, 9м-ээс доошгүй өргөнөөр дэвсэх хүчин чадалтай байна. Дэвсэгч нь гадаргуун дагуу налуу болон хөндлөн хэвгийг мэдэрч бруссыг тохируулдаг нарийн хяналтын системээр тоноглогдсон байх ёстой. Хяналтын систем нь бруссыг заасан хөндлөн хэвгийгээр $\pm 1\%$ -ийн нарийвчлалтайгаар ажиллуулах чадвартай байна. Дэвсэгч нь автомат хянах системийн зэрэгцээ гар хяналтын системтэй байх ёстой.

(d) Нягтруулах тоног төхөөрөмж

Гүйцэтгэгч асфальт хольцыг шаардлагын хэмжээнд нягтруулж чадахуйц тооны, зөвшөөрөгдсөн төрөл, жинтэй индүүгээр хангаж өгнө. Индүү нь төмөр, хийн дугуйтай болон доргиурт эсвэл эдгээрийн аль нэг нь хосолсон хэлбэрийн өөрөө явагч төхөөрөмж байх бөгөөд буцаж ухрахдаа дэвссэн хольцыг сэндийлж эвддэггүй байна. Асфальтобетон хольцыг дэвсэх ажлыг эхлүүлэхийн өмнө Гүйцэтгэгч тухайн тоног төхөөрөмж нь ажлын шаардлагыг хангаж чадахыг энэхүү Техникийн шаардлагын 200-р Хэсэгт заасны дагуу талбайн туршилтаар үзүүлж, индүүний ажлын дараалал, явалтын тоо болон ажиллагааны хамгийн тохиромжтой аргачлалыг тодорхойлсон байна.

1022. ГАДАРГУУГ БЭЛДЭХ

Битумэн хольцыг дэвсэхийн өмнө гадаргуу дахь бүх сул болон илүүдэл материалыг механик шүүрээр буюу өндөр даралттай хийн цоргиураар эсвэл өөр бусад зөвшөөрөгдсөн аргаар цэвэрлэж зайлуулна.

Гадаргууд илэрсэн аливаа дутагдлыг засаж залруулах ба Инженерээс зөвшөөрөх авах хүртэл битумэн хольцыг дэвсэхгүй.

Хэрэв Инженер өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч битумэн хольцыг дэвсэхээс өмнө битумэн бус суурийн гадаргуу буюу хуучин гадаргууд Техникийн шаардлагын 1200-р Бүлгийн “Б” Дэд бүлэгт заасны дагуу битумэн цацлага, эсвэл түрхлэг хийж өгнө.

Битумэн цацлага, эсвэл түрхлэг хийсэн гадаргуу нь хольц дэвсэхээс өмнө шингэж хатсан байх шаардлагатай. Харин битумэн түрхлэгийг арчлах хугацааг аль болох бага байлгах үүднээс түүнийг асфальт хольц дэвсэхийн өмнөхөн хийх хэрэгтэй.

Битумэн хольц дэвсэхээс өмнө Гүйцэтгэгч битум цацлага буюу түрхлэг хийсэн гадаргуугийн өө сэвийг засч янзлах бөгөөд хэрэв битумэн хольцтой харьцах замын бусад хийцүүд байвал тэдгээрийн гадаргууд битумэн түрхлэг хийж өгнө. Хуучин хучилт буюу суурийн тэгш бус байдлыг засч янзална. Суурийн үед гарсан нүх, хонхойсон буюу овойсон болон бусад гэмтэлтэй хэсгүүдийг цэвэрхэн ухааж авч, шинэ материалаар дүүргэж янзална.

Хуучин гадаргууд битумэн хольц дэвсэхээс өмнө Гүйцэтгэгч гадаргуугийн хөндлөн болон дагуу заадсуудыг зөвшөөрөгдсөн материалаар чигжинэ. Аль ч тохиолдолд дэвсэх ажиллагаагаа эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерээс ажил эхлэх зөвшөөрөл авна.

Хэрэв Гүйцэтгэгчийн ажлын арга барилаас шалтгаалан ажил удааширч, үүний улмаас битумэн хольц дэвсэхээс өмнө урьд хийсэн битумэн цацлага дээр буюу эсвэл хоёр үеийн завсар битумэн түрхлэг хийх шаардлагатай гэж Инженер үзэн зааварчилсан бол уг битумэн түрхлэгийн зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

1023. АСФАЛЬТБЕТОН ХОЛЬЦНЫ ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ

Асфальтобетон нь буталсан чулуу, битум болон эрдэс нунтгийг заасан орцоор хольсон хольцоос бүрдэнэ. Гүйцэтгэгч асфальтобетон хольцны жишиг орцын нормыг тодорхойлж Инженерээр батлуулна. Асфальтобетон хольцын орцын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийлгэж баталгаажуулсан байна.

Буталсан чулууг орцын нормын ширхэглэлийн найрлагад тавигдах шаардлагыг хангасан харьцаагаар ангилж холино.

Жишиг орцын норм нь дараах орц хэмжээг тодорхойлно. Үүнд:

- (a) шигшүүрийн хэмжээ тус бүрээр өнгөрөх чулууны хувь,
- (b) хольцонд хийх битум, эрдэс нунтгийн хувь,
- (c) хольцыг холих үеийн температурын дээд ба доод хязгаар,
- (d) хольцыг дэвсэх үеийн температурын дээд ба доод хязгаар.

Асфальтобетон хольцыг үйлдвэрлэж эхлэхээс 45-с доошгүй хоногийн өмнө Гүйцэтгэгч жишиг орцын норм болон лабораторийн шинжилгээний дүн, дээж, материал тус бүрийн эх үүсвэр болон барьцалдуулагчийн зунгалаг чанар ба температурын харьцаа зэргийг хавсарган Инженерт албан тоотоор хүргүүлнэ. Инженер орцын нормыг шалгаж батлахад шаардлагатай шинжилгээг нэмж хийхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Гүйцэтгэгч битумэн хольц үйлдвэрлэхдээ Зөвхөн Инженерээр батлагдсан жишиг орцын нормыг мөрдлөгө болгоно. Хэрэв Гүйцэтгэгч жишиг орцын нормд өөрчлөлт оруулах буюу материалын төрөл буюу эх үүсвэрийг өөрчлөх саналтай бол энэ тухайгаа Инженерт урьдчилан мэдэгдэж өөрийн саналаа нарийн тайлбарлан холбогдох баримт мэдээллийг хавсарган Инженерт бичгээр танилцуулна. Инженерийн зөвшөөрөл гарахаас нааш Гүйцэтгэгч дээрх өөрчлөлтийг хийж болохгүй.

Хэрэв Инженер Гүйцэтгэгчийн ирүүлсэн жишиг орцын нормыг хангалтгүй гэж үзвэл Гүйцэтгэгч хольц үйлдвэрлэхээсээ өмнө жишиг орцын нормыг дахин тогтоож холбогдох бичиг баримтын хамт Инженерт танилцуулж батлуулна.

Инженер асфальтобетон үйлдвэрийн дэргэд нөөцөлсөн буталсан чулуун материал болон Асфальт заводаас гарсан хольцыг түр хугацаагаар зөвшөөрөх буюу эс зөвшөөрөх эрхтэй.

Асфальтобетоныг талбайд дэвссэний дараа нягтруулахын өмнө хольцноос дээж авч шинжилгээнд оруулан жишиг орцын нормтой нийцэж байгаа эсэхийг шалгана.

Хэрэв жишиг орцын нормын дагуу хольцонд нэмэлт бодис хийхээр бол нэмэлт бодисын эх үүсвэрийг Инженерээр батлуулна. Нэмэлтийн орц хэмжээг Гүйцэтгэгч тодорхойлж Инженер лабораторийн дүн шинжилгээ болон орцын норм тогтоох лабораторийн журмыг үндэслэн батлана. Мөн нэмэлтийн орц хэмжээг үйлдвэрлэлийн явцад талбайн лабораторид шалгаж баталгаажуулна. Нэмэлтийг хольц үйлдвэрлэх явцад нэмэх буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар нэмж холино. Дээр дурьдсан журмыг жишиг орцын нормыг шинэчлэх бүрт мөрдлөгө болгоно.

1024. ТАЛБАЙН ТУРШИЛТУУД

Гүйцэтгэгч төлөвлөсөн машин тоног төхөөрөмжийг ашиглан хучилтын материалыг дэвсэж нягтруулах ба туршилтыг өөрийн төлөвлөсөн аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Туршилтыг Инженертэй зөвшилцөж, түүнийг байлцуулан, Инженерийн тодорхойлсон байршилд хийнэ.

Гүйцэтгэгч нь асфальтбетон хучилтын ажилд өөрийн төлөвлөсөн ажлын аргачлал, ажлын дараалал, машин техник, үйлдвэр, боловсон хүчний үйл ажиллагаа, асфальтбетон хучилтыг шаардлагын хэмжээнд хүртэл дэвсэж нягтруулах болон бусад шаардлагуудыг хангаж буйг үзүүлэх зорилгоор туршилтыг хийнэ.

Туршилтыг 100м-с доошгүй уртад, замын нийт өргөнд, материалын зохих зузаанаар хийнэ. Туршилтын хэсэг Техникийн шаардлага хангаж Инженер баталсан бол байнгын бүтээц хэсэг гэж үзэн хэвээр үлдээх ба харин шаардлага хангаагүй бол хусаж зайлуулна.

Гүйцэтгэгч өөрийн ажлын график төлөвлөгөөндөө талбайн туршилтыг хийх болон зохих шинжилгээ хийх хугацааг харгалзан үзэж тооцоолж оруулсан байна. Гүйцэтгэгч нь туршилтыг тухайн хэсгийн хучилтын үндсэн ажил эхлэхээс 14 хоногийн өмнө хийсэн байна.

Туршилтын хэсэг бүрт үе нэг бүрийг шаардлагын хэмжээнд хүртэл нягтруулж, дараахи мэдээллийг бичиж тэмдэглэнэ. Үүнд:

- a) Материалын бүрэлдэхүүн ба ширхэглэлийн зэрэглэл, битумын агууламж, битумын төрөл ба марк;
- b) Асфальт заводын халуун бункер дахь чулууны чийгийн агууламж,
- c) Холигчид орохоос өмнөх чулуу ба битумын температур, , холигчоос гарах үеийн, дэвсэж эхлэх үеийн, нягтруулж эхлэх үеийн, нягтруулж дуусах үеийн хольцны температур
- d) Индүүний төрөл тус бүрээр булны өргөн, жин, төрөл, дугуйны тоо, дугуйны ачаалал, дугуйны даралт, доргиулалтын давтамж, явалтын тоо
- e) Төлөвлөсөн сүвшил ба хольцны бусад төлөвлөсөн үзүүлэлтүүд лабораторийн туршилтын дүнгийн хамт
- f) Нягт ба сүвшил
- g) Үеийн хүлцэх алдааг тооцсон бүрэн нягтарсан зузаан
- h) Инженерийн шаардсан аливаа бусад холбогдох мэдээлэл;

Гүйцэтгэгч нь Инженерийг байлцуулан туршилтын хэсэгт нягтруулалтын төрөл тус бүрт, 100м тутамд 3-с доошгүй цэгт дээж авч шинжилж үзнэ. Хэрэв 3 дээж бүгдээрээ шаардлага хангасан гарвал туршилтын хэсгийг амжилттай хийгдлээ гэж үзнэ. Туршилтын явцад тэмдэглэгдсэн дээрх мэдээлэл нь цаашид нарийвчилсан шаардлагуудыг боловсруулахад ашиглагдах үндсэн материал болж өгнө.

Хэрэв Барилгын ажлын явцад чанарын хяналтын шинжилгээгээр материал нь шаардлага хангаагүй гэдэг нь тогтоогдвол Гүйцэтгэгч ажлыг зогсоож шалтгааныг тогтооно. Үүнд, материалын шинж чанарын иж бүрэн үзүүлэлтүүдийг тогтоох зорилгоор лабораторийн шинжилгээ болон талбайн туршилт хийнэ. Талбайн туршилтаар тэмдэглэгдсэн өгөгдлүүдийг Инженерээс зөвшөөрөх нь Гүйцэтгэгчийг энэхүү техникийн шаардлагыг хангах аливаа хариуцлагаас нь чөлөөлөхгүй.

1025. АСФАЛЬТОБЕТОН ХОЛЬЦЫГ ХОЛИХ

Асфальтбетон завод нь AASHTO M156 стандартын дагуу дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- (a) Хамгийн бага хүчин чадал 120 т/цаг
- (b) Буталсан чулууг энэхүү Техникийн шаардлагад заасан температурт халаах чадвартай цилиндр хэлбэрийн хатаагчтай,
- (c) Битумыг Инженерээс зөвшөөрөгдсөн саванд зохих температур хүртэл халааж дулааны алдагдлыг хамгийн бага болтол бууруулсан дулаалга бүхий хоолойгоор дамжуулан холигч төхөрөмжид хүргэх,
- (d) Заводын хуурай холилт 10-аас доошгүй секунд, битумтай холилт 30-аас доошгүй секунд үргэлжлэх,
- (e) Ердийн нөхцөлд битумтай холилтын хугацааг 60 секундээс дээш гаргахгүй байх,
- (f) Дүүргэгч материалын орцлолт, холилтын хугацаа болон холигчийг суллах үйл ажиллагааг хянах автомат хяналтын системтэй байх ёстой.

Гүйцэтгэгч битумыг жигд урсах болтол халаах ба хэт халаахаас сэргийлнэ. Халаасан битумын температур 170°C-аас хэтэрч болохгүй. Битумыг 24 цагаас дээш хугацаагаар халуунаар нь хадгалахаар бол битумын температур 90°C –аас хэтэрч болохгүй.

Дүүргэгч чулуулаг материалын холилтын үеийн температур материалын төрөл, шинж чанараас нь хамаарч 155°-165°С-т халаана. Чулуулаг материалтай холих үеийн температур 150°-160°С хооронд байна. Барьцалдуулагч ба чулууны температурын ялгаа хэзээ ч 14 °С-аас хэтрэх ёсгүй.

Гүйцэтгэгч хатаасан чулууг ширхэглэл тус бүрээр тогтоосон орц хэмжээгээр холигчид өгч дараа нь битумыг тогтоосон хэмжээгээр өгнө. Чулуулаг материалыг битумээр жигд бүрэгдтэл нь хольцыг зуурна.

Үйлдвэрээс гарч буй асфальтбетон хольцын температур ихэвчлэн 155 - 160°C байх нь тохиромжтой юм.

Гүйцэтгэгч нь асфальт дэвсэлтийн ажлыг төлөвлөсөн хугацаанд тасралтгүй явуулахад хүрэлцэх тооны тээврийн хэрэгслээр хангах ба асфальтын ажил явагдах цаг агаарын болон бусад тохиромжтой хугацааны туршид хуваарилагдсан машинуудыг өөр зориулалтаар ашиглахгүй.

Тээвэрлэх явцад асфальт хольцийг бохирдох, ширхэглэлийн ялгаралт гарахаас сэргийлэх ба асфальтбетон хольц тээвэрлэх үед самосволын тэвшийг халаагчаар тоноглон байх шаардлагатай. Ачаа бүрийг сайтар бэхэлсэн зотон даавуун буюу ижил төстэй дулаан алдуулахгүй эсгий бүтээлгээр бүтээж тээвэрлэх ба бүтээлэг нь тэвшний тал бүр лүү давж унжиж байхаар хэмжээтэй байна. Бүтээлгийг тээвэрлэлтийн явцад дэрвэж хийсэх, салж унахааргүйгээр сайтар бэхэлсэн байх ёстой. Хэрэв бүтээлэг урагдсан, цоорсон байвал нэн даруй солих шаардлагатай. Бүтээлэг нь хольцыг цаг агаарын нөлөөллөөс хамгаалж, тээвэрлэх үед болон хольцыг дэвсэгч рүү буулгаж байх үед тоос, шороо, хог орохоос сэргийлэх зориулалтай байна. Зохих ёсоор бүтээгээгүй хольцыг хэрэглэж болохгүй. Мөн асфальт хольц тээвэрлэх машинуудын тэвшний ёроол цэвэрхэн, гөлгөр байхаас гадна газрын тос, уусгагч болон хольцод муугаар нөлөөлөх бусад материалаар бохирдоогүй байна. Хольцыг тэвшний ёроолд наалдахаас сэргийлэх үүднээс Инженерийн зөвшөөрсөн тусгай бодис түрхэж болно.

Гүйцэтгэгч жишиг орцын нормд нийцсэн халуун хольц нийлүүлэх хариуцлага хүлээнэ.

1026. ХОЛЬЦЫГ ДЭВСЭХ

Гадаргууг бэлдэж дуусан зөвшөөрөл авмагц хольцыг тогтоосон чиг, төвшинд материалын ялгарал, бөөгнөрөл гаргалгүйгээр дэвсэгч тоног төхөөрөмжөөр дэвсэнэ. Хучилтын тавих чиг, хольцны дэвсэлтийн төвшинг зориулалтын дуран ашиглан замын тэнхлэгээс 2 тийш хэмжиж тавина. Харин дэвсэлтийн төвшинг тааруулан тавьж, утас татахдаа энгийн шугам г.м гар багаж буюу нарийвчлал багатай багаж ашиглахыг хориглоно.

Инженер өөрөөр зааварчлаагүй бол хольцийг явах ангийн өргөнөөр дэвсэнэ. Асфальт бетоны нягтрсан үеийн зузаан нь Техникийн шаардлагын 300- Бүлэгт заасан шаардлагыг хангасан байна. Гэхдээ хучилтын нягтарсан зузаан нь чулуулгийн хамгийн том хэмжээнээс наад зах нь 1,5 дахин их байна.

Өөрөө явагч асфальт дэвсэгчээр хольцыг дэвсэнэ. Дэвсэгч нь асфальт хольцыг Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан зузаан, төвшин, налуутайгаар дэвсэнэ. Дэвсэлтийн ажил эхлэхээс өмнө дэвсэгчийн бруссыг халааж, бункер болон хольц дамжуулах хусуурыг цэвэрлэсэн, доргиулагчийн ажиллагааг шалгаж бэлтгэсэн байна. Дэвсэгчийн ул брус нь зохих хэмжээнд халаагүй, мөн доргиулагч нь ажиллахгүй байгаа дэвсэгчийг ашиглахыг хориглоно.

Хольцыг жигд хурдаар явж, температурын горимыг баримтлан тасралтгүй дэвсэнэ. Хэрэв дэвсэлтийн явцад аль нэг хэсэгт зузаан, налуу алдагдах, нүх хонхор үүсэх, дэвсэн гадаргуу арзгар болох, брус сайн халаагүйгээс мөр үүсэх зэрэг дутагдал гарвал дэвсэлтийг нэн даруй зогсоож, гарсан алдааг Инженерийн шаардлагад нийцэхээр бүрэн засварлана. Инженер зөвшөөрсөний дараа дэвсэлтийг үргэлжлүүлнэ. Гүйцэтгэгч асфальтбетоны ажлыг бүхэлд нь хариуцсан чадварлаг мэргэжилтэнг томилон ажиллуулах бөгөөд тэр нь дэвсэлт, нягтруулалтын болон заводын үйл ажиллагааг хооронд нь нягт уялдуулан зохион байгуулах ёстой. Дэвсэлтийг хийхдээ дэвсэгчийг ойр ойрхон зогсоохгүйгээр жигд явуулах ба хучилтын хөндлөн залгаасыг аль болох цөөн гаргахаар ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Хэрэв дэвсэгчийн автомат хянах систем эвдрэх эсвэл буруу ажиллах тохиолдолд ажлын ердийн өдрийн үлдсэн хугацаанд гараар удирдаж ажиллуулж болно.

Хэрэв Гүйцэтгэгч гадаргуун тэгш байдал болон налуууг шаардлагын хэмжээнд хүртэл гаргаж чадаагүй бол Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл гадаргууг дахин засварлаж, тоног төхөөрөмжийг засварлах буюу өөр тоног төхөөрөмжөөр солих арга хэмжээ автал хучилтын ажлыг түр зогсооно. Хольцыг дэвсэх явцад чанарын шаардлага хангаагүй (шатсан, битум ихэдсэн, дутуу холигдсон, бага температуртай г.м) хольц ирвэл дэвсэгчид хүлээн авахгүйгээр талбайгаас шууд зайлуулж хаяна.

Дэвсэгчийг ашиглах боломжгүй жижиг талбайд хольцыг гараар дэвсэхийг зөвшөөрнө. Гэхдээ гараар хийсэн дэвсэлтийн чанарыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах ба хэрэв ямар нэгэн ажил шаардлагад нийцээгүй бол түүнийг зайлуулж, оронд нь шинээр хийхийг Инженер зааварчилж болно. Дахин хийсэн ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Өгсүүр хэсэгт дэвсэлт хийх үед хучилтын доогуур ус орохоос хамгаалсан арга хэмжээ авна.

1027. ХОЛЬЦЫГ НЯГТРУУЛАХ

Асфальт хольцыг дэвсээний дараа нэн даруй сайтар жигд индүүдэж нягтруулна. Хольцыг индүүдэж эхлэх үеийн хольцны температур 130°C-аас багагүй байна. Дэвсэлт болон нягтруулалтыг хийдээ техникийн шаардлагыг мөрдлөгө болгон ажиллах ба 90°C-аас багагүй температуртай байхад нягтруулалтын ажлыг дуусгах шаардлагатай.

Индүүний төрөл, жин, тоо ширхэг нь хольцыг тохиромжтой температуртай үед нь нягтруулахад шаардлагатай нягт авахад бүрэн хангалттай байх ёстой. Ашиглах тоног төхөөрөмж болон нягтруулах ажилбарын дараалал болон явалтын тоог Гүйцэтгэгч талбайн туршилтаар баталж үзүүлэн, Инженерээр зөвшөөрүүлсэн байх ёстой. Дор дурьдсан ерөнхий зарчимд заасанчлан үеийг шаардлагатай нягт авах хүртэл индүүднэ.

Нягтруулах ажил эхлэхээс өмнө ажиллах индүүнүүдийн түлшний системийг сайтар шалгаж, хэрэв түлш дусах юмуу гоожиж байвал засаж янзалсан байна. Мөн булны услалтын системийг шалгаж тохируулсан байх хэрэгтэй.

Эхний нягтруулалтыг 6-8тн жинтэй, ган бултай доргиурт индүүгээр дэвсэгч машины араас аль болох ойр зайд дагаж хийнэ. Дэвсэлтийн чиглэлд эхлээд хийх явалт бүрт доргиулагчийг ажиллуулахгүй, харин буцах явалт бүрийг доргиулагчтай хийнэ.

Дараагийн шатанд 12-16тн жинтэй хийн дугуйт индүүгээр нягтруулалтыг хийж сүүлчийн нягтруулалтыг хүнд жинтэй 3 булт индүүгээр индүүдэж түрүүчийн индүүний мөрийг дарна. Бүх индүү нь араараа ухарч ажиллах бөгөөд (өөрөөр хэлбэл индүүний хөтлөгч дугуй буюу бул нь дэвсэгчийн талд байрлалтай байна) цагт 5 км-ээс илүүгүй жигд хурдаар ажиллана.

Нягтруулалтыг хучилтын гадаад ирмэгээс эхэлж тэнхлэгийн шугам руу чиглэсэн байдлаар, индүүний явалт бүр урьд явсан мөрний хагасыг дарах маягаар хийнэ. Эргэцтэй хэсэгт хэвгийн нам талаас өндөр тал руу чиглэсэн байдлаар гүйцэтгэнэ. Индүүний хөдөлгөөний чиглэл нь замын тэнхлэгтэй аль болох паралель байхаар нягтруулалтыг хийх ба ялангуяа нэг, хоёрдугаар индүүдлэгийн үед огцом эргэж хажуу тийш шилжих, ташуу байдлаар явахыг хоиглоно.

Хучилтын захыг индүүдэх явцад индүүний дугуй дэвсэлтийн ирмэгээс 50-100 мм илүү гарч байх ёстой.

Нягтралаа бүрэн аваагүй хучилт дээр индүү болон бусад техник зогсоож болохгүй, хэрэв ажлын явцад индүү эвдрэх буюу өөр шалтгаанаар зогсох бол түүнийг нягтарсан хэсэгт эсвэл талбайн

гадна яаралтай гаргах арга хэмжээ авна. Нягтруулалт хийж буй индүүнүүд түр зогсохоор бол урьд нь нягтарсан хэсэгт шилжиж зогсоно.

Асфальтобетон хучилтын нягтыг Төслийн Чанарын хяналтын төлөвлөгөөнд заасан давтамжаар, үеийн нийт зузаанаар авсан хос дээжийн дундаж нягтаас тооцон гаргана. Ингэхдээ асфальтобетоны ажил хийгдсэн өдөр тутамд 1-ээс доошгүй хос дээж авна.

Асфальтобетон хучилтын нягт нь заасан нягттай ижил буюу түүнээс их байх ба дараалсан 10 туршилтаас 2-с илүүгүй тохиолдолд нягт нь заасан нягтаас 2-оос дээш хувиар доогуур байж болно.

Нягтруулсан үеийн хамгийн бага, шаардагдах нягтрал нь батлагдсан орцын нормын дагуу нягтруулсан. Маршаллын загварын нягтралын 98%-тай тэнцэх ёстой. Нягтралын хэмжээ нь тогтоосон стандартад хэмжээнд хүрээгүй гадаргууг дахин нягтруулж нягтралыг нь дараачийн өрөмдлөгөөр тодорхойлно.

Нягтруулсан үеийн дундаж нягт нь хамгийн бага шаардагдах нягтаас 1%-иас бага байгаа тохиолдолд хучилгыг Гүйцэтгэгч хуулах эсвэл шаардлага хангасан хольцыг хучилтын нийт өргөнд дахин дэвсэж нягтруулна. Хучилтын аль ч хэсэг дээр машин тоног төхөөрөмжийг түлшээр цэнэглэхийг хориглоно. Нягтруулалтын явцад огцом эргэхийг хориглоно.

Хольц наалдахаас сэргийлж индүүнүүд дүүрэн ус бүхий усны зориулалтын савтай байх бөгөөд булыг усаар бага зэрэг норгох тохиргоотой байна. Харин полимер битум хэрэглэж буй тохиолдолд усанд савангийн уусмалыг Инженерийн зөвшөөрсөн хэмжээгээр хийж болно. Ямар ч нөхцөлд дизель түлш, бензин хэрэглэхийг хориглоно. Индүү ажиллах боломжгүй хэт бага талбайд доргилтот нягтруулагч ашиглаж болно.

1028 ӨНГӨЛГӨӨ, ИРМЭГ БА ЗААДАС

Аливаа хольц хагарах, хог шороотой холилдож суларч гарах тохиолдолд түүнийг ухан авч шинэ халуун хольцоор дүүргэн эргэн тойрны гадаргуутай ижил хэмжээнд нягтруулна.

Өмнө нь хийгдсэн хучилттай залгаж дараагийн хэсгийг дэвсэхдээ урьд дэвссэн үеийг нийт өргөн ба гүнд нь шулуун шугамаар зүсэгч машин ашиглан хөндлөн зүснэ. Гар багаж (лоом, сүх г.м) ашиглаж болохгүй. Зүсэлт хийсэн босоо нүүрийг хийн халаагуураар халааж 130/200 маркийн халуун битум түрхэх ба үүний дараа нэн даруй шинэ хольцоо залгаж дэвсэнэ. Дэвсэлтийг эхлэхдээ дэвсэгчийн өнгөлөх хавтан нь зүсэлтийн шугамнаас хойш 20-30см илүү гарсан байхаар дэвсэгчийг байрлуулна.

Дэвсэгчийг явуулж эхлэхээс өмнө шнекээр татагдаж ирсэн халуун хольцыг залгаасны хэсгийн хуучин хучилт дээр 5-10 минут орчим байлгаад үүний дараа дэвсэгчийг ажиллуулна. Залгаасны хэсэгт дэвсэгч явж өнгөрмөгц овон товон дэвсэгдсэн хольцыг малтуураар жигд хусч аваад залгаасан дээрээ нарийн ширхэглэлтэй хольц цацаж гараа маш нямбай тэгшлэнэ. Тэгшилгээ сайн болсон гэж үзвэл индүүдлэгийг шууд эхлэнэ.

Залгаасны өнгөлгөөг гадаргууд тавигдах шаардлагын дагуу хучилтын бусад хэсэг дэх нягтрал, бүтэц, өнгөлгөө зэрэгтэй ижил байхаар хийж гүйцэтгэнэ.

Хэрэв дэвсэлтийн явцад гадаргууд чулууны ялгарал үүсч барзгар болсон бол халуун хольцноос авч нарийн нүхтэй шүүрээр тухайн хэсэг дээр шигшээд дараа нь модон малтуураар хөнгөн гүйлгэж сайтар тэгшлээд индүүднэ.

1029. АСФАЛЬТОБЕТОНООС ДЭЭЖ АВАХ БА ШИНЖЛЭХ

Гүйцэтгэгч нь MNS AASHTO T168:2003 (Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн асфальтобетон хольцоос дээж авах) стандарт, бүлэг 209(Д)-д заасан давтамжаар дээж авч, туршилтыг явуулна.

1030. ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭНҮҮД

Битумэн хольцыг холих ба дэвсэх үед Гүйцэтгэгч түүний Төслийн чанарын хяналтын төлөвлөгөө болон Техникийн шаардлагын Хэсэг 200, Зүйл 1229-ын дагуу хольц болон түүний бүрэлдэхүүн материалуудаас дээж авч шинжилж байх ёстой. Хэрвээ шинжилгээний үр дүн материалын шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч материал болон ажлын журамд оруулах шаардлагатай өөрчлөлтийг хийхээс өмнө Инженерийн зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хэрвээ хольц болон материалын 10 амжилттай шинжилгээ тутамд хоёроос дээш тооны шинжилгээний хариу нь Шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч шалтгааныг нь олж тогтоож залруултал хольц дэвсэхийг даруй зогсооно. Гүйцэтгэгч шаардлага хангахгүй байгаа бүх материалыг өөрийн зардлаар буцаан авч шаардлага хангах материалаар хучилтын нийт өргөнөөр солино.

1031. ХҮЛЦЭХ АЛДАА

Гүйцэтгэгч хучилтыг Техникийн шаардлагын 300-р бүлэгт заасан геометр хүлцэх алдааны хүрээнд барина. Гүйцэтгэгч хольцын найрлагыг жишиг орцын норм болон талбайн туршилтуудаар тодорхойлсоны дагуу Хүснэгт 10-5-д үзүүлсэн хүлцэх алдааны хүрээнд байлгана.

Хүснэгт 10-5: Асфальтобетон хольцны хүлцэх алдаа

<i>Бүрэлдэхүүн хэсэг</i>	<i>Хүлцэх алдаа</i>
<i>Битумын агуулга</i>	Хольцны нийт жингийн $\pm 0.3\%$
<i>4.75 мм ба түүнээс том шигшүүрээр өнгөрөх хувь</i>	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 6\%$
<i>2.36 - 0.15 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь</i>	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 4\%$
<i>0,075 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь</i>	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 2\%$
<i>Хольцны температур</i>	$\pm 10\text{ }^{\circ}\text{C}$

Нэг удаагийн шинжилгээгээр гарсан битумын агууламжийг хольцийн нийт жингээр үржүүлж тооцсон, аливаа үеийн нийт уртад орох битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой. Хольцын жинг шалгаж тодорхойлсон өдөр тутам үйлдвэрлэсэн хольцын битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой.

1000 м урт хэсэгт хоорондоо ижил зайтай 6 цэгт хэмжсэн асфальтобетон хучилтын өргөн зурагт заасан өргөнөөс бага байж болохгүй. Аль ч цэгт замын тэнхлэгээс хучилтын гадаргуугийн ирмэг хүртэл зай заасан зайнаас 10 мм-ээс илүү нарийссан байж болохгүй

1032. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР – ДЭД БҮЛЭГ “В”

(а) Ажлын нэр: Асфальтобетон хучилт

Хэмжих нэгж: м³

Асфальт бетон хучилтыг нягтруулсан үеийн хэмжих нэгж м³ байна. Асфальт бетон хучилтын ажлын эзэлхүүнийг Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсаны дагуу нягтруулсан үеийн хөндлөн огтлолын талбайг замын тэнхлэгийн дагуу Инженерийн зааварчилсаны дагуу хэмжсэн уртаар үржүүлж гаргана. Асфальтобетон хучилтын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Барьцалдуулагч болон буталсан чулууг бэлдэх, халаах, холих,
- Эрдэс нунтаг бэлдэх, холих,
- Шаардлагатай бол нэмэлт бодис бэлдэх, холих,
- Чулуу болон эрдэс нунтагийн хэмжээг өөрчлөх,
- Нэмэлт бодисын хэмжээг өөрчлөх,
- Гадаргууг бэлдэх,
- Эгц налуу газар ажиллах,
- Тээвэрлэх,
- Халаасан хольцыг нягтруулсан үеийн зузааныг хангахаар дэвсэх,
- Индүүдэх,
- Гадаргууг шаардагдах хэмжээнд хүртэл засах,
- Энэхүү техникийн шаардлагын 1200-р бүлгийн “А”, “В” дэд бүлгийн шаардлагад нийцүүлэх.
- Асфальтобетон хучилтын ажлын нэгж үнэлгээнд мөн дараах ажлууд багтана. Үүнд:
- Чулуу бутлах ба шигших тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах,
- нөөц газрыг ашиглах,
- газрын зөвшөөрөл авах, холбогдох татвар төлбөрийг хийх,
- ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийх,
- энэхүү Техникийн шаардлагын 100, 200, 300 ба бүлгүүдийн шаардлагад нийцүүлэх,

БҮЛЭГ 1100 – ХӨВӨӨ

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

БҮЛЭГ 1100 – ХӨВӨӨ

1101. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
1102. ХӨВӨӨНИЙ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА	2
1103. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	4

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

1101. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хөвөөг дараахь 2 төрлөөр хийнэ. Үүнд :

- **Хайрган хөвөө**

Хайрган хөвөөг зохист ширхэглэлтэй материал буюу ердийн хайрга, эсвэл буталсан чулуугаар баяжуулан хийнэ.

Хайрган хөвөө гэдэг нь дээрх материалыг дангаар нь буюу тэдгээрийн хольцыг хэрэглэн, зөвшөөрөгдсөн суурийн доод үе дээр суурийн хоёр захыг хамгаалах зориулалтаар, зурагт үзүүлсэний дагуу хийсэн зохист ширхэглэлтэй өнгөн үе юм.

Энэ бүлэгт хайрган хөвөөний материалын шаардлага, барих, нягтруулах, хэмжилтийн ажлууд багтана.

1102. ХӨВӨӨНИЙ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

Хөвөөнд хэрэглэх материал нь дараах шаардлагуудыг хангаж байх ёстой. Үүнд:

- Материалын хуурай үеийн хамгийн их нягтшил (MDD) 98%-аас багагүй байх ба 4 хоног усанд сойсны дараах CBR үзүүлэлт 20%-с багагүй
- Хөөлт (CBR-ийн туршилтын сойлтын үед) 1 %-иас ихгүй
- Уян налархайн индекс 6%-аас ихгүй
- Урсалтын хязгаар нь 25%-иас ихгүй
- Уян харимхайн үзүүлэлт нь 90-ээс ихгүй
- Хайрга болон дайрган хөвөөний материал нь дараах 3 төрлийн хөвөөний материалын аль нэгийг хангаж байна. Хайрган хөвөөний материалын ширхэглэлийн шаардлагыг (Хүснэгт 11-1)-т үзүүлэв

Хүснэгт 11-1 Хайрга дайрган хөвөөний чулуун материалд тавигдах
техникийн шаардлага

Шигшүүрийн хэмжээ, мм	Бүрэн өнгөрөлт, жингийн хувиар		
	Зэрэглэл		
	A/A	B/B	B/C
37,5	100	-	100
19,0	95-100	100	75-95
9,5	60-90	80-100	40-75
4,75	40-70	60-75	30-60
2,36	25-50	35-55	20-45
0,425	15-35	18-27	15-30
0,075	5-20	10-15	5-12

***Тухайн орон нутгийн материалын шинж чанараас хамаарч туршилтын үр дүнгээр тогтоогдсон тохиолдолд хольцын төрөл, ширхэглэлийн хязгаарыг тухайн материалд тохируулан хэрэглэнэ*

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Хүснэгт 11-2 Хайрган хөвөөнд тавигдах үндсэн шаардлага

№	Шалгах үзүүлэлт		Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Нягтралын зэрэг (%)		98-аас их	200м тутамд 2-оос багагүй хэсгийг шалгана
2	Тэгш байдал (мм)	хучлагагүй	20	3м рейк : 200м тутамд 4 шугамаар 2 хэсгийг хэмжинэ
		хучлагтай	12	
3	Хөндлөн хэвгий (%)		±0.40	Налуу хэмжигч: 200м тутамд 2 цэг авч хэмжинэ
4	Гадаргуугийн түвшин (мм)		±15	Нивлер: 20м тутамд хэмжинэ
5	Өргөн (мм)		Зурагт зааснаас багагүй ба +300 мм-ээс ихгүй	Хуваарьт уртын хэмжүүр: 200м тутамд 4 цэг авч хэмжинэ

Хайрган хөвөөний ажилд ашиглах тоног төхөөрөмж, тэдгээрийн ажлын аргачлалыг Инженерийн зааварчилсны дагуу талбайд туршилт хийж сонгох ба тогтооно. Гүйцэтгэгч нь хайрган хөвөөг хийхдээ аливаа үеийн гадаргуугийн усыг байнга гадагшлуулж байх нөхцөлийг хангасан аргачлалыг сонгож ажиллана.

Хайрган материалыг хөвөөний нийт өргөнөөр, хангалттай хэмжээгээр жигд тарааж, нягтруулсны дараах зузаан нь Инженерийн зааварчилсан хэмжээтэй байхаар дэвсэнэ.

Дэвссэн материалд том чулуу болон хар шороо орсон байвал зайлуулах ба хэрэв тэр нь их хэмжээтэй байх буюу шаардлага хангахгүй материал ихээр холилдсон бол хайрган материалыг нийтэд нь талбайгаас гаргаж зайлуулна. Хайрган материалыг ачих, тээвэрлэх, буулгах, тарааж дэвсэх, нягтруулах явцад хайрга ширхэглэлээрээ ялгарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Нэг удаагийн ажиллагаагаар дэвсэж, нягтруулсан аливаа үеийн зузаан нь 200мм-ээс илүүгүй байна. Нягтруулсан үеийн зузаан үүнээс их байх шаардлагатай хэсэгт материалыг хоёр буюу түүнээс дээш үеэр дэвсэж боловсруулна. Нягтруулсан үеийн хамгийн бага зузаан нь 100 мм байна. Хайрганы чийгийн агууламж нь тохиромжтой чийгийн агууламжаас (MNS AASHTO T180-93) 1%-иар их буюу 2%-иар бага байж болно. Үүний тулд материалыг нэгэн жигд усалж холих буюу эсвэл хатаах замаар чийгийг тохируулах хэрэгтэй. Хайрган материалыг заасан өргөнд хүргэж, хөндлөнгийн налууг гаргаж тэгшилнэ. Орчны температур 0⁰ С-оос доош орсон үед хөвөөг ямар нэг хэмжээгээр усалж, чийглэхийг хориглоно.

Эцсийн хэлбэржүүлэлт хийж тэгшилсний дараа хөвөөг ХҮХИ нягтын 98%-с доошгүй байхаар нягтруулна. Гүйцэтгэгч материалыг тараах, тэгшлэх, нягтруулах үед шаардлагатай чийгшилтэй байлгах үүднээс ус шүрших буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар тогтоосон чийгшлийн агууламжийг хангалттай хэмжээнд барина. Нягтруулалт хийж дууссаны дараа гадаргуу нь сайн нягтарсан, элдэв ан цав, хагаралгүй, индүүдлэгийн улмаас гулсалт, долгион

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

үүсээгүй, чулууны ялгарал гараагүй байх ёстой.

1103. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Зүйл: Хайрган хөвөө

Хэмжих нэгж: м3

Хайрган хөвөөний ажлыг суурийн доод үе дээр дэвсэж нягтруулсан шоо метрээр хэмжинэ. Ажлын тоо хэмжээг гаргахдаа хөвөөний өргөнийг нягтруулсан зузаан ба уртаар үржүүлнэ. Хайрган хөвөөний нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Материалын сонголт хийж, орд газрыг тогтоох, хөрс хуулах
- Орд газар, хуулсан өнгөн хөрс, бусад хаягдлыг зайлуулах
- Хэрэглэхэд тохиромжтой материалыг орд газраас ухаж гаргах, бутлах, шигших, угаах ба холих, том хэмжээтэй материалыг зайлуулах,
- Материалыг ачих, тээвэрлэж буулгах, тараах
- Овор хэмжээ томтой материалыг шигшиж, зайлуулах,
- Материалыг хатаах, услах замаар чийгшлийг тохируулах,
- Зохих хөндлөн хэвгийг аргах,
- Хөвөөний материалыг 150 мм-ийн зузаан үеэр нягтруулах
- Барилгын ажил дууссаны дараа орд газрыг буцааж булах, нөхөн сэргээх

**БҮЛЭГ 1200 – ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ
БАЙГУУЛАМЖ**

БҮЛЭГ 1200 – ХООЛОЙ БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

1201. БҮЛГИЙН АГУУЛГА.....	2
1202. АЖЛЫН ДЭС ДАРААЛАЛ.....	2
1203. НҮХ УХАХ АЖЛЫН АНГИЛАЛ.....	3
1204. ХООЛОЙН БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН НҮХ УХАХ.....	3
1205. ХАТУУ МАТЕРИАЛД НҮХ УХАХ.....	4
1206. УХСАН НҮХИЙГ ХУУРАЙ БАЙЛГАХ.....	4
1207. ДӨРВӨЛЖИН ТӨМӨР БЕТОН ХООЛОЙ.....	4
1208. ХООЛОЙН СУУРЬ ЦУТГАХ.....	5
1209. БЕТОН ХООЛОЙН ЦАГИРГУУДЫГ УГСРАХ БА ХОЛБОХ.....	5
1210. БЕТОН БӨГЖ БА ЗУЗААЛАХ ХЭСЭГ.....	6
1211. БУЦААН ДҮҮРГЭХ.....	6
1212. ШҮҮРҮҮЛЭХ ҮЕ.....	7
1213. ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛАМЖУУД.....	7
1214. УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН ЖИЖИГ ХИЙЦҮҮД.....	8
1215. ШУУДУУ, ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ БА РИСБЕРМ.....	8
1216. ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ /ЗУУРМАГТАЙ ЧУЛУУН ДОТОРЛОГОО/.....	8
1217. УС ТУСГААРЛАГЧ ҮЕ.....	9
1218. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	10

1201. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэг дор дурдсан зүйлсийг хамаарна. Үүнд:

Дугуй болон дөрвөлжин төмөр бетон хоолойнуудыг угсрах;

Хоолойны орох, гарах амсрын хийцүүд, ус цуглуулах худаг, усны урсгалын хурд сааруулах болон эдгээртэй төстэй байгууламжуудыг барих; Угаagdлаас хамгаалах тулц ханыг хийх;

Дор дурдсан байгууламжийн ухмал, өндөрлөгөө ба бусад ажлууд:

1. Дугуй хоолой байрлуулах суурийн нүх
2. Орох амсрын шуудуу
3. Гарах амсрын шуудуу
4. Уулын шуудуу
5. Замын хажуугийн шуудуу
6. Хөрсний ус шүүрүүлэх
7. Ус цуглуулах худаг
8. Тулц хана
9. Жижиг байгууламжууд

Хажуугийн шуудууны барилгын ажилд тавигдах шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 1215-д оруулсан болно. Ус зайлуулах байгууламжийн барилгын ажил, чулуун бэхэлгээтэй хажуу налуугийн хамгаалалтын ажлуудад тавигдах шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 1215-д оруулсан. Төмөр бетон дугуй хоолойны барилгын ажилд тавих шаардлагыг энэ техникийн шаардлагын бүлэг 1207 ба 1209 –д оруулсан.

1202. АЖЛЫН ДЭС ДАРААЛАЛ

Ажлын зургуудад хоолой бүрийн байршил, хэмжээний талаар заасан байдаг. Хоолойн налуу, орох гарах амсар, толгойны өндрийн төвшингийн ажлын зургийг Гүйцэтгэгч гаргаж, Инженер-т ирүүлж баталгаажуулна. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 300-д нийцүүлэн дагуу огтлол, хөндлөн огтлол болон бусад мэдээллийг ирүүлэхээс өмнө, байгаа бүх хоолойг цэвэрлэж, тэдгээрийн орох ба гарах амсрыг сэргээж, ус чөлөөтэй нэвтрэх боломжтой болгоно. Гүйцэтгэгч нь гэрээний заалтын дагуу танилцуулах ажлын хөтөлбөртөө дээр дурдсан мэдээллийг ирүүлэх ба хоолойн нарийвчилсан мэдээллийг бэлтгэх ажлын хугацааг тооцсон байна. Бүх хоолой ба ус зайлуулах байгууламжийн барилгын ажлыг сайтар төлөвлөсөн байна. Гүйцэтгэгч нь Инженер өөрөөр заагаагүй бол гэрээний заалтын дагуу эдгээр байгууламжийн дээр буюу хоёр талд далан барихаас өмнө бүх хоолой ба ус зайлуулах байгууламжийн ажлыг дуусгахаар ажлынхаа хөтөлбөрт тусгасан байх ёстой. Хэрэв Гүйцэтгэгч далан, дугуй хоолой ба ус залах байгууламжийг далангийн ажил эхлэхээс өмнө барьж дуусгах шаардлагагүй гэж үзвэл ажлын ердийн дарааллыг өөрчлөх хүсэлтийг бичгээр Инженерт гаргана.

Дор дурдсан нөхцөлд Инженер энэ хүсэлтийг зөвшөөрч болно. Үүнд:

- Гүйцэтгэгч нь хоолой болон даланд эвдрэл гарах эсвэл эдгээрийг барих ажил хойшлогдвол хариуцлага хүлээнэ.
- Гүйцэтгэгч далангийн ажил дуусангуут хоолойн барилгын ажлыг яаралтай эхэлнэ.

Ухмалтай хэсгийн замын далан доор хоолой барих газарт ухмал ба буцаан дүүргэлтийн газар шорооны ажлын ихэнх хэсэг дууссаны дараа, гэхдээ ухмал дахь далангийн гадаргуугаас доош 300 мм үеийг хийхийн өмнө гүйцэтгэнэ. Хэрвээ гүйцэтгэгч ажлын энэ дарааллыг

өөрчлөхийг хүсвэл Инженер-т энэ тухай хүсэлтийг бичгээр гаргана. Хоолойн ухмалын төлбөрийг далангийн түвшнээс доош ухсан хэмжээгээр хийх нөхцөлд газар шорооны ажлыг дуусахаас өмнө эдгээр хоолойн ухмалын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийн хүсэлтийг Инженер зөвшөөрч болно.

1203. НҮХ УХАХ АЖЛЫН АНГИЛАЛ

Хоолой ба ус зайлуулах байгууламжийн нүх ухах ажлыг дараах ангилалд хуваана. Үүнд:

а/ Хатуу материалын ухмал гэдэгт зөвхөн тэсэлгээний аргаар, эсвэл чулуу бутлагч хошуу бүхий механик бутлагч тоног төхөөрөмж ашиглан ухаж, боловсруулах ажил багтана. Том чулууны хэмжээ нь 0.20 м³-ээс их байвал хатуу материалын ухмалд багтана.

б/ Хатуу материалын ухмалаас бусад дахин ашиглагдах ба ашиглагдахгүй материалын ухмалыг ердийн ухмалд хамааруулна.

1204. ХООЛОЙН БА УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН НҮХ УХАХ

Гүйцэтгэгч нь хоолой ба ус зайлуулах байгууламжийн нүхийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан байрлал, төвшин, налуу хэмжээг баримтлан хийж гүйцэтгэнэ. Хэрэв Гүйцэтгэгч тодорхойлсон хэмжээнээс илүү гүн ба өргөнд ухсан бол өөрийн зардлаар зөвшөөрөгдсөн материалыг ашиглан зохих төвшин болон хэмжээнд хүргэж дүүргэх ба Инженерийн баталсны дагуу зэргэлдээ хөрсний нягтралын хэмжээнд хүртэл нягтруулна.

Гүйцэтгэгч нь ухаж гаргасан шорооноос ашиглах боломжтойг нь ялгаж, дүүргэх материалд нөөцөлж хадгална. Хэрэв Гүйцэтгэгчийн ухсан нүхний шороо нь дахин ашиглахад тохиромжгүй гэж үзвэл Инженерийн зөвшөөрлийн дагуу ашиглагдахгүй материалын талбайд шилжүүлнэ. Гүйцэтгэгч ухсан нүхийг цэвэр байлгах ба ус орохоос хамгаалж ус зайлуулах суваг ухах, усны хаалт барих, насосоор соруулах эсвэл нүхийг усгүйжүүлэх ажлыг хийнэ.

Инженер нь Гүйцэтгэгчийн ажлын арга барилаас шалтгаалан ухмалын ёроолын гадаргуу нь сул, зөөлөн буюу тохиромжгүй болсон гэж үзвэл Гүйцэтгэгчийн зардлаар тохирохгүй материалыг зайлуулж, Инженерийн зааврын дагуу зөвшөөрөгдсөн ширхэглэлтэй материалаар, эсвэл бүтээцийн бус бетоноор солино.

Гүйцэтгэгч нь бэлэн болсон нүхний ёроолыг AASHTO T99 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулсны дараа 150 мм-ийн зузаантай дэвсгэр материалыг дэвсэнэ.

Өндөржилтийн хувьд ойролцоогоор, одоо байгаа газрын хөрсөн дээр баригдах хоолойн тухайд бол Гүйцэтгэгч нь өнгөн хөрсийг хуулсны дараа газрын хөрсийг үечилж ухах буюу өндөрлөж тэгшилнэ. Ул суурийг сайн тэгшлэх ба хоолойн нийт уртад жигд нягтралтай байна. Дэвсгэр материалын доорх ул суурийг 150 мм-т AASHTO T99-94 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна.

Дэвсгэр материалыг дэвсэхээс өмнө Инженерээс ул хөрсний талаарх зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хоолой ба бусад байгууламжийг барих нүхийг бэхэлгээтэй ухах ёстой бөгөөд хоолойг угсрах, суурь бетон цутгах нүхийг буцааж дүүргэх болон нягтруулах ажлыг хийж гүйцэтгэхэд боломжийн хэмжээтэй байхаар ухна. Инженерийн зааварласан газарт нүхний бэхэлгээний шон ба хашилтыг үлдээж орхино. Хангалттай хэмжээнд хүртэл боловсруулах боломжгүй нөхцөл бүхий хөрсийг Инженерийн зааврын дагуу тохирох материал гарч иртэл нь буюу Инженерийн зааварласан гүн, өргөний хэмжээгээр ухаж, тохирохгүй материалыг зайлуулна. Үүний үр дүнд

гарах ухмалыг Гүйцэтгэгч нь зөвшөөрөгдсөн материалаар буцааж дүүргэн, AASHTO T180 стандартын дагуу хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна. Зөвшөөрөгдсөн материал нь дээр дурдсан 1203-т тодорхойлсон хатуу дүүргэгч материал ба зохист ширхэглэлтэй дүүргэгч материал, эсвэл 1211-ийн дагуу сонголт хийсэн буцааж дүүргэх материал байж болно.

1205. ХАТУУ МАТЕРИАЛД НҮХ УХАХ

Дугуй бетон хоолой

Бетон дугуй хоолой барих газарт хатуу материал тааралдвал ул хөрсний 50 мм-т ямар ч хатуу материал ил байлгахгүйгээр нүхийг тэгшилж янзална. Гүйцэтгэгч нь нүхний ёроолд 50 мм бүхий зузаантай бүтээцийн бус бетоноор тэгшилгээний үеийг дэвсэж хоолойн суурийн ёроолтой нэг төвшинд байхаар тэгшилж нягтруулна. Тэгшилгээний үеийн хамгийн их зузаан нь 50 мм байна. Сул хөрс ба тохиромжгүй материал тааралдвал тэдгээрийг 300 мм буюу Инженерийн заасан гүнд хүртэл хусаж зайлуулаад, оронд нь зөвшөөрөгдсөн материалаар буцааж дүүргэн хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар /AASHTO T99/ нягтруулна.

1206. УХСАН НҮХИЙГ ХУУРАЙ БАЙЛГАХ

Гүйцэтгэгч нь суурийн нүхэнд ус орохоос сэргийлэх ба ус орохоос хамгаалж, ус зайлуулах шуудуу ухах, усны хаалт барих, насосоор усыг соруулах эсвэл нүхийг усгүйжүүлэх ажлыг хийнэ.

а. Гүйцэтгэгч нь суурийн нүхэнд ус орохоос сэргийлэх ба ус орохоос хамгаалж, ус зайлуулах шуудуу ухах, усны хаалт барих, насосоор усыг соруулах эсвэл нүхийг усгүйжүүлэх ажлыг хийнэ.

б. Хайрган суурь

Хоолойн бетон суурийг цутгахаас өмнө хайрган суурийг зурагт үзүүлсэн хэмжээг баримтлан, зохистой ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй материалаар хайрган суурийг тохиромжтой материалаар хийнэ. Суурийн материалыг авчирч буулгахаас өмнө хоолойн суурь болон бусад хэсгийн нүхийг энэхүү ТШ-ын 1204-ын дагуу бэлэн болгосон байна.

Хоолойн хайрган суурийн материал нь дараах шаардлагыг хангасан байна.

Хөрсний даацын үзүүлэлт (CBR) нь 4 өдөр сойсны дараа ХҮХИН нь 98% (MNS ASTM D2217:2002/AASHTO T1810-10) хүртэлх нягтруулалтанд шалгаж үзэхэд 20%-иас их байвал зохистой.

- ХҮХИН (AASHTO T1810-10) 1,85 т/м³-аас багагүй
- 0,075мм шигшүүрээр өнгөрсөн хэсгийн хувь 15-аас бага,
- Ширхэглэлийн хамгийн том хэмжээ нь 60мм-ээс бага байна.

Хоолойн хайрган суурийг ХҮХИН нь хамгийн багадаа 95% (MNS ASTM D 2217:2002/AASHTO T180-10) хүртэл нягтруулах ба тохиромжтой чийгийн агууламжийг 1-2%-ийн хэлбэлзлээс хэтрэхгүй байхаар тохируулна.

Бетон суурийн ажил эхлэхээс өмнө хайрган суурийн геометр хэмжээ, нягт, төвшинг шалгаж, Инженерээс зөвшөөрөл авсан байна. (Дөрвөлжин хоолойн хувьд зурагт заасан тэгшилгээний бетоныг цутгаж холбогдох зөвшөөрлийг авсан байх).

1207. ДӨРВӨЛЖИН ТӨМӨР БЕТОН ХООЛОЙ

Дөрвөлжин төмөр бетон хоолойг ИНЗ-д заасны дагуу хийнэ. Хоолойн бетон нь энэхүү техникийн шаардлагын 1300-р бүлэгт нийцэж байна.

1208.ХООЛОЙН СУУРЬ ЦУТГАХ

Гүйцэтгэгч нь хоолойн нийт уртын дагууд (хүчитгээгүй) 150 мм зузаантай эсвэл ажлын зурагт заасан зузааны дагуу бетон суурь цутгана. Бетоны анги нь ажлын зурагт зааснаар байх ёстой. Бэлтгэл ажил нь бүрэн дуусч зөвшөөрөгдсөн хайрган суурь/ тэгшилгээний бетон дээр бетон суурийн 2 захын болон тулц хана, толгой, далавчны арматур зэрэг холбогдолтой бүхий ажлыг энэхүү техникийн 208-д заасныг баримтлан гүйцэтгэнэ.

Бэлэн болсон арматурчлалын хэмжээг Инженер шалгаж зөвшөөрсөний дараа бетон суурийн хэвийг ажлын зургийн дагуу угсарч зөвшөөрөл авна. Хэв хашмалыг төсөллөх, барих, ажилд бэлтгэх, буулгахад энэхүү техникийн зүйл 1318-д заасаныг тус тус мөрдөнө.

1209. БЕТОН ХООЛОЙН ЦАГИРГУУДЫГ УГСРАХ БА ХОЛБОХ

Хоолойн бетон цагиргуудыг холбох ажлыг дараах аргуудаар хийж болно.

Үүнд:

a/ Хоолойн цагиргуудыг угсрах ба холбох

Хоолойн цагиргуудыг угсрахын өмнө Гүйцэтгэгч нь цагиргуудын амсрыг шавар, шороо, тоосноос цэвэрлэх ёстой. Зурагт үзүүлснээр цутгамал хоолой нь тэгш амсартай байна. Тэгш амсартай цагиргуудын уулзварыг гадна ба дотор талаас нь цементэн зуурмагаар жигд дүүргэж чигжинэ. Гүйцэтгэгч хоолойн цагиргийг угсарсны дараа уулзваруудын дотор талыг нь хусаж тэгшлээд, усаар норгож цемент-элсний 1:2 харьцаатай зуурмагаар чигжинэ.

Гүйцэтгэгч хоолойн цагиргуудыг угсарч хоорондох зайг цемент-элсний зуурмагаар чигжиж, цул болгосны дараа хоолойн их бие ба бетон суурьтай нийлэх хэсгийн хоёр хажуугийн зайг B15 ангийн бетоноор чигжиж нягтруулна. Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн бүрээс, халхавчаар бүх уулзварыг бүтээж, салхи, нар, ус борооноос хамгийн багадаа 3 хоногийн турш хамгаалж, чийгийг нь хадгална. Хоолойн цагиргуудыг холбосны дараа 48 цагийн дотор хоолойг хөдөлгөөнгүй байлгахад Гүйцэтгэгч анхаарах ёстой.

Дэвсэх төхөөрөмж, залгаас, арматур болон хэв хашмалтай харьцахад тэдгээрт наалдаж алдагдах шингэн хольцын алдагдлыг нөхөх зорилгоор хатуурсан бетон гадаргуу дээр дэвсэх эхний үеийн бетонд байх ёстой чулуун материалын зөвхөн хийнэ.

Инженер ажлын залгаас болон байрлалыг шалгаж үзээд зөвшөөрөл өгөхөөс нааш гадаргууд бетон дэвсэхгүй. Инженерийн зааварласан газруудад хуучин ба шинэ бетонуудыг хооронд нь сайн барьцалдуулах үүднээс ажлын залгаасанд эпоксид резин хэрэглэнэ. Эпоксид резин хэрэглэх болон гадаргууг бэлдэхдээ Инженерийн зааварчилгаа болон үйлдвэрлэгчийн зааврыг удирдамж болгоно.

Эпоксид резиний төрөл болон үйлдвэрлэгчийг Инженер зөвшөөрсөн байх ёстой. Ажлын залгаас нь хоёр даацын элементүүдийг хооронд нь барьцалдуулалгүй залгах шаардлагатай бол Гүйцэтгэгч тэдгээрийн дунд хоёр үе ус нэвтэрдэггүй барилгын цаас хийж өгнө. Цаасыг нугалж үрчийлгэлгүй тааруулж хийнэ. Илүү гарсан ирмэгийг цавуутай туузаар нааж бэхэлнэ.

Хоёр үе барилгын хар цаасыг залгаасны нийт талбайд дэвсэнэ. Гүйцэтгэгч бетоны ажил хийх явцад цаасыг гэмтээхгүй байх талаар анхаарах ёстой.

1314. ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Хэв гажилтын заадас нь бетоны доторх дулааны болон бусад хөдөлгөөнийг хангахад зориулагдсан заадас юм. Хэв гажилтын заадас гэдэг нь бетоны агшилт болон тэлэлтийг зохицуулах зориулалтаар бетоны дунд гаргасан зай юм. Хэв гажилтын заадас нь бетоны агшилт болон тэлэлтийг хангах ба тусгай дүүргэгчээр дүүргэгдэнэ. Хэв гажилтын заадсын байршлыг ажлын зураг буюу техникийн шаардлагад заасны дагуу тодорхойлно. Хэв гажилтын заадсыг бетонд аливаа хагарал үүсэхээс өмнө, бетоны ирмэгийг үйрэх буюу бутралгүйгээр хөрөөдөх боломжтой болмогц хийнэ.

1315. УС ТОГТООГЧ

Ус тогтоогчийн тухай заалтууд нь шингэн зуурмаг тогтоогчид адил хамаарна. Ус тогтоогчийг ажлын зурагт үзүүлсэн материалаар хийнэ. Гүйцэтгэгч ус тогтоогчийн материалын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон дээжийг Инженерт танилцуулж батлуулахаас нааш ус тогтоогчийн материалыг талбайд авчирч болохгүй. Дээжийн урт нь туршилт хийхэд хүрэлцэхүйц байна.

Ус тогтоогч нь хлорид, сульфат болон барилгын ажлын орчин тойронд байж болох бусад

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

хортой бодисын нөлөөнд ордоггүй материалаар хийгдсэн байна. Резинэн ус тогтоогч нь байгалийн болон хиймэл резинээр хийгдсэн байх ба 25°C-ын дулаанд хийсэн туршилтаар 500 хувиар сунах чадвартай ба залгаасын 50 мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даах чадвартай байна.

Поливинилхлорид (PVC)-р хийсэн ус тогтоогч нь PVC-ийн өөдөс агуулаагүй PVC-ин полимерээс гаргаж авсан материалтай байна. Ийм ус тогтоогч 25°C-ын дулаанд хийсэн туршилтаар 225%-аар сунах чадвартай ба залгаасын 10мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даана.

Бага модулийн ус тогтоогч нь 25°C-ын дулаанд хийсэн 6 N/мм² хүчээр татах туршилтаар 200%-аар сунах чадвартай ба залгаасын 50мм-ээс доошгүй хөдөлгөөнийг даах ёстой. Ус тогтоогч нь барилгын ажлын шаардлагын дагуу ажиллахад хялбар байхаар хангалттай урт байна.

Амлуулах залгааснаас бусад резинэн ба хуванцар материалтай залгаасыг үйлдвэрлэгчээс бэлэн хийснээр авчирна. Амлуулах залгаасыг талбай дээр үйлдвэрлэгчийн хангасан тоног төхөөрөмж болон заавраар хийнэ.

Ус тогтоогчийн материалыг тос болон бусад бодисоор бохирдуулж гэмтээхээс болгоомжлон талбайд хадгална. Резинэн болон хуванцар ус тогтоогчийг сэрүүн, агааржуулалт сайтай, нарны гэрэл шууд тусахааргүй газарт хадгална.

Резинэн болон хуванцар ус тогтоогчийг залгаасны нэг талд нөгөө талын бетон дэвсэхээс 1 сар ба түүнээс дээш хугацааны өмнө бэхэлсэн бол ус тогтоогчийг нарнаас хамгаална. Ус тогтоогчийг бетон цутгах үед хөдлөхгүй байхаар хэв хашмалд бэхлэн, бетон цутгахаас өмнө тэдгээрийг аливаа хог, шавар, тосноос цэвэрлэнэ.

Арматурын төмөрт сайтар уяж тогтоосон төмөр гогцоонд ус тогтоогчийг бэхлэх ба ямар ч тохиолдолд ус тогтоогчийг хадаасаар буюу бусад зүйлээр цоолж, тогтоож болохгүй. Бетон дэвсэх үед ус тогтоогчийг хөдөлгөлгүй тойруулан нямбай цутгаж сайтар нягтруулна.

Ус тогтоогчийг хэвтээ буюу бараг хэвтээ байрлалд бэхэлж байгаа бол түүний дор хоосон зай үлдээхгүй байх хэрэгтэй. Ус тогтоогчтой зэрэгцсэн хэв хашмалыг ус тогтоогчийг гэмтээлгүйгээр нямбай салгаж авна. Хэрэв талбайн нөхцөлд засварлах боломжгүйгээр эвдэрвэл Инженер ус тогтоогч бэхэлсэн бетоны хэсгийг зайлуулан шинээр хийхийг шаардаж болно.

1316. ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ

Хэв хашмалтай шууд харьцаагүй, хэвтээ буюу бараг хэвтээ гадаргууг зурагт заасан ангиллын дагуу дор тодорхойлсон аргаар өнгөлнө.

Үүнд:

(a) UF 1 өнгөлгөө

Зурагт заасан буюу Инженерийн зааварчилсан өнгөлгөөний ангиллаасдоогуур ангиллын өнгөлгөө шаардах бүх гадаргууд UF 1 өнгөлгөөг хийнэ. Бетоныг нягтруулсны дараа нэн даруй тэгшлэгч рейкээр илүүдэл бетоныг хусан авч гадаргууг нэгэн жигд болтол тэгшилж засна.

(b) UF 2 Өнгөлгөө

Энэ өнгөлгөөг дээвэр, шалны хавтан болон бусад хатуу өнгөлгөө шаарддаггүй гадаргууд хэрэглэнэ. Гадаргууг эхлээд UF 1 өнгөлгөөгөөр янзалж, бетоныг нэлээд хатуурсны дараа модон буюу үйсэн хөвөгчөөр гадаргуугийн өнгөлгөөг зөвхөн тэгшлэгч рейкний мөрийг арилгах хэмжээнд тэгшилнэ.

(c) УФ 3 Өнгөлгөө

Энэ нь түргэн урсгалтай усны үйлчлэлд өртдөг хэсгүүд буюу цаг агаарын үйлчлэлийг эсэргүүцэх чадвар болон гадаад үзэмж чухал байдаг даацын хэсгүүдийн гадаргууг нийвийгээр хатуу өнгөлгөө хийхийг хэлнэ. Эхлээд гадаргууг УФ 2–ийн дагуу өнгөлнө. Гадаргуугаас чийгийн давхарга хатаж, алга болж бетон хангалттай хатуурсны дараа цахилгаан үүсгүүрт хөвөгчөөр нийвийн мөргүй, нягт, гөлгөр, жигд гадаргуу үүстэл өнгөлнө.

(d) Зорчих хэсгийн гадаргуун өнгөлгөө

Гүүрний хавтан болон дамжих хавтангийн гадаргууг төмөр замаар явдаг тараах төхөөрөмжөөр тэгшилнэ. Уг төхөөрөмж нь хавтангийн нийт өргөнд бэхлэгдсэн байна. Төмөр зам нь нэлээд бат бэх байх ба тараах ажилбарын явцад хотойхгүй байхаар ойр ойрхон зайнд бэхлэгдсэн байна. Төхөөрөмж болон төмөр замыг тэгшилгээний дараах бетон гадаргуу нь шаардлагатай дагуу болон хөндлөн хэвгийг хангасан байхаар тохируулдаг байх ёстой.

Бетон цутгаж эхлэхээс өмнө төмөр замыг газар дээр нь авчирч тэгшилгээ хийхээр төлөвлөсөн нийт уртын дагууд сайтар суулгаж бэхэлнэ. Төмөр замын урт нь тэгшилгээ хийхээр төлөвлөсөн уртын 2 үзүүрээс тараах төхөөрөмжийг бетоноо султгахад хангалттай зайгаар илүү гарсан байна.

Шаардлагатай бол хэв хашмалын суулт, хотойлт, овойлт зэргийг харгалзан төмөр замын өндрийн төвшинг тохируулж болдог байх ёстой. Тараах төхөөрөмж нь талбайн нийт уртад тасралтгүй ажиллах хүчин чадалтай байх ёстой. Мөн урьд нь төлөвлөөгүй, тараах төхөөрөмжийн ажиллагааны үед үүссэн суулт буюу хотойлтыг засахад төмөр замыг тохируулж болдог байх хэрэгтэй.

Бетон цутгах талбайд байрлаж байгаа төмөр замын тулгууруудыг хэрэггүй болмогц бетоны төвшингээс доош 50–аас доошгүй мм байхаар тайрч зайлуулаад, тулгуурын ороор гарсан зайг шинэ бетон хольцоор бөглөнө.

Гүйцэтгэгч бетон гадаргууг шалгах, засварын ажил хийх , тулгуураас үлдсэн нүхийг бөглөх, цахилгаан хөвөгч явуулах, арчлалт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэх зорилгоор замын тэнхлэгийн дагуу ажлын хөдөлгөөнт гүүр хийнэ.

Гадаргууг тэгшилсний дараах бүх ажлыг энэ ажлын гүүрэн дээрээс гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч ажлын гүүрэнд хүрэх бололцоотой болгохын тулд аль аль талдаа аюулгүйн хашлага бүхий, бат бөх явган зам барина.

Гүйцэтгэгч бетон хольцыг авчрахаас өмнө тараах төхөөрөмжийг бетон цутгах нийт талбайгаар ажиллуулж, төмөр замын муруйлт, хавтангийн зузаан, арматурын төмөр ба гадаргуун төвшин хоёрын хоорондын зай зэргийг шалгаж, бүх тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг баталгаажуулна. Шаардлагатай тохиргоог бетон дэвсэхээс өмнө хийж дуусгасан байна.

Гүйцэтгэгч гүүрийн хавтан болон дамжих хавтангийн шинэхэн цутгасан хэсгээр бетон цутгаж дууссанаас хойш 48 цаг өнгөртөл хөнгөн даацын тоног төхөөрөмж явуулж болохгүй.

Хэрэв Инженер хавтан хангалттай бат бэхээ авч чадаагүй гэж үзвэл дээрх хугацааг сунгана. Бетон бат бэхийн 80% автал аливаа хүнд механизмыг гүүр болон дамжих хавтангаар явуулахгүй.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Тэгшлэх төхөөрөмж нь шаардлагатай дагуу болон хөндлөн хэвгийг гаргатал гадаргуу дээгүүр явна. Тэгшлэх төхөөрөмжийн урд талд бага зэргийн илүүдэл бетон байнга явж байх ёстой.

Энэ илүүдэл бетоныг дэвсэж буй бетон руу хийж болохгүй бөгөөд цутгалтын зах руу аваачиж хаяна. Өнгөлгөө хийх явцад илүү гарсан ус, шавар болон гаднын материалуудыг буцаан хавтан руу хийж болохгүй бөгөөд тэгшлэгч рейкээр хавтангийн төвөөс зах руу чиглүүлсэн хөдөлгөөнөөр гаргаж хаяна. Бетоныг өнгөлөх зориулалтаар гадаргуу руу ус хийж болохгүй.

Гадаргууг тэгшилсний дараа 1316 (в) дэд зүйлд дурдсан UF 3 өнгөлгөө буюу цахилгаанаар ажилладаг хөвөгчөөр өнгөлгөө хийнэ.

Талбайд өнгөлгөө хийсний дараа Гүйцэтгэгч 3 метрийн төмөр рейкийг гүүрийн тэнхлэгийн дагуу тавьж, нийт гадаргууг шалгана. Захуудын шугам, тэнхлэгийн шугам болон тэнхлэг ба захуудын дундах цэгүүдийг мөн шалгах хэрэгтэй.

25 мм ба түүнээс зузаан материал нэмж дэвсэх шаардлагатай гадаргуугийн төвшингийн зөрүү рейкний хэмжилтээс 10 мм-ээс илүү байж болохгүй.

Энэ хязгаараас илүү гарсан өөрчлөлтийг бетоныг бэхжихээс өмнө засаж залруулна. Талбайг урьд шалгасан талбайн талыг давхардуулан шалгаж явна.

Бусад бүх хэвлэмэл бус гадаргуу нь ажлын зурагт заасны дагуу байх ба (хүснэгт 13-10)-г тодорхойлсон хүлцэх алдааны хязгаар дотор хэлбэлзэх ба гадаргуугийн төвшин огцом өөрчлөгдөж болохгүй.

Хэрвээ ажлын зурагт хүлцэх алдаа өгөгдсөн бол тэдгээрийг (хүснэгт 13-10)-т үзүүлсэн хүлцэх алдаанаас илүү хүчинтэйд тооцно.

1317. ХЭВЛЭМЭЛ ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ

Бетон гадаргууг ажлын зураг дээр үзүүлсний дагуу дор заасан аргаар өнгөлж засна. Үүнд:

(а) Гадаргуун ердийн өнгөлгөө

Ажлын зураг дээр өөрөөр өгөгдөөгүй буюу Инженер өөрөөр заагаагүй бол бетоны ил гарсан бүх гадаргууд ердийн заслыг хийнэ. Энэ заслаар сийрэгжиж арзайсан, цухуйсан зүйлс, овойлт, элдэв өнгө хувиралт, зураас, гадаргуугийн бусад элдэв өө сэвийг арилгаж, гөлгөр тэгш гадаргуу бий болгоно. Стандартчилал, технологийн институтээс гаргасан PCI стандартын В-В дотор заслын I ангиллын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг BS 1088 стандартын наамал банз эсвэл том хавтгайгаар үйлдвэрлэгддэг ижил төстэй материалаар хэв хашмалыг доторлоно.

Наамал банз нь нэгэн жигд батлагдсан ширхэгтэй байна. Боллоцотой бол хавтангуудыг хооронд нь уран барилгын элементээр холбох буюу гадаргуун чиглэлийн залгаасыг тааруулж өөрчилнө.

Хавтан буюу банзнуудын зузаан нь бетон цутгасны дараа бетоны даралтаар ямарваа нэг хэв мөр гаргахааргүй байна. Өөрөөр заагаагүй байвал хавтангуудыг хооронд нь хэвтээ буюу

босоо байдлаар залгана.

Шаардлага хангасан гадаргуун ердийн өнгөлгөө гэдэг нь төмөр зангилааг салгаж авсны улмаас гарсан нүхнээс бусад нүхийг бөглөх гэх мэт засвар хийх шаардлагагүй гэж Инженер үзсэн гадаргууг хэлнэ.

Сийрэгжиж арзайсан, цухуйсан зүйлс, овойлт, элдэв өнгө хувиралт, зураас буюу гадаргуугийн элдэв өө сэвийг Инженерийн зөвшөөрсөн аргаар арилгана. Цементээр угаах буюу гипс хэрэглэж болохгүй.

Хэвийг авсан даруй бетон гадаргуугийн согогыг Инженерт мэдэгдэнэ. Гадаргуугийн согогыг техникийн шаардлагын дагуу Инженерийн заасны дагуу засварлана.

Хөндий хэсэг буюу нүхийг тэр орчин тойронд хийсэн бетоной адил чанар, хольц бүхий гэхдээ 2,36 мм шигшүүр дээр үлдсэн чулуу агуулсан цемент элсний зуурмагаар чигжиж, нийт гүнд нь хүртэл дүүргэнэ.

Нүх цоорхойг шавахад хэрэглэх шавар зуурмаг нь зуураад 1-ээс илүү цаг болсон чигжээс байж болохгүй. Цементэн зуурмаг хатсаны дараа нөхөөс хийсэн хэсгийг бусад гадаргуугийн хамт засч тэгшилнэ.

Суларч хөндийрсэн бетон ба муу барьцалдсан чулууг гарган авч хаян, техникийн шаардлагын зүйл 1321-ийн дагуу бат бөх бетон буюу шавар зуурмагаар бөглөн тэгшилж өгнө.

Хэрэв Инженерийн үзэж байгаагаар бетоны гадаргуу ердийн өнгөлгөөний шаардлагад нийцэхгүй байгаа бол Гүйцэтгэгч зүлгэх өнгөлгөөг техникийн шаардлагын зүйл 1317 (б)-ийн дагуу өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

б) Зүлгэх өнгөлгөө

Зураг дээр өөрөөр өгөгдөөгүй бол энэ ажлыг засварын ажил гэж үзэх ба Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэнэ. Хэвийг салгаж авсны дараа зүлгэх өнгөлгөөг аль болох хурдан эхлүүлэх хэрэгтэй.

Гадаргууд эхлээд техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлд заасан ердийн өнгөлгөө хийнэ. Шавар зуурмаг бэлэн болмогц бетон гадаргууг цэвэр усаар сойздож норгоно. Үүний дараа цахилгаанаар ажилладаг чулуу өнгөлөгчөөр гадаргууг зүлгэнэ.

Гадаргуу дахь хэв хашмалын мөр, хонхойж эсвэл овойж илүү гарсан хэсэг болон бусад согогууд арилж, гөлгөр гадаргуу үүстэл зүлгэнэ. Зүлгэх явцад нунтаглагдаж гадаргууд үлдсэн нялцгай материалыг нийт гадаргууд жигд тарааж хатаана.

Эцсийн өнгөлгөөг цахиурын карбид чулуугаар гадаргууг толигор, тэгш, жигд өнгөтэй болтол нь үрж хийнэ. Энэхүү өнгөлгөөг хийж дуусаад гадаргууг хатсаны дараа сул шаврыг тааран материалаар үрж зайлуулна.

Гадаргууд чанаргүй нөхөөс, шаваас, нунтаг ба элдэв ул мөр байх ёсгүй. Ямар ч тохиолдолд гадаргууг цементээр угаах буюу гипсыг хэрэглэж болохгүй.

1318. ТУЛАХ ТҮР БАЙГУУЛАМЖ БА ХЭВ ХАШМАЛ

(а) Тулах түр байгууламж

Тулах түр байгууламжийн зураг төслийг Инженерийн хүлээн зөвшөөрсөн, тулах түр байгууламж болон хэв хашмалын зураг төсөл хийх туршлага бүхий байгууллагаар хийлгэнэ.

Гүйцэтгэгч бетоны ажил эхлүүлэхээс өмнө 21 хоногийн дотор, түр байгууламжийн нарийвчилсан ажлын зураг ба тооцоог Инженерт танилцуулна.

Ажлын зураг болон тооцоог мэргэжлийн зураг төслийн байгууллагаар баталгаажуулсан байх ёстой. Тооцоог хийхдээ бетоныг цутгах, нягтруулах, тэгшлэх, засварлахад шаардагдах тоног төхөөрөмж, дэвсэх дараалал ба хурдыг харгалзан үзсэн байх ёстой.

Гүйцэтгэгчээс ирүүлсэн түр байгууламж болон хэв хашмалын ажлын зураг болон тооцоог Инженер баталсан ба үүний дагуу Гүйцэтгэгч хэв хашмал болон түр байгууламжийг барьсан байсан хэдий ч хэв хашмал болон түр байгууламжийн шаардлага хангасан эсэх болон аюулгүй байдлыг Гүйцэтгэгч дангаар хариуцна.

Гүйцэтгэгч хэв хашмал болон түр байгууламжийн зураг төсөл, барилга болон арчлалттай холбоотойгоор хүн буюу эд хөрөнгөнд гарч болзошгүй аливаа хохирлоос Захиалагч ба Инженерийг сэргийлнэ.

Тулах түр байгууламж болон хэв хашмал нь тухайн дэвсэх хурд болон аргачлалаар бетоныг дэвсэх болон нягтруулахад бетон хатуурч бэхэжсэний дараа бетоны хэвлэмэл гадаргуу нь техникийн шаардлагын зүйл 1321-т заасан хүлцэх алдааны хязгаарт хэлбэлзэж, зурагт үзүүлсэн байрлалд байхаар, мөн ийнхүү тавьсан бетоны ачааллыг даах чадвартай байхаар тооцож баригдсан байна.

Инженер зургийг зөвшөөрсний дараа Гүйцэтгэгч зургийн дагуу тулах түр байгууламжийг барина. Ажлын зурагт үзүүлсэн тулах түр байгууламжид өөрчлөлт хийхээр бол зураг төслийг боловсруулсан этгээдээр батлуулж, Инженерт танилцуулахаас нааш өөрчилж болохгүй.

(1) Ачаалал

Хэв хашмалд ирэх тооцоот ачаалал нь босоо чиглэлийн тогтмол ба хөдөлгөөнт бүх ачаалал ба хэвтээ чиглэлийн ачааллын нийлбэрээс бүрдэнэ. Тогтмол ачаалалд барилгын ажилд хэрэглэж байгаа бүх материал болон хэв хашмалын нийт жин багтана. Бетон, арматур төмөр болон хэв хашмалын нийт жин нь ердийн бетоны жингийн 2.60 тн/м^3 -ээс багагүй байна.

Хөдөлгөөнт ачаалал нь аливаа тоног төхөөрөмжийн гадаргуутай харьцаж байгаа цэгүүдэд төвлөрч ирэх жин ба нийт талбайд ирэх 98 кг/м^2 -аас доошгүй жигд ачаа болон хавтангийн гадаад ирмэгт ирэх 112 кг/м ачаанаас бүрдэнэ.

Түр байгууламжийн холболтын системийг төсөллөхөд шаардлагатай хэвтээ ачаалал нь тоног төхөөрөмж, ажлын дараалал, шингэн бетоны тэнцвэргүй гидростатик хүч, урсалт, салхины хүч зэргээс үүдсэн хэвтээ ачааллын нийлбэрээс бүрдэнэ. Ямар ч чиглэлд ирж байгаа хамгийн бага хэвтээ ачаалал нь нийт тогтмол ачааллын 2 хувьтай тэнцүү байна. Хуучин, шинэ эсвэл хэсэгчлэн бэлэн болсон хийцэд тулах түр байгууламжаас ирэх ачаалал нь авто замын гүүрний AASHTO, II Бүлгийн “Ачааллын тухай 8.15-р зүйлд зөвшөөрөгдсөн хэмжээнээс

хэтрэхгүй байна.

(2) Суурь

Түр байгууламжийг суулт өгдөггүй, ирж байгаа ачааллыг даах чадвартай материалаар хийгдсэн бат бэх суурин дээр суурилуулсан байна. Хэрэв суурь норох магадлалтай бол суурийн материалд үзүүлэх усны нөлөөг бодолцох хэрэгтэй. Инженер шаардвал Гүйцэтгэгч нь ачааллын туршилт хийж түр байгууламжийн суурийг төсөллөхөд тооцсон хөрсний даах чадвар нь тухайн хөрсний даах чадвараас илүүгүй гэдгийг нотолно.

Хэрвээ тулах түр байгууламжийг шаардлага хангасан суурь дээр суурилуулах боломжгүй бол түр байгууламжийг Инженерийн шаардлагад нийцсэн бат бэх, туршигдсан тулгууруудаар тулж өгнө.

(3) Хазайлт

Түр байгууламжийг, хэрэв Инженер шаардсан бол бэлэн болсон гадаргууд зохих хэвгий ба налуу гаргахын тулд түр байгууламжийн дам нуруу болон хэвийн хооронд янз бүрийн хотойлттой гүдгэр хавтанцруудыг бэхэлж барина. Гүйцэтгэгч тогтмол ачааллын улмаас үүсэх хазайлт ба бетон дэвссэнээр үүсэж болох бусад хэв гажилтыг тооцсон байна.

Газар дээр нь цутгасан бетон хийцүүдийн хувьд, гулзайлтыг зохих гүдгэр хавтанцруудаар зохицуулсан байсан хэдий ч түр байгууламжийн эд ангиудын гулзайлтын тооцоолсон хэмжээ нь тэдний ургын 1/240-өөс хэтрэх ёсгүй.

(4) Чөлөөт зай

Инженер өөрөөр заагаагүй бол барилгын ажлын үеэр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн явж байгаа үед түр байгууламжийн доторх чөлөөт зайн өргөн нь түр байгууламжтай нийлэх замын өргөнөөс 1.5 метрээр их харин өндөр нь 4.5 м байна.

(5) Түр байгууламжийг барих

Тулах түр байгууламжийг даацын ган материалаар барина. Даацын ган хоолой нь нимгэн байж болохгүй. Түр байгууламжийг зохих түвшинд угсрах, бетон цутгах үед бага зэргийн зохицуулалт хийх болон түр байгууламжийг бага багаар буулгах боломжтой болгох зорилгоор шон бүрт эрэг боолт, хос шаантаг болон бусад зөвшөөрөгдсөн тоноглолыг бэхэлж өгнө.

Үүнээс гадна Гүйцэтгэгч нь хэв хашмалд тоолуур суулгах, төвшин ба чиг заах хатуу цэгт уртасгагч холбох зэрэг зөвшөөрөгдсөн аргаар бетон цутгалтын үед түр байгууламжийн суултыг нарийн хэмжих хэрэгслээр хангана.

(b) Хэв хашмал

(1) Ерөнхий

Хэв хашмалыг мод, төмөр болон бусад зөвшөөрөгдсөн материалаар доторлож хийсэн хийц байна. Хэв хашмалыг түүнд ирэх аливаа даралтыг гажилтанд оролгүйгээр даахуйц, бат бөх байхаар хийнэ. Хэв хашмал нь бетоны нүүрэн талд эвдрэл үүсгэлгүйгээр амархан салахаар хийгдсэн байх ба, хэрэв шаардлагатай бол, бетоны нүүр талуудын зөв байрлалыг хангах үүднээс бетоны байрлалыг бага зэрэг өөрчлөх зориулалттай хэрэгслээр тоноглогдсон байна. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой.

Бетоны нүүрэн талыг Инженерийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд нэгэн жигд бүтэц ба өнгө бүхий гөлгөр гадаргуутай байлгах зорилгоор хэв хашмалыг РСІ стандартын В-В дотор заслын 1 ангиллын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг BS 1088 стандартын наамал банзаар доторлоно.

Бетоны ил гарах гадаргуугийн хэв хашмалын залгаасууд нь хэрэв өөрөөр заагаагүй бол, хэвтээ ба босоо байдлаар тэгш байрлуулагдсан, үргэлжилсэн байх буюу эсвэл нэгэн жигд хээтэй байна. Хийцийн нийт хэсэг бүрт хэвийн доторлогооны ижил төрлийн материал хэрэглэнэ.

Хэрвээ хэв хашмал цухуйсан байвал агаарыг гаргаж тэр хэсгийг сайтар нягтруулагдсан бетоноор дүүргэнэ. 30°-ийн налуутай буюу түүнээс налуу байдлаар бетон гадаргуу цутгахаар бол хэв хашмал ашиглана.

Харин 20°-ээс бага налуутай хийвэл гадаргууг тэгшлэх аргаар налуу гаргана. 20°- 30° хоорондох налууг Гүйцэтгэгч, хэрвээ бетоныг нягтруулах үед бетоныг байранд нь байлгаж чадах тусгай тэгшлэгч хавтан хэрэглэн гадаргууг тэгшилж чадахаа Инженерт баталж чадахгүй бол хэв хашмал хэрэглэнэ.

Бетоны гадаргуу дээр хэвтээ ба налуу байдлаар хийгдсэн хэв хашмалыг шинэ бетоны хийн даралтын улмаас дээшээ өргөгдөхгүй байхаар сайтар бэхэлнэ. Бетоны их бие доторх нүхний хэв хашмалыг хөвөхөөс сэргийлж арга хэмжээ авна.

Эвдэрсэн хэв хашмалыг салгасны дараа энэ нь бетон гадаргууг гэмтээж болзошгүй бол дахин хэрэглэж болохгүй. Бэлэн бетон хийцийг барилгын ажилд байнгын хэв хашмалын зориулалтаар ашиглахаар Гүйцэтгэгч санал болгож болох бөгөөд Инженерээс зөвшөөрөл авна.

Эдгээр хийцүүдийг 1321 хэсэгт заасан хүлцэх алдааны хязгаарт зөв төвшин ба чигт суулгаж, бетон цутгах үед хөдлөхгүй байхаар бэхэлсэн байна.

Бетонтой харьцах хэв хашмалын бүх гадаргууг арматур байрлуулахаас өмнө сайтар цэвэрлэж, хэвийг бетоноос салгахад хялбар болгох зориулалттай зөвшөөрөгдсөн химийн буюу бусад эмульсийг түрхэж өгнө. Цэвэр эрдэс тос ба усанд уусдаг эмульс хэрэглэхгүй.

Гүйцэтгэгч нь төлөвлөсөн шингэн нэмэлтүүдийг тохирох эсэхийг батлах туршилтын хавтан цутгана. Дараах шинж чанар бүхий эмульсийг хэрэглэж болохгүй. Үүнд:

- хэвлэмэл гадаргуугийн дээр тавигдах аливаа материалын барьцалдах чанарыг бууруулдаг;
- хэвлэмэл гадаргуун бэхжилтийг удаашруулдаг;
- гадаргууг хэврэг болгодог;
- агаарын зай үүсгэдэг;
- толбо үүсгэдэг;
- гандуулдаг;
- өнгө өөрчилдөг.

(2) Хэв хашмалыг төсөллөх

Хэв хашмал нь АСІ стандарт, “Бетоны хэвийн практик зөвлөмж,” (АСІ 347) эсхүл Инженерийн зөвшөөрсөн олон улсад түгээмэл хэрэглэгддэг стандартыг хангасан байна. Хэв хашмалыг төсөллөхөд гидростатик даралтыг сонгохдоо доорх зүйлүүдийг анхаарна.

Үүнд:

- ✓ бетон дэвсэх үеийн тооцоолж буй хамгийн их хэмжээ;
- ✓ төлөвлөсөн хольцны өтгөрөлт ба хөдөлгөөнт чанар;
- ✓ доргилтын нөлөө;
- ✓ бетоны температур;
- ✓ орчны температур;
- ✓ бетон хольц дахь удаашруулагч буюу зөөлрүүлэх бодисууд.

(3) Хэв хашмалыг барих

Хэв хашмалыг дахин хэрэглэхээс өмнө цахилгаан хөдөлгүүрт механик багажаар цэвэрлэж эвдрэл, гэмтлийг шалгаж, шаардлагатай засварыг хийнэ. Хэрвээ бетон цутгах үеэр буюу цутгахаас өмнө ямар нэгэн согог илэрвэл Инженер(хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)- согогыг залруултал ажлыг зогсоож болно.

Гүйцэтгэгч хэв хашмалыг угсрахдаа хэвийн хажуугийн талуудыг буулгах үед доод хэсгийн хэвийг хөндөхөөргүй хийнэ. Хэрэв тулгууруудыг үлдээж, доод хэсгийн хэвийг салгах шаардлагатай бол цохилтын үед тулгууруудыг хөндөж болохгүй. Гүйцэтгэгч хэв хашмалыг задлах зорилгоор тулгууруудыг түр зуур зайлуулаад дараа нь буцааж тавих ёсгүй.

Хэвэн доторх төмөр холбоос ба бэхэлгээнүүдийг бетоныг гэмтээлгүйгээр бетоны нүүрнээс хамгийн багадаа 60мм-ийн зайнд салгаж болохоор хийнэ. Төмөр холбогчийг авсны дараа бетонд үлдэх хонхор зай нь аль болох бага байхаар бэхэлгээг суулгаж өгнө. Хонхор зайг техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлийн дагуу цементэн зуурмагаар шавж гадаргууг янзална.

Хэвийн тулгууруудыг өмнөх тавьсан бетоной нь Инженерийн хэрэглэхийг зөвшөөрсөн эрэг чагтаар холбож боож болно. Хэрвээ бетоны төмөр холбогч нь эрэг чагттай холбоотой бол байранд нь салгалгүй үлдээх төмөр нь бетоны нүүрэн талд 60мм-ээс илүү ойр байж болохгүй.

Хэв хашмалын дотор талыг нь цэвэрлэхэд түвэгтэй бол энэ зориулалтаар хэвэнд түр нээлхий гаргаж өгнө.

Бетоны дотор ба гадна өнцгүүдэд 20мм х 20мм-ийн шинэ хатуу банзны тусламжтайгаар ховил гаргаж өгнө. Инженер өөрөөр заавар өгөөгүй бол ил харагдах бетон гадаргууд цэвэр, тэгш, хэвтээ залгаас үүсгэхийн тулд хэвэнд шинэ 25 мм² -ийн дөрвөлжин хатуу банз суулгаж өгнө.

Хэвийг хийхдээ бетоны овор хэмжээ болон чиглэл нь бүх талаараа ажлын зурагт заасан бүх өгөгдлүүдийг нарийн баримталсан байхаар хольцтой нягт суух байдлаар хийнэ. Арматурын хэвнээс цухуйсан хэсгүүдээр цементийн сүүг гоожуулахгүйн тулд хэвийг арматуруудын эргэн тойронд маш нягт хийнэ.

(4) Хэв хашмалыг бетон цутгахад бэлдэх

Түр байгууламж ба хэвийг угсарсны дараа төмөр арматурыг байрлуулахаас өмнө Гүйцэтгэгч, түр байгууламж ба хэвийг сайтар шалгаж үзнэ. Хэмжээсүүдийг шалгаж, овор товонтой гадаргууг тэгшилж, ялангуяа эрэг чагт, холбоос чанга хийгдсэн эсэх ба суурийн бат бэх байдал зэргийг сайтар анхаарч үзэх ёстой.

Хэв хашмалд арматур суурилуулахаас өмнө хэв хашмалын дотор талыг сайтар цэвэрлэж, техникийн шаардлагын 1318(б) зүйлд заасны дагуу зөвшөөрөгдсөн эмульсээр түрхлэг хийнэ. Зэрэгцээ бетон гадаргуунуудын өнгө өөр өөр болохоос зайлсхийж нэг барилгын ажлын хэв

хашмалд зөвхөн нэг төрлийн эмульс, шингэнийг хэрэглэнэ.

Хэв хашмалыг суулгахаас өмнө арматурыг байрлуулах шаардлага гарвал хэв хашмалын гадаргууг бэлдэх бүх ажлуудыг түүнийг эцсийн байршилд байрлуулахаас өмнө хийж гүйцэтгэнэ.

Арматурыг эмульс шингэнээр бохирдуулж болохгүй. Бетон цутгахаас өмнө хэв хашмалаас бүх хог, шороо, барилгын хаягдал болон бусад гаднын материалыг гарган хаяна. Гүйцэтгэгч бетон цутгаж эхлэхээс өмнө бүх шаантаг ба тохиргооны хэрэгслүүдийг бетон цутгах үед хөдлөхөөс хамгаалж бетоныг цутгах үед тэдгээрийг хөдөлгөөнгүй байлгах талаар байнга хяналт тавьж байна.

Гүйцэтгэгч, хэв хашмал, тулах түр байгууламж болон арматур төмрийг байрлуулсны дараа бетон цутгах гэж байгаагаар бетоны ажил эхлэхээс өмнө 24 цагийн өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ. Гүйцэтгэгч Инженерт ийнхүү мэдэгдэхээс өмнө өөрөө ажил нь энэхүү техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байна. Инженер Гүйцэтгэгчид ажил эхлэх зөвшөөрөл бичгээр өгөхөөс нааш бетон цутгах ажлыг эхлэхгүй.

(с) Түр байгууламж ба хэвийг задалж буулгах

(1) Ерөнхий

Гүйцэтгэгч, Инженерийн зөвшөөрлийг бичгээр урьдчилан авахаас нааш түр байгууламж ба хэвийг буулгахгүй. Түр байгууламж болон хэвийг буулгах хугацааг тухай хийцийн байршил ба төрөл, цаг агаарын нөхцөл, бетон хольцод орсон материал болон бетоны бат бэхэд нөлөөлж болох бусад хүчин зүйлүүдийг харгалзан тогтооно.

Хэвийг бетоныг цохиж хөндөлгүйгээр болгоомжтой буулгана. Бетон нь түр байгууламж болон хэвийг буулгах үед бетонд ирж болох аливаа ачааллыг даах хэмжээний хангалттай бат бэхтэй болтол хэвийг салгахгүй.

Бетонд хэт их ачаалал өгөх эсвэл гадаргууг гэмтээж болох аргаар хэвийг буулгаж болохгүй. Хийц нь жигд, аажмаар өөрийн жингийн ачааллаа авах боломжтой байдлаар тулгууруудыг буулгана. Инженер өөрөөр заагаагүй бол гүүрийн хашлагыг барихаас өмнө хэв хашмалыг буулгана.

(2) Хэв хашмалыг салгах хугацаа

Бетоныг цутгаж дуусах ба хэв хашмал, түр байгууламжийг буулгах хоёрын хооронд өнгөрөх хамгийн бага хугацаа 0°C - 25°C хэмийн орчны температурт ямар байхыг хүснэгт 13-11-т өгөв. Дээр зааснаас бага температурт буюу энгийн ба сульфатад тэсвэртэй портландцементээс бусад төрлийн цемент хэрэглэж байгаа бол Инженер өөр хугацаа өгч болно.

Хүснэгт 13–11: Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа
(энгийн болон сульфатад тэсвэртэй портландцемент бетон)

Хэв хашмалын төрөл	Орчны дундаж температур					
	Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа					
	25° C	20° C	15° C	10° C	5° C	0°

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Багана, хана ба том дам нурууны босоо хэв хашмал	9 өдөр	0 өдөр	12 өдөр	15 өдөр	20 өдөр	30 өдөр
Хавтангийн хэвтээ хавтгай хэв хашмал	3 өдөр	3 өдөр	4 өдөр	5 өдөр	7 өдөр	10 өдөр
Дам нуруу болон дам нурууны тулгуурын хэвтээ хавтгай хэв хашмал	7 өдөр	8 өдөр	10 өдөр	13 өдөр	17 өдөр	25 өдөр
Дам нурууны тулгуурын хэв хашмал	10 өдөр	12 өдөр	14 өдөр	18 өдөр	24 өдөр	36 өдөр

Бетоноос авсан шоог эх бетоной адил арчилж, бэхжүүлсний дараа шооны бат бэх (хүснэгт 13-12)-г өгөгдсөн бат бэхтэй болсон хойно хэв хашмал ба түр байгууламжийг буулгаж болно.

Хүснэгт 13-12: Хэв хашмалыг салгахаас өмнөх бетон шооны бат бэх
(Энгийн болон сульфатад тэсвэртэй портландцемент бетон)

Түр байгууламж ба хэв хашмалын төрөл	Хэвийг буулгахаас өмнөх шооны 28 хоногийн бат бэх %
Багана, хана ба том дам нурууны босоо хэв хашмал	30
Хавтангийн хэвтээ хавтгай хэв	35
Дам нуруу болон дам нурууны тулгуурын хэвтээ хавтгай хэв	40
Props to beams	50

Эдгээр шаардлагыг биелүүлэх нь Гүйцэтгэгчийг бетоныг гэмтээлгүйгээр хэв хашмалыг хугацаанд нь салгах хариуцлагаас чөлөөлөхгүй.

Хэв хашмалыг буулгасны дараа дараагийн ажилд хэрэглэгдэхгүй, бетоны нүүрэнд байгаа эрэг чагтны нүхнүүдийг хольцоор сайтар бөглөж, техникийн шаардлагын 1317 (а) дэд зүйлийн дагуу өнгөлнө.

(3) Хязгаарлалт

Дор дурдсанаас бусад тулах түр байгууламж болон хэв хашмалыг буулгана. Үүнд:

- Замын далангийн хөлдөлтөөс хамгаалах үеэс доош 0.3 м-ээс илүү гүнд байгаа, эсвэл замын далангаас гадна ул хөрсний төвшнөөс 0.6 м болон урсгал залах сувгаас 0.6 м доош гүнд байгаа тулах түр байгууламжийн тулгуурын хэсэг;
- Хэв хашмалыг нь салгавал бусад хэсгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй суурийн хэв хашмалууд;
- Хүрч болохооргүй хаалттай хэсгүүдийн хэв хашмал;
- Зурагт үзүүлсэн бусад байгууламжийг нэмж угсрахад тэдэнтэй харьцдаггүй

- хайрцган дам нуруут гүүрнүүдийн хэв хашмал.

1319. ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ (ЦЕМЕНТИЙН УУСМАЛ БА ЗУУРМАГ)

(а) Ерөнхий

Энэ хэсэгт бетон хийцэд ашиглах зуурмагийн тухай заасан байгаа. Тухайлбал чулуун бэхэлгээнд орох, гадаргуугийн нүх болон бусад гологдлыг засах, бэхэлгээний боолтын хөндийг дүүргэх гэх мэт ажлуудад хэрэглэгдэнэ.

Зуурмаг түрхэх гадаргуу дахь бүх сул ба гаднын материалыг цэвэрлэнэ. Дараа нь зуурмаг хийхээс өмнөхөн тэдгээрийг усаар урсган гадаргууг хатаана.

Бага хэмжээний зуурмагийг гараар зуурч болох боловч 0.5м^3 -ээс их зуурмагийг зуурагчаар зуурна. Зуурсны дараа зуурмагийг усаар шингэлж болохгүй ба нэг цагийн дотор дэвсэх хэрэгтэй.

Зуурмагийг дэвссэний дараа техникийн шаардлагын дэд зүйл 1312 (в) (2)-ийн дагуу 5-аас доошгүй хоног усаар арчилна.

(b) Нийтлэг зорилгоор ашиглах зуурмаг

Зуурмаг нь техникийн шаардлагын дэд зүйл 1303 (г)-д заасан шаардлагыг хангасан нарийн чулуун материал болон AASHTO M85 стандартыг хангасан IA ангиллын портландцементээс бүрдэнэ. Зуурмагийн орцыг зурагт болон техникийн шаардлагад заасны дагуу орцлох ба хэрэв алинд нь ч заагаагүй бол цемент- чулууны жингийн харьцаа 1:2 байна.

Зуурмаг дахь усны агуулга нь аль болох бага байх ба ямар ч тохиолдолд ус/цементийн харьцаа нь 0,5-аас ихгүй байна. “Хуурай чигжээс” гэх зуурмаг нь хольцыг барьцалдуулахад хангалттай хэмжээний устай боловч гарт базах үед уян биш байна. Хуурай чигжээсийг хөндий рүү гар чигжигчээр дүүргэж, гүйцэд нягтралтай болгох үүднээс гар алхаар сайтар чигжинэ.

(c) Хонхор ба нүхийг чигжих

Хонхор ба нүхнүүдийг өндөр даралтын агаар болон ус шүршигчээр сайтар цэвэрлэнэ. Алмаазан хошуутай өрмөөр өрөмдсөн нүхнүүдийг барзгар болгоно. Цэвэр ус ба цементийг жингийн 1:2 харьцаагаар хольсон шингэн зуурмагаар хонхор, нүхнүүдийг дүүргэнэ. Бүх нүхийг дүүрэнгүүт шингэн зуурмаг хийхээ зогсоож, бетон суурь дээр гоожсон зуурмагийг сайтар цэвэрлэн дараагийн ажил хийгдэхээс өмнө гадаргууг хатаана.

(d) Суурийн хавтангуудын доорх чигжээс

Суурийн хавтангууд болон бетон дэвсгэр үеийн завсрыг портландцемент болон нарийн ширхэгтэй чулууг 1:1 харьцаагаар хольсон тусгай зуурмагаар дүүргэнэ. ASTM C845-ийн шаардлагад нийцсэн, Инженерийн зөвшөөрсөн агшилтын эсрэг үйлчилгээтэй нэмэлт бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу орцлон нэмж холино.

Тусгай зуурмагийн ус/цементийн харьцаа нь зуурмагийг хамгийн их нягт авахаар нягтруулж чигжихэд хангалттай боловч аль болох бага байна. Тусгай зуурмагийг суурийн хавтангийн доогуур хэвтээ чиглэлд дүүргэх ба нөгөө гурван талаар зуурмаг гарч иртэл алхаар чигжинэ. Зуурмагийг ямар ч агаарын зайгүй нягтруулах үүднээс шахагдан гарч ирсэн зуурмагийг алхаар буцааж чигжинэ.

1320. БЕТОН ЦУТГАЛТЫН АЖЛЫН БҮРТГЭЛ

Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн маягт дээр бетоны цутгалт бүрийн тухай бүртгэл хөтөлнө. Энэ бүртгэлд дараах зүйлүүдийг багтаана.

Үүнд:

- Бетоны төрөл;
- Бетоны суулт;
- Цутгасан байршил;
- Цутгасан огноо, цаг;
- Дэвсэх үеийн орчны болон бетоны температур;
- Чулуун материалын чийгийн агуулга;
- Хольцын найрлага;
- Зууралтын дугаар;
- Цементийн нийлүүлэлтийн дугаар;
- Бэхжих үеийн орчны температур;
- Туршилт, шинжилгээнүүдийн хариу;
- Туршилтын шоо авсан байршил ба шооны өгөгдлүүд;
- Өрөмдлөг хийсэн тухай тодорхойлолт.

Гүйцэтгэгч 7 хоног бүр өнгөрсөн долоо хоногт гүйцэтгэсэн ажлыг тусгасан эдгээр бүртгэлийн 4 хувийг Инженерт өгнө.

Үүнээс гадна 28 хоног дахь шооны бат бэх, нормоос зөрсөн хэлбэлзлийг сар тутмаар болон өссөн байдлаар (хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)-ийн шаардсан бетоны ажилтай холбоотой бусад мэдээллийг Инженерт гаргаж өгнө.

1321. СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСАХ

Хэвийг салгасны дараа бетоны гадаргуу элдэв согогтой байвал гадаргууг Инженерт үзүүлж заавар авахаас нааш Гүйцэтгэгч гадаргууг засварлах ёсгүй. Согогтой гадаргууг шаваасаар засаж болохгүй. Гадаргуун засварын ажлыг техникийн шаардлагын 1317 (б) дэд зүйлийн дагуу гүйцэтгэнэ.

Инженер засварлахыг зөвшөөрсөн сийрэгжиж, арзайсан гадаргууг бат бэх бетон гарч иртэл буюу 75 мм гүн ухаж авна. Хэрвээ төмөрбетон байгаа бол арматураас цааш 25мм гүн ухаж авна. Гарсан нүхний тал бүрийг тэгш өнцөгт болгож засна. Хөндийг даралтат ус шүршигч буюу агаараар үлээлгэж цэвэрлэсний дараа зөвшөөрөгдсөн резин, цавуу түрхсэний дараа нэн даруй их биед хийсэн бетонтой адил ангиллын, гэхдээ 10 мм-ийн хэмжээтэй чулууг нь авсан бетоноор дүүргэнэ. Бетоноор хөндийн дээд ирмэгийн дээд цэг хүртэл дүүргэж өгнө.

Долоо хоногийн дараа бетоны ирмэгийг тайрч аваад гадаргууг тэгшилнэ.

Техникийн шаардлагын 302 (ж) дэд зүйлд тодорхойлсон хүлцэх алдааны хязгаараас давсан гадаргуугийн тэгш бус хэсгүүдийг зэрэгцээ гадаргуунуудын шилжих налуу 1:50-аас бага байхаар Инженерийн зааварчилсны дагуу тэгшилж засна. Дээр зааснаас бусад согогийг Инженерийн зааварчилсны дагуу засна.

1322. БЕТОНД ХИЙХ АРМАТУР

(а) Ерөнхий

Энэ зүйл нь цутгамал бетонд орох иржгэр арматур ба ган хийцийн тухай болно.

Бүх арматур нь догшин налархайшилттай, барзгар арматур байх бөгөөд дараах ААSНТО стандартыг хангасан байна. Үүнд:

BS 4449 Карбон ган төмөр арматур

BS 4482 Бетоны арматурт хэрэглэх төмөр утас

BS 4483 Бетоны арматурт хэрэглэх ган хийц

AASHTO M 31 M Иржгэр ба цулгуй ган арматур

AASHTO M 221 M Бетоны арматурт хэрэглэх төмрөөр гагнасан, барзгар утсан материал,

AASHTO M 225 M Бетоны арматурт хэрэглэх барзгар төмөр утас

(b) Арматурт хийх шинжилгээ, туршилтууд

Гүйцэтгэгч, Инженерийн баталсан үйлдвэрлэгчээс арматур нийлүүлэх ба үйлдвэрлэгчийн гэрчилгээг Инженерт танилцуулна.

Гүйцэтгэгч барилгын ажилд ашиглахаар төлөвлөж буй бүх арматур төмрийг Инженерийн зөвшөөрсөн лабораторид ААSНТО стандартын дагуу туршиж туршилт бүрийн 2 хувь гэрчилгээг Инженерт танилцуулна.

Шинжилгээ, туршилтын давтамжийг тухайн ААSНТО стандартын дагуу тогтооно. Дээрх туршилтуудаас гадна Гүйцэтгэгч Инженерээс шаардаж болзошгүй нэмэлт туршилтуудыг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч техникийн шаардлагад нийцээгүй аливаа арматур төмрийг ажлын талбайгаас зайлуулна.

(c) Арматурыг тээвэрлэх ба хадгалах

Арматурыг урт чигээр нь, тайрч эсвэл гэрээний шаардлагын дагуу нугалж авчирна. Тээвэрлэхэд хялбар болгох үүднээс уртаар нь нугалж авчирсан арматурыг хэрэглэж болохгүй.

Арматурын төмрийг чигээрээ нугалрахгүй, аливаа гэмтэл авахааргүй, мөн бохирдохгүй байхаар хатуу суурь дээр байрлуулсан тавиур дээр хурааж хадгална. Удаан хугацаагаар

хадгалж болзошгүй төмрийг зэврүүлэхгүй байх үүднээс цаг агаарын нөлөөллөөс хамгаалж өгнө. Зэвэрсэн төмөр нь Инженерийн үзэж байгаагаар чанараа алдсан бол талбайгаас зайлуулах буюу техникийн шаардлагын 1322 (б) дэд зүйлийн дагуу AASHTO стандартад нийцсэн аргаар гүйцэтгэгчийн зардлаар туршина.

(d) Арматурыг нугалах бүдүүвч

Ажлын зураг дээр заагаагүй бол Гүйцэтгэгч арматурыг нугалах бүдүүвчийг Инженерт танилцуулж, шалгуулан зөвшөөрөл авна. Арматурыг нугалах схем нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Арматурын байршил ба байрлуулах аргачлал;
- Холбогдох тэмдэглэгээ;
- Гангийн марк;
- Хэмжээний заалт;
- Арматурын тоо;
- Арматурын урт;
- Арматурын хэлбэр;
- Тайлбар.

Дээрх жагсаалтыг Инженер батлахаас нааш арматурын ажлыг эхэлж болохгүй. Нугалах бүдүүвчийг Инженер батлах нь Гүйцэтгэгчийг арматурыг нарийвчлалтай үйлдвэрлэх хариуцлагаас чөлөөлөхгүй. Ажлын зурагт нийцүүлэн нугалах бүдүүвчийн дагуу материалыг шалгах ажил Гүйцэтгэгчийн зардлаар хийгдэнэ.

(e) Үйлдвэрлэл

(1) Таслах ба нугалах

Зураг дээр өөрөөр заагаагүй бол, таслах ба нугалах ажлуудыг төмөр бетоны ACI 318 барилгын нормын дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч арматурыг нугалах бүдүүвчийг нарийвчлан мөрдөх ба арматурыг зургийн дагуу таслах, нугалах хариуцлага хүлээнэ. Хэрэв нугалах бүдүүвч болон ажлын зургийн хооронд зөрүү гарвал Гүйцэтгэгч Инженерт даруй мэдэгдэнэ.

Арматуруудыг удаан тогтмол даралтаар нугална. 5°C-аас доош температурт нугалах төмрийг хугарахаас хамгаалах шаардлагатай бол нугалах хугацааг удаашруулна. Үйлдвэрлэлтийн хүлцэх алдаа ACI 315-ын дагуу байна. Арматурыг нугалсны дараа багцлан боож, ACI 318-т заасны дагуу тод шошго, тэмдэг тавина. Өндөр налархайшилтай арматурыг халаах ба нугалахыг зөвшөөрөхгүй.

(2) Хаяглах

Арматурын төмрийг стандартын багцаар боож “Бетоны арматур төмрийн институтийн гарын авлага”-д заасны дагуу хаяглаж тээвэрлэнэ.

(f) Арматурын гадаргууг арчлах

Арматурыг байрлуулах үед түүн дээрх зэв, өнгөр, хольц, будаг, тос болон бусад

барьцалдалтыг багасгаж болох зүйлээс цэвэрлэсэн байна. Арматур нь ан цав, үе хагарал гэх мэт согоггүй байна. Хэрэв төмрийн гадаргуу дээр тогтсон зэв, гадаргуугийн барзгар, нунтаг хагийг сайтар цэвэрлэсэн бол арматурыг ажилд хэрэглэж болно. Гэхдээ ийнхүү төмөр утсан сойзоор цэвэрлэсэн арматурын хэмжээ, хөндлөн огтлол болон сунах шинж чанар нь заагдсан арматурын марк хэмжээнд тавигдах шаардлагыг хангаж байх ёстой.

(g) Арматурыг байрлуулах ба бэхлэх (боох)

(1) Ерөнхий

Төмөр арматурыг ажлын зурагт заасны дагуу бетон цутгахын өмнө ба цутгах үед тогтвортой байхаар байрлуулна. Арматурыг бетон цутгалтын үеэр хөдөлгөөнгүй байхаар сайтар бэхэлж өгнө. Инженер өөрөөр зааварлаагүй бол огтлолцох арматуруудыг 1,25 мм-ээс багагүй голчтой шатааж, цайрдсан төмөр утсаар холбож утасны үзүүрүүдийг бетоны их бие рүү хийнэ. Гүйцэтгэгч ил гарсан арматуруудыг муруйх, хөдлөх буюу эвдэрч гэмтэхээс сэргийлнэ. Гүйцэтгэгч бетоноос ил цухуйн гарсан арматуруудыг түр нугалах шаардлагатай болбол нугалах радиус нь зөөлөн төмөр арматурын голчийн дөрөвний нэгээс их байх буюу догшин налархайшилтай арматурын голчоос зургааны нэгээс их байна. Эдгээр нугалсан арматуруудыг бетон цутгалт эхлэхээс өмнө ямар нэг долгион үлдээлгүйгээр эсвэл арматурын орчмын бетоныг эвдэлгүйгээр тэгшилнэ.

(2) Тулах систем

Арматурын төмрийг байх ёстой байршилд цементэн блок, төмөр арматуран тулгуурууд, нэмэлт арматурууд, эсвэл бусад зөвшөөрөгдсөн хэрэгслүүдийг ашиглан байрлуулна. Эдгээр тулгууруудыг байршуулахдаа арматур болон хэвлэмэл гадаргуугийн хоорондох зохистой зайг барих ба арматураас бетон хавтангийн дээд гадаргуу хүртэлх зайг зурагт заасан хэмжээнээс 5 мм-ийн хязгаарт байхаар байрлуулна. Бетон цутгах үед хүмүүс болон тоног төхөөрөмж байрлуулах ажлын тавцанг арматур дээр тавьж болохгүй.

(3) Цементэн гулдмай

Цементэн гулдмайн шахалтын бат бэх нь суурилуулах бетоныхоос бага байж болохгүй. Гулдмайн хэв хашмалтай харьцаж байгаа тал нь 50 мм х 50 мм-ээс хэтрэхгүй хэмжээтэй байх ба бетонон гадаргуутай ижил өнгө хээтэй байна. Цементэн гулдмай нь 1,25 мм-ийн голчтой шатааж, цайрдсан төмөр утсаар арматурт бэхлэгдэнэ. Инженер зөвшөөрвөл зай баригч гулдмайн тохирох төрлийг хэрэглэж болно.

(4) Тулгуур бэхэлгээ

Тулгуур болгож хэрэглэх төмөр нь “Төмөр бетоны институтийн стандартын гарын авлага”-ын шаардлагыг хангаж байх ёстой. Ил гарах гадаргуугийн хэв хашмалд тулах эдгээр тулгуур нь ASTM A493, Ангилал 430 стандартын зэвэрдэггүй ган бүхий “хамгийн их хамгаалалттай” - Ангилал 1 эсвэл, “дунд зэргийн хамгаалалттай” Ангилал 2-ын төмөр байна.

(5) Арматурыг гагнах

Бетон хийцийн арматурыг Инженер бичгээр зөвшөөрөл өгсөн тохиолдолд гагнана. Гагнуур хийхдээ Америкийн гагнуурын нийгэмлэгийн “Барилгын гагнуурын журам, арматур

төмөр, AWS D1.4"-ийг буюу зохих тусгай заалтуудыг дагаж мөрдөнө.

(б) Арматурыг залгах

Өөрөөр хийх зөвшөөрөл өгөөгүй бол бүх арматуруудыг зурагт заасны дагуу нийт уртаар байрлуулна. Зурагт зааснаас бусад тохиолдолд арматуруудыг холбоход Инженерийн зөвшөөрлийг бичгээр авсан байна. Холбоосууд нь хоорондоо аль болох хол зайтай байна. Арматурын үзүүрүүдийг зурагт үзүүлсэн уртаар зөрүүлж холбоно. Зурагт заагаагүй бол зөрүүлэх уртыг зам гүүрийн ажилд тавигдах AASHTO стандартын 8.32-р зүйлийн 1-р хэсэгт дурдсан уртаар, эсхүл Инженерийн зааварчилсны дагуу тогтооно.

Зөрүүлсэн холбоосуудыг ажлын зурагт буюу техникийн шаардлагын 1310 (д) дэд зүйлд заасан бетоны гадаргуу ба арматурын хоорондох зайг баримтлан төмөр утсаар ороож бооно. Инженер зөвшөөрсөн тохиолдолд холбоосыг техникийн шаардлагын 1322 (ё) (5) дэд зүйлийн дагуу гагнаж болно. Гүйцэтгэгч, Инженерээс урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр арматурыг механик холбогч буюу муфтаар холбож болохгүй. Механик муфтын таталт болон шахалтын бат бэх нь догшин налархайшилттай арматурынхаас 25%-иар илүү байх ёстой. Арматурыг холбосон механик холбогчоос тус бүр 100 мм-ийн урттай 2 холбогчийг Инженер сонгон авч Гүйцэтгэгч 125%-ийн бат бэхийг шалгана. Сараалж торон арматурыг хооронд нь холбохдоо бүх үзүүрүүдийг сараалжийн төмөр хоорондын зайгаас 1.5 дахин илүү уртаар зөрүүлж сайтар бооно.

1323. ӨӨР ХЭМЖЭЭНИЙ АРМАТУРААР ОРЛУУЛАХ

Зурагт өгөгдсөн арматурыг өөр хэмжээ буюу налархайшлын эсэргүүцэлтэй арматураар зөвхөн Инженерийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр сольж болно. Орлуулах арматурын хөндлөн огтлолын талбай ба налархайшлын эсэргүүцлийн бат бэхийн үржвэр нь зурагт заасан арматуруудынхаас багагүй байх ба “Зам гүүрийн AASHTO” стандартын хэсэг 1, зүйл 8.16.8.4-ын дагуу байна.

1324. УГСАРМАЛ ТӨМӨР БЕТОН

(а) Ерөнхий

Гэрээнд заагдсан буюу Гүйцэтгэгчийн хэрэглэхээр төлөвлөж буй бүх төрлийн угсармал бетоныг энд хамруулж үзнэ.

(b) Угсармал хийцийн хэв

Угсармал хийцийн хэв нь энэхүү техникийн шаардлагын 1318 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байх ёстой. Хэвийг бетон хольц дахь жижиг ширхэглэлтэй хэсгүүд болон цементийн уусмал асгарч гоожихгүйгээр угсарсан байна.

Хэвийг шинэ бетон хольцын жингийн үйлчлэлд сууж, хөдлөхгүй байхаар хатуу суурин дээр байрлуулна. Цутгагдсан хийцийг авах явцад түүнд ямар нэг эвдрэл үүсэхээргүй хэвийг угсарна. Гүйцэтгэгч нь зөвхөн 1318-р зүйлийн (с)-ийн (1)-д заасан шаардлагыг хангаж байх салгах бодисуудыг хэрэглэнэ.

(с) Угсармал хийцийн арматур

Угсармал хийцэд хэрэглэх арматур нь энэхүү техникийн шаардлагын 1322-р зүйлд

заасан шаардлагуудыг хангаж байх ёстой. Бэлэн хэв хэрэглэх гэж байгаа тохиолдолд хэмжээсийн нарийвчлалыг хангах зорилгоор түүнийг арматур байрлуулах кондуктор дээр суулгаж, бетон цутгах явцад хөдлөхгүй байхаар хэвээр хашиж, тулж өгнө.

Гол арматуруудыг бүрэх байдал нь ажлын зурагт заасны дагуу байх ба хэрэв ажлын зурагт хэмжээ өгөгдөөгүй бол 50 мм-ээс буюу шилбэний голчоос багагүй байна. Шилбүүдийг тэдгээрийн хоорондох цэвэр зай нь чулууны хамгийн их номиналь хэмжээн дээр 5 мм-ийг нэмсэнтэй тэнцүү буюу ямар ч тохиолдолд шилбэний голчоос багагүй байхаар байрлуулна.

d) Угсармал хийцийг цутгах

Угсармал хийцэд хэрэглэх бетон нь ажлын зурагт өгсөн маркийн бетон байх ба энэхүү техникийн шаардлагын 1303-аас 1310-р зүйлүүдэд заасан шаардлагуудыг хангаж байх ёстой. Хөнгөн дүүргэгчүүд нь AASHTO M 195 стандартын шаардлагад нийцсэн байна.

Хийцийг цутгах гэж буй талбай нь ус, бороо, нар, салхинаас зохих байдлаар хамгаалагдсан, тэгш гадаргуутай байх ёстой.

Хийцүүдийг ажлын зурагт заасан хэмжээ болон хүлцэх алдааны дагуу цутгаж хэлбэржүүлнэ.

(e) Угсармал хийцийг бэхжүүлэх

Бэхжүүлэх ажил нь энэхүү техникийн шаардлагын 1312-р зүйлд заасан шаардлагыг хангаж байх ёстой. Гүйцэтгэгч нь бэхжүүлэх явцад уг хийцийг цутгаснаас хойш доод тал нь 4 хоногт температурын огцом өөрчлөлтөд орох буюу чийг нь алдагдахаас сэргийлэх хэрэгтэй.

Бэхжүүлэх явцад усаар шүршиж, норгох шаардлагатай бол хэрэглэх ус нь уг хийцийн температураас 5⁰C хэм дотор байна.

Хэрэв Гүйцэтгэгч өндөрсгөсөн температурт бэхжүүлэх арга ашиглахаар төлөвлөж байгаа бол Инженерээс зөвшөөрөл авах ба уг аргад хийцийг халааж, температурын огцом өөрчлөлтгүйгээр хөргөх хэрэгслийг ашиглана.

(f) Угсармал хийцийг зөөх, хадгалах

Угсармал хийцүүдийг аливаа эвдрэлээс сэргийлсэн байдлаар зөөх бөгөөд хатуу, ус үл нэвтрэх суурин дээр хадгална. Угсармал хийц болон ердийн байдлаар арматурласан том хэмжээтэй цутгамал хийцүүдийг хадгалахдаа тэдгээрийн ажилд тавигдах эцсийн байрлал дээр ирэхээс өөр нэмэлт ачаалал өгөгдөхгүй байхаар байрлуулна.

Ажлын зурагт заасан байрлалын дагуу хийцүүдэд зохих дэгээ, гогцоо, нүх хийж өгөх ба зөвхөн тэдгээрийг ашиглаж хийцийг өргөж буулгана. Дэгээ буюу нүх хийх боломжгүй бол татлага хийхэд тохиромжтой газрыг хийц дээр тосон будгаар тэмдэглэж өгнө.

Угсармал хийцүүд дээр тэдгээрийн дугаар, цутгасан огноог арилахааргүй тэмдэглэнэ. Хийцүүдийг бетонд ямар нэг эвдрэл үүсэхээргүй буюу гадаргуугийн өнгө алдагдахгүй байхаар, тохирох хавтан буюу түшлэг дээр хураана.

Хийц бүрийн дор байх хавтан нь хоёроос ихгүй байх бөгөөд тэдгээрийг хөдөлгөөнгүй тулж өгөх буюу хийц дээр ирэх ачаалал хамгийн бага байх байрлалд тавина.

(g) Угсармал хийцийг шалгаж, турших

Угсармал хийцүүд нь тооцоолсон ачааллыг дааж чадахуйц байх ёстой. Гүйцэтгэгч нь

Инженерийн сонгосон хийцүүд дээр ажлын нөхцөлтэй ижил загварын ачаалал өгч туршина. Туршилтаар гүйцэтгэх зүйлсийг Гүйцэтгэгч, Инженер хоёр зөвшилцөж тохирсон байна.

Туршилтад хэрэглэх угсармал хийцийг нийт алгаслын дагуу дороос нь тулах ба хийцийн тооцоонд авч үзсэн үл хөдлөх ба хөдөлгөөнт ачаануудын нийлбэрийг 1.25 дахин авсантай тэнцэх хэмжээний ачааллыг өгч нэг цагийн туршид барина. Энэ үед эвдрэлийн ямар нэг шинж тэмдэг гарахгүй байх ёстой. Ачааг авсны дараа нэг цагийн дотор буцаж хэвдээ орох байдал нь бүрэн ачааллын үеийн хотойлтын 75 хувиас багагүй байх ёстой.

Хэрэв туршсан угсармал хийц нь дээрх шаардлагуудыг хангаж чадахгүй бол дахин хоёр хийц дээр туршилт хийх ба эдгээр нь мөн л шаардлага хангаж чадахгүй бол бүх хийцүүдийг гологдол болгоно. Инженер шаардсан тохиолдолд хийцүүд дээр эвдлэх туршилт хийнэ.

Хийцийг нийт алгаслын дагууд нь тулах ба ачааг Инженерийн зааварчилсан нэмэлтийн дагуу тооцоот хамгийн их ачааны 95 хувьд хүртэл өгнө. Уг ачааг 15 минутын туршид барина. Энэ хугацааны төгсгөлд байх хотойлт нь алгаслын 2.5 хувиас ихгүй байх ёстой. Ачааг цаашид уг хийц эвдрэлд орох хүртэл нэмж өгнө.

Хэрэв хийц нь тогтоосон хугацаанд шаардлагатай ачааг тэсвэрлэж чадахгүй эвдрэх буюу хотойлт нь тогтоосон хэмжээнээс хэтэрвэл Инженер дахин хоёр туршилт хийлгэх ба эдгээр нь мөн шаардлага хангахгүй бол тухайн хэсгийн бүх хийцийг гологдол болгоно.

1325. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(а) Зүйл Төмөр бетон (арматурын үнэ ороогүй)

Нэгж: м³

Арматурын үнэ ороогүй төмөр бетоны хэмжих нэгж нь зурагт үзүүлсэн буюу Инженерийн заасан тухайн байршил бүрт цутгасан бетоны шоо метр байна.

Эзлэхүүнийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн заасан хэмжээг үндэслэн тооцно.
Үүнд:

(1) Эрэг, чагтны нүх зэрэг 0,15 шоо метрээс бага эзлэхүүнтэй цутгамал хэсгүүд, үүнээс дээш эзлэхүүнтэй ажлын хэмжээг хасна;

(2) суурь, гударга, ус хязгаарлагч ба дөрвөлжин ховилууд, догол, ховилт залгаа, ирмэгийн даруулга гэх мэт 100 мм буюу түүнээс бага өргөнтэй ажлууд, үүнээс дээш өргөн бүхий ажлын хэмжээг хасна;

(3) арматур;

(4) арматур сүвлэх хоолой.

Арматурын үнэ ороогүй төмөрбетоны нэгж үнэлгээнд дараах ажлууд багтсан байна.

Үүнд:

- Цемент, буталсан чулуу, элс, ус, нэмэлт бодисууд болон бетон хольцтой ажиллахад хялбар болгох зориулалттай бодисыг нийлүүлэх, тээвэрлэх болон тэдгээрийн тодорхойлолтыг танилцуулах;

- Орцлох, холих, тээвэрлэх, өргөх, цутгах, нягтруулах, арчлах, орчны нөлөө болон дулаанаас хамгаалах зурагт заасан хэвлэмэл бус гадаргууг өнгөлөх;

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- Хэвлэмэл гадаргууг ердийн өнгөлгөөгөөр өнгөлөх;
- Хэв хашмал болон түр байгууламж;
- Налуу гадаргууд дэвсэх;
- Ухмалын гадаргууд бетон цутгах, нягтруулах ба илүү ухсан ажлын зайг бетоноор дүүргэх;
- Тулгуур, хоолойн босоо хана болон далавчинд ус зайлуулах нүх гаргах;
- Бетон хавтангаас ус зайлуулах тоноглол суулгах;
- Техникийн шаардлагын зүйл 1301-1314, 1316-1318, 1320-1322 болон 1325 заасан шаардлагыг хангах.

Ухмалын гадаргууг янзлах, засах ажилд нэмэлт төлбөр хийхгүй.

(b) Зүйл: Ердийн бетон (арматургүй)

Нэгж : м³

Арматургүй ердийн бетоны хэмжих нэгж нь зурагт үзүүлсэн буюу Инженерийн заасан тухайн байршил бүрт цутгасан бетоны шоо метр байна. Эзэлхүүнийг зурагт үзүүлсэн буюу Инженерийн заасан хэмжээг үндэслэн тооцно.

Энэ ажилд тулгуурын толгой, дамжих хавтан, явган зам дор тэгшилгээний зориулалтаар дэвсэх бетон болон ул бетоны ажил орно. Хатуу материал дээр дэвссэн ул бетоны эзлэхүүнийг 130 мм-ээс илүү зузаанаар тооцохгүй. 130 мм-ээс илүү дэвссэн зузааны зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Арматургүй ердийн бетоны үнэлгээг техникийн шаардлагын 1325 (a) дэд зүйлийн дагуу тогтооно.

(c) Арматур төмөр

Нэгж: тонн

Арматур төмрийг тонноор хэмжинэ.

Арматур төмрийг техникийн шаардлагын 1325 (c) дэд зүйлийн дагуу хэмжинэ.

Өндөр налархайшилттай үечилсэн ган төмрийн жинг арматурын ажлын бүдүүвчээс харж тодорхойлно. Төмрийг ороогоод илүү гарах төмрийг тайрах зааг хэлбэлзэж болохгүй. Төмрийн нягтралыг нэг шоо метрт 7.850 тонн байхаар авна.

Хүчитгэсэн арматурын жинг арматурыг нугалах ажлын графикаас тооцож авна. Таслахад үүсэх хаягдал буюу ороож эвхэхэд гарсан хугацаа зэргийг нэмж тооцохгүй.

Арматурын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтсан байна. Үүнд:

- ✓ Ган төмрийг нийлүүлэх, тээвэрлэх, хураах, хадгалах;
- ✓ Тайрах;
- ✓ Зурагт зааснаас гадна арматурыг холбох;

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- ✓ Зөрүүлэх, нугалах, матах;
- ✓ Тайралтаас гарсан илүүдэл;
- ✓ Төмрийг цэвэрлэх;
- ✓ Зай баригч;
- ✓ Төмөр тулгуур болон бусад бэхэлгээг нийлүүлэх байрлуулах;
- ✓ Гагнах;
- ✓ Арматурыг хэвэнд байрлуулж, төмөр утас болон бусад бэхэлгээний материалаар боож бэхлэх;
- ✓ Төмрийг хэвнээс гадна түр нугалах ба тэгшлэх;
- ✓ Арматурыг тойруулан бетон цутгах, нягтруулах;
- ✓ Техникийн шаардлагын зүйл 1322 болон 1323-т заасан шаардлагыг хангах.

(d) Угсармал хийц

Нэгж Төрөл тус бүрт ширхгээр

Угсармал хийц бүтээцийг тогтоосон төрөл тус бүрд ширхгээр хэмжинэ. Угсармал хийц бүтээцийн ажлын өртөг нь бүх материал, хэвлэх, хийцийг цутгах болон энэхүү техникийн шаардлагыг хангахтай холбогдсон ажлуудын зардлыг багтаана.

Угсармал хийцэд орох хүчитгэсэн арматурын багц буюу төмрийг тусад нь хэмжиж төлбөр хийхгүй.

БҮЛЭГ 1400 – ТӨМӨР БЕТОН ГҮҮРИЙН АЖИЛ

/энэ төсөлд хэрэглэгдэхгүй/

БҮЛЭГ 1400 – ТӨМӨР БЕТОН ГҮҮРИЙН АЖИЛ

ДЭД БҮЛЭГ А – УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН УХМАЛ, ДҮҮРГЭЛТИЙН АЖИЛ, УС ЗАЛАХ ДАЛАН, ГҮҮРИЙН ХАМГААЛАЛТЫН АЖИЛ	3
1401. БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	3
1402. УХМАЛЫН АНГИЛАЛ	3
1403. БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЙГ УХАХ	3
1404. УХМАЛЫГ ХУУРАЙ БАЙЛГАХ.....	4
1405. УХСАН НҮХЭНД СУУРЬ БА ЗАХЫН ТУЛГУУР ЦУТГАХ	4
1406. УХМАЛ БА ГҮНЭЭС ГАРСАН ИЛҮҮДЭЛ БОЛОН ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛ.....	4
1407. УХМАЛ БА НҮХИЙГ ДҮҮРГЭХ	4
1408. БАЙГУУЛАМЖУУДЫГ ХАМГААЛАХ	5
1409. УС ЗАЛАХ ДАЛАН БА ШИНЭ ГОЛЬДРОЛ ГАРГАХ УХМАЛ	5
1410. УС ЗАЙЛУУЛАХ ХООЛОЙ БА ЦОРГО	6
1411. УС ТУСГААРЛАГЧ.....	6
1412. ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ	6
1413. ЧУЛУУН АСГААС.....	7
1414. ТҮШИЦ ХАНА /АР ХАНА	7
ДЭД БҮЛЭГ Б – ТУЛАХ ХЭСЭГ	8
1415. ЕРӨНХИЙ.....	8
1416. РЕЗИНЫ ФИЗИК ШИНЖ ЧАНАР	8
1417 ГАН ЯЛТАС	8
1418 БАРЬЦАЛДУУЛАЛТ	9
1419 ҮЙЛДВЭРЛЭЛТ.....	10
1420. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ШИНЖИЛГЭЭ.....	10
1421 ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ	11
1422 ХАДГАЛАХ БА АРЧЛАХ	12
1423. СУУРИЛУУЛАХ	12
1424. АРЧЛАЛТ	13
1425. ДАВИРХАЙТ ЦААСАН ТУЛАХ ХЭСЭГ	13
ДЭД БҮЛЭГ В- ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС	13
1426. ЧИГЖЭЭС БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС	13
1427. ДҮҮРГЭГЧ БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС	15
ДЭД БҮЛЭГ Г ГҮҮРИЙН ХАШЛАГА	16
1428. ЕРӨНХИЙ.....	16
1429. ГАЗАР ДЭЭР НЬ ЦУТГАХ ХАШЛАГА	16
1430. УРЬДЧИЛАН ЦУТГАСАН ХАЙС.....	17
ДЭД БҮЛЭГ Д – ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР	17
1431 РЕЗИНЭН ТУЛАХ ХЭСЭГ	17
1432 ДАВИРХАЙТ ЦААСАН ТУЛАХ ХЭСЭГ	17
1433 ЧИГЖЭЭС БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС	17
1434 ДҮҮРГЭГЧ БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС	18

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

1435	ГҮҮРИЙН ХАШЛАГА.....	18
1436	УС ЗАЙЛУУЛАХ ЦОРГО БА СУВАГ	19
1437	УС ТУСГААРЛАГЧ.....	19
1438	ЗӨӨЛӨН МАТЕРИАЛД БАЙГУУЛАМЖ БАРИХ УХАЛТ ХИЙХ.....	19
1439	ЗӨӨЛӨН МАТЕРИАЛД ГОЛЬДРОЛ ЗАСАХ УХАЛТ ХИЙХ	20
1440	ХАТУУ МАТЕРИАЛЫН УХАЛТ.....	20
1441	ШҮҮРҮҮЛЭХ МАТЕРИАЛ.....	21
1442	ЗОХИСТОЙ ШИРХЭГТЭЙ ДҮҮРГЭГЧ МАТЕРИАЛ	21
1443	ЦЕМЕНТЭН ЗУУРМАГААР БЭХЖҮҮЛСЭН ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ.....	21
1444	ЧУЛУУН АСГААС	22

БҮЛЭГ 1400- ТӨМӨР БЕТОН ГҮҮРИЙН АЖИЛ

ДЭД БҮЛЭГ А – УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖИЙН УХМАЛ, ДҮҮРГЭЛТИЙН АЖИЛ, УС ЗАЛАХ ДАЛАН, ГҮҮРИЙН ХАМГААЛАЛТЫН АЖИЛ

1401. БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү бүлэгт гүүр, туннель дөрвөлжин хоолой, түшиц хана болон бусад байгууламжийн ухмал, дүүргэлтийн ажлуудыг оруулсан. Үүнээс гадна ус залах далан болон гүүрийн хамгаалалтын ажлуудыг хамруулна. Харин замын ухмал болон далангийн ажил энэ бүлэгт хамаарахгүй.

1402. УХМАЛЫН АНГИЛАЛ

Материалыг доор тодорхойлогдсоны дагуу “хатуу”, “зөөлөн” гэж ангилна.

Үүнд: Хатуу материалд зөвхөн тэсрэх дэлбэрэх бодис ашиглан тэсэлгээ хийж ил гаргах эсвэл хийн буюу гидравлик механик ховхлогч царилыг ашиглан ухаж гаргах материал багтана. Зөөлөн материалаас гарсан тусдаа буй чулуу буюу 0.75м³-ээс том хэмжээтэй материалыг хатуу материал гэж ангилна. Зөөлөн материал гэдэг нь дахин хэрэглэхэд тохиромжтой буюу тохиромжгүй, хатуу материалаас бусад бүх материал болно.

1403. БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЙГ УХАХ

Байгууламжууд болон бусад шуудууны суурийг аль болох бага ухна. Ухмалын хажуу талуудыг босоо байдлаар ухах ба эргэн тойрны сул хөрсөнд суулт үүсэх /нурах буюу эвдрэх /-ээс сэргийлэх үүднээс мод эсвэл шпунтан бэхэлгээ /чулуун бэхэлгээ/, тулгуур, тулаас зэргийг хийж өгнө.

Хатуу материалаас бусад материалд хийсэн байгууламжийн суурийн ёроолыг хамгийн их хуурай нягт (MNS ASTM D 1557:2002) -ын 95%-иас дээш байхаар нягтруулна.

Хатуу материалын ухмалын ёроолд хамгийн багадаа 50мм зузаан даац багатай /тэгшилгээний/ бетон дэвсэнэ.

Ухмалд хатуу зөөлөн холимог материал байвал, байгаа материалын үе давхаргаас хамааран Гүйцэтгэгч Инженерийн өгсөн зааврын дагуу суурийн доод төвшингөөс доош 300 мм-ээс багагүй гүнд зөөлөн материалыг зайлуулж, оронд нь тэгшилгээний үеийн дээд хэсэг хүртэл бүтээцийн бус бетон хийх, эсвэл суурийн доод төвшингөөс доош 300 мм-ээс багагүй зузаан хатуу материалыг зайлуулж оронд нь зөөлөн материал дэвсэн, хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулна.

Газрын байдлаас үүдэн шаардлага хангасан суурийг хийх боломжгүй байвал Гүйцэтгэгч нь Инженерийн зааврын дагуу тохиромжтой суурийн материалын үе гарах хүртэл, эсвэл Инженерийн зааварласан гүн ба өргөнд зохисгүй материалыг ухаж зайлуулна. Гүйцэтгэгч нэмж ухалт хийсэн газруудад, даац багатай /тэгшилгээний/ бетоны ёроол хүртэл зөвшөөрөгдсөн материалаар буцаан дүүргэлт хийж ХҮХИ нягтын 95% -иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулна. Ухмал хийсэн хэсгүүдэд барилгын ажил эхлэхээс өмнө Инженерийн зөвшөөрлийг авна.

1404. УХМАЛЫГ ХУУРАЙ БАЙЛГАХ

Бүх ухмалыг хуурай байлгах ба тэдгээрийг усанд автагдах, цас мөсөнд дарагдахаас сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Инженерийн шаардсан тохиолдолд суурийн үеийн гадна талд усгүйжүүлэх насос бүхий худаг барина. Суулт, эвдрэл үүсгэх буюу эргэн тойрны газраас жижиг ширхэгтэй хэсгүүдийг угааж арилгах талтай тул ухмалын усыг хэт их шахуургадахыг үл зөвшөөрнө. Инженерийн үзсэнээр суурь нь зөөлөрсөн буюу тогтворгүй болсон бөгөөд зөвхөн Гүйцэтгэгчийн ажлын арга барилаас үүдэн нэмэлт ухмалын ажил хийх шаардлагатай болсон гэж үзвэл Инженерийн зааварласнаар зөвшөөрөгдсөн материалаар дүүргэлтийг хийж, ХҮХИН-ын 95%-иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулах, эсвэл бетоноор дүүргэлтийг хийнэ. Бүх ухмал болон буцаан дүүргэлтийн ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

1405. УХСАН НҮХЭНД СУУРЬ БА ЗАХЫН ТУЛГУУР ЦУТГАХ

Суурь ба захын тулгуурыг зургийн дагуу буюу Инженерийн зааварласнаар ухсан нүхэнд цутгана. Суурь ба захын тулгуурын нүхийг маш нямбай ухаж шаардлагатай хэлбэрээр засаж тэгшилнэ. Илүү ухсан тохиолдолд суурь ба захын тулгуурын ухсан нүхний ёроолд тэгшилгээний үед хэрэглэхээр заасан бетоной адил зэргийн бетон цутгана. Энэ бетон дүүргэлтийг суурь ба захын тулгуурыг цутгахаас өмнө дэвсэх ба Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

1406. УХМАЛ БА ГҮНЭЭС ГАРСАН ИЛҮҮДЭЛ БОЛОН ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛ

Ухмал ба нүхний илүүдэл материалыг энэхүү техникийн шаардлагын бүлэг 500 ба 600 заасны дагуу хаягдал материал зайлуулах тогтоосон газарт хаях, эсвэл Инженерийн зүгээс ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд газар шорооны ажилд ашиглаж болно.

Байгууламжийн ар хэсэг эсвэл эргэн тойронд буцаан дүүргэлт, чигжээс зэргийг хийхдээ зөвхөн Инженерийн зөвшөөрсөн материалыг ашиглана.

1407. УХМАЛ БА НҮХИЙГ ДҮҮРГЭХ

Гүйцэтгэгч байгууламжийн эргэн тойронд дүүргэлт хийх буюу нүх ба ухмалыг буцаан дүүргэх болон аливаа байгууламжид ачаалал өгөхөөс өмнө Инженерийн зөвшөөрлийг авна.

Байгууламжийн ар тал буюу эргэн тойронд дүүргэлтийн тогтоосон өндөр хүртэл тэдгээрийн төвшний хоорондын дүүргэлт эсвэл буцаан дүүргэлт хийх ажлын төлөвлөсөн дарааллыг Гүйцэтгэгч Инженерт танилцуулж батлуулна.

Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн сонгосон материалыг ашиглан дүүргэлт, буцаан дүүргэлтийн ажлыг хийж гүйцэтгэх ба 150 мм-ээс хэтрэхгүй зузаан хэвтээ үеэр дэвсэж нягтруулна. Үе бүрийг сайтар тэгшилж чигжих шаардлагатай бол хатаах бөгөөд дор хаяж ХҮХИН-ын 95%-иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулна.

Нүхний хажуу ханыг нуралтаас хамгаалах зорилгоор хийсэн модон тулц, шпунтан бэхэлгээг 150мм-ийн шатлалаар нягтруулалт хийсний дараа үечлэн дээшлүүлж сугална. Инженерийн зааварласан газруудад модон тулц буюу шпунтан бэхэлгээг сугалж авахгүй байлгана. Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан газарт Гүйцэтгэгч Инженерийн

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

зөвшөөрсөн ширхэглэлийн бүрэлдэхүүн нь шигшүүрийн №89 (9.5-1.18)мм-д тохирох АASHTO M6 /АASHTO M43-ын шаардлагыг хангасан зохистой ширхэгтэй дүүргэгч материал ба шигшүүрийн №467 (37.5-4.75)мм-д тохирох АASHTO M43-т нийцэх ширхэглэл бүхий шүүрүүлэх материалыг дэвсэнэ.

Гүйцэтгэгч хөдөлгөөнт хашлага буюу Инженерийн зөвшөөрсөн өөр бусад аргыг буцаан дүүргэлтийн үед ашиглаж зохистой ширхэгтэй дүүргэгч материалыг дэвсэхээс өмнө уг үеийг дэвсэн хамгийн багадаа 150 мм хүртэл нягтруулан, дараа нь хажуу хэсгийн газар шорооны дүүргэлтийг хийхээс өмнө тэрхүү зохистой ширхэгтэй дүүргэгч материалын үеийг дэвсэн 150 мм хүртэл нягтруулна. Энэ техникийн шаардлагын бүлэг 500-ын дагуу хийгдэх ёстой ширхэгтэй дүүргэгч материал ба энэхүү техникийн шаардлагын бүлэг 500-ын дагуу хийгдэх хажуугийн газар шорооны ажлын хоорондын зааг нь зурагт үзүүлсний дагуу буюу Инженерийн зааварчилснаар хийгдэнэ. Газрын төвшнөөс дээших хэсэгт даланд хэрэглэж буй материалыг хэрэглэнэ.

1408. БАЙГУУЛАМЖУУДЫГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэгч шаардлагатай усны хаалт, кессон, заамал тулгуур, суваг, судаг, бусад түр зам, хамгаалалтын ажлуудыг хийх, барих, засвар арчлалтыг хангахаар зэрэг ажлыг хийж, ажлын талбайн хэсгүүдэд тогтсон усыг зайлуулахад шаардлагатай насос болон бусад тоног төхөөрөмжийг суурилуулж, ажиллуулан, засвар арчлалтыг хийнэ.

Усны хаалт болон бусад түр суурилуулах байгууламжуудын зураг төслийг түр ажил эхлэхээс өмнө Инженер-т танилцуулж батлуулна. Гүйцэтгэгч тэдгээр байгууламжуудийг суурилуулахдаа ажлын талбайн дээд болон доод хэсэгт үер болох, хүн амьтан, эд хөрөнгөнд аюул учруулахаас зайлсхийнэ. Инженерийн зүгээс өөрөөр заагаагүй бол тэдгээр бүх байгууламжуудыг ажил дуусахад буулгаж зайлуулна.

1409. УС ЗАЛАХ ДАЛАН БА ШИНЭ ГОЛЬДРОЛ ГАРГАХ УХМАЛ

Гол горхины хажуугаар түр зам барих, өргөсгөх, гүнзгийлэх буюу тэгшлэх, эсвэл шинэ гольдрол гаргахад зориулан ухмал хийх ажлыг зурагт заасны дагуу буюу Инженерийн заавраар хийж гүйцэтгэнэ. Энэ ухмалын ажилд талбайн цэвэрлэгээ, налуу засаж тэгшлэх, шороон даланг тэгшлэх, ухмалаас гарсан материалыг зайлуулах гэх мэт ажил багтана.

Усны гольдролыг шилжүүлэх шаардлага гарах эсвэл Инженер зааварчилгаа өгсөн тохиолдолд анхны сувгийн өвс ургамал, зөөлөн хаягдал зэргийг цэвэрлэн зайлуулж, зөвшөөрөгдсөн материалаар буцаан дүүргэж, ХҮХИН-ын 95%-иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулна.

Гүүрийг барих явцад хуучин сувгийг буцаан дүүргэх ажлыг хамтад нь хийнэ. Буцаан дүүргэх ажлыг нэг улирлын дотор хийж гүйцэтгэхийн тулд бүх хүчээ дайчилж ажиллана. Хэрвээ бүх дүүргэлтийн ажлыг нэг ажлын улирлын дотор хийж гүйцэтгэхэд эргэлзээтэй гэж үзвэл Гүйцэтгэгч хийгдэж дууссан ажлыг хамгаалах тохиромжтой арга хэмжээг авна.

Ус залах далан ба хамгаалах бэхэлгээний ажилд чулуун бэхэлгээ ба асгаасны ажлууд багтах ба эдгээр нь үерийн ус, хайлсан цасны уснаас үүсэж болох эвдрэлээс гүүрийн байгууламж ба замуудыг аюулгүй байлгах явдлыг баталгаажуулахад шаардагдана.

1410. УС ЗАЙЛУУЛАХ ХООЛОЙ БА ЦОРГО

Энэ ажилд гүүрийн зорчих хэсгээс ус зайлуулах хоолой ба цорго угсрах ажил орно.

Ус зайлуулах хоолойг зурагт үзүүлсэн хэмжээгээр AASHTO M160 стандартыг хангасан зөөлөн гангаар хийнэ. Ус зайлуулах хоолойг хооронд нь гагнаж холбох ба гагнасны дараа AASHTO M111 стандартын дагуу халуун цайраар цайрдаж бэлтгэнэ. Цайрын зузаан хамгийн багадаа 0.075 мм байна. Ус зайлуулах хоолойг зурагт заасан зайнд байрлуулна.

Бетон цутгахаас өмнө цайрдсан ган тоноглолд хоёр үе битумэн түрхлэг хийж зурагт заасан байрлалд бэхэлнэ. Ус зайлуулах хоолойг хэв хашмалд суулгахад гарсан тэдгээрийн хоорондох завсрыг бетон хольц гадагш гоожихоос сэргийлж сайтар чигжинэ. Цементобетон хучлагыг дэвссэний дараа ус зайлуулах цоргоны орчимд гарсан аливаа хагарлыг зөвшөөрөгдсөн материалаар Инженерийн шаардлага хангах хэмжээнд чигжинэ.

Ус зайлуулах хоолойг шаардлагатай хэмжээгээр уртасгаж, усыг гүүрийн хавтангаас гадагшлуулж зайлуулна.

1411. УС ТУСГААРЛАГЧ

Гүйцэтгэгч ус тусгаарлагч үеийг ажлын зурагт үзүүлсний дагуу Инженерийн заавраар гүйцэтгэнэ.

1412. ЧУЛУУН БЭХЭЛГЭЭ

Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварласан газарт Гүйцэтгэгч суурь, талбайг ухаж, засаж тэгшлэн, чулуун бэхэлгээ хийнэ. Чулуун бэхэлгээг хатуу, бат бөх, ердийн хэлбэртэй чулуугаар хийнэ. Чулуун ордын чулууг ашиглана. Бөөрөнхий хэлбэртэй чулууг ашиглахыг хориглоно. Ус буюу цаг агаарын нөлөөгөөр элэгдэж өгөршсөн чулууг ашиглахгүй.

Том хэмжээтэй чулууг ашиглах бөгөөд Инженер өөрөөр зааварчлаагүй тохиолдолд 35 кг-аас бага жинтэй чулууг хэрэглэж болохгүй. Чулууны хэсгүүдийн хамгийн бага зөвшөөрөгдөх хэмжээ 25 мм байх ба бэхэлгээний зай завсрыг бөглөхөд тохирсон байна. Бэхэлгээний чулууны бэхэлгээний хувийн жин нь хамгийн багадаа 2.40 байна.

Чулуун бэхэлгээ хийх талбайг ухаж, хэлбэржүүлэн тэгшилж, чулуунуудыг тавихад бэлэн болгон ХҮХИН-ын 95%-иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулна.

Бэхэлгээ хийх хажуу налуугийн хормойн дагуу буюу голын гольдролын ёроолд хийгдсэн бэхэлгээний устай харьцах хэсгийн дагуу шуудуу татна. Шуудууны ёроолоос эхлэн чулуунуудыг байрлуулан хажуу налуу дээр чулуунуудыг хооронд нь сайтар чигжиж суулгаж өгнө.

Чулуун бэхэлгээний тогтоосон зузаанаас чулууны хамгийн өргөн тэгш өнцөгтэй тал нь илүү гараагүй л бол тэдгээрийг хажуу налуугийн ирмэг дээр шигтгэн суулгана. Чулуунуудыг хамгаалалт хийх гадаргуу дээр сайтар чигжиж дагтаршуулж хооронд нь зайгүй болтол нь тааруулан байрлуулах замаар маш бага завсар үлдээх ба тэдгээрийг тохирох байдлаар нь зорж хэлбэр гарган шаантагласан үртэс чулуугаар чигжиж дүүргэнэ. Бэхэлгээний дээд хэсгийг залгаа үетэй хамт тэгшилнэ.

Цементэн зуурмаг хийхээр заагдсан газруудад чулууны гадаргууг сайтар цэвэрлэж,

наалдсан хог, шавраас нь салгана. Ус зайлуулах нүх болгон 20%-ийн босоо заадас үлдээнэ гэж Инженер зааварласан гэж тооцон, бүх зай завсрыг нийтэд нь бөглөх үүднээс цемент, элсний 1:3 харьцаагаар бэлтгэгдсэн цементэн зуурмагийг чулуунуудын хоорондох зай завсраар чигжиж шавна.

Цементэн зуурмагийг бэхэлгээ хийсэн гадаргуутай хамт тэгшилж, багсаар сайтар шүүрдэж, цэвэрлэн дээд талын хэсгийг ил гаргана. Цементэн бэхэлгээг нойтон шуудайгаар хучих, эсвэл зөвшөөрөгдсөн аргаар бэхжүүлэх замаар бэхэлгээ хийснээс хойш 7-оос багагүй хоногийн турш цаг агаарын нөлөөнд автахаас хамгаалах арга хэмжээ авна.

Бэлэн болсон налуу буюу чулуун бэхэлгээг хийхийн өмнө гадаргуу дээр чулуун бэхэлгээний зай завсраар дамжин далангийн шүлтгүйжилт үүсэхээс сэргийлэх, бэхэлгээн дээр хөрсний овойлт үүсгэлгүй усыг чөлөөтэй урсгах боломжийг хангах үүднээс шүүрүүлэх үеийг тавина. Чулуун бэхэлгээний дор тогтоосон зузаан бүхий нэг үе шүүрүүлэх үеийг хийнэ. Шүүрүүлэх үед орох материал нь техникийн шаардлагын бүлэг 500 шаардлагыг хангах ёстой.

Чулуун рисберм: Рисбермд ашиглах чулуу нь хатуу, бат бөх, ердийн хэлбэртэй чулуу байна. Ус, цаг агаарын нөлөөгөөр элэгдэж өгөршсөн чулууг ашиглахгүй. Бөөрөнхий хэлбэртэй чулуунаас илүү өнцөг хэлбэртэй чулууг ашиглана. Чулууны хэмжээ нь зурагт заагдсан буюу Инженерийн зөвшөөрсний дагуу байна. Рисбермын хийх гадаргууг зурагт заасан өргөн, уртад тэгшилж бэлтгэнэ.

1413. ЧУЛУУН АСГААС

Чулуун асгаас нь хатуу, бат бөх, чулуун ордоос олзворлосон буюу байгалийн чулуунаас бүрдэнэ. Чулуу нь хамгийн багадаа 75мм зузаан, 23кг-ын жинтэй байх чулууны 60% нь 35кг-аас илүү жинтэй байх ба чулуун асгаасны жигд тархалтыг хангах үүднээс чулуунуудын хооронд шаантаглаж чигжихэд тохирох хэмжээтэй чулууны хэсгүүдийг агуулсан байна. Чулууны хувийн жин нь 2.40г/см^3 –с доошгүй байна.

Чулуун асгаас дэвсэх гадаргууг тэгшилж ХҮХИН-ын 95%-иас дээш байхаар (MNS ASTM D 1557:2002) нягтруулна. Чулуун асгаасыг түүний тогтоосон өндөртэй шуудуунд баригдсан 1м өргөн хуурай чулуун өрлөг ханаар бэхэлнэ.

Инженерийн зааварласан буюу зураг дээр үзүүлсэн хэсэгт нэвчүүлэх материалуудаас ширхэглэлийн бүрэлдэхүүнээр сонгосон шүүрүүлэгч материалыг бэлтгэсэн гадаргуу дээр нэг, эсвэл хоёр үеэр шаардагдах зузаантайгаар дэвсэж, дэвссэн үе бүрийг тэгшилж засна. Шүүрүүлэх материалыг ширхэглэлийн бүрэлдэхүүнээр сонгох нь техникийн шаардлагад нийцсэн буюу Инженерийн зааварласны дагуу байна.

Чулуунуудыг далангийн налуугийн ёроолоос эсвэл газрын хөрснөөс дээш том чулуунуудыг доод хэсэгт нь тавих байдлаар хооронд нь тулгаж байрлуулна. Тэгш, дагтаршуулсан гадаргуу үүсгэх зорилгоор чулуунуудын хоорондох зайг тохиромжтой хэмжээ бүхий чулуугаар шаантаглан чигжинэ.

1414. ТҮШИЦ ХАНА /АР ХАНА

Гүйцэтгэгч зурагт заасан буюу Инженерийн зааварласан чиглэлийн дагуу зохих өргөн, урттай түшиц ханыг барина. Түшиц ханын материал нь энэ техникийн шаардлагын “Бетоны ажил” буюу бүлэг 1500-д тавигдсан шаардлагыг хангасан байна. Бетоны анги нь В30 байна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Шүүрүүлэх материал нь энэ техникийн шаардлагын зүйл 1307 /ё/-ын дагуу байна.

Түшиц ханын араас ус зайлуулах нүх нь 50 мм-ийн голчтой, ханын нийт уртад хийгдэх ба хананы нүүр тал руу чиглэсэн босоо 1 хэвтээ 20-ын налуутай байна. Ус зайлуулах нүхний хоорондын зай нь аль ч чиглэлд 1.0 м-ээс хэтрэхгүй бөгөөд сөөлжүүлэх буюу Инженерийн зааварласны дагуу байрлуулагдсан байна.

ДЭД БҮЛЭГ Б – ТУЛАХ ХЭСЭГ

1415. ЕРӨНХИЙ

Тулах хэсгүүд нь AASHTO M 251-ын шаардлагыг хангасан ба авто замын гүүрийн AASHTO стандартын дагуу төсөлөгдсөн байна.

Тулах хэсгүүдийг зурагт үзүүлсний дагуу буюу энэ техникийн шаардлагад заасны дагуу үйлдвэрлэж суурилуулна. Тулах хэсгүүд нь тулж байгаа хийцүүдийн тэлэлт, гулгалт, эргэлт, агшилт гэх мэт хөдөлгөөнийг хангаж байх үүрэгтэй юм.

Тулах хэсгүүдийн нүүрэн талыг аливаа бохирдлоос хамгаалж хавтанг байрлуулсны дараа түүний ойр орчмыг цэвэр байлгана. Тулах хэсгүүдийг суурилуулсны дараа тэдгээрийн марк болон дугаарыг ил харагдахаар газарт арилдаггүй будгаар тэмдэглэнэ.

Тулах хэсгүүдэд техникийн шаардлагын дагуу зохих шинжилгээг хийж, үр дүнг Инженерээр батлуулахаас нааш талбайд авчирч болохгүй.

1416. РЕЗИНЫ ФИЗИК ШИНЖ ЧАНАР

Түүхий резин нь байгалийн неопрен (полихлоропрен) байна. Резины бүтцийг бага температурын 0, 2, 3, 4 ба 5-р зэргийн гэж ангилна. Зэргийг (хүснэгт 14-1)-д үзүүлсэн шинжилгээний үзүүлэлтийн дагуу тогтооно. Доод зэргийн резиныг дээд зэргийн резинээр орлуулж болно.

Инженер өөрөөр заагаагүй бол резин нь (хүснэгт 14-1)-д үзүүлсэн хамгийн бага шаардлагыг хангасан байх ёстой. Дундаж хатуулагтай байх үеийн шаардлагыг интерполяцийн аргаар тооцож болно. Хэрэв материалыг түүний шилжилтийн модулиар тодорхойлсон бол материалын шилжилтийн модуль нь тогтоосон хэмжээний 15 хувийн дотор хэлбэлзэх ёстой. Мөн (хүснэгт 14-1)-д үзүүлсэн туршилтуудын хязгаарыг тогтоох зориулалтаар хатуулгийн тогтмол хэмжээг тодорхойлох хэрэгтэй.

Хэрэв хатуулаг нь өгөгдсөн бол материалын шилжилтийн модуль нь (хүснэгт 14-2)-т заасан хязгаарын дотор хэлбэлзэх ёстой. Хэрэв дээжийг бэлэн болсон бүтээгдэхүүнээс тайрч авсан бол дээжийн физик шинж чанар нь (хүснэгт 14-1)-д өгсөн үзүүлэлтүүдийн 10%-ийн дотор хэлбэлзэхийг зөвшөөрнө.

Өөрөөр заагаагүй бол материалын бүх шинжилгээг $23^{\circ}\text{C} \pm 2^{\circ}\text{C}$ хэмд явуулна. Шилжилтийн модулийг тодорхойлох шинжилгээг ASTM D4014-ийн хавсралт “А”-д заасан төхөөрөмж болон аргачлалаар гүйцэтгэнэ.

1417 ГАН ЯЛТАС

Инженер өөрөөр заагаагүй бол ган ялтсыг ASTM A 36/A 36M, ASTM A 570M буюу тэдгээртэй адил стандартад нийцсэн зөөлөн, хуйлсан гангаар хийнэ. Зурагт заагаагүй бол ган

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

ялтсанд үйлдвэрлэх зориулалтаар нүх гаргахыг хориглоно.

1418 БАРЬЦАЛДУУЛАЛТ

Тулах хэсэг болон ган ялтасны хоорондын барьцалдуулалтын хуулах эсэргүүцэл 5.2 кН/м-ээс багагүй байна. Ган ялтастай тулах хэсгийн хуулах эсэргүүцэл 6.9 кН/м-ээс доош байж болохгүй. Хуулах эсэргүүцлийг ASTM D429 “B” аргачлалаар тодорхойлно.

Хүснэгт 14-1: Неопрений шинж чанарыг тодорхойлох шинжилгээ.

ФИЗИК ШИНЖ ЧАНАР				
ASTMD 2240	Хатуулаг чанар	50 + 5	60 + 5	70 + 5
D 412	Таталтын хүч, хамгийн бага МПа	15.50	15.50	15.50
	Хамгийн их суналт, хамгийн бага %	400	350	300
ДУЛААНД ТЭСВЭРЛЭХ ЧАНАР/HEAT RESISTANCE				
ASTM D 573 100°C дэх 70 цаг	Хатуулаг чанарын өөрчлөлт, дээд цэг	15	15	15
	Таталтын хүчний өөрчлөлт, хамгийн их %	-15	-15	-15
	Хамгийн их суналт, хамгийн их %	-40	-40	-40
ДАРАЛТ ТЭСВЭРЛЭХ ТУРШИЛТ				
ASTM D 395 Арга В	100°C хэмд 22 цаг, хамгийн их %	35	35	35
Озон ASTM D1149	100 цагийн турш өсгөх арга, "А" аргачлал Method to mounting for 100 hours, method "A"	Хагаралгүй No cracks	Хагаралгүй No cracks	Хагаралгүй No cracks
ХҮИТЭНД ТЭСВЭРЛЭХ ЧАНАР				
ASTMD746 Арга"В"	0 - 2 - р зэргүүдэд туршилт хийх шаардлагагүй			
	3-р зэрэг-40°C хэмд тэсвэрлэх	Тэсвэртэй	Тэсвэртэй	Тэсвэртэй
	4-р зэрэг-48°C хэмд тэсвэрлэх	Тэсвэртэй	Тэсвэртэй	Тэсвэртэй
	5-р зэрэг-57°C хэмд тэсвэрлэх	Тэсвэртэй	Тэсвэртэй	Тэсвэртэй
ТЕМПЕРАТУР УНАХАД ШУУД ХАТУУРАХ ЧАНАР				
D1043	0 - 2-р зэрэг, -31°C хэмд туршихад	Туршилтын температур дахь хатууралт нь 23°C дэх хатууралтаас 4 дахин ихээс илүү байж болохгүй		
	3-р зэрэг, -40°C хэмд туршихад	Туршилтын температур дахь хатууралт нь 23°C дэх хатууралтаас 4 дахин ихээс илүү байж болохгүй		
	4-р зэрэг, - 45°C хэмд туршихад			
	5-р зэрэг, - 54°C хэмд туршихад			
ХҮЙТЭНД ТАЛСТЖИЛТ ЯВАГДАХ				
Дөрвөлжин шилжилтийн туршилт	0 – 1-р -р зэрэгт туршилт хийх шаардлагагүй	Туршилтын хугацаа болон температур дахь хатууралт нь 23°C дэх хатууралтаас 4 дахин ихээс илүү байж болохгүй ба хугацаагаар хоцорч		
	2--р зэрэг- 7 хоног -18 ⁰			
	3--р зэрэг- 14 хоног -26 ⁰ с			
	4--р зэрэг-21 хоног -37 ⁰ с			

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

	5--р зэрэг- 28 хоног -37 ⁰ с	болохгүй. Хатуурлыг битүү хөлдөөгч туршилтын саванд шилжилтийн дөрвөлжин тавцангаар хэмжинэ. Дээжийг дурын сонгож авсан тулах хэсгээс авах ба + 25% даралтын эргэлтээр нэг эргэлтийг 100 секунд үргэлжлэхээр туршина. Эхний эргэлтийн дээжийг хаях бөгөөд дээжийн хатуурлыг дараагийн 3 эргэлтийн хүчний хазайлтын муруйгаас тодорхойлно.
--	---	---

Тайлбар: ASTM D1043 стандарт нь “Хатуулгийн модульд”, ASTM D4014 “Шилжилтийн модуль” тус тус хамаарна.

Хүснэгт 14-2: Янз бүрийн хатуулагтай резины физик шинж чанар

Хатуулаг ('A')	50	60	70
Шилжилтийн модуль (C) (pз^) Фаренгейтийн 73 хэмд (МПа)	95-130 0.68-0.93	130-200 0.93-1.43	200-300 1.43-2.14
25 жилийн дараах гулсах хазайлт Шууд хазайлт	25%	35%	45%
К	0.75	0.6	0.55

1419 ЛДВЭРЛЭЛТ

- Ган ялтастай тулах хэсгүүдийг нэг нэгээр нь тэвшинд хийж дулаан болон даралтын үйлчлэлээр хайлуулж цутгана.
- Тулах хэсгийн эд ангиудыг тус тусад нь цутгаж, дараа нь нийлүүлэх буюу том хэмжээний тулах хэсгийг тайрахыг хориглоно.
- Тухайн нэг гүүрэнд ашиглах ижил хэмжээний тулах хэсгүүдийг ижил аргачлалаар нэг багцаар бэлтгэнэ.
- Тулах хэсгийг бэлдэх тэвшний гадаргууг нь аливаа согоггүй гадаргуу бүхий тулах хэсэг үйлдвэрлэхийн тулд сайтар өнгөлсөн байна.
- Ган ялтасыг наахаас өмнө элсээр шүршиж цэвэрлэн, элдэв нарийн хог, тоосгүй цэвэрхэн болгоно. Зэвэрсэн ган ялтсыг хэрэглэж болохгүй. Ган ялтасны өнцгүүдийг дугуйлсан байна.
- Ялтсыг зөв байрлуулах зорилгоор ашиглах зай авагч блокийг аль болох олон болон том хэмжээтэйг хэрэглэнэ. Ялтасны гадаргууд болон ирмэгүүдэд гарсан нүхийг бөглөнө.

1420. ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ШИНЖИЛГЭЭ

- Үйлдвэрлэгч нь өөрийн үйлдвэрийн дэргэд Инженерийн зөвшөөрөх хэмжээнд шаардлагатай туршилт, шинжилгээг хийх тоног төхөөрөмжтэй байна. Шинжилгээ хийх төхөөрөмж болон ажиллагаа нь Инженерийн шаардсан үед шалгалт хийхэд нээлттэй байх

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

ёстой.

- Зөвшөөрөл авах болон хяналтын шинжилгээнүүдийг үйлдвэрлэгчийн үйлдвэрт буюу Инженерийн зөвшөөрсөн бие даасан лабораторид гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч дараах ажлуудын зардлыг хариуцна.

Үүнд:

- Лабораторийн туршилт, шинжилгээний зардал;
- Дээж бэлдэх;
- Дээжийг тээвэрлэх;
- Лабораторийн ажилчдыг байлцуулах.
- Үйлдвэрлэгч шинжилгээ хийх хөтөлбөрөө Инженерт урьдчилан танилцуулж зөвшөөрөл авсны дараа зөвшөөрөл авах шинжилгээг эхлүүлнэ.
- Үйлдвэрлэснээс хойш 180-аас дээш хоногийн дараа хийгдсэн зөвшөөрөл өгөх шинжилгээнд хэрэв Инженер шаардлагатай гэж үзвэл шинэчилсэн шаардлагын дагуу Инженерээс тусгай зөвшөөрөл авна.
- Зөвшөөрөл авах бүх шинжилгээг байцаагч болон үйлдвэрлэгчээс хангасан туршлага бүхий туслах ажилтнууд гүйцэтгэх ба туслах ажилтнууд нь байцаагчийн шууд удирдлага дор ажиллана.

Хүснэгт 14-3: Хүлцэх алдаа

Ажлын нэр		Хүлцэх алдаа
1	Нийт босоо хэмжээсүүд:	
	Тооцоот зузаан 32мм ба түүнээс доош	-0, +3
	Тооцоот зузаан 32мм-ээс дээш	-0, +6
2	Нийт хэвтээ хэмжээсүүд:	
	Хэмжихэд 914мм ба түүнээс доош	-0, +6
	Хэмжихэд 914мм-ээс дээш	-0, +12
3	Тулах хэсгийн аливаа цэг дэх эластомерийн үеийн зузаан- (зөвхөн ялтсан тулах хэсгүүдийн)	Тооцоот зузаан+ 20 %, гэхдээ +3мм-ээс илүүгүй
4	Орой	Ёроолтой харьцуулсан налуу 0.005 радианаас ихгүй
	Талууд	6
5	Ил гарсан холбогч хэсгүүдийн байрлал	+ 3
6	Холбогч хэсгүүдийн ялтасны ирмэг	-0, +3
7	Нүх, ухлаас, нэмэлтүүдийн хэмжээ	+3
8	Нүх, ухлаас, нэмэлтүүдийн байршил	+3

1421 ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

Үйлдвэрлэгч нь тулах хэсгүүдийн багц бүрт дараах зүйлийг баталсан гэрчилгээ ирүүлнэ.

Үүнд:

- Тулах хэсгийн багц бүрийг үйлдвэрлэх явцад хяналт тавьж байсныг чанарын хяналтын

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

бүртгэл буюу графикаас харж болох ба Инженерийн шаардсан үед бүртгэлийг үзүүлж шалгуулна.

- Үйлдвэрлэлд ашигласан эластомерийн дээжид хийсэн шалгалтын туршилтын дүнгийн дараах мэдээллийг агуулсан баталгаажуулсан хувийг хавсаргасан байна.

- Үүнд: Бүтэц найрлага – түүхий эластомер болон үнсний хэмжээ, түүхий эластомерийн төрөл (нэр, эх үүсвэр, хадгалсан хугацаа), хатуулгийн шинжилгээний дүн, сунгалтын бат бэх, тасрах үеийн суналт, шахалтын үеийн суулт, хурдасгасан хуучралт гэх мэт.

- Гэрчилгээ ба тэмдэглэгээ

Инженер эцсийн зөвшөөрлөө өгсний дараа тулах хэсгийг гүүр рүү аваачих ба баталгаажуулсан гэрчилгээг дагалдуулна.

Үйлдвэрлэгчээр баталгаажуулсан гэрчилгээ нь дараах мэдээллийг агуулсан байна.

Үүнд:

- Үйлдвэрлэгчийн нэр;
- Үйлдвэрлэсэн огноо;
- Эластомерийн-р зэрэг;
- Тулах хэсгийн овор хэмжээ;
- Үйлдвэрлэсэн багцын дэс дугаар;
- Зөвшөөрөл өгсөн багцын дэс дугаар;
- Шинжилгээ хийсэн огноо;
- Тухайн гүүрийн байршил;
- Тулах хэсэг дээр тавьсан тэмдэглэгээний тайлбар.

Тулах хэсэг бүр дээр мэдээлэл агуулсан кодон тэмдэглэгээ тавьж өгнө. Тэмдэглэгээг угсарсны дараа арилдаггүй бэх буюу будгаар ил харагдах газарт тавина. Тулах хэсгийн дээд тал болон суурилуулах чиглэлийг тэмдэглэж үзүүлсэн байна.

1422 ХАДГАЛАХ БА АРЧЛАХ

• Резинэн тулах хэсэг бүрийг хаяглах буюу тэмдэглэгээ хийсэн байна. Тулах хэсгийг боож, булан ба ирмэгүүдийг хамгаалах, ямар ч хөдөлгөөнгүй байлгах арга хэмжээ авсан модон хайрцагт хийнэ.

• Тулах хэсгийг тээвэрлэх, хадгалах явцад механик гэмтэл учруулах, тос, тослох материал, хог шороогоор бохирдох, нарны гэрэл болон цаг агаарын нөлөөнд оруулах зэргээс сэргийлсэн арга хэмжээ авах хэрэгтэй.

1423. СУУРИЛУУЛАХ

• Тулах хэсгийг үйлдвэрлэгчийн өгсөн зааврын дагуу үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн хяналт дор суурилуулна.

• Нэг шугам дээр ар араас нь олон тулах хэсэг суулгах бол эдгээр нь ижил хэмжээтэй байх ёстой.

• Тулах хэсгийг жинхэнэ хэвтээ гадаргуунуудын хооронд (хамгийн их хүлцэх алдаа нь перпендикуляр ирэх ачаалалд 0.2% байна) тулах хэсгийг хүлээн авах гадаргуу дээр тэмдэглэсэн

хяналтын шугамын жинхэнэ байрлалд (хамгийн их хүлцэх алдаа ± 3 мм) суурилуулна.

- Бетон гадаргууд аливаа овор товон байж болохгүй (хамгийн их хүлцэх алдаа нь өндрийн ± 1 мм байна).
- Тулах хэсгийг гүүрийн хавтанг цутгахаас өмнө суурилуулж байгаа тохиолдолд тулах хэсгийг тойрсон хэв хашмалыг дараа нь хялбар салгаж авахаар зөөлөн материалаар хийнэ. Эдгээр хэв хашмал нь бетон хольц завсраар нь гоожихгүй байхаар тулах хэсэгт нягт суусан байна. Бетон цутгах үед тулах хэсэгт хүрсэн хольцыг хатахаас нь өмнө сайтар цэвэрлэж авна.
- Гүүрийн хавтанг газар дээр нь цутгаж байгаа үед гадаргууг зохих ёсоор бэлтгэсний дараа тулах хэсгийг эпокси цавуугаар нааж болох юм. Наалдамтгай материал, ажлын аргачлал ба хяналтыг Инженерээр батлуулна. Барьцалдуулагчийг буруу хэрэглэж, улмаар тосолсон үе үүсэхээс сэргийлэх хэрэгтэй. Барьцалдуулагч материалыг тулах хэсэгт тооцоот шилжилтээс сэргийлэх бус зөвхөн суулгаж өгөх зорилгоор ашиглана.

1424. АРЧЛАЛТ

- Тулах хэсгийг суурилуулсны дараа төлөвлөгөөт арчлалтыг хийнэ.
- Ил гарсан тулах хэсгийг тос, тослох материалаар бохирдуулахгүй цэвэр байлгах хэрэгтэй.
- Тулах хэсгийг суурилуулсны дараа баталгаат засварын хугацаа дуустал аливаа гадаргуун хагарал, эвдрэл гарсан эсэхийг байнга шалгаж байна.
- Гэмтэж муудсан тулах хэсгийг нэн даруй солих хэрэгтэй. Тулах хэсгийн жигд бат бэх чанарыг хангах зорилгоор гэмтэж муудсан тулах хэсэгтэй нэг шугам дээр зэрэгцээ байрлах тулах хэсгүүдийг мөн солих шаардлагатай.

1425. ДАВИРХАЙТ ЦААСАН ТУЛАХ ХЭСЭГ

Зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан хэсгүүдэд Гүйцэтгэгч давирхайт цаасан тулах хэсэг хийнэ. Ийм тулах хэсэг нь цэвэрхэн, ширхэглэл бүхий үйсийг тохиромжтой битумэн барьцалдуулагчаар барьцалдуулан AASHTO M213 стандартад нийцсэн хоёр эсгий дунд хавчуулсан байна.

ДЭД БҮЛЭГ В- ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

1426. ЧИГЖЭЭС БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

(а) Бүтэц

Чигжээс бүхий хэв гажилтын заадас нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүтнэ. Үүнд:

- Сайн гагнагддаг, цохилтын бат бэх сайтай, хуйлсан хуудас төмрөөр хийсэн хавчаар хэлбэртэй захын хөндлөн нуруу;
- Тасралтын эсэргүүцэл сайтай, удаан элэгддэг, тос бензин болон озонд тэсвэртэй полихлоропрен чигжээс;
- Захын хөндлөн нуруунд хэд хэдэн цэгт гагнагдсан хатуу анкер хавтан;
- Хатуу анкер хавтанг гүүрийн хавтангийн оройн арматурт холбох зориулалтай хавтангийн оройн арматурт холбох зориулалтай гагнуур авдаг анкер гогцоо.

(b) Материал

Захын хөндлөн нуруунд Германы Rst 37-2 буюу ижил төстэй стандартад нийцсэн төмөр ашиглана. Бүх төмөр эд ангиуд нь зэврэлтээс хамгаалагдсан байна. Полихлоропрен чигжээс нь AASHTO M297 стандартын шаардлагад нийцсэн байна. Полихлоропрен чигжээсийн физик шинж чанар нь авто замын гүүрийн AASHTO стандартын II Хэсэг, хүснэгт 18.2.3.1 “А” ба 18.2.3.1 “В”-д заасан шаардлагад нийцсэн байна. Анкер хавтан болон анкер гогцоо нь AASHTO M270 стандартын дагуу байна.

(c) Үйлдвэрлэлт

Захын хөндлөн нуруунд хэрэглэх хуудас төмрийг зурагт үзүүлсэн хэлбэр ба хэмжээгээр үйлдвэрлэхэд хангалттай урттай байх ёстой. Захын хөндлөн нурууг гүүрийн хөндлөн огтлол ба хэвгйд тааруулан хөрөөднө. Гүүрийн хөндлөн огтлолын хэмжээсүүдийг ажлын тавцан дээр нарийвчлан тэмдэглэнэ. Төмрийг хэмжээсүүдийн дагуу хэмжээний дараа ажлын тавцанд хөдөлгөөнгүй бэхэлж холбож гагнана.

Анкер хавтанг зурагт үзүүлсэн зайгаар захын хөндлөн нуруунд барьж гагнана. Анкер гогцоонуудыг зохих хэлбэрт нугалж, анкер хавтанд гагнаж өгнө. Үйлдвэрлэгч хэв гажилтын заадсыг суурилуулах бүх туслах материал болон чигжээс ба ус үл нэвтрүүлэх хальсыг ханган нийлүүлнэ.

Мөн заадсанд орох материалыг найдвартай тээвэрлэх зориулалтын бэхэлгээ тулгууруудыг нийлүүлнэ. Хэв гажилтын заадсанд орох материалыг агуулах саравчинд буюу контейнерт модон шалавч дээр хурааж хадгална.

(d) Суурилуулах

Температурын өөрчлөлт, агшилт, гулсалт, гүүрийн хавтангийн болон тулгуурын хэв гажилтын үйлчлэлээр үүсэх хөдөлгөөнийг хангах зурагт үзүүлсэн зайг Гүйцэтгэгч баталгаажуулж, улмаар үйлдвэрлэгчид мэдэгдэнэ. Үйлдвэрлэх үеийн дулаан болон суурилуулах үеийн дулааны магадлалыг харгалзан уг зайг дахин тогтооно.

Гүүрийн хавтанд гаргах хэв гажилтын заадасны ховилыг зурагт үзүүлсэн буюу үйлдвэрлэгчийн зөвлөсөн хэмжээгээр гаргана. Хавтанд гаргасан ховилыг хог шорооноос сайтар цэвэрлэнэ. Ил гарсан арматурын төмрийг заадсыг саадгүй суурилуулж болохуйц тохируулж өгнө. Хуучин бетоны гадаргуу болон хэв гажилтын заадас хийгдэх шинэ бетоны хэв хашмалын хоорондох зайг бетон цутгах үед хольц урсаж орохооргүй болтол сайн чигжсэн байна.

Зайны хэмжээ нь заадсыг суурилуулах үеийн дундаж температурт тохирсон байх ба энэ температурыг Гүйцэтгэгч ба Инженерийн урьдчилан тохирсон аргаар тодорхойлно.

Суурилуулах үеийн температур нь тооцоолсон температураас өөр байвал бетон цутгахаас өмнө шаардлагатай тохиргоог хийнэ.

Заадсыг урьдчилан бэлтгэсэн ховилд суулгаж, заадасны нэг талын анкер гогцоог хавтангийн хамгийн дээд талын арматурт техникийн шаардлагад заасны дагуу гагнахаас өмнө тэгшилж чиглүүлнэ. Үүний дараа заадасны нөгөө талд мөн ажилбарыг давтаж хийнэ.

Заадсыг байрлуулсны дараа түр тулгуурыг нэн даруй салгаж авна.

Дараа нь ховилыг хавтангийн бетоной ижил бат бэхтэй, агшилт багатай бетоноор техникийн шаардлагын бүлэг 1300-д заасны дагуу дүүргэнэ. Заадсан доорх бетоныг цутгах ба

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

бэхжих үед заадасны эд ангиуд болон тэдгээрийг бэхэлсэн тулгууруудын хооронд харьцангуй хөдөлгөөн орохоос сэргийлнэ. Ялангуяа заадасны хоёр талыг барих хэв хэрэглэж байгаа тохиолдолд тэдгээрийг нэгэн зэрэг хоёр талд суулгаж болохгүй. Шурагны хээг цэвэр байлгаж, зэврэхээс хамгаална.

Гүйцэтгэгч полихлоропрен чигжээсийг уртыг нь тааруулан тайрч, захын хөндлөн нуруунуудын завсраар чигжээсийг гэмтээлгүйгээр болгоомжтой хийнэ. Бетоныг хангалттай хатуурсны дараа заадсуудыг тээврийн хөдөлгөөний ачааллаас хамгаалах зорилгоор заадсан дээгүүр бат бэх тавцан тавина. Зорчих хэсгийн хучилтыг тавьж Инженер тавцангуудыг авахыг зөвшөөртөл тээврийн хэрэгслийг тавцан дээгүүр явуулахгүй.

Зорчих хэсгийн хучлагын гадаргууг захын төмөр нурууны оройн хэсэгтэй нэг төвшинд байхаар тавина. Хучлагын ирмэг болон захын төмөр нурууны завсрыг шаантаг хэлбэртэй зөвшөөрөгдсөн чигжих материалаар чигжинэ. Ил гарсан захын төмрийн гадна талыг чигжээс хийхээс өмнө сайтар цэвэрлэнэ.

(е) Зөвшөөрөл авах шинжилгээ

Полихлоропрен чигжээсийн зөвшөөрөл авах шинжилгээг зөвшөөрөгдсөн лабораторид авто замын гүүрийн AASHTO стандартын II хэсэг, 18.2.3.1A ба 18.2.3.1B хүснэгтэд заасны дагуу гүйцэтгэж баталгаажуулна. Гүйцэтгэгч шинжилгээний сертификатыг Инженерт өгч батлуулна.

Үйлдвэрлэгч нь Инженерийн зөвшөөрсөн лаборатори буюу байгууллагаас дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасныг баталсан гэрчилгээг өгнө. Үүнд:

- Захын төмөр нуруу болон анкеруудын цуцалтын бат бэх нь илэрхий эвдрэлгүйгээр 2×10^6 ачааллын өөрчлөлтийн мөчлөгийг даах чадвартай,
- Заадас нь 4 бар даралттай усыг нэвтрүүлэхгүй байх чадвартай,
- Патентлагдсан заадас нь барилгын ажлын талбайд дийлэнх байх магадлалтад ижил төстэй нөхцөлд сайн ажилласан байх.

1427. ДҮҮРГЭГЧ БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Энэ төрлийн заадсыг дараах материалаар хийнэ. Үүнд:

- Доод тал нь 2мм-ийн зузаантай хэлбэржүүлсэн зэс ялтас;
- 20мм-ийн зузаан битум шингээсэн мяндсан банз ба бусад зөвшөөрөгдсөн заадас дүүргэгч;
- 20мм-ийн зузаан, зөвшөөрөгдсөн хэвэнд урьдчилан цутгасан заадас дүүргэгч;
- бусад зөвшөөрөгдсөн заадас дүүргэгч;

Урьдчилан хэвэнд цутгасан заадас дүүргэгч нь дараах стандартуудын аль нэгийг хангасан байна. Үүнд:

(a) AASHTO M33, Бетоны урьдчилан хэвлэсэн хэв гажилтын заадас дүүргэгч;

(b) AASHTO M153, Бетон хучилт болон даацын барилгад хэрэглэх урьдчилан хэвлэсэн резинэн болон үйсэн хэв гажилтын заадас дүүргэгч;

(c) AASHTO M213, Бетон хучилт болон даацын барилгад хэрэглэх урьдчилан хэвлэсэн

хэв гажилтын заадас дүүргэгч.

Битум шингээсэн мяндсан банз ба бусад зөвшөөрөгдсөн заадас дүүргэгчийг бүрэн хэмжээт материалын хавтангаас хэлбэрт оруулан тайрч авна. Жижиг тайрдсуудыг заадсын дүүргэгчээр ашиглахыг хориглоно.

Хэв гажилтын заадсын материалыг Гүйцэтгэгч нямбайлан арчилж, агуулах, сүүдрэвч буюу контейнерт газраас хөндий хадгална. Заадсын зайг зурагт үзүүлсний дагуу гаргана. Заадсын завсраас хог шороо, сул материалыг үлээлгэж буюу угааж цэвэрлэнэ.

Инженерээр шалгуулж зөвшөөрөл авалгүйгээр заадсыг дүүргэхийг хориглоно. Урьдчилан хэвэнд цутгасан заадас дүүргэгчийг зэрэгцээ материалыг дэвсэхийн яг өмнө байрлуулна. Хэрэв нэг заадсын хоёр талд байгаа гадаргууг өөр өөр хугацаанд хийхээр бол сүүлд хийгдэх гадаргуун материалыг дэвсэхийн өмнө дүүргэгчийг хийнэ. Дүүргэгч болон заадсын суурь өнгөлгөөг үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу хийнэ. Дүүргэгч бүхий хэв гажилтын заадсын дээгүүр хучих бетонд 100 мм өргөн ба 10 мм гүн ховил гаргаж өгнө. Ховилыг нягтруулсан 6%-ийн битум агуулсан том ширхэглэлт элсний хольцоор дүүргэнэ.

Гүүрийн зорчих хэсгийн гадаргуу дээр гарсан заадсын материалын ул мөр, үлдэгдлийг цэвэрлэж, гадаргууг Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл засна.

ДЭД БҮЛЭГ Г ГҮҮРИЙН ХАШЛАГА

1428. ЕРӨНХИЙ

Гүүрийн хашлага нь явган зорчигч болон тээврийн хэрэгслийг хамгаалах зорилгоор явган замын гадна талаар баригдсан хийц юм.

Хашлагын бетон нь өөрөө өөрийгөө даах чадвартай болохоос нааш хашлагын хэв хашмалыг авч болохгүй бөгөөд энэхүү бетон нь энэ техникийн шаардлагын бүлэг 1300-ын шаардлагыг хангасан байна.

Гүүрийн хашлагыг зурагт үзүүлсэн хэмжээ, түвшин, чиглэл, төлөвлөгөөний дагуу угсарна. Ялангуяа гүүрийн хашлагын хэв гажилтын заадсыг зөв гаргах талаар Гүйцэтгэгч анхаарах хэрэгтэй. Хашлагын шонгуудын босоо хэмжээсийн хүлцэх алдаа 1м тутамд 2мм-ээс хэтрэхгүй байх ёстой. Хашлаганы материалыг тос буюу хог шороогоор бохирдохоос сэргийлэн газраас хөндий тавцан буюу тавиурууд дээр хурааж хадгална.

1429. ГАЗАР ДЭЭР НЬ ЦУТГАХ ХАШЛАГА

Газар дээр нь цутгах хашлагыг хамгийн том ширхэглэл нь 10 мм-ийн хэмжээтэй буталсан чулуу бүхий В30 ангийн бетоноор техникийн шаардлагын бүлэг 1300-д заасны дагуу цутгана. Газар дээр нь цутгах хашлагын хэв хашмал нь дан өргөнтөй банз буюу Инженерийн зөвшөөрсөн материалаар зэрэгцүүлж зүүсэн хэв байна. Хэвний зүүдлийг хашлаганы тэгш гадаргуу дээр ирэхээр тааруулахыг хориглоно.

Бүх хэв, хавтан, ховил, налууг зурагт үзүүлсний дагуу гаргаж угсарна. Цутгасны дараа бүх өнцгүүд тэгш, хагарал, хэлтэрхий болон согоггүй байна. Шонг нэг цутгалтаар цутгана.

1430. УРЬДЧИЛАН ЦУТГАСАН ХАЙС

Урьдчилан цутгах хайсыг хамгийн том ширхэглэл нь 10 мм-ийн хэмжээтэй буталсан чулуу бүхий В30 ангийн бетоноор техникийн шаардлагын бүлэг 1300-д заасны дагуу цутгана.

ДЭД БҮЛЭГ Д – ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

1431 РЕЗИНЭН ТУЛАХ ХЭСЭГ

Нэгж: ширхэг

Резинэн тулах хэсгийн ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Ажлын зураг, тооцоог боловсруулан Инженерт танилцуулах;
- Материал;
- Үйлдвэрлэлт;
- Нийлүүлэх, тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, тулах хэсгийг суурилуулахад шаардагдах бусад багаж

хэрэгсэл;

- Туршилт;
- Лабораторийн туршилтын зардал;
- Лабораторийн ажилчдыг ажиллуулах;
- Үйлдвэрлэгчийн төлөөлөгчийг ажиллуулах;
- Техникийн шаардлагын 1400-р бүлгийн дэд бүлэг Б болон авто замын гүүрийн АASHTO стандартын II хэсэг, 18.2 зүйлийн шаардлагыг хангах.

1432 ДАВИРХАЙТ ЦААСАН ТУЛАХ ХЭСЭГ

Давирхайт цаасан тулах хэсгийг хавтгай дөрвөлжин метрээр хэмжинэ. Давирхайт цаасан тулах хэсгийн талбайг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан хэмжээний дагуу тооцно. Давирхайт цаасан тулах хэсгийн ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Материал;
- Тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, давирхайт цаасан тулах хэсгийг суурилуулахад шаардагдах бусад багаж хэрэгсэл;
- Туршилт;
- Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, хэрэв шаардлагатай бол;
- Техникийн шаардлагын зүйл 1425-ийн шаардлагыг хангах.

1433 ЧИГЖЭЭС БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Нэгж: м

Чигжээс бүхий хэв гажилтын заадсыг зурагт үзүүлсэн гүүрийн хоёр талын хашлагын

шонгийн дотор хануудын хоорондох зайны урт метрээр хэмжинэ.

Чигжээс бүхий хэв гажилтын заадсын ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Материал;
- Тээвэрлэх, арчлах, хадгалах;
- Ажиллах хүч, тоног төхөөрөмж, заадсыг суурилуулах ба чигжихэд шаардагдах бусад багаж хэрэгсэл;
- Туршилт;
- Заадасны ховил гаргах ба хэв хашмалыг бэлдэх;
- Үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу патентлагдсан хэв гажилтын заадас суурилуулах;
- Анкер гогцоог хавтангийн ховилд ил гарсан арматурт гагнаж анкер хавтанг тогтоох;
- Хэв гажилтын заадсын орчмын бетоныг цутгах, нягтруулах, арчлах;
- Цементобетон хучлага болон захын төмөр нуруунуудын хоорондох завсрыг чигжих,
- Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд, хэрэв шаардлагатай бол;
- Техникийн шаардлагын зүйл 1426-ын шаардлагыг хангах.

1434 ДҮҮРГЭГЧ БҮХИЙ ХЭВ ГАЖИЛТЫН ЗААДАС

Нэгж: м

Дүүргэгч бүхий хэв гажилтын заадсыг метрээр хэмжих ба уртыг зурагт үзүүлсний дагуу тодорхойлно. Хэв гажилтын заадсын ажлын үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Хэмжих нэгж: ширхэг

Анхааруулах тэмдгийг Инженерийн зааварчилсан тэмдгийн төрөл тус бүрийн ширхгээр хэмжинэ.

(2) Ажлын нэр: Зохицуулах, хориглох ба заах тэмдэг

Хэмжих нэгж: ширхэг

Зохицуулах, хориглох ба заах тэмдгийг Инженерийн зааварчилсан тэмдгийн төрөл тус бүрийн ширхгээр хэмжинэ.

(3) Ажлын нэр: Мэдээллийн самбар

Хэмжих нэгж: ширхэг

Мэдээллийн самбарыг Инженерийн зааварчилсан самбарын хэмжээ тус бүрийн ширхгээр хэмжинэ.

(4) Ажлын нэр Чиглэлийн самбар

Хэмжих нэгж: м²

Чиглэлийн самбарыг зурагт үзүүлсэн буюу Инженерийн зааварчилсан самбар тус бүрийн талбайн хэмжээгээр хэмжинэ.

d) Ажлын нэр: Хамгаалалтын хашилт

Хэмжих нэгж: м

Хашилтыг урт метрээр хэмжинэ. Инженерийн зааварчилсан уртаар төлбөр хийнэ. Хашилтын ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Шон ба бусад материал, бэхэлгээг бэлдэх;
- Ажиллах хүч;
- Хашилтын шонгийн нүхийг ухах;
- Түр тулгууруудыг бэлдэх, угсарч суулгах;
- В15/20 ангилалын бетон бэлдэх, цутгах, нягтруулах;
- Нүхийг шороогоор булаах ба нягтруулах;
- Нүхнээс гарсан илүүдэл шороог зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях;
- Ажлын тавцан барих;
- Энэхүү техникийн шаардлагын 200-р бүлгийн шаардлагатай нийцүүлэх;
- Энэхүү техникийн шаардлагын 1604-р зүйлийн шаардлагатай нийцүүлэх

e) Ажлын нэр: Замын гэрэлтүүлэг

Хэмжих нэгж: ширхэг

Замын гэрэлтүүлгийг Инженерийн зааварчилсан гэрэлтүүлгийн ширхгээр хэмжинэ.

Замын гэрэлтүүлгийн ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Ажиллах хүч, шон ба бусад материал, бэхэлгээг бэлдэх;
- Шонгийн нүхийг ухах;
- Шаардлагатай хэсэгт тулгууруудыг бэлдэх, угсарч суулгах;
- Будах;
- В15/20 ангиллын бетон бэлдэх, шонгийн дор болон шонг тойруулан бетон цутгах, нягтруулах;
- Нүхийг шороогоор булах ба нягтруулах;
- Нүхнээс гарсан илүүдэл шороог зөвшөөрөгдсөн газарт аваачиж хаях;
- Энэхүү техникийн шаардлагын 1605-р зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

f) Ажлын нэр: Цасны хамаалалт хийх /мод тарих/

Хэмжих нэгж: м

Цасны хамгаалалтыг урт метрээр хэмжинэ. Тэдгээрийн уртыг Инженерийн зааварчилсан уртаар авна. Түр ажилтай холбогдуулан барьсан аливаа цасны түр хаалт хамгаалалтад төлбөр хийгдэхгүй.

Цас, элсний хамгаалалтын далангийн ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана.

Үүнд:

- Хамгаалалтын далан барих шороог ухаж ачих, тээвэрлэх;
- Далангийн шороог тарааж тэгшлэх, шаардлагатай бол усалж нягтруулах;
- Шаардлагатай бол талбайг цэвэрлэх, шороо авах болон далан барих газрын өнгөн хөрсийг хуулж зайлуулах;
- Шороо авсан газрыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл эргүүлж булах, тэгшлэх;
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр;
- Энэхүү техникийн шаардлагын 1606-р зүйлийн шаардлагатай нийцүүлэх.

g) Ажлын нэр: Төмөрбетон хашлага

Хэмжих нэгж: м

Ажлыг Инженерийн тодорхойлсон уртаар хэмжинэ.

Төмөрбетон хашлага тавих ажлын нэгж үнэлгээнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Ул хөрсийг нягтруулах;
- Хашлагыг ачих, тээвэрлэх, суурилуулж тавих, заадсыг чигжих;

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- Хашлагын дор хийх В15/20 ангиллын бетон бэлдэх, бетон цутгах, нягтруулах;
- Арын манаас, чигжээсийг хийх, нягтруулах;
- Тавьсан хашлагыг арчлах;
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэглэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр
- Энэхүү техникийн шаардлагын 1607-р зүйлийн шаардлагатай нийцүүлэх

h) Ажлын нэр: Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол

Хэмжих нэгж: ш

Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглолын ажлыг хэмжих нэгж нь ширхэг байна. Ажлын зурагт үзүүлсэн буюу Инженерийн тодорхойлсон тоо хэмжээгээр тооцоолно. Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглолын ажлын нэгж өртөгт дараах ажлууд багтана. Үүнд:

- Тоноглол суурилуулах гадаргууг бэлдэх, тэгшлэх, засах
- Зориулалтын суурийг бэхлэх, угсах
- Тоноглолын ажлыг хийхэд шаардлагатай ажиллах хүч, материал, багаж, тоног төхөөрөмж үнэ өртөг
- Гэрлийн тусгалаас хамгаалах тоноглолын өөрийн өртөг, угсах, байрлуулах
- Зааглах хашлагыг нэг шугам ба төвшинд тэгшлэх
- Хаягдал материалыг зөөж, зайлуулах
- Тоноглолыг бэлдэх бүхий л шаардлагатай тээвэрлэлтүүд

Дэд зүйл 1608(1)-д заасан гэрлийн тусгалаас хамгаалах тоноглол суурилуулах

i) Ажлын нэр: Шилэн гэрэл ойлгогч тавих

Хэмжих нэгж: ш

Замын эгнээ болон тэнхлэгийн дагууд тавигдсан шилэн гэрэл ойлгогчийн төрөл тус бүрийг ширхэгээр хэмжинэ. Инженерийн зааврын болон ажлын зургийн дагуу тавьсан гэрэл ойлгогчийг хэмжиж баталгаажуулсан уртад төлбөр хийгдэнэ. Дэд зүйл 1611(1)-д заасан шилэн гэрэл ойлгогчийг суурилуулах ажлын нэгж өртөгт дараах ажлууд багтана. Үүнд:

- Бүх шаардлагатай материалуудын хангалт, туршилт, тээвэрлэлт
- Хадгалалт, гэрэл ойлгогч төхөөрөмж, нийлүүлэлт
- Шаардагдах ажиллах хүч
- Улаан шугам тавих
- Замын тэмдэглэгээ тавих ба тээврийн хөдөлгөөний хяналт
- Зориулалтын машинаар суулгах нүхийг ухах

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

- Гэрэл ойлгогчийг хөдөлгөөнгүй суурилуулах
- Хамгаалах арга хэмжээ
- Үйлдвэрлэгчийн гаргасан зөвлөмж болон техникийн шаардлагыг биелүүлэх
- Бүлэг 1600-т заасан шаардлагыг биелүүлэх

БҮЛЭГ 1700- ТӨМӨР БЕТОН ШОН СУУРИЙН АЖИЛ

/Энэ төсөлд хэрэглэгдэхгүй/

БҮЛЭГ 1700- ТӨМӨР БЕТОН ШОН СУУРИЙН АЖИЛ

1701	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
1702	ХЭРЭГЛЭХ СТАНДАРТ БОЛОН ШААРДЛАГА.....	2
1703.	БЕТОН ЦУТГАХ.....	3
(1)	Барилгын машин, багаж, төхөөрөмж сонгох	3
(2)	Туршилтын шон барих	3
(3)	Бетон шонгийн чанарын хяналт.....	4
(4)	Барилгын ажлын бэлтгэл	4
(5)	Газар шорооны ажил.....	5
(6)	Арматур.....	7
	Цутгамал шон барьж байгуулах.....	8
1704.	ЭРГЭЛТЭТ ӨРӨМДЛӨГИЙН ГАН ШОН	8
(1)	Туршилтын (хяналтын) шон	9
(2)	Ажлын дэс дараалал, гүйцэтгэлийн хяналт.....	10
(3)	Өрөмдөх ажил	11
(4)	Даацын үеийг магадлах, ажиллагааг дуусган зогсоох	12
(5)	Барилгын менежмент	12
(6)	Хэмжилтийг хянах тогтолцоо.....	14
1705.	ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР.....	14
(1)	Өрөмдмөл цооног	15
(2)	Туршилтын цооног.....	15
(3)	Инженер-геологийн цооног	16
(4)	Байнгын хамгаалалтын (бүрхүүл) яндан	16
(5)	Ачааллын туршилт	16

1701 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү бүлэгт гүүрийн суурь барих болон түүнтэй холбогдсон бусад нэмэгдэл ажлын талаар өгүүлнэ.

1702 ХЭРЭГЛЭХ СТАНДАРТ БОЛОН ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь зурагт өөрөөр заагаагүй эвэл ажлын шаардлагад өөрөөр дурдаагүй бол дараах стандарт болон шаардлагыг дагана. Бетон шонгийн шинжилгээ, туршилт нь 200-р бүлэгт заасан туршилт шинжилгээний стандартууд болон 1500 - р бүлгийн ерөнхий заалтуудыг хангасан байна.

Энэхүү техникийн шаардлага нь дээр дурдсан стандарт, шаардлагын аливаа нэг заалтыг зөрчсөн эсвэл тэдгээртэй нийцэхгүй тохиолдолд энэхүү техникийн шаардлагын заалт давамгайлна.

Зурагт болон техникийн шаардлагад тухайн ажлын хэсгийн талаар бүрэн дүүрэн нарийвчлан заагаагүй, зөвхөн ерөнхий үг томъёогоор дурдаад орхисон тохиолдолд Гүйцэтгэгч Инженерийн заавар зөвлөмжид бүрэн дүүрэн нийцүүлж хамгийн сайн ажлын арга дадал, материал ашиглаж, чанарын дээд түвшинд гүйцэтгэнэ.

Ашигласан стандартууд болон гарын авлага:

- Хурдны замын гүүрийн техникийн тодорхойлолт, Гүүрийн доод байгууламжийн тухай 4-р бүлэг (2002 оны 3-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Хурдны замын гүүрийн техникийн тодорхойлолт, Сейсмик (газар хөдлөлт)-ийн эсрэг арга хэмжээ төсөллөхийн тухай 5-р бүлэг (2002 оны 3-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Замын хашилт (хайс) барих гарын авлага, түүнийг суулгах удирдамж (2004 оны 3-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Шон суурь барьж байгуулах гарын авлага (2007 оны 1-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Шон суурь төсөллөх гарын авлага (2007 оны 1-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Авто замын газар шорооны ажилд зөөлөн хөрсийг боловсруулах техникийн шаардлагын удирдамж (1986 оны 11-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Авто замын газар шорооны ажлыг гүйцэтгэх техникийн шаардлагын удирдамж (1986 оны 11-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Авто замын газар шорооны ажлын түр байгууламжийн холбогдолтой техникийн шаардлагын удирдамж (1999 оны 3-р сар), Японы авто замын нийгэмлэг
- Газар шорооны ажлын холбогдолтой бүтээцийг төсөллөх гарын авлага, Бүтээц ба гүүрний тухай бүлэг (1999 оны 11-р сар), Барилгын яам
- Газар шорооны ажлын холбогдолтой бүтээцийг төсөллөх гарын авлагатай холбоотой зураг төсөл, барилгын гарын авлага (2001 оны 12-р сар), Газар зохицуулалт, дэд бүтэц, тээвэр, жуулчлалын яам.

1703. БЕТОН ЦУТГАХ

(1) Барилгын машин, багаж, төхөөрөмж сонгох

Гүйцэтгэгч нь шонгийн хэмжээс, ажлын талбайн орчин, суурийн байдал, ажиллагааны аюулгүй нөхцөл зэргийг харгалзан бүтээцийн зөв зохистой хэмжээсийн өгөгдөл болон ажиллагаа (функц)-г хангахуйц барилгын машин, багаж, төхөөрөмж сонгоно. Гүйцэтгэгч нь сонгосон барилгын машинаа ажлын янз бүрийн нөхцөлд ажиллуулан янз бүрээр ашиглаж болох аргыг таньж мэдэж авна.

(1) Туршилтын шон барих

Гүйцэтгэгч нь шон барьж байгуулахын өмнө эхлээд талбайн туршилтаар туршилтын шон хийж Инженерээр баталгаажуулна. Ачаа даацын туршилт хийж шонгийн даацыг тодорхойлолтыг тодорхойлно. Цутгамал шонгийн ИНЗ болон АХЗ-ийг харгалзан хэд хэдэн туршилтын шон барьж байгуулах шаардлагатай. Үүнд:

- Суурийн шон гол нь талбайн ажлаас шалтгаалдаг тул түүний найдвартай байдлыг хангах зорилгоор барилгын талбайн нөхцөлд нийцсэн барилгын зохистой аргуудыг зайлшгүй сонгож авах шаардлагатай.
- Шон бүрт очих ачааллыг төсөллөсөн тул тэдгээрийг орлох боломж маш хязгаарлагдмал. Тиймээс тэдгээрийг маш нямбай барьж байгуулах шаардлагатай.
- Гүйцэтгэгч нь барих аргыг тодорхой судлан байж, анхны үйлдвэрийн зориулалттай шон барьж, шаардагдах бүх зүйлийг судална. Чингэхдээ, туршилтын шон барьж байгуулах байршлыг хадгалж үлдээнэ.
- Гүйцэтгэгч нь үндсэн зорилгоо хангахуйц туршилтын шон барьж, үйлдвэрийн зориулалттай шон барьж байгуулах үеийн болон барьж байгуулсны дараахи үеийн үед бүтээцэд муу нөлөө үл үзүүлэх арга барилыг сонгож авна.
- Гүйцэтгэгч нь Японы геотехникийн нийгэмлэгээс тодорхойлсон хурдан өнгөрөх ачааллыг даах чадварыг нотлох зорилгоор “Хурдан өнгөрөх ачааллыг даах чадварын туршилт”-ыг (JGS 1815 2002)-ын дагуу гүйцэтгэнэ.
- Гүйцэтгэгч нь шон төслөх, барихад их нөлөө үзүүлэх туршилтын шон барьж байгуулах ажлын агуулгыг судалсны үндсэн дээр тухайн цутгамал шонг барьж байгуулах нөхцөл өөрчлөгдөх бүрт шон барьж байгуулах арга барил, ажиллагааны агуулгыг өөрчилнө.


(2) Бетон шонгийн чанарын хяналт

Гүйцэтгэгч нь бетоны чанарыг батлан нотлох зорилгоор шахалтын бат бэхийг тодруулах дараах туршилт хийнэ. Туршилтын талбайд хийсэн бетон шонгоос өрөмдөж дээж аван шахалтын бат бэхийг тодорхойлно.

Бетон цутгаснаас хойш 28 хоног болоход туршилт хийнэ. Яаруу барьж байгуулж байгаа тохиолдолд наад зах нь бетон цутгаснаас хойш 14 хоногийн дараа л туршилт хийнэ.

- Дээжийн хэмжээ: диаметр болон зузааны харьцаа $d=10\text{cm} \times L=20\text{cm}$
- Дээж авах байршил, арга: JIS A 1107-ын “Бетоноос керн авч, бат бэхийг нь турших аргачлал”-ын дагуу 1 багц (3 ширхэг) дээж авна. Мөн Инженерийн заасан шонгоос дээж авна.

Дээж авах байршил: доорх зургийг стандарт болгон ашиглана.



- Сорьцын нүхийг засварлах арга: дээж авсаны дараа үлдсэн нүхийг маш сайн цэвэрлээд шонг хийсэн ангийн бетон зуурмагаар гүйцэд дүүргэнэ.
- Шахалтын бат бэх болон нягтыг шалгах туршилт: JIS A 1107-ын “Бетоноос керн авч, шахалтын бат бэхийг турших арга”-ын дагуу туршилтыг гүйцэтгэнэ.

(3) Барилгын ажлын бэлтгэл

Гүйцэтгэгч дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Суурь барьж байгуулах бэлтгэл ажлыг эхнээс нь ажлын зургийн дагуу нягт нямбай хийж гүйцэтгэнэ.
- Өрөмдлөгийн машин, экскаватор, помп болон бусад холбогдох тоног төхөөрөмжийг заасан газар нь зөв байрлуулж, тэднийг ажиллуулах үеийн тэгш бөгөөд тогтвортой байдлыг бүрдүүлнэ.
- Бетон шон цутгах талбайд дөхөж очих, гарах зам барьж, тэдгээрээ арчлан хамгаална.
- Ус эсвэл өрмийн шингэн шавар ихээр ордог цутгамал шонгийн ажлыг гүйцэтгэхдээ ус зайлуулж цэвэрлэх арга хэмжээ авч, бетон хольцыг түргэн цутгах төхөөрөмж ашиглана.

- Төслийн ажлын орчны газар доорх усны байгууламжийн усны хэмжээ, чанарт барилгын ажлын улмаас нөлөө үзүүлэхүйц эрсдэл байгаа бол техникийн даалгавар, авах арга хэмжээний холбогдолтой асуудлаар Инженертэй зөвлөлдөнө.

- Газар доорх болон газрын түвшнээс дээр байрлаж буй байгууламж, саадын талаар урьдчилсан судалгаа хангалттай хийж, машин төхөөрөмжийг ажиллуулах, шилжүүлэхэд хүндрэл учрах тохиолдолд тэдгээрийг хамгаалах, шилжүүлэн байрлуулах арга хэмжээ авна.

- Гүйцэтгэгч нь барилгын гол ажил эхлэхийн өмнө машин механизм, багаж хэрэгслээ шалгаж, арчилж, ажлыг саадгүй, зогсолтгүй явуулах арга хэмжээ авна.

(4) Газар шорооны ажил

Бүрэн хэмжээгээр хамгаалалтын (бүрхүүл) яндан хоолой ашиглан нүх ухах үед эхний суурилуулах яндан хоолойн чиглэл нь тэгш босоо чиглэлийг хангахад шийдвэрлэх нөлөө үзүүлдэг тул богино яндан хоолой ашиглахаас зайлсхийнэ. Гүйцэтгэгч нь элс ба хайрган хурдсанд өрөмдлөг хийхдээ хурдсын налуу зэргийг харгалзан тэгш босоо чиглэлийг хангах зорилгоор урвуу эргэлтийн өрөмдлөг хийх, газар өрөмдөх арга ашиглахад анхаарлаа хандуулна.

а) Урвуу эргэлтийн өрөмдлөг хийх арга

Энэ аргыг ашиглах үед зохих утга хэмжээг баримтлах, түүнчлэн хөрсний нөхцөл, өрмийн машины хүчин чадлыг хууль мэт харгалзах шаардлагатай болно. Энэ аргыг ашиглах үед хамгаалалтын (бүрхүүл) яндан хоолойн урт, өрмийн шингэн шаврын байдал, түүнчлэн сүвэрхэг хана үл нурах хэмжээнд тохируулан өрөмдөх, ухах хурдыг зохицуулна. Ялангуяа, шанаганы өргөх, буулгах хурд хэт их бол усны даралтын балансыг алдагдуулах, нүхний сүвэрхэг хажуу ханыг шанагаар цохиж эвдэх магадлалтай тул түүнээс зайлсхийнэ. Гүйцэтгэгч нь заасан гүн нотлогдсон тохиолдолд даацын үе, хурдсыг эвдэхгүй байхад анхаарна.

Гүйцэтгэгч нь ухах хурдад анхаарахаас гадна ухсан хөрснөөс болон өрөмдсөн нүхний зүсэлтээс авсан дээжийг харьцуулан даацын үед хийх ухалтын гүнийг магадална.

Ухах, малтах ажил хуучин бүтээц эсвэл барьж байгуулсан шонгийн дэргэд хийгдэх бол суулт, шилжилт үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авна. Ялангуяа, ухах, малтах ажил газар доорх байгууламж, тухайлбал нийтээр ашигладаг шугам хоолой, цахилгаан болон утасны кабель, хий болон усны шугам хоолойд ойртох аваас Гүйцэтгэгч нь Инженертэй зөвлөлдөж, тэдгээрийг шилжүүлэх эсвэл хамгаалах арга хэмжээ авна.

Сүвэрхэг хана нурахаас сэргийлэх: Гүйцэтгэгч нь экскаваторын төрөл, хөрсний нөхцөл, ажлын агуулгад нийцэх түрэлтэт хоолой, хамгаалах (бүрхүүл, углах) яндан хоолой ашиглана.

б) Бүрэн хэмжээгээр хамгаалалтын яндан хоолой ашиглан нүх ухах арга

Хөрсний усны түвшингээс доош, түүнчлэн ус үл нэвчих хурдасны дор усны түрэлттэй байх тохиолдолд нүх өрөмдөх үед нүхний ёроол нурах нь хялбар байдаг. Үүнээс сэргийлэх нэг үр дүнтэй арга нь нүхийг усаар дүүргэх арга байж болох боловч өрөмдлөгийн хурдыг тохируулах, шаардлагын дагуу зохистой арга ашиглахад анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Хамгаалах яндан хоолой давхар яндан хоолой ашиглана. Дан яндан хоолой зайлшгүй

ашиглах тохиолдолд ажил явагдаж байх хугацаанд даац бүрэн даах аюулгүйн бөгөөд хатуу хөшүүн байх арга хэмжээ авна. Аюултай хэв гажилт үүсэхээс сэргийлж хөшүүн хатуу түрэлтэт хоолой хэрэглэнэ.

Түрэлтэт хоолойн урт хөрс болон хөрсний усны нөхцөлтэй шууд хамаатай тул туршилтын шонгийн туршилтын үр дүнг харгалзан шийдвэр гаргана. Өрөмдөж байх үед өрмийн шингэн шавар ер нь сүвэрхэг хана нурахаас сэргийлдэг боловч нуралт үүсэх аюулаас зайлсхийж, үеийн нимгэн хэсэгт хамгаалалтын яндан суулгаж өгвөл зохино. Гүйцэтгэгч нь газар өрөмдөх явцад нүхэн доторх усны түвшинг гадна усны түвшингээс доош буулгахгүй байх арга хэмжээ авна.

Газар доорхи усны түвшин өндөр бол нүхэн доторх усны түвшинг газар доорх усны түвшингээс өндөрт барьж, өрөмдлөгийн үзэгдэл гэгч үүсэхээс сэргийлнэ. Энэ аргыг хэрэглэх үед хөрсний усны түвшинг хянан зохицуулах нь чухал болно. Хөрсний ус болон гадна усны түвшин хоорондын зөрүү 2 м гаруй байхаар зохицуулна. Улмаар, өрөмдлөгийн үед цооног дахь усны түвшинг зохих хэмжээнд барих нь чухал. Үүний тулд, цооног дахь хөрсний ус шүүрэх эсвэл даралт ихтэй гүний усны улмаас цооног дахь хөрсний усны түвшин гэнэт буурах тохиолдолд түүний эсрэг зогсож чадах байгууламж байгуулах шаардлагатай.

с) Ухсан элсийг зайлуулах

Ухсан элсийг зайлуулах үед Гүйцэтгэгч дараах арга хэмжээнүүдийг авна. Үүнд:

- Газар доорх далд байгууламж илэрсэн тохиолдолд зураг төсөл, техникийн шаардлагын холбогдолтой асуудлаар Инженертэй зөвлөлдөнө.
- Газар шорооны ажлын үед хөрсний геологийн хатуулаг, зөөлний чанар, топограф, талбайн нөхцөл харгалзан зураг төсөл, техникийн шаардлагад заасан барилгын ажлын зорилго хангах ухмал суваг, шуудууг заасан гүнд гүйцэтгэнэ.
- Суваг, шуудуу ухах явцад гэмтэж магадгүй бүтээц илрэх аваас зураг төсөл, техникийн шаардлагын холбогдолтой асуудлаар Инженертэй даруй зөвлөлдөн яаралтай арга хэмжээ авна. Суваг, шуудууны гадаргыг эцэслэн янзлах үед байгалийн хөрсийг хөндөхгүй байх, тэгш бус байдал үүсгэхээс зайлсхийнэ.
- Хад дэлбэлж суваг, шуудуу байгуулах тохиолдолд зураг төсөл, техникийн шаардлагад заасанчлан ажил дуусаж, хөндлөн гарах эцсийн байдлын тэр хэсэгт дэлбэлэлт хийхээс аль болохоор зайлсхийнэ. Ямар нэгэн алдаагаар дуусаж дүүргэсэн гадаргууд тэслэлт хийсэн бол эцсийн гадаргуу ямар байхаар төсөллөсөн тэр хэмжээнд хүртэл нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд, нөхөн сэргээх цэгүүд дэх ажлыг зурагт заасан бүтээцийн ажиллагааг тасалдуулахгүй, улмаар одоо байгаа хөрсний нөхцөлд харш нөлөө үзүүлэхгүй байдлаар гүйцэтгэнэ.
- Суваг, шуудуу ухсан хэсэг дэх булаг шандны ус, улмаар шахуурга (насос) ашигласан эсвэл хоолой байгуулсны улмаас үүссэн зогсонги, тогтмол усыг зайлуулна.
- Зураг төсөл, техникийн шаардлагын дагуу одоо байгаа бүтээц дээгүүр хөндлөн гарах суваг, шуудуу зайлшгүй байгуулах тохиолдолд зураг төсөл, техникийн шаардлагын холбогдолтой асуудлаар Инженертэй урьдчилан зөвлөлдөж байна.
- Бүтээцийг эргүүлж булахад Инженерийн заасны дагуу энэхүү шаардлагад заасан

холбогдох зүйл бүрт заасан хөрсийг ашиглана.

- Буцаан дүүргэлтийн ажил гүйцэтгэсний дараа тэрхүү ажлын хэсэгт үлдсэн хог, модны холтос зэргийг цэвэрлэж, буцааж булах шорооны үеийн зузаан 30 см хүртэл байхаар дэвсэж, тухай бүрт нь гүйцэд нягтруулна.

- Буцаан дүүргэх цэгт булаг шанд эсвэл тогтмол ус хуримтлагдсан байвал барилгын ажлаа эхлүүлэхээс тэдгээрийг зайлуулна.

- Буцааж дүүргэлтийн ажлыг хуучин байсан байгууламж, давчуу газар гүйцэтгэхээр бол нягтруулах, дагтаршуулах машиныг ашиглан нягтрал, дагтаршуулалтыг жигд гүйцэтгэнэ. Харин хүнрэл тохиолдвол, зураг төсөл, техникийн шаардлагыг баримтлан тэр тухай Инженертэй зөвлөлдөнө.

- Буцаан дүүргэх орчинд далд байгууламж байгаа бол газрын даралтын тэнцвэрийг үл алдагдуулах байдлаар буцаан булах ажлыг гүйцэтгэнэ.

- Гүйцэтгэгч нь чийгийн хэмжээ зохих хэмжээнд байх үед л буцаан булах ажлыг гүйцэтгэнэ.

- Шонгийн орой дээрх илүүдэл зуурмагийг цэвэрлэн зайлуулах

- Илүүдэл зуурмагийг цэвэрлэн зайлуулна. Эс тэгвэл тэрхүү илүүдсэн үлдэц зуурмаг нь шонгийн чанар, даах чадварт муугаар нөлөөлнө.

Гүйцэтгэгч нь мөн төмөр бетон хүрээний бүтээцээс илүүдэл зуурмагийг цэвэрлэн зайлуулна. Ямар ч боловч Гүйцэтгэгч нь төмөр бетон хүрээ барихын өмнө, барьсны дараа дахин шинэ наалдац үлдэхгүйн тулд илүүдэл зуурмагийг цэвэрлэн зайлуулна.

(5) Арматур

Гүйцэтгэгч нь арматурласан хүрээний тэгш босоо байдлыг хангах үүднээс түүнийг суурилуулахдаа дэгээдэх цагариг хэрэглэх зэргээр онцгой анхаарал хандуулна.

Бэхэлгээний гол холбоос болон дэгээдэх цагаригийг хатаасан ган утсыг ашиглан гагнуурын аргаар гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд, гол бэхэлгээний хэсэгт хэмнэлт гаргаж байна гээд гологдол дутагдал гаргах, гагнуурын улмаас уях цагаригийн хэсэгт гологдол дутагдал гаргахаас зайлсхийнэ.

Гүйцэтгэгч нь урвуу өрөмдлөгийн аргаар, мөн газар ухах аргаар гүйцэтгэсэн нүхэнд бэхэлгээний хүрээг сүвэрхэг хана, налуу нурахгүй байдлаар болгоомжтой суулгана.

Бэхэлгээний хүрээг өөрийн нь жингээр нүхний ёроолд суурилуулж болохоор түүний залгаас хэсгүүд хангалттай бат бэх хийгдсэн байна. Давхардсан залгаасыг тэрхүү арматурлан хүчитгэх хүрээний дээд болон доод давхардсан хэсэгт хийвэл зохино.

Үндсэн бэхэлгээний давхардсан холбоосыг ган утсаар боож ч болно. Дээд, доод бэхэлгээний хүрээг суурилуулах зориулалтын уях цагариг хийж, үндсэн (гол) бэхэлгээний давхардах холбоосыг өнцгийн эсвэл булангийн оёдол гагнах (*сварка угловых швов* - оросоор) аргаар гүйцэтгэнэ. Харин, энэ тохиолдолд, үндсэн (гол) бэхэлгээний хөндлөн огтлолын талбайн хэсэг хэсэгчлэн алдагдахаас сэргийлэх асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Бэхэлгээний хүрээнд суулгасан дэрийг хөдөлгөөний үед сүвэрхэг ханыг үрж гэмтээхгүй байхаар хэлбэршүүлсэн байна. Дэрийг ерөнхий гүний зайн чиглэлд 4~6 газар 3~5 м-г ижил

гүнд байрлуулна. Дэрийн төслийн өндөр, сүвэрхэг хана болон дотор талын бүрхүүл яндан хоорондын зайг бүрхүүл янданг сугалах үед гацахгүй байх, түүнчлэн сүвэрхэг ханын гадаргуу тэгш байхад онцгой анхаарна.

d) Цутгамал шон барьж байгуулах

Гүйцэтгэгч нь бетоны ажлыг тасралтгүй гүйцэтгэх зорилгоор усанд бетоны ажил гүйцэтгэх хоолой ашиглана. Бетоны ажил гүйцэтгэхдээ плунжер (живэх) төрлийн хоолой хэрэглэнэ.

Бэлэн бетон хольц хэрэглэх тохиолдолд түүнийг хольсноос хойш 1.5 цагийн дотор цутгана гэж төлөвлөнө. Тээвэрлэлтийн хугацаа, тээвэрлэлт хоорондын хугацаа тодорхой бус байж болохыг харгалзан бетон бэхжилт авах хугацааг сааруулагч бодис хэрэглэхэд нэгэн адил анхаарна.

Өндөрт бетон цутгах тохиолдолд, заасан өндөрт сайн чанарын бетон хүргэхийн тулд цутгаж буй бетоны материалын ялгаралт үүсгэхгүй байх зохих арга хэрэглэнэ.

Гүйцэтгэгч нь цементийн сүү ялгарах, түрэгдэн гарах шаврыг тэгшлэх гадаргуун ойролцоо бетон гадагш урсахгүй байлгах үүднээс өрөмдөх нүхний төв цэгийг баримтлан усан дотор бетоны ажил гүйцэтгэх хоолойг хэзээ бүрт суулгахаас гадна цутгасан бетоны гадаргуугаас 2 м дээр байх байдлыг хангана.

Бетон цутгах үед бүрхүүл (хамгаалалтын) яндан хоолойг сугалах шаардлага гарвал бэхлэгээний хүрээг хамтад нь гаргахгүйн тулд, мөн сүвэрхэг ханын шороо, элс холилдохгүйн тулд бүрхүүл (хамгаалалтын) яндан хоолойн ёроолын төгсгөлийг цутгах бетоны гадаргуун доор байрлалд байх байдалд суурилуулахад байнга анхаарна.

Гүйцэтгэгч нь заасан өндөрт бетоны ажлыг сайн чанартай гүйцэтгэнэ. Нүхний гүний буюу газар доорх ус ашиглах тохиолдолд энэ нь шонгийн толгойн хэсэг дэх бетоны чанарт муугаар нөлөөлдөг тул нэмэлт бетон хэрэглэхэд хүргэнэ. Тухайлбал, нүхний гүний буюу газар доорхи 0.8м орчим гүний ус ашиглах, 0.5м орчмын нүхний бус ус ашиглах тохиолдолд хатуурсан бетоныг төслийн өндөрт хүргэнэ.

Гүйцэтгэгч нь цутгамал шонгийн толгой орчмын шаврыг зайлуулахдаа шонгийн эх биеийг эдвлэхгүй байхад анхаарна.

Цутгамал шон барьж байгуулахдаа Гүйцэтгэгч нь зураг төсөл, ажлын даалгаварт заасан даацын үеийг нэмж, ухмалын гүн, ухсан элс, ухсан нүхний баганын хөндлөн огтлолыг магадалж, авсан дээж, хийсэн тэмдэглэлийн хамт Инженерийн шаардсан үед саадгүй өгнө.

Гүйцэтгэгч нь ухмалын ажлыг дуусгасны дараа (шонгийн хэтэрсэн хэсгийн бетоныг зайлуулахын өмнө) бүх шонгийн толгойн диаметрийг шалгаж, гүйцэтгэлийг гэрэл зургаар баталгаажуулан Инженерт өгнө. Шонгийн диаметрийн хяналтын шалгуур хангагдаагүй бол Гүйцэтгэгч нь тэрхүү дутагдлыг засах талаар Инженертэй зөвлөлдөнө.

1704. ЭРГЭЛТЭТ ӨРӨМДЛӨГИЙН ГАН ШОН

Гүйцэтгэгч нь зураг төсөл, ажлын даалгавар, хөрс, орчин, ажлын нөхцөлийг бүрэн дүүрэн судалсны үндсэн дээр эргэлтэт өрмийн аргаар ган шонг суулгах төлөвлөгөө бэлтгэж Инженерт гардуулна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Эргэлтэт өрмийн аргаар ган шон суулгахын өмнө доорх (хүсн.17-1)-д дурдсан зүйлсийн дагуу арга хэмжээ авна.

Хүснэгт 17-1 Магадлах зүйлс

Агуулга	Магадлах шаардлагатай зүйлс
Материалын захиалга	Болзошгүй нэмэлт өрөмдлөгийн зураг төсөл гаргах, төлөвлөх, шонгийн уртыг эргэж шалгах, дээрх эсвэл доорх түвшинд шон гацвал түүнийг аргалах аргыг олсон байх, материал/барилгын шаардлага хангах нэмэлт нийлүүлэлт хийх нөхцөлийг хангаж, холбогдох зураг төслийг боловсруулсан байна.
Барилгын талбайд нэвтрэх	Барилгын талбайд нэвтрэх зам, тийнхүү нэвтрэх цагийн хязгаар (хаалгаар), барилгын талбайн гадна, дотно машин техник хүлээлгэн зогсоох байршил
Барилгын талбай	Барилгын талбайд борооны улмаас хөрс нурахын эсрэг түүнийг тогтворжуулах арга хэмжээ авах, овоолгын цөмийг зөв байрлуулах, барилгын талбай, агаарын зайн хязгаарлалт, хэт авиа, боломжийн цаг хугацаа, зэрэгцээ бүтээцийн байршил, хязгаарлалт
Гүйцэтгэлийн шалгуур	Туршилт, хяналтын шон, талбайн нөхцөлд гүйцэтгэсэн гагнуурын арга, давтамж, гүйцэтгэлийн зураг, шонгийн голын хазайлт, шонгийн оройн байршлын шалгалтын дүнгийн тухай гарын авлага

(1) Туршилтын (хяналтын) шон

Гүйцэтгэгч нь эхний шонгоо энэ ажилд хяналтын шон болгон барьж байгуулан үндсэн мэдээлэл хуримталж, дараа дараагийн эргэлтэт өрмийн аргаар суулгах ган шонг барьж байгуулах нөхцөлийг тодруулна. Туршилтын шонг өрөмдөн судалгаа гүйцэтгэсэн газрын орчимд барьж байгуулна.

а) Шонгийн суурь хөрсийг бэлтгэх шалгуур

Гүйцэтгэгч нь барилгын ажил гүйцэтгэх явцад эргэлтийн (мушгилтын) момент, нэвтрэлтийн гүнийг хэмжээд SPT-N-ийн гистограмм (өрөмдсөн цооногийн огтлол)-ын хөрс шинжилгээний үр дүн, стандартын нэвтрэх туршилттай харьцуулан явагдаж буй барилгын ажлыг удирдан залах аргыг сонгон ажиллана.

б) Газар доорх далд саадыг мэдэх

Гүйцэтгэгч нь хөрсийг судалсан үед илрээгүй, улмаар том хэмжээний хайрга тохиолдсон гэх аливаа саадыг даван туулах барилгын ажлын нэмэлт арга хэмжээ авна. Энэхүү барилгын нэмэлт ажилд, жишээ нь яндан хоолойд орсон шороог алх ашиглан зайлуулах, өрөмдөхийн өмнө сэргийлэх арга хэмжээ авах, доргиурт төхөөрөмж ашиглан өрөмдлөг хийхдээ сэргийлэх арга хэмжээ авч, хамгаалах (бүрхүүл) яндан хоолой ашиглах зэрэг арга хэмжээ байж болно.

с) Туршилтын шонгийн туршилтын давтамж

Туршилтын (хяналтын) шонгийн туршилтын давтамж тухайн нэг барилгын талбайд нэгээс илүү тоотой байна. Гэхдээ даацын үеийн хазайлт их, мөн геологийн нөхцөл ихээр ялгагдах тохиолдолд энэ тухай асуудлыг жич авч үзнэ.

(2) Ажлын дэс дараалал, гүйцэтгэлийн хяналт

а) Эргэлтэт шахах (дарж шахах) төхөөрөмжийг суурилуулах (байршуулах)

- Гүйцэтгэгч нь барилгын машин механизм, төхөөрөмжийг зохих байршилд байрлуулж, тогтвортой байх байдлыг хангана.

- Гүйцэтгэгч нь барилгын газар тэгш бус, хөрс тун зөөлөн бол машин механизм, төхөөрөмжийн тогтвортой байдлыг хангах үүднээс барилгын газрыг тэгшлэх, ган хуудсаар бүрхэх эсвэл гадаргуун өнгөн үеийг бэхжүүлэх арга хэмжээ авна. .

- Гүйцэтгэгч нь ухах зэргээр бул чулуу, чулуун асгаас, мод зэргийг урьдчилан зайлуулж бүтцийн суурийг тодруулна.

б) Шонг тээвэрлэх, буулгах, түр хадгалах

- Гүйцэтгэгч нь овоолго хийхдээ дараа нь үүсэж болох саадаас зайлсхийж, тээвэрлэх, буулгах, овоолох газар, цэгийг болзошгүй бэрхшээлийг харгалзан сонгож авна.

- Гүйцэтгэгч нь бүтээгдэхүүн хүлээн авах үзлэг шалгалтын дараа л шонг тээвэрлэж болно.

- Гүйцэтгэгч нь шонг тээвэрлэх, байршлыг нь шилжүүлэх үед шонгийн толгой болон эх биед нь гэмтэл учруулахгүй байхад анхаарна.

- Гүйцэтгэгч нь шонг буулгахдаа түүний ёроолын хэсгийг гэмтээхгүй байхад анхаарна.

- Гүйцэтгэгч нь газрыг тэгшилж, ачиж авчирсан шонг гэмтээхгүй байх зорилгоор тэрхүү шон хөмөрч унахгүй байх үүднээс ажлын талбайд түр арга хэмжээ авна.

с) Шонгийн чиг шугамын хяналт

- Шонгийн чиг шугамын чигийг хянах ажил барилгын ажлын нарийвчид ихээр нөлөөлөх тул энэ ажилд маш нарийн хандана.

- Гүйцэтгэгч нь шонгийн ажлыг гүйцэтгэхдээ дуран, хэмжих метрийн тууз хэрэглэж, шонгуудын байршлыг нэг шугамын дагуу жигдрүүлнэ. Тийнхүү шонгуудын байршлыг нэг шугамын дагуу жигдрүүлэхдээ хүнд машин механизм хэрэглэхгүй байна.

д) Эргэлтэт дагтаршуулах төхөөрөмжийг туршин ажиллуулах

- Барилгын машин механизм, багаж хэрэгслийг бүрэн дүүрэн шалгаж, урьдчилан тосолж, шаардлагатай тэдгээрийг туршиж ажиллуулна.

- Өрмийн машины тухайд гэвэл шон суулгах машинаа угсарсны дараа өрмийн машиныг туршин ажиллуулж, ажиллах чадварыг нь магадална. Гүйцэтгэгч нь зангилаа, өрмийн машины зориулалтын дүүжин утас ороох төхөөрөмж, нарийсах утасны хэт ачааллыг шалгана.

- Гүйцэтгэгч нь бүхий л төрлийн эргэх төхөөрөмжийг дээрхийн нэгэн адил шалгаж, ажиллах байдлыг нь магадална. Гүйцэтгэгч нь эсрэг баланс (тэнцүүлэх зориулалтын сөрөг жин, ачаа) ашиглан тогтвортой байдлын зэрэглэлийг магадална.

е) Хэмжих төхөөрөмжийн ажлын байдал

Гүйцэтгэгч нь өрөмдөх, эргэх бүх төхөөрөмжийн ажлын бүтээл, эргэлтийн момент, нэвтрэх гүн, ажиллах гүн, хэт ачаалал, ажлын бүтээмж зэргийг харгалзан эрэгдэн суулгах шонг хянах тогтолцоог шалгана. Үүний тулд доорх зүйлсийг шалган магадална. Үүнд:

- (Тосон шахуургын тусламжтай ажилладаг өрөм, тосны даралт бууруулдаг төхөөрөмж ашиглах тохиолдолд) өрмийн машины цахилгаан гүйдлийн ачаалалгүй үе, ажиллах бүтээмж.
- Барилгын ажлын гүнийг хэмжих багажийн ажиллаж буй байдал, ажлын бүтээмж.
- Эргэлтийн чиглэлээс хамаарсан ажлын бүтээмж, (хэвийн болон эсрэг чиглэлээр эргэсний).

(3) Өрөмдөх ажил

а) Шонг суурилуулах

- Гүйцэтгэгч нь шонг өлгөн өргөж хажуу орчинд элдэв нөлөөгүйгээр суурилуулна.
- Гүйцэтгэгч нь шонгийн эгц босоо байдал тогтвортой байх эсэхийг магадална. Шонг хэрхэн суурилуулах нь тун чухал ач холбогдолтой тул түүнийг зөв өнцгөөр суурилуулсан эсэхийг хоёр талаас нь дурангаар дурандаж баталгаажуулна.

б) Өрөмдлөгийн эхлэл

- Шон өрөө эгц босоо байх, түүнчлэн шонгууд нэг шугамд байх нөхцөлийг хангахын тулд нүх өрөмдөж эхлэнгүүтээ үүнд онцгой анхаарал хандуулна.

-

- Гүйцэтгэгч нь шонгийн гадна диаметрийг баримтлангаа шонгийн нүхийг нурангиас сэргийлж аль болохоор доргиулахгүй байхаар заасан гүн хүртэл ухна.

- Гүйцэтгэгч нь эргэлтэт бүх төхөөрөмжийн цөмрөн ухах хүчийг тохируулж, хажуу нягтруулна.

с) Шонгийн эгц босоо байдлыг хангах

Гүйцэтгэгч нь шон яг таг байх байдлыг хангана. Чингэхдээ өрөмдлөг газрын гадаргуугаас наад зах нь 5.0 м гүн хүртэл хийгдэх хүртэл онцгой анхаарал хандуулна. Гүйцэтгэгч нь дуран, шугам ашиглан эгц босоо байдлын тогтворжилтыг хангана.

д) Эрэгдэн суулгах арга

- Гүйцэтгэгч нь далавчийн урагшлан ухах хүчид тохируулан өрмийн машиныг ажиллуулна. Ингэхдээ, гол нь овоолго үүсгэхгүй байхаар өрмийн машиныг ажиллуулна.

- Гүйцэтгэгч нь шон суулгах машины шонгийн толгойд өрөм (шнек) суулган өөрийн жингээр нэвтрэх байдлаар машиныг ажиллуулна.

- Гүйцэтгэгч нь аливаа эргэлтэт машин ашиглах тохиолдолд гүйх поршны хамгаалах хаалт (клапан) нээгдэх үеийн даралтад тохируулан эргэх төхөөрөмжийг ажиллуулж ашиглана. Нэвтрэх гүн хөрсний байдлаас шалтгаалан өөрчлөгдөх боловч машины далавчийн хөдлөх (татах) хүч саадгүй ажиллаж байх ёстой.

- Далавчийн үзүүр хатуу үед орвол эсвэл шаварлаг үеэс элсэн үед орвол, түүнчлэн нэвтрэлтийн гүн багасах бол шахалтын хүчлэлийг тогтооно. Шахалтын хүчлэлийг тогтоох аргыг туршилтын шонгоор магадална.

(4) Даацын үеийг магадлах, ажиллагааг дуусган зогсоох

Эргэлтэт өрөмдлөгийн ган хоолой ашиглах аргыг хэрэглэхдээ барилгын явцад үүсэх эргэлтийн моментын өөрчлөлт болон хөрсний бат бэх (SPT-N-Value)-ийн өөрчлөлт хоорондын харьцаа, түүнчлэн даацын үед хүрснийг магадалсан хэмжилтийн үр дүнг ашиглана.

Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн үеийн хөрсний судалгааны дүн, эргэлтийн момент, нэвтэрсэн гүн болон өрөмдлөгийн зураг (SPT-N-Value Histogram буюу хөрсний бат бэхийн гистограмм)-ийг үндэс болгон ажиллагаа заасны дагуу явагдаж байгаа эсэхийг магадална.

Гүйцэтгэгч нь дараах нөхцөл хангагдсан тохиолдолд шон нэвтрэлтийн ажлыг зогсооно. Үүнд:

- Шонгийн толгой шонгийн төслийн уртад хүрсэн;
- Даацын үеийн хэмжсэн гүнд хүрсэн нь магадлагдсан;
- Даацын үед зохих ($1.0 \cdot D_p$ -ээс илүү) гүнд суулгана. Суналт эсэргүүцэх хүч их байх бол даацын үед суулгах гүн $1.5 \cdot D_p$ -ээс илүү байж ч болно.

Гэхдээ, даацын үеийн хатуулаг төсөөлж байснаас их бол даацын үед суулгах гүнийг хангах, хэтэрсэн эргэлтийн моментоор ажиллуулах явцад их биед гэмтэл үүсэх аюултай. Иймд, даацын үеийн хатуулаг их тохиолдолд шон суулгах ажлыг зогсоох бол даацын чадлыг төслийнхтэй харьцуулан магадлаад шийдвэр гаргана.

Дээр дурдсанчлан даацын үеийг магадалж, шон суулгах ажиллагааг зогсооход эргэлтийн моментыг абсолют утгаар нь хянах аргагүй тул Гүйцэтгэгч нь хяналтын шон гүйцэтгээд талбай бүрийн нөхцөлд тохируулан хэрхэн шон суулгах талаар Инженертэй зөвлөлдөнө.

(5) Барилгын менежмент

Барилгын менежментийг (хүсн.17-2)-ын дагуу гүйцэтгэнэ.

Хүснэгт 17-2. Барилгын менежмент

Хянах зүйлс	Хяналтын агуулга	Арга	Шалгалтын/объектын агуулга (жишээ)
-------------	------------------	------	------------------------------------

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Хянах зүйлс	Хяналтын агуулга	Арга	Шалгалтын/объектын агуулга (жишээ)
Материалын хяналт	Гадаад байдал, үзэмж	Харж магадлах (хувингийн диаметр, шонгийн диаметр, хуудасны зузаан, Далавчийн диаметр, далавчийн зузаан, материалын тоо хэмжээ)	Шалбарсан, гэмтсэн зүйл байгаа эсэхийг шалгах Check on existence of scratches or deformation
	Материалын тоо хэмжээ Material Quantity	Ган шон эсвэл үйлдвэрийн дагалдах баримт дээр тэмдэглэл хийх замаар магадлах	
	Оролтын хяналт Admission Control	Хадгалах арга, түр хадгалах байршлыг шалгах	
Барилгын менежмент	Хөрсөнд үзүүлэх ачааллыг шалгах	Хөрсний даах чадал, бэхэлгээний аргыг шалгах	Хүнд машин механизмын хөрсөнд үзүүлэх даралтыг хөрсний даах чадалтай харьцуулан шалгах
	Газар доорх саадыг зайлуулах	Хуучин бүтээцийн суурь, чулуу, чулуун асгаас, модон материалыг урьдчилан зайлуулах	
	Барилгын машин, багажид үзлэг хийх	Хүнд машин механизмын хөдөлгөөнийг шалгаж, мөн ажлын бүтээмжийн холбогдолтой мэдээллийг шалгана.	
	Шонгийн чиг шугам	Тэмдэгт газраас хэмжсэн зайг шалгах	
	Шон суулгах машин суурилуулах	Шон суулгах машиныг шонгийн чиг шугамын байршилд суурилуулах. Бүтээцийг ажлын эргэлтийн моментоор үүсэх эргэлтийн хариу хүчний эсрэг байрлуулна.	Шон тус бүр дээр машин ашиглах үеийн ажлын эргэлтийн моментын хяналтын утгыг шалгаж
	Шон суулгах нөхцөл	Шонгийн чигээс хазайсан хазайлтыг шалгах, тэгш өнцгийн хоёр шугамыг шугам, дуран (теодолит), эгцлүүр, тэгшлүүрээр хэмжих	
	Эргэдэн шахах нөхцөл	Эргэлтийн момент, нэвтрэлтийн гүн, хэмжилт-хяналтын системийн хэт ачаалал болон бүтээмжийг шалгаж, хөрс судалгааны хөрсний бат бэх (SPT-N)-ийн гистограммын үр дүнтэй харьцуулах	Далавчийн налууугаас ихээр хэтрэх өрөмдлөг буюу нэвтрэлт хийхгүй байх
	Талбайн нөхцөлд тойргон гагнуур хийх нөхцөл	Мэргэшсэн ажилтны гүйцэтгэсэн тойргон гагнуурыг үзэж шалгах (гэмтэл үл учруулах хэлбэрээр туршиж үзэх)	Хялгасан (судсан) туршилт, хэт авиан үзлэг

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг (Баянбулаг баг), Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн Улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох авто зам

Хянах зүйлс	Хяналтын агуулга	Арга	Шалгалтын/объектын агуулга (жишээ)
	Даацын үеийг шалгах, ажиллагааг дуусгах	Хөрсний судалгааг эргэлтийн момент, гүн, хөрсний баг бэх (SPT-N)-ийн гистограммтай харьцуулах. Даацын үед суусан гүнийг шалгах.	Зарчмын хувьд, 1.0Dp-ээс дээш байна. Даацын үе хатуугаас болж нэвтрэлт хүндрэлтэй тохиолдолд Dp хэд байх талаар жич зөвлөлдөнө.
	Нягт нямбай гүйцэтгэл	Шонгийн толгой, шонгийн эксцентриситетийг хазайлтыг хэмжинэ.	Эксцентриситет нь $\pm 100\text{мм}$, Dp/4-ийн дотор, хазайлт нь 1/100-ийн дотор, шонгийн орой $\pm 50\text{мм}$ -ийн дотор тус тус байна.
Явцын хяналт	Байрлуулах журам	Хүнд машин механизмыг тараан байрлуулах төлөвлөгөө, материал зохицуулалтын төлөвлөгөөг тус тус шалгах	
Аюулгүйн хяналт	Аюул осолгүй ажиллагаа	Барилгын талбайн аюул осолгүй ажиллах нөхцөлийг хангах, цахилгаан тасалдахаас сэргийлэх, шон суулгах төхөөрөмж унахаас сэргийлэх, ослоос сэргийлэх, ойролцоо бүтээцүүдийг харгалзах зэрэг аюулгүйн арга хэмжээ авах	

(6) Хэмжилтийг хянах тогтолцоо

Гүйцэтгэгч нь эргэлийн моментыг хэмжилтийг хянах тогтолцоог ашиглан нэвтрэлтийн гүн болон хэт ачааллын аргаар бодит цагт (байнга) хянахын зэрэгцээ эрэгдэх (буюу өрөмдөх, нэвтрэх) ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

1705. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Өрөмдмөл цооног

Тухайн газар өрөмдөж дууссан цооногийг ажлын хэмжээнд заасан цооног бүрийн хэмжээг баримтлан уртааш (погонный - *оросоор*) метрээр хэмжинэ. Хэмжилтийг голын шугамын дагуу, зурагт заасан эсвэл Инженерийн зааварласан үзүүрийн болон цооногийн огтлолын өндрийн түвшнээр хийнэ.

Туршилтын цооног

Тусгайлан заасан диаметрийн туршилтын цооногийг өрөмдлөг эхлэх үед илүү өндөр түвшинд тохиолдсон хөрсний эсвэл усны аль нэгийн нь өндрийн түвшингээс уртааш метрээр хэмжинэ.

Инженер-геологийн цооног

Зөвшөөрсөн инженер-геологийн цооног бүр дээр хэмжилт хийхдээ цооногийн өндрийн түвшингээс ёроолоос инженер-геологийн цооногийн ёроол хүртэл уртааш метрээр хэмжинэ.

Байнгын хамгаалалтын (бүрхүүл) яндан

Хэрэглэхээр зөвшөөрсөн байнгын хамгаалалтын янданг хэмжээс тус бүрээр нь уртааш метрээр хэмжинэ. Хэмжилтийг байнгын хамгаалалтын яндан зөвшөөрөгдөн ашиглагдаж байгаа цооног бүр дээр яндангийн дагуу яндангийн орой эсвэл цооногийн оройноос (дор түвшинд байгаагаас нь) яндангийн ёроол хүртэл уртааш метрээр хэмжинэ.

Ачааллын туршилт

Ачааллын туршилтыг тухайн шонгийн даацын чадлыг тодорхойлохоор гүйцэтгэсэн удаагийн тоогоор хэмжинэ. Тухайлбал:

(1) Өрөмдмөл цооног

Өрөмдмөл цооногийн төлбөрийг заасан диаметрийн өрөмдмөл цооногийн уртааш метр тутамд оноосон гэрээт үнийн дагуу гүйцэтгэнэ.

Энэхүү төлбөрийг цооног ухах, ухаж гаргасан материалыг зайлуулах, тоноглох, бетондох болон ган арматурын бүхий л зардлын бүрэн гүйцэд нөхөн төлбөр гэж үзнэ. Түүнчлэн, энэ төлбөрт бүхий л хөдөлмөр, материал, тоног төхөөрөмж, мөн төлөвлөгөөнд заасан бол бүрэн бүтэн байдлын туршилт, улмаар өрөмдмөл цооногийг гүйцээх, шалгахад шаардагдах нэмэлт зардал багтаж байгаа болно. Харин үүнд үл тооцсон гэнэтийн саад багтахгүй болно. Энэхүү заалтын дагуу төлбөр хийгдэх ажлын нэр төрлийг хэмжих нэгжийн нь хамт доор харуулав.

Үүнд:

Ажлын төрөл	Хэмжих нэгж
Газар дээр угсрах завсрын тулгуурын шон	м
Усан дотор угсрах завсрын тулгуурын шон	м

(2) Туршилтын цооног

Зурагт заасан диаметр бүхий туршилтын шонгийн цооногийн төлбөрийг уртааш метр бүрт тогтоосон гэрээний нэгж үнийн дагуу гүйцэтгэнэ. Энэхүү төлбөр нь ухах, бетондох, буцааж булаах ажил, түүнчлэн бүхий л хөдөлмөр, материал тоног төхөөрөмж, туршилтын цооногийг гүйцээх, шалгахад шаардагдах нэмэлт зардлын бүрэн гүйцэд нөхөн төлбөр байна

Энэхүү заалтын дагуу төлбөр хийгдэх ажлын нэр төрлийг хэмжих нэгжийн нь хамт доор харуулав. Үүнд:

Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж
Усан дотор зоох туршилтын шон	м
Газар дээр зоох туршилтын шон	м

(3) Инженер-геологийн цооног

Тусгайлан заасан эсвэл төлөвлөгөөнд тусгагдсан бол хөрсний дээж эсвэл хадны керн авах зориулалтын инженер-геологийн цооногийн төлбөрийг уртааш метр бүрт тогтоосон гэрээний нэгж үнийн дагуу гүйцэтгэнэ.

Энэхүү төлбөр нь цооног, керн ухах, дээж, керн авах, савлах, тэдгээрийг Инженерт хүргэх, түүнчлэн ажлыг гүйцээхэд шаардагдах бусад бүх зардлын бүрэн гүйцэд нөхөн төлбөр байна.

Ажлын нэр төрөл	Нэгж
Хөрсний дээж авах зориулалтын инженер-геологийн цооног	м
Хадны керн авах зориулалтын инженер-геологийн цооног	м

(4) Байнгын хамгаалалтын (бүрхүүл) яндан

Байнгын хамгаалалтын яндангийн төлбөрийг уртааш метр бүрт тогтоосон гэрээний нэгж үнийн дагуу гүйцэтгэнэ. Энэхүү төлбөр нь төлбөрийн зохих нэр төрлийн дагуу төлбөр нь хийгдсэн ажлын холбогдолтой зардлаас гадна хамгаалалтын янданг тоноглох, суурилуулах ажлын бүрэн гүйцэд нөхөн төлбөр байна. Энэхүү заалтын дагуу төлбөр хийгдэх ажлын нэр төрлийг хэмжих нэгжийн нь хамт доор харуулав. Үүнд:

Ажлын нэр төрөл	Нэгж
Шонгийн байнгын хамгаалалтын ган яндан	м
0.9м-ийн ийн диаметр бүхий шонгийн байнгын хамгаалалтын ган яндан	м

(5) Ачааллын туршилт

Ачааллын туршилтын төлбөрийг туршилт тус бүрт тогтоосон гэрээний нэгж үнээр гүйцэтгэнэ. Энэхүү заалтын дагуу төлбөр хийгдэх ажлын нэр төрлийг хэмжих нэгжийн нь хамт доор харуулав. Үүнд:

Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж
Усанд зоох шон дээр гүйцэтгэсэн босоо статик ачааллын туршилт	Удаа (тоо)
Газар дээр зоох шон дээр гүйцэтгэсэн босоо статик ачааллын туршилт	Удаа (тоо)